



ӨӨРЧЛӨЛТИЙН УДИРДЛАГА CHANGE MANAGEMENT

Улаанбаатар хот
2022 он

Редактор: Д.Дэмчигсүрэн (Ph.D)

Эмхэтгэсэн : А.Булгаа (Ph.D)

Г.Дагва

Д.Бишүүгарам

Д.Наран-Отгон

Д.Энхтулга

Г.Галбадрах

Эх бэлтгэсэн: Э.Золбоо

ISBN: 978-9919-27-180-0

АГУУЛГА

ӨМНӨТГӨЛ	5
АНГЛИЙН CIRP (БОЛОВСОН ХҮЧИН БА ХӨГЖЛИЙН ИНСТИТУТ)-ТЭЙ хамтран зохион байгуулж байгаа хүний нөөцийн мэргэшсэн ажилтан бэлтгэх сургалтыг нээж хэлсэн үг 2022.05.17	7
“ӨӨРЧЛӨЛТИЙН УДИРДЛАГА-CHANGE MANAGEMENT” Нийслэл, аймаг, дүүргийн ЗДТГ-ын дарга нарын сургалтад зориулсан лекцийн хураангуй 2022.05.13	9
“ТЭГШ БОЛОМЖ-ТӨРИЙН АЛБАНЫ ХҮНИЙ НӨӨЦИЙН БОДЛОГО” Төрийн захиргааны удирдах албан тушаалын эмэгтэй албан хаагчдын анхдугаар чуулга уулзалтыг нээж хэлсэн үг, илтгэлээс 2022.03.07	15
“АВЛИГЫН ЭСРЭГ ҮНДЭСНИЙ ЧУУЛГАН 2021” Авлигын эсрэг үндэсний чуулганд тавьсан “Төрийн албаны томилгоо, ил тод байдал: томилгооны зөрчлөөс сэргийлэх нь” илтгэл 2021.12.08	25
“ТӨРИЙН АЛБАНД ЦОГЦ ЧАДАМЖИЙГ НЭВТРҮҮЛЭХ НЬ” Төвийн бүсийн сургалтын нээлтэд “Ёс зүйн элч-Төрийн албаны бүтээмж” хэлсэн үг 2021.11.18	31
“ШИНЭТГЭЛИЙН БОДЛОГО” Аймаг, нийслэлийн Засаг даргын Тамгын газрын дарга нартай хийсэн уулзалт дээр хэлсэн үг 2021.11.12	33
“ТӨРИЙН АЛБАНЫ ШИНЭТГЭЛ ДЭХ ЁС ЗҮЙ” Улсын Их Хурлын Ёс зүй, сахилга хариуцлагын байнгын хорооны хурал дээр хэлсэн үг 2021.10.19	39
“ЁС ЗҮЙ – ЦОГЦ ЧАДАМЖ” Цогц чадамжид суурилсан хүний нөөцийн удирдлагын онлайн сургалтыг эхлүүлэх видео мэндчилгээ 2021.10.04	52
“ТӨРИЙН АЛБАН ХААГЧ ЭМЭГТЭЙЧҮҮДИЙН МАНЛАЙЛАЛ” Төрийн албан дахь Эмэгтэйчүүдийн Манлайллын хөтөлбөрийн нээлт дээр хэлсэн үг 2021.09.21	55
Ли Куан Юүгийн нэрэмжит Төрийн бодлогын сургуулийн сургалтад оролцогчдын төгсөлтийн үйл ажиллагаа дээр хэлсэн үг 2021.08.26	58
“ТӨРИЙН АЛБА: ШИНЭТГЭЛ, БОДЛОГО, ШИЙДВЭР” УИХ-ын удирдлага, гишүүдээс төрийн бодлогын тодорхой асуудлаар Төрийн албаны зөвлөлийн бүрэлдэхүүнийг хүлээн авсан уулзалт дээр хэлсэн үг 2021.08.24	60
“Сингапурын Үндэсний их сургуулийн харьяа Ли Куан Юүгийн нэрэмжит Төрийн бодлогын сургуулийн сертификаттай тэтгэлэгт цахим хөтөлбөр” Хөтөлбөрт оролцогчидтой хийсэн уулзалт дээр хэлсэн үг 2021.07.09	67
“ИРГЭДЭЭ АНХААРЧ СОНСЪЁ, ҮГ, ҮЙЛДЛЭЭ АНЗААРЧ ӨӨРЧИЛЬЕ” “Анхаарч сонсъя, анзаарч өөрчилъе” сошиал медиа нөлөөллийн аяны хаалт дээр хэлсэн үг 2021.07.08	70
“ТӨРИЙН АЛБАНЫ ШИНЭТГЭЛ” УУЛЗАЛТ-ХЭЛЭЛЦҮҮЛЭГ УИХ-ын ТББХ-ны дарга, гишүүдийн Төрийн албаны зөвлөл дээр хийсэн уулзалт дээр хэлсэн үг 2021.07.03	73

“НЭГДСЭН ҮНДЭСНИЙ БАЙГУУЛЛАГЫН ТӨРИЙН АЛБАН ХААГЧИЙН ӨДӨР” НҮБ-ын төрийн албаны өдөрт зориулсан уулзалт дээр “Ирээдүйн төрийн албыг цогцлоох нь” нээж хэлсэн үг 2021.06.23	82
“АНХААРЧ СОНСЪЁ, АНЗААРЧ ӨӨРЧИЛБЕ” сошиал медиа нөлөөллийн аяны нээлт дээр хэлсэн үг 2021.06.17	87
“ТӨРИЙН АЛБАНЫ ШИНЭТГЭЛ: САНГИЙН ЯАМ” Сангийн яаманд хийсэн танилцах уулзалт дээр хэлсэн үг 2021.06.15	88
“ТӨРИЙН АЛБАНЫ ХҮНИЙ НӨӨЦИЙН УДИРДЛАГАД ЦОГЦ ЧАДАМЖИЙН ХҮРЭЭГ НЭВТРҮҮЛЭХ НЬ” сургалтыг нээж хэлсэн үг 2021.06.09	90
“ТӨРИЙН АЛБАНЫ ШИНЭТГЭЛ: ХӨДӨЛМӨР, НИЙГМИЙН ХАМГААЛЛЫН ЯАМ” Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яаманд хийсэн танилцах уулзалт дээр хэлсэн үг 2021.06.08	95
“НАСАН ТУРШИД ҮЛДЭХ УР ЧАДВАР” “Төрийн албан дахь эмэгтэйчүүдийн манлайллын хөтөлбөр”-ийн цахим төгсөлтийн баярт зориулан хэлсэн үг 2021.05.18	98
Яамдын Төрийн нарийн бичгийн дарга, агентлагийн дарга, аймаг, нийслэлийн Засаг даргын Тамгын газрын дарга нартай хийсэн цахим уулзалтыг хааж хэлсэн үг 2021.05.12	101
Яамдын Төрийн нарийн бичгийн дарга, агентлагийн дарга, аймаг, нийслэлийн Засаг даргын Тамгын газрын дарга нартай хийсэн цахим уулзалтыг нээж хэлсэн үг 2021.05.12	105
“ТӨРИЙН АЛБАНЫ ЕРӨНХИЙ ШАЛГАЛТ - 2021” Шалгалтыг нээлт дээр хэлсэн үг 2021.03.12	109
Төрийн албаны ерөнхий шалгалтын бэлтгэл ажлын хүрээнд сэтгүүлчидтэй хийсэн уулзалт дээр хэлсэн үг 2021.03.10	111
“МОНГОЛ ТӨРИЙН ТҮШМЭДИЙН УЛАМЖЛАЛ, ЁС СУРТАХУУНЫ АСУУДАЛ” сургалтыг дүгнэж хэлсэн үг 2021.01.21	115
“ТӨРИЙН БАЙГУУЛЛАГАД ЗАН ҮЙЛИЙН МЕНЕЖМЕНТИЙГ ХЭРЭГЖҮҮЛЭХ НЬ” сургалтыг хааж хэлсэн үг 2021.01.14	118
“2021 ОН ТӨРИЙН АЛБАНЫ ШИНЭТГЭЛД ТУЛГАМДАЖ БУЙ АСУУДАЛ, СОРИЛТЫГ ШИЙДВЭРЛЭХ ЖИЛ”	121
ТАЗ-ийн Салбар зөвлөлийн нарийн бичгийн дарга нарт зориулсан мэдээллийн цагийг хааж хэлсэн үгнээс 2020.12.23	124
Төрийн албаны зөвлөлөөс яамны дэргэдэх салбар зөвлөлийн дарга, нарийн бичгийн дарга нартай хийсэн цахим уулзалт дээр хэлсэн үг 2020.12.22	126
“ТӨРИЙН АЛБАНЫ ШИНЭТГЭЛ-ЁС ЗҮЙН ХАНДЛАГА” Төрийн байгууллагуудын ёс зүйн зөвлөлийн нэгдсэн зөвлөгөөнд хэлсэн үг 2020.09.10	131
“ТӨРИЙН АЛБАНЫ ШАЛГАЛТЫН СОРИЛ” цахим номын нээлт дээр “Монгол төрийн ирээдүйн түшмэл эрдэнэ танаа” хэлсэн үг 2020.08.27	139
“ТӨРИЙН АЛБАНЫ ШИНЭТГЭЛ” Завхан, Хөвсгөл аймагт ажиллах үеэр төрийн албан хаагчидтай хийсэн уулзалтууд дээр хэлсэн үгнээс 2020.05.29	141

Хүний нөөцийн удирдлага, аудитын газрын албан хаагчидтай хийсэн уулзалт дээр хэлсэн үгнээс 2020.01.19	147
“ШИНЭ ХАНДЛАГА” Өвөрхангай аймгийн Хархорин суманд болсон уулзалт дээр хэлсэн үгнээс. 2020.05.15	149
“ШИНЭ ОН –ШИНЭ ХАНДЛАГА” Яамдын Төрийн нарийн бичгийн дарга, агентлагийн дарга нарын оролцсон зөвлөлдөх уулзалтад тавьсан илтгэлээс. 2020.02.03	154
Монгол Улсын Их Хурлын гишүүний ёс зүйн дүрэм, төрийн албаны ёс зүй, сахилга, хариуцлагын тухай хуулийн төслүүдийн хэлэлцүүлгийг нээж, хэлсэн үгнээс 2019.12.16	166
Төрийн албаны зөвлөлийн нэгдсэн сургалтыг нээж хэлсэн үг 2019.12.09	173
Өмнөговь аймгийн төрийн албан хаагчдад зориулсан сургалтыг нээж хэлсэн үгнээс 2019.06.13	183
“21 ДҮГЭЭР ЗУУНЫ ТӨРИЙН АЛБАНЫ МЕНЕЖЕР” номын нээлтийн ёслолын үйл ажиллагаа дээр хэлсэн үг 2019.08.30	188
Яамны Төрийн нарийн бичгийн дарга, Агентлагийн дарга нарын төрийн жинхэнэ албан хаагчийн тангараг өргөх ёслолын үйл ажиллагааг нээж хэлсэн үг 2019.05.31	192
УИХ-д үйл ажиллагаагаа тайлагнадаг байгууллагын Тэргүүн түшмэлүүдэд зориулсан Төрийн албаны мэргэшүүлэх сургалтыг нээж хэлсэн үгнээс 2019.06.08	194
Төрийн албаны зөвлөлийн салбар зөвлөл, орон нутгийн төрийн албаны зарим удирдах ажилтнуудтай хийсэн видео хурлыг хааж хэлсэн үг 2019.05.15	196
Аймаг, нийслэлийн ИТХ-ын нарийн бичгийн дарга, ЗДТГ-ын дарга нарт зориулсан Төрийн албаны мэргэшүүлэх сургалтыг нээж хэлсэн үг 2019.05.05	199
“МОНГОЛ УЛСАД МЭРГЭЖЛИЙН, ИРГЭН ТӨВТЭЙ ТӨРИЙН АЛБЫГ ТӨЛӨВШҮҮЛЭХ НЬ” (МОН/18/101) төслийн Удирдах зөвлөлийн хурал дээр хэлсэн үг 2019.05.22	202
Төрийн албаны шинэчлэлийн шинэ үе шатны гарааны жил буюу 2019 он	206
Төрийн ордонд 2019 оны 2 дугаар сард болсон орон нутгийн удирдах ажилтны улсын зөвлөгөөн дээр тавьсан “Төрийн албаны шинэтгэлийн зарим асуудал” илтгэлээс...	207

ӨМНӨТГӨЛ

Улс орны хөгжил цэцэглэлтэд төрийн бодлого, хууль тогтоомжийн хэрэгжилтийг тууштай мөрддөг, мэдлэг, чадвар, ёс зүйтэй албан хаагчдаас бүрдсэн төрийн албаны төлөвшил нэн чухал байгааг тангараг өргөсөн төрийн албан хаагчийн хувьд гүнээ ухамсарлан ажил үүргээ нэгэн үзүүрт сэтгэлээр хичээн хашиж буй төрийн албан хаагчийн жирийн нэгэн төлөөлөл Балдангийн Баатарзоригоор би бахархдаг.

Төр, засгийн байгууллагуудад гуч гаруй жил ажиллаж хуримтлуулсан мэдлэг, туршлагатай нь харьцуулахад Төрийн албаны зөвлөлийн даргаар ажиллаж буй гурван жил гэдэг зурвасхан мэт боловч үүрч буй ачааг нь харахад хавьгүй урт санагддаг билээ.

Эл учир шалтгааныг эрхбиш харгалзан шинэтгэлээс шинэтгэл рүү буухиалсан, сургамж судалгаанаас амжилт ололт руу хөтөлсөн төрийн албаны тасралтгүй, бүхэл бүтэн үйл явцын гинжин хэлхээг үл тасалдуулж, үл мартагдуулах үүднээс сүүлийн гурван жил гаруйн хугацаанд түүний хэлсэн үг, тавьсан илтгэл, илэрхийлсэн байр суурийг нь цомхон байдлаар хураангуйлан бэлтгэж толилуулахаар шийдсэн нь энэ буюу.

Нэр төртэй энэхүү албыг үүрэг хариуцлага хэмээвээс энэ хүний ажил Монгол төрийн албаны нэн шинэ түүхийн өв болон үлдэж, иргэд, олон түмнээр цэгнэгдэн үнэлэгдэх учиртай.

Чадварлаг, ёс зүйтэй төрийн албыг төлөвшүүлэх зорилтын төлөөх төрийн албаны шинэтгэлийг бэрхшээл сорилтоос үл шантран өртөөлөн тээх философийг тодорхойлж ирсэн мэдээлэл, судалгаа, зөвлөмж, санал, тайлбараас нь энэхүү эмхэтгэлд шигтгэн оруулахыг эрмэлзэв.

Төрийн албаны үндсэн зорилт, чиг үүрэг шинэ утга агуулгаар улам бүр баяжиж, тэр хэрээр төрийн албан хаагчдын мэдлэг, ур чадварын шаардлага өндөрсөж байна. Өрсөлдөх чадвар, бүтээмжийн ойлголт төрийн албанд нэвтэрч, хүний нөөцийн удирдлагын онол, чиг хандлагын цоо шинэ орчин бий боллоо.

Олон улсын нөлөө бүхий байгууллагуудаас ирээдүйн төрийн албаны хөгжлийн хандлагын талаар судалгаанд суурилсан таамаглал дэвшүүлж, түүнд зохицон нийцсэн өвөрмөц чиглэлүүд тогтсоор байна. Энэ бүхнийг хөндсөн өргөн хүрээтэй сэдвүүд нь хувь хүний болоод байгууллагын хөгжилд дэм тус болж, сэдэл санаа төрүүлнэ хэмээн найдна.

“Сөрөг үйл явдлыг сөрөн зогсож болдог, харин цаг нь ирсэн үзэл санааг зогсоох боломжгүй” гэсэн ухаантны үгийг иш татсан нь анхаарал эрхгүй татна. Хуулиар тогтоосон, бодлогоор баталгаажсан, нийгэм, иргэдийн хүсэн хүлээж буй төрийн албаны шинэтгэл болох чухамхүү “үл зогсох” шинэ үзэл санааг тээж явах,


түгээн дэлгэрүүлэгч байх эрх, бас үүрэг нь төрийн албан хаагч бүхэнд ногдож буйг илэрхийлсэн хэрэг.

Монгол төрийн алба хэмээх эрхэм хүндтэй ойлголтын ард төрийн албан хаагч олон мянган хүний нөр их хичээл зүтгэл оршдог. Төрт ёсны эртний улбааг өнөө цагийн өнгөнд түүчээлэн эх орон, түмэн олныхоо тусын тулд нэгэн үзүүрт сэтгэлээр зүтгэж, сорилт бэрхшээлийг гэтлэн, үүрэг зорилтоо бүрэн дүүрэн биелүүлж чадахуйц ирээдүйд чиглэсэн төрийн албыг цогцлоож буй төрийн албан хаагчдаараа бахархсан үгс ч энд цөөнгүй тохиолдоно.

Нийгэм дэх төрийн албаны үүрэг хариуцлага өсөн нэмэгдэж буй цаг дор төрийн албаны шинэтгэлийн шинэ содон хуудсыг хамтдаа эргүүлж байгаа Төрийн албаны зөвлөлийн хамт олондоо болон өөртэй нь гар, сэтгэл нийлэн ажиллаж буй төр, засаг, олон улсын байгууллагууд, хамтран ажиллаж буй хүмүүст илэрхийлсэн гүн талархлыг нь энэ дашрамд уламжилъя.


Эмхэтгэлд ижил төстэй санаа, үг хэллэг цөөнгүй давтагдаж байгааг уншигч Та анзаарах нь лавтай. Энэ нь гагцхүү үйл явдлын цаг үе, үйлс зорилгын хүрэх өндөрлөг нэгэн учир Б.Баатарзоригийн зүгээс шинэтгэлийн өртөө бүрд учирсан өөр өөр зочдодоо зориулж үгийн хүч нэмэн утгын холбоос өгч байсных биз ээ.

Антропологийн ухааны доктор (PhD)



Доржийн ДЭМЧИГСҮРЭН

---o0o---



АНГЛИЙН CIPD (БОЛОВСОН ХҮЧИН БА ХӨГЖЛИЙН ИНСТИТУТ)-ТЭЙ ХАМТРАН ЗОХИОН БАЙГУУЛЖ БАЙГАА ХҮНИЙ НӨӨЦИЙН МЭРГЭШСЭН АЖИЛТАН БЭЛТГЭХ СУРГАЛТЫГ НЭЭЖ ХЭЛСЭН ҮГ

2022.05.17

1. Төрийн албаны сургалт хөгжил яагаад чухал вэ?

Төрийн албаны шинэтгэлийн гол хөдөлгөгч хүч болсон төрийн албан хаагчдаа чадавхжуулах, мэргэшүүлэх, олон улсын түвшинд бодож сэтгэдэг болгохыг аль аль талдаа хичээж байна.

Цахим засаглалд шилжих, хүнд суртал, авлигагүй төрийн үйлчилгээг бүрдүүлэх үндэсний хорооны хуралд Ерөнхий сайд Л.Оюун-Эрдэнэ нэг зүйлийг онцолсон. Тавьж буй зорилтдоо амжилттай хүрэхэд төрийн албаны бодлого, судалгааны чиглэлээр бүс нутаг, олон улсад хүлээн зөвшөөрөгдсөн хөтөлбөртэй Ли Куан Юүгийн нэрэмжит Сингапурын их сургуулийн Төрийн бодлогын сургууль зэрэг нэр хүндтэй газруудад төрийн албан хаагчдаа сургаж хөгжүүлэх нь чухлыг зөвлөсөн.

Сая нэр дурдсан сургуультай гэрээ байгуулан өнгөрсөн жилээс эхлэн төрийн албан хаагчдаа суралцуулж, хоёр удаагийн төгсөлт хийсэн. Энэ сургуульд манай хүмүүс суралцах гурав дахь сургалт удахгүй эхлэх гэж байна.

Түүнчлэн олон улсад хүлээн зөвшөөрөгдсөн ном, гарын авлагуудыг албан ёсны эрхтэйгээр эх хэл рүүгээ орчуулж, төрийн албан хаагчдадаа уншиж судлах боломжийг олгож ирлээ.

Одоо нэгэн нэр хүндтэй байгууллагад манай төрийн албан хаагчид суралцаж эхлэх гэж байна. Энэ бол Английн Лондон хотод төвтэй “Боловсон хүчин ба хөгжлийн институт”- (CIPD)-тэй хамтран зохион байгуулах энэ удаагийн сургалт.

Удаан хугацаанд бэлтгэж, гэрээ, харилцан ойлголцлын баримт бичгүүд бэлтгэсний эхний үр дүн ийнхүү гарч байна. Энэ сургалтыг төлөвлөж, ажил хэрэг болгоход олон хүний хүч оролцоо, цаг зүтгэл гарсныг тэмдэглэх хэрэгтэй. Тэр бүх хүмүүст талархал илэрхийлье.

2. Энэ сургалтын онцлог

Хүний нөөцийн удирдлага, сургалт хөгжлийн чиглэлээр мэргэшсэн, ажлын туршлагатай олон улсын түвшний зөвлөх багш нар эл сургалтыг чиглүүлэн зохион байгуулна. Сургалтаа амжилттай төгсвөл олон улсад хүлээн зөвшөөрөгдсөн, хугацаагүй мэргэшлийн гэрчилгээтэй болно.

Төгсөгчид маань тус институтын 100 гаруй жилийн түүхтэй мэдлэгийн санд нэвтрэх эрхтэй гишүүн болно. Нээлттэй мэдээллийн эх үүсвэрээс тэр бүр олддоггүй мэдлэг, мэдээллийн сангаас хүртэх чөлөөт орон зай Та бүхэнд нээгдэнэ гэсэн үг.

Энэ сургалтыг төрийн албаны сургалт хөгжлийн үйл явцад гарч ирж буй нэг шинэ үзэгдэл гэж болно. Тиймээс ч сургалтад оролцож буй төрийн албан хаагчид, тэдний ажиллаж буй байгууллагууд онцгой анхаарах хэрэгтэйг сануулъя.

3. Сургалтын явцад юунд анхаарах хэрэгтэй вэ?

Байдаг нэг сургалт, болох юм болдгоороо болоод өнгөрнө гэж боддог хүмүүс байвал яг энэхүү мөчөөс цагаас уг бодлоо толгойноосоо авч хаяхыг нөхөрсгөөр зөвлөх байна. Энэ сургалтад оролцож буй хувь албан хаагч чадавхжаад өнгөрөх ёсгүй. Та бүхний мэдлэг, чадвар зөвхөн нэг албан хаагчийн “олз” болох ёсгүй.

Сургалтад хамрагдсан хүмүүс яам, агентлаг, ЗДТГ-ынхаа “үнэт капитал” болох ёстой. Иймд сургалтын үр дүнг хамтдаа үзнэ, хамтдаа хуваалцана гэдгийг оролцогч, оролцуулагч талууд сайн ойлгоорой. Нийт 285 цагийн багтаамжтай сургалт цахимаар явагдана. Мөн сургалтын явцад бие даан суралцах, сурч мэдсэнээ практикт нэвтрүүлэх дадлага ажил агуулга, хөтөлбөрт багтсан.

Иймээс яамдын Төрийн нарийн бичгийн дарга, агентлагийн дарга нар, ЗДТГ-ын дарга зэрэг байгууллагын удирдлагууд оролцогч албан хаагчдынхаа ажлын ачааллыг зохицуулахад анхаарч, энэ сургалтад манай байгууллага бүхлээрээ оролцож, суралцаж байна гэж холч, нийтлэг өнцгөөс хараарай хэмээн хүсье.

Аль ч орны хувийн хэвшлийнхэн аливаад овсгоотой, шинийг эрэлхийлэгч талдаа хурдтай явдгийг бид мэднэ. Харин манай улсын хувийн хэвшлийнхэн CIPD-ийн ямар нэг сургалтыг хараахан аваагүй байгаа юм билээ.

Хүний нөөцийн стандарт тогтоогч нэр хүндтэй байгууллагын сургалтад оролцож байгаа нь тухайн хүнд төдийгүй ажил олгогч байгууллага, цаашилбал манай төрийн алба, Монгол Улсын хувьд том олз гэж бодоорой.

Легаси буюу сургалт судалгааны өв болж үлдэхүйц тийм үйл явц өрнөөсэй гэж бодож байна. Төрийн байгууллагын хүний нөөцийн удирдлагыг хэрэгжүүлэх чиглэлээр олон улсын жишиг стандарт, туршлагыг нэвтрүүлэх зорилтоо хэрэгжүүлэхэд энэ удаагийн сургалт үр дүнгээ өгнө гэдэгт итгэж байна.

Та бүхэнд сурлагын амжилт хүсье!


---o0o---



“ӨӨРЧЛӨЛТИЙН УДИРДЛАГА-CHANGE MANAGEMENT”

Нийслэл, аймаг, дүүргийн ЗДТГ-ын дарга нарын сургалтад зориулсан лекцийн хураангуй

Өөрчлөлтийн менежментийн шийдлийн чиглэлээр глобал лидер гэгддэг зөвлөх үйлчилгээний Prosci компанийг үндэслэгч Жефф Хиаат 700 гаруй байгууллагын өөрчлөлтийн хэв маягийг судалсны үндсэн дээр боловсруулсан олон улсад өргөн ашиглагддаг хувь хүний хөгжил, өөрчлөлтөд анхаарал төвлөрүүлж, хувь хүний тодорхой өөрчлөлтөөр удирдан чиглүүлж, саад бэрхшээл, сорилтыг шийдвэрлэхэд чиглэгддэг **ADKAR** загварыг танилцуулъя.



Хувь хүн бүрийн өөрчлөлт байгууллагад
өөрчлөлтийг авчирдаг.

Jeffrey M. Hiatt

ADKAR

Change Management Model



Судалгаа шинжилгээний 20 гаруй жилийн түүхтэй, олон улсын хэмжээнд 100 мянга гаруй хүнийг сургалтад хамруулан сертификатжуулсан, АНУ-ын шилдэг 100 (Fortune 100) компанийн 80%-тай хамтран ажилладаг өөрчлөлтийн удирдлагын энэхүү хүчирхэг загвар зөвхөн хувь хүн өөрчлөгдөх үед байгууллагын өөрчлөлт гарч болно гэсэн ойлголт дээр суурилдаг бөгөөд байгууллагын өөрчлөлт салбар, салбарын өөрчлөлт улс орны хэмжээний үр дүнтэй өөрчлөлт болдгийг тодорхойлдог.


ӨӨРЧЛӨЛТ ХИЙХ ХҮНИЙ НӨӨЦИЙН МЕНЕЖМЕНТИЙН ҮЙЛ АЖИЛЛАГАА, ФУНКЦҮУД



“ОНОВЧТОЙ БҮТЭЦ, ЗОХИСТОЙ ХАРИЛЦАА, ҮР ДҮН”

Эртний архитектурын шийдэлд түгээмэл тохиолддог эв нэгдэл, тэнцвэрт байдал, эрч хүчний бэлгэдэл гексагон буюу зургаан өнцөгт дүрсээр төлөөлүүлэн төрийн албаны шинэтгэлийн зарим асуудлыг хөндье.

1980-аад онд үүссэн олон салаа зам дахь **тодорхой бус, нарийн төвөгтэй орчны** тухай **VUCA** ойлголт бий. Харин цаг уур, глобал системийн өөрчлөлтөөс үүдэн 2020-иод онд гарсан **дараа үеийн** буюу next generation орчны тухай **BANI** ойлголтод шилжсэн тийм цаг үед бид ажиллаж амьдарч байна.



Өөрөөр хэлбэл “хэврэг, сэтгэл түгшээсэн, шугаман бус, ойлгомжгүй” цаг үед Монгол төрийн албыг хэрхэн оновчтой эрхлэн явуулах тухай онцолж, өөрчлөлт хийх арга зам, гарц шийдлийг загварчлан томъёолж байна.

ОНОВЧТОЙ БҮТЭЦ, ЗОХИСТОЙ ХАРИЛЦАА, ҮР ДҮН



Үе шат / дараалал	Хамрах хүрээ	Хугацаа	Үр дүн
СИСТЕМ (ТОГТОЛЦОО)-ийн реформ			
ТОГТОЛЦООНЫ ӨӨРЧЛӨЛТ Эрх зүйн орчин Бүтэц /яам, агентлаг/ Ангилал, зэрэглэл Цалин хөлс	a. Төрийн байгууллагын тогтолцоо b. Төрийн албаны төрөл, ангилал c. Төрийн захиргааны байгууллагын дотоод бүтэц d. Ангилал, зэрэглэл e. Цалин хөлс	2022-2030	Төрийн албаны тогтолцоо бүхэлдээ өөрчлөгдөнө: - Бүтэц, тогтолцоо, чиг үүрэг; - Дотоод бүтэц, удирдлагын хэлбэр, харилцаа - Төрийн жинхэнэ албаны ангилал, тодорхойлолт - Төрийн албаны ангилал, зэрэглэлийн өөрчлөлт - Цалингийн тогтолцоо (цалин хөлс нэмэгдүүлэх); - Шударга ёсны зарчим; - Үр дүнд суурилах;
ҮЙЛ ЯВЦ /НӨХЦӨЛ БАЙДАЛ/-ЫН ШИНЭТГЭЛ			
АНГИЛАЛ, ЗЭРЭГЛЭЛИЙН ӨӨРЧЛӨЛТ Цалин хөлсний хамт	a. Ангилал зэрэглэлийг цөөлөх b. Төв, орон нутгийн ялгамжтай тогтоох	2022-2030	Одоогийн төрийн захиргааны тогтолцоо үндсэндээ хэвээр үлдэнэ: - Төрийн захиргааны албан тушаалын зэрэглэлийн өөрчлөлт (15-аас 10 болж цөөрөх); - Цалингийн сүлжээ, хэмжээнд өөрчлөлт орох (доод хэмжээг тогтоох, дээш чөлөөтэй); - Үр дүнд суурилах; - Орон нутгийн нэмэгдэл (ажилласан жил, цалингийн хэмжээ үл хамааран);
ЦАЛИН ХӨЛСНИЙ ӨӨРЧЛӨЛТ	a. Ижил хувиар нэмэх b. Ижил хэмжээгээр нэмэх c. Ялгамжтай хувь, хэмжээгээр нэмэх		Бүтэц тогтолцоо, ангилал зэрэглэл хэвээр байна: - Цалингийн хэмжээ нэмэгдэж, өөрчлөгдөх (доод хэмжээг тогтоох, дээш чөлөөтэй); - Төв, орон нутагт харилцан адилгүй тогтоогдох; - Орон нутгийн нэмэгдэл (ажилласан жил, цалингийн хэмжээ үл хамааран);

Гишүүн орнуудынхаа бодлогын туршлагыг харьцуулах, нийтлэг тулгамдсан асуудалд хариулт хайх, сайн туршлагыг тодорхойлох, дотоодын болон олон улсын бодлогыг уялдуулах талбар болж ажилладаг Эдийн засгийн хамтын ажиллагаа, хөгжлийн байгууллага (OECD)-аас ирээдүйн төрийн албан хаагч, төрийн албаны төлөвшил хөгжлийн чиг хандлагын талаар гаргасан дүн шинжилгээнд тулгуурлан ярилцъя.

Ирээдүйн төрийн албан хаагч		
Урагш тэмүүлсэн (Forward-looking)	Уян хатан (Flexible)	Сэтгэл ханамжтай (Fulfilling)
Шинээр шаардагдах ур чадвар	Иргэн бүрийн төлөө хаанаас ч, хэзээ ч ажиллах	Тэгш байдал-Тэгш оролцоо
Ажиллах хүчний стратегийн зохистой төлөвлөлт	Насан туршдаа суралцах	Утга учир бүхий ажил
Найдвартай өгөгдөл	Хөдөлмөрийн зах зээлээс ур чадвар олж авах	Ажилтны туршлага, оролцоо, гүйцэтгэл



- ◆ Өнөөгийн төлөв байдал
- ◆ Ирээдүйн төлөв байдал

----oOo----



“ТЭГШ БОЛОМЖ - ТӨРИЙН АЛБАНЫ ХҮНИЙ НӨӨЦИЙН БОДЛОГО”

АНХДУГААР ЧУУЛГАН

Төрийн албаны зөвлөлийн дарга
Б.БААТАРЗОРИГ

Улаанбаатар хот
2022.03.07



Нэг. Төрийн бүтээмж - Хүмүүн капитал

Хоёр. Тэгш гарааны шударга нөхцөл

Гурав. Боломж ба арга барил

Дөрөв. Тэгш боломж - хамтын үр дүн

“ТЭГШ БОЛОМЖ-ТӨРИЙН АЛБАНЫ ХҮНИЙ НӨӨЦИЙН БОДЛОГО”

Хатагтай, ноёд оо,

Монгол Улсын Их Хурлын дарга Г.Занданшатар, Улсын Их Хурлын гишүүн болон Засгийн газрын гишүүд ээ, Канад Улсаас Монгол Улсад суугаа Онц бөгөөд Бүрэн эрхт Элчин сайд хатагтай Ивкофф Та бүхэнд энэ өдрийн мэнд хүргэе.

Шинэ өдөр бүр шинэ боломжоор эхэлдэг. Төрийн албаны шинэтгэлийн хүрсэн түвшинг ахиулж, бүтээмжийг нэмэгдүүлэх чиглэлээр шинэ өдөр эхэлж байна.



Өнөөдөр Олон улсын эмэгтэйчүүдийн эрхийн хамгаалах өдрийн хүрээнд төрийн албаны шинэтгэлийн зарим асуудлууд болоод тэгш байдал, тэгш боломжийн тухай хэлэлцэхээр Та бид чуулж байна.

Төрийн албаны шинэтгэл хууль, эрх зүйн шинэ орчин, төрийн албан хаагчийн харилцаа, хандлага, зан төлөвийн өөрчлөлт, үйлчилгээний соёл, чанар-хүртээмж, технологийн дэвшлээр хүрээгээ тэллээ.

Бид КОВИД-19-ийн дараах төрийн албаны шинэ соёл, шинэ менежментэд бэлтгэж, хэрэгжүүлж байна.

Иймд та бүхний анхаарлыг

Нэг. Төрийн бүтээмж-Хүмүүн капитал,

Хоёр. Тэгш гарааны шударга нөхцөл,

Гурав. Боломж ба арга барил,

Дөрөв.Тэгш боломж-хамтын үр дүн сэдвүүдэд хандуулъя.

Олон сэдвийг хамарсан өргөн хүрээний өөрчлөлтөөс товч онцолъё.

Төрийн албаны мерит зарчим, карьер хөгжлийн шатлан дэвших тогтолцоо, төрийн алба мэргэшсэн, тогтвортой байх бодлого хууль тогтоомж хэрэгжсэнээр батжиж, “Алсын хараа-2050”, “Шинэ сэргэлтийн бодлого”-оор төгөлдөржиж байна.

Төрийн албаны хууль шинэчлэгдэн мөрдөгдсөнөөр хөгжлөөр тэргүүлэгч орнуудын төрийн албанд үр дүнгээ өгсөн зарчим, зохицуулалтыг нутагшуулах үйл явц хурдацтай өрнөлөө.


Улс орны хөгжлийн урт хугацааны бодлогын гол цөм нь Монгол хүний амьдралын чанарыг дээшлүүлэх, иргэдийн итгэлийг хүлээсэн төрийн албыг төлөвшүүлэх явдал юм.

Эдгээр үзүүлэлтийг сайжруулах асуудлыг төрийн бодлогынхоо тэргүүлэх зорилгоо болгосон улс орнууд тогтвортой, зөв хурдтай, хүчтэй хөгжиж байна.

Нийгмийн хөгжилд төрийн гүйцэтгэх үүрэг, оролцооны илүү уян хатан, үр дүнтэй арга хэлбэрийг ашиглаж төрийн албан хаагчийн хандлага, сэтгэлгээг өөрчилж чадвал “төрийн бүтээмж”-ийн хэрэгжилт үр дүнд хүрнэ. Шийдлээ хүлээсэн энэ ажлууд бидний анхаарлын төвд байна.

Үндсэн хуульд шударга ёс, тэгш байдал, хууль дээдлэх нь “Монгол төрийн үйл ажиллагааны үндсэн зарчим мөн” хэмээн тунхагласан. Энэ зарчмыг хэрэгжүүлэхэд төрийн бүх шатны байгууллагын албан хаагчдын, тэр тусмаа та бидний манлайлал чухал юм.

Хүмүүн капитал зөвхөн тухайн хүний боловсрол мэдлэгээр хэмжигддэг үе байсан. Харин одоо энэ ойлголтыг эрүүл мэнд, эзэмшсэн боловсрол, туршлагаа хэрэгжүүлэх ур чадвар, хандлага зан үйлийг багтаасан илүү өргөн хүрээнд, олон хүчин зүйлийн уялдаанд авч үздэг боллоо. Төрийн бүтээмжийг нэмэгдүүлэхэд төрийн илүү тодорхой процесс, зарцуулах цаг хугацаа, технологи-хүмүүн капиталыг сайжруулахтай холбоотой олон асуудлуудыг хөндөнө.



Шинэтгэлийн бодлого, үзэл баримтлалыг хэрэгжүүлэх, сайн засаглалыг бэхжүүлэх, төрийн үйл ажиллагааны бүтээмжийг дээшлүүлэхэд гол хөдөлгөгч хүч болох төрийн албаны төлөө гэх сэтгэлтэй, мэдлэг чадвартай хүний нөөц-хүмүүн капитал чухал үүрэгтэй.

Мэдлэг, ур чадвар сайтай, үндэсний язгуур эрх ашгийн төлөө сэтгэлтэй, ямар ч иргэнд Монгол төрийн албанд өндөр бүтээмжтэй ажиллах боломж нээлттэй байна. Тийм эрх зүйн орчин, нийгмийн үзэл санаа, бодлого зохицуулалт манайд хангалттай бий.

Төрийн албанд ажиллаж, төр, түмний үйлсийн төлөө зүтгэх нь нэр төрийн хэрэг гэдгийг тангараг өргөсөн төрийн албан хаагчид та бид сайн мэднэ. Зөвхөн “мэдэх” нь

хангалттай биш. Албан хаагч бүр сэтгэл гаргаж өндөр бүтээмжтэй ажиллах шаардлага тавигдаж байна.

Бүтээмж нь эдийн засаг, нийгмийн үр өгөөж, ард түмний амьдралын чанараар дүгнэгддэг. Хэн илүү хийж бүтээсэн нь, хэн илүү сэтгэл, үр ашиг гаргасан манлайлагчдад үр дүнд суурилсан цалин хөлсний систем үйлчилнэ.

Төрийн албаны чадварлаг хүний нөөцийг хэрхэн бүрдүүлэх вэ?

Тавигдаж буй зорилтоо БИД хэрхэн хэрэгжүүлж, ямар үр дүнд хүрэх вэ?

БИД яавал зөв ажиллаж, өндөр бүтээмж гаргах вэ?

Энэ асуултын хариулт нь, “Зөв хүнийг шударгаар зөв сонгон шалгаруулж, чадах ажилд нь томилж, зөв үр дүнд хүрэх” явдал юм. Энэ талаар тодорхой ахиц дэвшил гарч байна.

Төрийн албан дахь тэгш боломжийг хангах өөр нэг чиглэл бол цахимжуулалт.

Төрийн албаны зөвлөл үндэсний цахим сүлжээ “eMongolia”-д нэгдлээ. Төрийн албаны ерөнхий болон тусгай шалгалтад бүртгүүлэх, шалгах, дүгнэх зэрэг шалгалтын бүхий л үйл явцыг цахимд шилжүүлснээр хүний оролцоо, хөндлөнгийн нөлөөлөлгүй, олон нийт, мэргэжлийн байгууллагуудын хяналт дор ил тод, нээлттэй явуулдаг боллоо.

Гэхдээ олон нийтийн зүгээс төрийн албаны хүний нөөцийг зөвхөн сонгон шалгаруулалтаар бүрдүүлэх нь өндөр бүтээмж бүхий хүмүүн капиталыг төрийн албанд татаж оруулахад зарим талаар учир дутагдалтай байгааг шүүмжилдэг. Тухайлбал, өндөр түвшний мэдлэг, онцгой ур чадвартай, ховор мэргэжилтэй хүмүүсийг төрд урин ажиллуулах уян хатан зохицуулалтын орон зай бий болгох хэрэгцээ шаардлага байгаа юм. Энэ орон зайг ч нөхөх болно.

Энэ бол тархины ангуучлал (headhunting)-ын тухай ярьж байгаа хэрэг.

Шинэтгэлийг үр дүнд хүргэх, шинэ сэргэлтийн бодлогыг хэрэгжүүлэн төрийн бүтээмжийг дээшлүүлэхэд цогц чадамжид суурилсан хүний нөөцийн удирдлагыг төрийн албанд нэвтрүүлэх явдал хамгаас чухал байна.

Ийм учраас бид энэ ажлын бэлтгэлийг хангах зорилгоор “Цогц чадамж”, “Ёс зүй”, “Хүний нөөц”, “Системийн сэтгэлгээ”, “Зан үйлийн ухаан” “Дизайн сэтгэлгээ” сэдвүүдээр бүсчилсэн сургалт зохион байгуулж, Улаанбаатар хот болон 21 аймгийн 611 хүний нөөцийн удирдах ажилтнуудыг хамрууллаа.



Албан тушаалын томилгооны тухайд Засгийн газрын Хэрэг эрхлэх газартай хамтарсан хяналт шалгалтын ажлын хэсэг ажиллаж, Төрийн албаны тухай хуулийн үндсэн зарчмыг зөрчсөн 1513 хууль бус томилгоог хүчингүй болгох арга хэмжээг авлаа. Энэ ажил цаашид ч үргэлжилнэ.

Өнөөдрийн байдлаар чадвартай төрийн албан хаагчид ажиллах боломжтой 2148 сул орон тоо байгаагаас 351 нь удирдах албан тушаалын орон тоо. Та бүхэнд сонгон шалгаруулалтаар өрсөлдөх боломж нээлттэй гэсэн үг.



Тэгш гарааны шударга нөхцөл гэдэг нь нийгмийн орчин, ажлын байр, хамт олон, гэр бүл зэрэг хүний амьдралын бүхий л хүрээнд, онцлог нөхцөл байдлыг харгалзан тэгш боломжийг бүрдүүлэх тухай ойлголт юм.

Төрийн албан хаагч бүрийн ялгаатай хэрэгцээ шаардлага, өөр өөрийн онцлогтой байдлыг нь хүлээн зөвшөөрч, тэнцвэрт оролцоотой, олон талт нийгмийн гишүүдийн төлөөллөөр бүрдүүлж, хэрэгцээнд суурилсан уян хатан төрийн бодлогыг үе шаттайгаар хэрэгжүүлэх нь төрийн албаны хүний нөөцийн удирдлагын нэгэн цөм юм.

Төрийн албаны хөдөлмөр эрхлэлтийн зөв тогтолцоог хангах уян хатан бодлого, ил тод, тэгш шударга байдлын хэмжүүр болох **хүний нөөцийн аудитыг** төрийн албанд шинээр нэвтрүүлж, **олон нийтийн хяналтын тогтолцоог** бүрдүүлж байна.

Манай улсын хамгийн том ажил олгогч нь ТӨР, төрийн алба. 2021 оны байдлаар хөдөлмөр эрхэлж байгаа иргэдийн дөрөвний нэг нь төрийн салбараас цалинжиж байна.¹

Нийт 208864 төрийн албан хаагчийн 62.6 хувь, үүнээс төрийн захиргааны албан хаагчдын 62.8 хувь, их, дээд сургуульд суралцагчдын 63.7 хувь, мөн салбарт ажиллагсдын 63.1 хувийг тус тус эмэгтэйчүүд эзэлж байна.

¹ 2021 оны байдлаар ажиллах хүч 1.2 сая гаруй байгаагийн 1.1 сая нь ажил эрхэлдэг бол түүний 200 мянга гаруй нь төрийн албан хаагчид байна



ТӨРИЙН АЛБА

4.206 байгууллага, 208.864 албан хаагч



Төрийн албаны ангилал



Төрийн захиргаа

21.135




62.86 %



Улс төрийн

4.165



Төрийн тусгай

45.899



Төрийн үйлчилгээ

137.665



Энэ танхимд оролцогчдын хувь ч нэгийг хэлж, хоёрыг бодогдуулах байх аа.

Засгийн газрын гишүүдэд эмэгтэйчүүдийн эзлэх хувь өсөх зөв эхлэл жишиг тогтож байна. Харин яамдын Төрийн нарийн бичгийн дарга, агентлагийн дарга, аймаг, дүүргийн ЗДТГ-ын дарга, ИТХ-ын нарийн бичгийн дарга зэрэг захиргааны шийдвэр гаргах түвшний албан тушаалд эмэгтэйчүүдийн эзлэх хувь зорилтот түвшинд хүрэхгүй байна.

Эмэгтэйчүүдийн албан тушаалд ахин дэвшихэд нь сорилт бэрхшээл болдог үл үзэгдэх "шилэн тааз"-ыг хүний нөөцийн бодлогын хүрээнд "чөлөөлж" явахаас өөр аргагүй.



ХОЁР. ТЭГШ ГАРААНЫ ШУДАРГА НӨХЦӨЛ

Төрийн Ажлын Министр

МОНГОЛ

rank
out of 156 countries 69

score
0.00 = parity
1.00 = parity 0.716

156/69-р байр

2017-р байр

Дэлхийн эдийн засгийн форумын "Жендерийн тэгш бус байдлын индекс"



Global Gender Gap Index

эдийн засаг,
боловсрол,
эрүүл мэнд,
улс төрийн эрх мэдэл

	2006 score	69	2021 score
42	0.682		0.716
21	0.704	23	0.769
20	0.999	73	0.993
1	0.980	1	0.980
101	0.046	116	0.122



"ШИЛЭН ТААЗ"

Дэлхийн эдийн засгийн форумын “Жендерийн тэгш бус байдлын индекс”-д эдийн засаг, боловсрол, эрүүл мэнд, улс төрийн оролцоо гэсэн 4 үзүүлэлтээр тухайн орны жендерийн тэгш бус байдлыг үнэлдэг.

Манай улс энэ индексээр Зүүн Ази, Номхон далайн бүсийн 20 орноос 7-д, дэлхийн 156 орноос 69-д эрэмбэлэгдэж байгаа нь харьцангуй дэвшилттэй үзүүлэлт. Цаашид ч нийгмийн амьдрал, эдийн засаг, улс төрийн үйл ажиллагаанд эмэгтэйчүүдийн оролцоог нэмэгдүүлэх боломж бий.

Төрийн албаны зөвлөлөөс адил ажил албан тушаалд ижил ойролцоо цалин хөлс олгох судалгааны ажлыг Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яам, Сангийн яам, Дэлхийн банктэй хамтарч эхлүүлээд байна.

Судалгаанд суурилсан, бүтээмжид чиглэсэн цалин хөлсний тогтолцоог нэвтрүүлснээр нийгмийн баталгаа сайжирч, төрийн албаны хүний нөөцийн шинэтгэл эдийн засгийн агуулгаар өргөжих болно.



Аливаа зүйлийг хийж бүтээх арга зам нь инновац, түүнээс ч сайн хийж бүтээх арга бол та бидний сэтгэл, дотоод итгэл үнэмшил, хандлага соёлын эрс өөрчлөлт юм.

Эмэгтэйчүүдийн карьер хөгжлийг дэмжих, замаар төрийн албан дахь тэгш боломжийг бүрдүүлж эхэллээ. Төрийн албаны зөвлөлөөс “Төрийн албанд жендерийн тэгш байдлыг хангах үйл ажиллагааны төлөвлөгөө (2021-2023)-г батлан хэрэгжүүлж байна. Өнөөдрийн энэхүү чуулган ч төлөвлөгөөнд тусгагдсан ажлуудын хэрэгжилтийн нэг нь юм. Иргэдийн төрийн алба хаах тэгш эрхийн боломжийг бодит утгаар нь өргөтгөх, жендерийн тухай хэвшмэл ойлголт, хандлагыг арилгах чухал алхам гэдэгт итгэлтэй байна.

Төрийн албаны тэгш боломжийг хүнд суртал, ашиг сонирхлын зөрчлөөс ангид байлгахгүйгээр төсөөлөхөд хэцүү.

Хүнд суртлын хүлээснээс нийгэм, иргэдийг ангижруулах үйл явц хурдацтай өрнөж эхэллээ. Хүнд суртлын “Улаан тууз”-ыг улам бүр сулруулах, тайлах, таслах ажил явагдаж байна. Өнөөдөр манай улсад 600 орчим хууль, 6700 гаруй стандарт мөрдөгдөж байна.

Хэт их зөвшөөрөл, зохицуулалтыг бууруулах, давхардлыг арилгах шаардлагатай байгаа, үүнд та бидний манлайлал чухал. Төрийн хүнд суртлын ард нуугддаг ашиг сонирхлын зөрчлийг арилгаж, төрөөс үзүүлэх үйлчилгээг цахимжуулах замаар төрийн хүнд суртлыг бууруулах чухал.



Төрийн албаны шинэтгэлд нийгмийн сорилт, шударга ёсны хүлээлт өндөр байна. Амжилтын 20 хувь ур чадвар, 80 хувь нь сайтар төлөвлөсөн стратеги гэсэн энгийн логик бий. Иргэдийн итгэл хүлээсэн төрийн албаны шинэтгэлийн амжилтын нэг хэмжүүр нь сайтар төлөвлөгдсөн стратеги, төрийн албан хаагчийн ур чадварт тулгуурласан тэгш боломж, хамтын үр дүн юм.

Төрийн албан хаагчид аа,

Шударга ёсны хүлээлтийн сорилтыг үр дүнтэй даван туулах уян хатан бодлого, гагцхүү хуулийн хүрээнд шинэлэг арга барилаар шуурхай ажилладаг төрийн албыг бэхжүүлэх ажил үе шаттай эрчимжиж байна. Цаашид ч үр дүнтэй үргэлжилнэ.

Төрийн албанд **тэгш боломж, хүртээмжтэй байдлыг хангах** хүний нөөцийн удирдлагыг хэрэгжүүлэхэд дараах асуудлуудад анхаарлаа хандуулахыг Та бүхнээс хүсье.

1. Ашиг сонирхлын зөрчлөөс ангид, ёс зүйтэй, хариуцлагатай байдлыг дэмжих нэгдмэл тогтолцоог бий болгоно. Нарийн мэргэжил, ур чадвартай, зан төлөвийн зөв хандлагатай, бусдад хүлээн зөвшөөрөгдсөн хүний нөөцөөр төрийн албыг бэхжүүлнэ.
2. Албан тушаалтны ёс зүй, мэдлэг, боловсрол, туршлага, ур чадварын шалгуурыг олон улсын жишигт нийцүүлэн шинэчлэх, мэдлэг, боловсролд суурилсан мерит зарчмыг баримтлан томилон дэвшүүлдэг тогтолцоог

бататгана. Сонгон шалгаруулалтад хүний хүчин зүйлийн оролцоог хязгаарлаж, технологийн дэвшил, хиймэл оюун ухаан, сэтгэл зүйн сорилыг нэвтрүүлэх ажлыг үргэлжлүүлнэ.

3. Цахимаар үзүүлэх төрийн үйлчилгээний хүртээмж, тоог нэмэгдүүлэх, төрийн байгууллага, албан тушаалтны хүнд суртлыг арилгасан цахим үйл ажиллагааг үнэлж дүгнэж нийтийн соёл болгоно.
4. Чиг үүргийн хийдэл, давхардлыг арилгах, төрийн үйлчилгээг хүргэх байгууллага, албан хаагчийн зохистой харьцааг тогтооно.
5. Төрийн албаны бүтэц зохион байгуулалтад чиг үүргийн иж бүрэн шинжилгээ хийж, оновчтой бүтцийг тогтоон, төрийн зарим ажил үйлчилгээг судалгаанд үндэслэн мэргэжлийн холбоод, хувийн хэвшилд шилжүүлэх асуудлыг үе шаттай хэрэгжүүлнэ.
6. Бүтээмж болон ур чадварт суурилсан цалин урамшууллын тогтолцоог нэвтрүүлнэ. Тогтвортой, бүтээмжтэй ажиллах боломжийг бэхжүүлэх шударга ажлын байрны баталгааг бий болгоно.

Ноёд, хатагтай нар аа, энэхүү шинэтгэлийн үр дүн төрийн албаны манлайлагч эмэгтэйчүүд та бүхний оролцооноос шууд шалтгаална. Та бүхний ухаан бодол, ур чадвар нь төр улсын хэргийг удирдан явуулах сайн угтал хэмээн бэлгэдэж байна.

Төрийн захиргааны албан хаагч эмэгтэйчүүдийн анхдугаар чуулганыг хамтран зохион байгуулсан нийт байгууллага, хамт олонд талархал илэрхийлье.

Та бүхэнд амжилт хүсье. Баярлалаа.



---o0o---



Авлигын эсрэг үндэсний чуулганд тавьсан илтгэлээс

2021.12.08

**ТӨРИЙН АЛБАНЫ ТОМИЛГОО, ИЛ ТОД БАЙДАЛ:
ТОМИЛГООНЫ ЗӨРЧЛӨӨС СЭРГИЙЛЭХ НЬ
/Хураангуй/**

Шударга, ил тод, авлигагүй төрийн төлөө ажиллах асуудлаар үндэсний чуулган зохион байгуулж байгаа нь иргэд олон нийт, шударга төрийн албан хаагчдын хүссэн, бас хүлээсэн арга хэмжээ болж байна. Төрийн албаны тухай хуулийн шинэтгэлийн бодлого “**авлигад үгүй**” гэж хэлэх нийгмийн соёлыг бүтээж, авлигыг уг үндсээр нь устгахад чиглэгдсэн.

Иргэддээ хүлээн зөвшөөрөгдсөн шударга төрийн албыг төлөвшүүлэх зорилт **Үндсэн хуулийн нэмэлт, өөрчлөлт, “Алсын хараа-2050”** урт хугацааны хөгжлийн баримт бичгээр баталгаажсаныг Та бүхэн мэднэ.

Монгол Улсын Ерөнхийлөгч, Улсын Их Хурал, Засгийн газрын нэгдмэл байр суурь, манлайлал, олон талын оролцоо, хамтын ажиллагаанд тулгуурлан төрийн албаны шинэтгэлийг эрэмбэлэн хэрэгжүүлж байна.

Төрд ажиллах хүний ёс суртахууны төлөвшил, сахилга бат юу юунаас чухал байгаатай бүгдээрээ санал нийлэх байх.

Ажил, мэргэжил, оюуны өндөр чадвартай, төрд чин үнэнчээр зүтгэх сэтгэлтэй, төр түмний эрх ашгийг хувийнхаасаа өмнө эрэмбэлж чадах, шударга,

зарчимч, хариуцлагатай иргэнийг шалгаруулж мэргэжлийнх нь салбарт ажиллуулах, тасралтгүй сургаж хөгжүүлэх, мэргэшиж чадсаныг нь тогтвортой ажиллуулах, тэднийхээ нийгмийн баталгааг нь хангах, **харин** ажил хийдэггүй, сэтгэл зүтгэлгүй, зарчмаа умартаж авлига, ашиг сонирхлын зөрчил гаргасантай нь үл эвлэрэх замаар **ЭНЭ ШИНЭТГЭЛ ХЭРЭГЖИНЭ.**



“Гараа сайн бол бариа сайн” гэсэн мэргэдийн зүйр үг бий. Төрийн албаны шударга байдал хүний нөөцийн зөв томилгооноос гараа нь эхэлнэ. Зөв хүнийг зөв аргаар зөв ажилд томилж зөв үр дүнд хүргэх нь томилгооны зорилго, шинэтгэлийн үр дүнд байх ёстой.


Энэ талаар манай **2014** оны тайланд нэг асуудлыг онцолсон байдаг.

Төрийн албаны үндсэн зарчмыг баримтлахгүй явж ирсэн нь монгол төрийн залгамж чанар, төрийн удирдлагыг сулруулж, Үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлалын 3.3-т заасан дотоод аюулгүй байдлыг доройтуулж болзошгүй хэмжээнд хүрээд байгааг УИХ-ын анхааралд хүргэсэн. Үр дүнд нь хуулиа шинэчилсэн.

Өнгөрсөн хугацаанд танил талын дэмжлэг, садан төрлийн нөлөөллөөр төрийн албанд **шууд** томилогддог явдал гарсаар байна. Тэр хэрээр төрийн албаны нэр хүнд, иргэдийн итгэл унаж, засаглалын үнэт зүйлийг хүчгүйдүүлж байна. “Цүнх баригчид”, “ургийн мод”, “төрлийн алба” гэх нэр томъёо хүртэл гарч, нийгмийн шүүмжлэл дагуулсаар ирсэн.

Шинэ хуулийг хэрэгжүүлж эхэлснээр өмнөх үеийн зохисгүй арга барил, дадал хэвшлийг эвдэж, хуулиа дээдэлж, зарчмаа мөрддөг шинэ соёлыг тогтооход Төрийн албаны зөвлөлийн одоогийн бодлого, үйл ажиллагаа бүхэлдээ чиглэгдэж байна. Үр дүн ч эхнээсээ гарч байгаа.

Төрийн байгууллагуудын өнөөгийн үйл ажиллагааны талаар сар гаруйн өмнө **10** аймгийн иргэдийн дунд судалгаа явууллаа.



Судалгаанд оролцогчдын **65.4** хувь нь төрийн байгууллагуудаас үйлчилгээ авахад ямар нэгэн хүндрэлгүй болж, цахимжиж байна, **49.5** хувь нь төрийн байгууллагууд төрийн албаны хууль тогтоомжийг үр дүнтэй хэрэгжүүлж чадаж байгаа гэж хариулсан.

Төрийн захиргааны албан хаагчид хамаарах **21821** албан тушаалын тодорхойлолтыг хянан зөвшөөрөл олгодог боллоо. Томилох эрх бүхий зарим этгээд хүнд тохируулж дураараа засдаг өмнөх практикийг халж, ажилд тавигдах босго шаардлагыг өндөрсгөлөө.

Иргэдийг төрийн алба хаах адил тэгш боломжоор хангах зарчмыг хэрэгжүүлэх суурь нөхцөл ийнхүү бүрдсэн.



Шалгуур, шаардлагын дагуу төрийн захиргааны нийт **1865**, төрийн үйлчилгээний төсвийн шууд захирагчийн **214** сул орон тоог тусгай шалгалтын дүнгээр нөхөж, эрдэм оюунаараа өрсөлдөж томилогдох эхлэлийг баттай тавьж байна.

Сүүлийн 3 жилд төрийн албаны ерөнхий шалгалт өгч тэнцсэн **10428** хүний **42** хувь нь төрийн албанд ажиллаж байна.

ЗГХЭГ-тай хамтарсан ажлын хэсэг энэ оны сүүлийн саруудад сард **11** аймагт ажиллалаа. Төрийн **350** гаруй байгууллагын **4606** албан хаагчийг хамруулан төрийн албаны хууль тогтоомжийн хэрэгжилт, томилгооны байдалд хяналт шалгалт хийсэн. Томилгоотой холбогдсон **95** шийдвэрийг хүчингүй болголоо.



Авлига, албан тушаалын гэмт хэрэг үйлдсэн нь **шүүхээр тогтоогдсон 91** иргэнийг төрийн албанаас **чөлөөлүүлэв**.



Энэ оны 9 дүгээр сарын байдлаар, Ковидын хуулийг баримтлан сул орон тоонд хуулийн шаардлага хангаагүй **1037** хүнийг удирдах албан тушаалд сонгон шалгаруулалтгүйгээр томилсныг тогтоолоо. **Хяналт, шалгалтыг цаашид үргэлжлүүлнэ.**

Дэлхийн нийтээр Ковидын цар тахалтай нүүр тулан тэмцэж буй VUCA эриний эгзэгтэй цаг үед Төрийн албаны зөвлөлийн бодлого, чиглэл тодорхой байгаа. Энэ бол Төрийн албаны тухай хуулийн мэргэшсэн, ил тод, ёс зүйтэй, хариуцлагатай байх зарчмыг мөрдүүлэн, нийтийн сайн сайхны төлөө санаачилгатай, иргэдийн итгэлийг хүлээн ажиллах төрийн албыг төлөвшүүлэх явдал юм.

Төрийн байгууллагуудад хийх хүний нөөцийн аудитын үйл ажиллагааг улам эрчимжүүлнэ. Төрийн албанд томилгооны зөрчил гаргахаас урьдчилан сэргийлэх, соён гэгээрүүлэх ажлыг **яам, агентлаг**, төрийн бүх шатны байгууллагуудад өргөн хүрээнд зохион байгуулж ажиллаж байна.




Монгол Улсын Ерөнхий сайдын ахалсан Цахим засаглалд шилжих, хүнд суртал, авлигагүй төрийн үйлчилгээг бүрдүүлэх үндэсний хороо болон Авлигын индексийг бууруулах Ажлын хэсэгтэй үйл ажиллагаагаа хамтатган хэрэгжүүлж байна. Авлига, албан тушаалын гэмт хэрэг, ашиг сонирхлын зөрчлийг үндсээр нь таслан зогсооход төрийн бүх байгууллагын хамтын ажиллагаа, зорилго олон нийтийн хяналт нэн чухал байна.

Үндэсний чуулганд оролцогчид оо

Хууль бус томилгооны зөрчлөөс **урьдчилан сэргийлэх, таслан зогсоох** хамтын ажиллагааг өргөжүүлцгээе.

1. Хууль зөрчсөн томилгоо бүхний ард ашиг сонирхол байгаа эсэхийг шалгадаг болъё.

2. Шударга байдлын үнэлгээ, судалгаанд тулгуурлан авлигын эрсдэл бүхий салбар, байгууллагуудад нэгдмэл, цогц хяналт шалгалт хийе.
3. Төрийн албан тушаалтан, төрийн албан хаагчийн ёс зүй, зан үйлийн стандартыг шинээр гаргаж, шударга ёсны соёлыг хэвшүүлье.
4. Албан тушаалтны буруутай шийдвэрийн улмаас төрд учирсан хохирлыг нөхөн төлүүлэх ажилд хүчээ нэгтгее.
5. Төрийн захиргааны болон төсвийн шууд захирагчийн албан тушаалд зөвхөн сонгон шалгаруулалтаар орж нэр дэвшүүлсэн иргэний урьдчилсан мэдүүлгийг хянах нэгдсэн зохицуулалттай больё.
6. Төрийн үйлчилгээний чанар, хүртээмж, үр нөлөөнд олон нийтийн хяналт тавих зөвлөлийн үйл ажиллагааг **зөв, тууштай** хэрэгжүүлэхэд **манлайлал** үзүүлж ажиллацгаая.



Шинэ технологи, инновацад суурилсан цахим шилжилт төрийн үйл ажиллагааны ил тод байдлыг хангах үндсэн арга зам болж байна.

Төрийн албаны зөвлөл төрийн албаны их өгөгдөлд суурилсан Хүний нөөцийн нэгдсэн удирдлагын цахим системийг хөгжүүлж Сангийн яамны цалингийн нэгдсэн системтэй холбож орон тоо, цалингийн давхардал, томилгооны зөрчил илрүүлэх, төрийн албан хаагчийн бүртгэл хөдөлгөөний мэдээлэл үнэн зөв, шуурхай хийгдэх, төрийн байгууллагуудын орон тоонд хяналт тавих нөхцөл бүрдсэн.

Одоо төрийн бусад байгууллагуудын цахим системтэй интеграцжуулах ажил хийж байна.

Төрийн албаны сонгон шалгаруулалтын бүртгэх, дүгнэх зэрэг шалгалтын бүхий л процессыг бүрэн цахимжууллаа. Сонгон шалгаруулалтыг хүний оролцоо, хөндлөнгийн нөлөөлөлгүй, олон нийт, мэргэжлийн байгууллагуудын хяналтын дор ил тод, нээлттэй шударгаар явуулдаг боллоо.

Төрийн албаны шалгалтад амжилт үзүүлэх эсэх нь **зөвхөн шалгалт өгч байгаа** иргэнээс **өөрөөс нь** шалтгаалдаг болсон. Цаашид хиймэл оюун ухаанд суурилсан шалгалтын арга хэлбэрийг нэвтрүүлнэ.

Цахим шилжилтийг төрийн байгууллагуудын ажлын үр дүнгийн шалгуур болгоё. Ингэх нь улс орны хөгжлийг урагшлуулах, ил тод байдлыг дээшлүүлэх, хүнд суртал хүлээлгэн чирэгдүүлэлтийг арилгахад шийдвэрлэх ач холбогдолтой.

Өндөр хөгжилтэй орнууд хүнд суртлын хүлээс болсон төрийн албаны олон дүрэм, журмыг багасгаж, иргэддээ ээлтэй байдлыг бий болгож байна.



**Хоёр. ТӨРИЙН АЛБАНЫ ҮЙЛ
АЖИЛЛАГААНЫ ИЛ ТОД БАЙДЛЫН
ТАЛААР**

- “УЛААН ТУУЗ”,
- “НЭГ НЭГИЙН ДҮРЭМ”




Сайн туршлага болон хэрэглэгдэж байгаа **“УЛААН ТУУЗ”, “НЭГ НЭГИЙН ДҮРЭМ”** зэрэг аргуудыг нутагшуулахад Та бүхнийг хамтран ажиллахыг хүсье.

Төрийн албаны шинэтгэлийн бүхий л асуудлаар олон талын өргөн оролцоотой хамтын ажиллагааг тогтмолжуулснаар авлигаас ангид төрийн албыг төлөвшүүлэх үйлсэд **үр дүн гаргах болно.**

Хэлэлцүүлгийн үйл ажиллагаанд амжилт хүсье.

---o0o---



***“Төрийн албанд цогц чадамжийг нэвтрүүлэх нь”
сэдэвт Төвийн бүсийн сургалтыг нээж хэлсэн үг***

Та бидний хамтран хэрэгжүүлж буй төрийн албаны шинэтгэлийн агуулга улам баяжиж байна. Энэ хэрээр асуудалд хандах хандлага, шийдэх арга замын олон хувилбар, шийдлүүд гарч ирж байгаа.

Түүний нэг нь төрийн албанд цогц чадамжийг нэвтрүүлэх асуудал. Өнөөдөр энэ асуудлыг ёс зүйн өргөн ойлголттой уялдуулан тал бүрээс нь авч үзэх Төвийн бүсийн сургалт эхлэх гэж байна.

Төрийн албаны зөвлөлийн Салбар зөвлөлийн нарийн бичгийн дарга нар гэдэг бол орон нутагт, яам, агентлагт төрийн албаны төв байгууллагын чиг үүргийг үндсэн ажлын хэмжээнд өдөр тутам шууд хариуцан хэрэгжүүлдэг хүмүүс.

Тэд нар маань Архангай, Баянхонгор, Өвөрхангай, Дундговь, Өмнөговь аймгийн ахлах, дэс, туслах түшмэлийн төлөөллөөс бүрдсэн тус бүр 8 хүний бүрэлдэхүүнтэй багийг ахлан Арвайхээр хотод ирээд байна.

Цогц чадамж гэдэг тусдаа нэгэн чадвар биш, харин бүхэлдээ ёс зүй, зан төлөв, харилцаа хандлагын “хуримтлал”.

Энэ ажил зөвхөн нэг удаа яриад, цуглаад дуусахгүйгээрээ онцлогтой. Манай зөвлөхүүдийн баг явсан газар бүртээ ширээний ном үлдээж байгаа. Мөн цахим ном, зааварчилгаа ч гаргаж байгаа.

Төрийн байгууллагад цахим систем бий болгох, хөгжүүлэх, ашиглахад шаардлагатай зарим хүчин зүйлийг, тухайлбал ажиллах хүчний чадавх, чадамж, тэдгээрийн ёс зүйн хэм хэмжээ, оновчтой тодорхойлогдсон үйл ажиллагааны процесс, шийдвэр гаргалтын түвшин зэрэг үзүүлэлтүүдийг анхаарч үзэх нь зүйтэй.

Ялангуяа төрийн албаны хүнд суртлыг арилгах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх, төрийн байгууллагын үйлчилгээний чанарыг ахиулахад төрийн албаны сонгон шалгаруулалт, “зөв” хүнийг “зөв” ажилд томилох зарчмыг хэрэгжүүлэх явдал ихээхэн ач холбогдолтой.

Сонгон шалгаруулалтын үнэлгээнд цогц чадамжийн үндсэн шалгуур үзүүлэлт болох зан үйлийн шалгуурыг нэмж оруулан, түүнийг үнэлэх аргуудыг хэрэглэхээр аргачлал боловсруулж байна. Ингэж хувь хүний зөөлөн ур чадварыг тодорхойлж, ёс зүйтэй, зөв хүнийг төрийн албанд томилох нөхцөлийг бүрдүүлнэ.



Иймд НҮБХХ-ийн төслийн хамтын ажиллагааны хүрээнд сонгон шалгаруулалтын агуулга, шалгаруулалтын үйл ажиллагаа, мэдлэг, ур чадварыг үнэлэх арга, аргачлалыг боловсронгуй болгох, мэдлэг, зан үйл, хандлага, харилцаа, ёс зүйн үзүүлэлтүүдийг тусган хэрэгжүүлэх зорилгоор “цогц чадамж”-ийн агуулгыг тодорхойлж Сангийн яам, Зам тээврийн хөгжлийн яаманд туршин нэвтрүүлж эхэлсэн.

Ялангуяа удирдах албан тушаалтны хувьд “цогц чадамж”-ийг ярилцлага, сэтгэл зүйн тест зэрэг арга зүйгээр үнэлэгдэн тодорхойлогдох боломжтой гэж үзэж байгаа бөгөөд сонгон шалгаруулалт, сургалт, хөгжлийн үйл ажиллагаанд нэвтрүүлэхийг зорьж ажиллаж байна. Ингээд энэ сургалтын ачааны хүндийг үүрч яваа НҮБ-ын төслийн зөвлөхүүд, бүс нутгийнхаа төлөөллийг аймагтаа хүлээн авч буй Өвөрхангай аймгийн төрийн албаныханд онцлон талархал илэрхийлье.

-oOo-



Аймаг, нийслэлийн Засаг даргын Тамгын газрын дарга нартай хийсэн уулзалтад хэлсэн үгнээс

2021.11.12


Төрийн албаны зөвлөлийн орон нутаг дахь шууд төлөөлөл Салбар зөвлөлийг ахлан ажилладаг хүмүүстэйгээ нүүр тулан хамтдаа уулзалгүй удсан байна. Цар тахлын нөхцөл байдлаас шалтгаалан нэг дор цугларах боломж үнэхээр бага байлаа.

Гэхдээ аль ч юманд хоёр тал бий гэдэгчлэн өнгөрсөн хоёр жил орчимд цахим үйл явц төрийн албанд идэвхжилээ. Оны эхнээс 7:4:10 сургалт тогтмолжиж Та бид хэсэг хугацааны давтамжтай биш, харин 7 хоног бүр цахимаар уулздаг болсон.



1. Бодлого, шийдэл, үр дүн


Төрийн албаны шинэтгэлийн бодлого маш тодорхой. Хуульчлагдсан шинэтгэл, бас “Алсын хараа-2050” урт хугацааны хөгжлийн бодлогоор баталгаажсан шинэтгэл.



Бодлого хэрэгжүүлэх шийдэл, гарцыг өнгөрсөн хугацаанд нэг мөр ойлгуулах ажил улсын хэмжээнд хангалттай хийгдсэн.

Ойлгосон, ойлгуулсан бодлогоо бүгдээрээ хэрэгжүүлж байгаа. Хэрэгжүүлж байж үр дүн гарах нь бас тодорхой. Шинэтгэл нэг өдөр хэрэгжээд үр дүн нь гарахгүй хэдий ч одоо шинэтгэлийн шилжилтийн үе шат буюу бэлтгэл ажил дууссан гэдэг утгаар ажиллах цаг болсон.

Шинэтгэлийн үр дүнг нүдэнд харагдаж, гарт баригдах хэмжээнд үр дүн гаргах үе шат руу орж байгаа цаг үед Та бид уулзацгааж байна.



2. Сорилт

Өргөн хүрээнд авч үзвэл төрийн албаны шинэтгэлийн бодлого тасралтгүй хэрэгжиж ирсэн. Хүний нөөцийн менежмент, сургалт, судалгааны үйл ажиллагаа хэвийн, бүр илүү эрчтэй хийгдэж ирснийг тэмдэглэх хэрэгтэй.

Харин явцуу хүрээнд харвал КОВИД-19 цар тахлын нөлөөлөл, үүнтэй уялдан батлагдсан тодорхой хуулийн үйлчлэл энэ шинэтгэлд сорилт болж байгаа.

Төрийн албаны шинэ хууль хүчин төгөлдөр болсноос хойш 3 жил хүрэхгүй хугацаа өнгөрч байгаа бол үүний тал хувьд нь Коронавируст халдвар /ковид-19/-ын цар тахлаас урьдчилан сэргийлэх, тэмцэх, нийгэм, эдийн засагт үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах тухай хууль үйлчилж ирсэн. Албан тушаалтныг сонгон шалгаруулахаар хуульчилсан зохицуулалт үндсэндээ зогссон.

УИХ-ын байнгын хороодын хуралдаан дээр гишүүдийн хэлж байгаагаас үзвэл энэ хуулийн үйлчлэлийг сунгахгүй байх магадлал өндөр байгаа. Сонгон шалгаруулалттай холбоотой асуудал хэвийн горимоор, илүү идэвхэжсэн байдлаар үргэлжилнэ. Та бүхэнд ч энэ ажлын чиглэл очсон.



3. Үндэсний хороо

Цахим засаглалд шилжих, хүнд суртал, авлигагүй төрийн үйлчилгээг бүрдүүлэх Үндэсний хороо өнгөрсөн 9 дүгээр сараас ажиллаж эхэлсэн.

Ерөнхий сайд тэргүүлж, сайд нар, УИХ-аас удирдлага нь томилогддог байгууллагуудын удирдлага, нийслэлийн Засаг дарга оролцдог, Засгийн газрын өргөтгөсөн хуралдаан байдлаар ажилладаг бүтэц гэж болно. Үндэсний хороо өчигдөр хуралдаж, төрийн албаны шинэтгэлийн асуудлаар миний бие мэдээлэл хийсэн.

Ерөнхий сайдын зүгээс “төрийн албаны томилгоотой холбоотой аливаа асуудлыг УИХ-ын гишүүдээр яаж ийгээд аргалуулна гэдэг” ойлголт байхгүй гэдгийг

хатуухан хэлснийг сонссон байх. Төрийн албаны шинэтгэлд гүйцэтгэх засаглалын тэргүүн манлайлал үзүүлэх итгэл үнэмшлээ илэрхийлж байгаа хэрэг.

Орон нутгийн хувьд ч мөн адилхан. Улс төрөөс ангид төрийн жинхэнэ алба бүрдүүлэх асуудалд онцгой анхаарах ёстой.

Төрийн албан хаагчдын цалинг цаашдаа нэмэх бодлого баримтлахаа Ерөнхий сайд хэлсэн. Ямар ч хүн, түүний дотор төрийн албан хаагчид маань цалин хөлс нь хүрэлцээтэй байж ажил амьдралаа тэгш авч явах нь бодит үнэн.

Төрийн албаны ангилал, зэрэглэлийг боловсронгуй болгох, цалин хөлсний системийг шинэчлэх судалгааны ажлыг Төрийн албаны зөвлөлөөс олон талын оролцоотойгоор эхлүүлсэн. Энэ ажил цаашид эрчимтэй үргэлжилнэ.



4. Шинэтгэлийн эрх зүйн шинэ орчин

Төрийн албаны шинэтгэлийн эрх зүйн орчин илүү боловсронгуй болох, илүү олон асуудлыг хамран баяжих хандлагатай байна.

Боловсруулалтын шатанд, бас УИХ-д өргөн баригдсан хэд хэдэн хуулийн төсөл бий.

Төр, хувийн хэвшлийн байгууллагын үйл ажиллагааг шүүмжилсэн, мэдээлсэн, илчилсэн тохиолдолд хууль зүйн хариуцлагад татах, дарамтлахаас мэдээлэгчийг хамгаалах, урамшуулах зорилготой Шүгэл үлээгчийн тухай хуулийн төслийг өчигдөр Ерөнхий сайд УИХ-д өргөн барьсан.

Сонгон шалгаруулалтын хуулийн төслөөр Төрийн албаны зөвлөлийн одоогийн сонгон шалгаруулах үйл ажиллагаа илүү өргөн хүрээтэй болж төрийн алба төдийгүй төрийн өмчийн хуулийн этгээдүүдийг хамруулах хандлагатай болох нь. Төрийн албаны ёс зүйн харилцааг хуульчлах бэлтгэл ажил явагдаж байна. Өргөн хүрээний хэлэлцүүлэг өрнөж байгаа. Та бүхний саналыг ч авсан.

УИХ-ын хяналт шалгалтын тухай хууль батлагдвал орон нутагт УИХ-аас удирдлага нь томилогддог байгууллагуудын чиг үүргийг хэрэгжүүлдэг нэгж, ажилтнуудын эрх, үүрэг нэмэгдэх магадлал өндөр болно. Төрийн албаны зөвлөл, Үндэсний аудитын байгууллага зэргийг энд дурдаж болно.

5. Төрийн албаны Салбар зөвлөл

Аймгууд дахь Салбар зөвлөлийн нарийн бичгийн дарга нар бараг бүгдээрээ орон тооны болсон. Шинэтгэлд орон нутгаас оруулж буй хувь нэмрийн нэг илэрхийлэл ч гэж болно.




Төрийн албаны зөвлөлөөс Салбар зөвлөлийн нарийн бичгийн дарга нартайгаа илүү ойр ажиллах, мэдээлэл шуурхай солилцох, мэдээллийн харилцан урсгалыг түргэтгэх талаар ирэх онд тодорхой ахиц дэвшил гаргах болно.

Томилгооны зөрчилгүй төрийн албатай болох явдал Салбар зөвлөлийн үйл ажиллагаанаас шууд хамаарна гэдгийг бүгдээрээ ойлгож, үйл ажиллагаандаа мөрдлөг болгож ажиллах хэрэгтэй байна.

Томилох эрх бүхий албан тушаалтанд эрх зүйн зөрчилгүй, хууль мөрдлөг болгосон шийдвэр гаргахад нь мэргэжил, арга зүйн тусламж үзүүлэх эрхтэй, бас үүрэгтэй хүмүүс бол Та бүхэн, Та бүхнээр ахлуулсан салбар зөвлөл, түүний гишүүд, нарийн бичгийн дарга нар шүү.

ҮР ДҮНД СУУРИЛСАН ЦАЛИН ХӨЛС



Болохгүй бүтэхгүй, зөрчилтэй шийдвэрийг гаргасны дараа нь биш, гарахаас нь өмнө залруулдаг соёл тогтохгүйгээр энэ ажил явахгүй, бас төлөвшихгүй. Үйлдэл, эс үйлдлийн асуудлыг энд ярьж байгаа хэрэг.

---o0o---



**Улсын Их Хурлын Ёс зүй, сахилга
хариуцлагын байнгын хорооны хурал
дээр хэлсэн үг**

2021.10.19

“ТӨРИЙН АЛБАНЫ ШИНЭТГЭЛ ДЭХ ЁС ЗҮЙ”

Улсын Их Хурлын Ёс зүй, сахилга хариуцлагын байнгын хорооны дарга, эрхэм гишүүд ээ,

Төрийн албан дахь ёс зүйн асуудалд онцгойлон анхаарал хандуулж, Төрийн албаны зөвлөлийн мэдээллийг тусгайлан сонсохоор шийдвэрлэсэн Та бүхэнд талархал илэрхийлье.

Төрийн албаны тухай хуулийн шинэчилсэн найруулгыг баталж 2019 оноос эхлүүлсэн төрийн албаны шинэтгэлийн цаг хугацаа, мэдлэг, мэдээлэл шаардсан багц ажлуудыг олон талын оролцоо, хамтын хүч, оюунаар гүйцэтгэж ирлээ.

Хууль шинэчлэн батлагдсанаар төрийн албаны шинэтгэлийн шинэ үеийн бодлого, стратеги тодорхой болсон. Бодлогыг олон нийтэд ойлгуулах нь шинэтгэлд итгэх иргэдийн итгэл, дэмжлэгийн шимт хөрс бүрдүүлэх нь эхний алхам гэж үзсэн. Энэ чиглэлээр нийт иргэд болон Төрийн албан хаагчид гэсэн 2 үндсэн чиглэлээр шинэ хууль, шинэчлэлт бодлогыг сурталчлах, таниулах, соён гэгээрүүлэх ажлыг 21 аймаг, нийслэл, нийгмийн салбар бүрийн төлөөлөлд хүргэж, зайн болон танхимын сургалт, семинар, хэлэлцүүлэг, үндэсний зөвлөгөөн, нүүр

тулсан уулзалт, ярилцлагын олон хэлбэрээр, нийгмийн сүлжээний олон аргаар зохион байгуулж ирлээ.

Үүний үр дүнд мерит зарчим, карьерын тогтолцоо бүхий шинэ цагийн төрийн албаны тухай шинэ ойлголт, шинэ мэдрэмж, шинэ төсөөлөл, шинэ итгэлийн үзэл санаа нийгэмд бүрэлдэж, өөрчлөлт шинэчлэлийн хүлээлт бий болсон.

Нэг судалгааны дүн байдаг. “төрийн албан хаагчдын 98 хувь нь ажлын үр дүндээ А, В үнэлгээ авдаг” гэж. Гэтэл Үндсэн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах асуудлаар 2019 онд явуулсан санал асуулгаар иргэдийн “89 хувь нь төрийн албанд сахилга хариуцлага сул, 89.9 хувь нь төрийн албан хаагчдын мэдлэг чадварыг дээшлүүлэх шаардлагатай” гэсэн байдаг.



Нийгмийн ийм л санаа, үзэл хандлагын орчинд шинэтгэлийн энэ үйл явц эхэлсэн.

Ер нь энэ шинэтгэл захиргааны гэхээсээ илүүтэй хүний нөөцийн шинэтгэл гэж болно. Учир нь төрийн албаны сонгон шалгаруулалтаас өгсүүлээд сургалт, хөгжил, ёс зүй, маргаан хянан шийдвэрлэлт, албан тушаалын тодорхойлолт, хүний нөөцийн удирдлага, аудит, төрийн албаны мэдээллийн нэгдсэн сан зэрэг цогц асуудлыг шинэ хуулиар голлон зохицуулснаас тодорхой харагдана.

Ийнхүү Монгол төрийн хүний нөөцийн бодлогын энэ гол зангилаа асуудлыг хуулиар тогтоосон чиг үүргийн хүрээнд Төрийн албаны зөвлөл хариуцан ажиллаж ирлээ.

Төрийн албаны тухай хуулийн шинэчилсэн найруулгын хүрээнд шинэтгэлийн эхний онуудад хийх ажлуудаа үндсэнд нь бүрэн дуусгалаа.

Шинэтгэлийн шилжилт гэж болох эхний үе шатанд албан тушаалын тодорхойлолт хянах, батлах зөвшөөрөл олгох, хүний нөөцийн аудит цоо шинээр нэвтрүүлэх, хүний нөөцийн удирдлага, мэдээллийн нэгдсэн санг бүрдүүлэх, төрийн албаны шалгалт, сонгон шалгаруулалтын шинэтгэл зэрэг ажлуудыг хийсэн.


Төрийн албаны ёс зүйн асуудлыг бүх шатанд анхаарч, байгууллагууд дахь Ёс зүйн зөвлөлийг чадавхжуулах, төрийн албаны сургалтын тогтолцоог шинээр бүрдүүлэх, сургалт, соён гэгээрэл, албан тушаалтны буруутай шийдвэрээс үүдэлтэй төрд учруулсан хохирлыг барагдуулах ажлуудыг тасралтгүй явуулж ирлээ.

Учир нь Төрийн албаны зөвлөл “...төрийн албаны удирдах болон гүйцэтгэх албан хаагчид төрийн албан хаагчийн ёс зүйн хэм хэмжээг сахиулахтай холбогдсон зөвлөгөө өгөх, арга зүйн удирдлагаар хангах” үүргийг хуулиар хүлээдэг билээ. (ТАТХ-д “ёс зүй” гэдэг үг 11 орсон байдаг)

Иргэд төрийн захиргааны албанд анх орохдоо “...хууль, ёс зүйн хэм хэмжээг чанд сахиж...” хэмээн төрийн жинхэнэ албан хаагчийн тангараг өргөдөг. Тэгэхлээр төрийн албан дахь ёс зүй бол **хуульчлагдсан тангаргийн** түвшин дэх ойлголт юм.

Шинэтгэлийн нэг тулгуур зарчим болох төрийн албаны хаагчийг шатлан дэвшүүлэх ойлголтод ч ёс зүйн асуудал нэг гол шаардлага болж орсон.

(тусгай шаардлагын 50 хувийг хангасан төрийн албан хаагчийг үйл ажиллагааны үр дүн, мэргэшлийн түвшингийн үнэлгээ, **ёс зүй, мэдлэг**, мэргэжил, мэргэшил, туршлага, ур чадварыг харгалзан хугацаанаас өмнө шатлан дэвшүүлж болно. 26.3)





1. Бодлого, стратегийн шинэтгэл.

Сүүлийн жилүүдэд болсон улс төрийн 3 удаагийн сонгуульд иргэдийн олонх нь төрийн тогтвортой байдал, бодлогын залгамж чанар, улс төрийн нэгдмэл байдлыг баримжаалсан сонголт хийсэн нь төрийн албаны шинэтгэлд итгэх итгэл, бас их хүлээлтийн илэрхийлэл гэж үзвэл үүнийг төрийн албаны шинэтгэлийн бодлого, стратегийн шинэтгэл, соён гэгээрүүлэх үйл ажиллагааны зохих хувь нэмэр, үр дүнтэй холбож үзэж болно.

СОНГОН ШАЛГАРУУЛАЛТ

Албан тушаалын тодорхойлолт

Нийт батлах зөвшөөрөл олгосон 22050


Төрийн захиргааны төв байгууллага, Засгийн газрын агентлаг, УИХ-ын харьяа байгууллагууд, Орон нутгийн захиргааны байгууллага, бусад төрийн байгууллагууд.

MERIT
A CESO AND WUSC PROGRAM


2. Мерит /Албан тушаалын тодорхойлолт/-д суурилсан шинэтгэл.

Мерит зарчим, шатлан дэвшүүлэх тогтолцоо бүхий төрийн албаны төлөвших нэг үндсэн нөхцөл нь хуулийн шаардлагад нийцсэн төрийн албан тушаалын тодорхойлолтыг баталж, тогтвортой мөрдүүлэх явдал. Энэ чиглэлд онцгойлон анхаарч 2019, 2020 онд багтаан Төрийн захиргааны удирдах, гүйцэтгэх болон төрийн үйлчилгээний удирдах /нийт 22000 гаруй/ албан тушаалыг үндсэнд нь стандарт шаардлага бүхий албан тушаалын тодорхойлолттой болгоод байна.

Нэг үгээр хэлбэл, төрийн захиргааны албан тушаал бүрийн зорилго, зорилт, чиг үүрэг, түүнийг хэрэгжүүлэх албан хаагчид, тавигдах үндсэн шаардлага, үүрэг хариуцлагыг иж бүрэн зураглаж, баталгаажууллаа.



3. Сонгон шалгаруулалтын шинэтгэл



Төрийн албаны тухай хуулийн 26.3-т заасны дагуу ажилласан жилийг тогтоосон тусгай шаардлагын 50 хувийг хангасан төрийн албан хаагч сүүлийн 12 сарын хугацаанд ёс зүйн хариуцлага, сахилгын шийтгэл хүлээгээгүй байх ёстой.

Томилох эрх бүхий байгууллага, албан тушаалтнаас ёс зүйн хариуцлага, сахилгын шийтгэл хүлээсэн, Төрийн албаны тухай хуулийн 26.3-т заасны дагуу ажилласан жилийг тогтоосон тусгай шаардлагын 50 хувийг хангаж байгаа албан хаагчийг шатлан дэвшүүлэх тухай санал ирүүлж байгаагүй. Сахилга, ёс зүйн зөрчил болон зөрчил үүсэхээс урьдчилан сэргийлэхтэй холбоотой элемент агуулсан асуулт нийт ярилцлагын асуултын 10 хувийг бүрдүүлж байна.

Монгол улсын иргэн төрийн алба хаах адил тэгш боломжоор хангагдах төрийн албаны зарчмыг бодитоор хэрэгжүүлэх, төрийн албаны ерөнхий шалгалт болон албан тушаалын тодорхойлолтод суурилсан тухайн албан тушаалын тусгай шалгалтын агуулга, хэлбэр, арга зүй, аргачлал, зохион байгуулалтын талаар зөвлөл цахимд суурилсан томоохон шинэчлэл хийлээ.

Шалгалтын төрөл, хэлбэрийг шинэчилж, эрдэмтэд, судлаачдын оролцоотойгоор сорил, тестийн агуулгыг баяжуулан шинэчилж, сонголт хувилбарыг олшруулж, тестийн сангийн өгөгдлийг хэд дахин нэмэгдүүлснээс гадна, e-taz аппликэйшнийг хөгжүүлж, бичмэл болон онлайн хэлбэрээр, гар утас, facebook зэрэг нийгмийн сүлжээнд нээлттэй, хэрэглэгчдэд тэгш хүртээмжтэй, ил тод болгосон нь ахиц дэвшил байлаа.

Үр дүн нь шалгалт иргэдэд тэгш нөхцөлөөр, ил тод нээлттэй байдлаар, аль нэг албан тушаалтан болон субъектээс үл хамаарсан, хөндлөнгийн нөлөөлөлгүй, шударга үнэлгээний зарчмаар явагддаг болсноор сонгон шалгаруулалт тойрсон маргаан гомдол үндсэндээ арилсан. Шалгалтад оролцогчдод шалгалтын дүн шууд хүлээн зөвшөөрөгдөх хэмжээнд хүрсэн. Энэ бол төрийн албанд шударга ёсны зарчим хэрэгжих эхлэл, нийгмийн шударга ёс тогтооход оруулж буй хувь нэмэр гэж бодож байна.




4. Сургалт хөгжлийн шинэтгэл.

Хурдтай өөрчлөгдөж буй “VUCA” орчинд төрийн алба тулгарсан зорилтыг шуурхай давж, үр бүтээлтэй, иргэддээ ээлтэй ажиллахын нэг үндэс нь төрийн албан хаагчдын сургалт, хөгжлийн тасралтгүй үйл явц. Шинэ хууль хэрэгжсэнээр төрийн албаны сургалт хөгжлийн үндэсний тогтолцоо шинээр бүрдсэн. Албан тушаалын мэргэшүүлэх багц сургалт, ажлын байрны богино болон дунд хугацааны сургалтын агуулга, хөтөлбөрийг үндсээр нь шинэчилж Удирдлагын академи дээр тогтмол зохион байгуулж байна.

Төрийн албан хаагчдын сэтгэлгээ, зан үйлийг өөрчлөх нөлөөлөл, арга зүйн сургалтыг тогтмолжуулж, үндэсний болон гадаадын эрдэмтэн, судлаачид, экспертүүдийг оролцуулан онлайн болон вебинар хэлбэрээр явуулж хэвшлээ. Албан хаагчдын сургалтын хэрэгцээ, идэвх оролцоо өндөр байгаа бөгөөд хэрэглэгчдийн хүрээ байнга өсөж нэг удаад 1000-1500-д хүрч байна. Энэ оны эхний хагас жилд 20000 шахам албан хаагч хамрагдсан.


Энэхүү сургалтын үр дүнд албан хаагчдын танин мэдэхүй болон сэтгэл зүйд эерэг хандлагууд гарч суралцагч байгууллага, албан хаагч байх эрмэлзэж нэмэгдэж байна. Шатлан дэвших сургалтад хамрагдах эрэлт илт өсөж байна. Энэ нааштай хандлагыг цаашид түүштай дэмжих болно.



5. Судалгаа, инновацад суурилсан шинэтгэл.

Шинэтгэл болон шийдвэр нь судалгаанд суурилсан, сургалт хөгжил нь инновацад хөтөлсөн төрийн албыг төлөвшүүлэх нь бас нэг чухал зорилт байлаа.

Төрийн байгууллага, албан хаагчдын дунд жил бүр инновацын уралдаан зарлаж, тодорхой төсөл хөтөлбөрийг хэрэгжүүлж, шалгарсан сайн туршлагыг түгээн, тодорхой үр дүнд хүрч байна. Төрийн албаны зөвлөл болон салбар зөвлөлүүд үндсэн үйл ажиллагаандаа шинэ технологи нэвтрүүлэх, цахимжуулах, төрийн үйлчилгээг иргэдэд хүртээмжтэй, шуурхай, шууд хүргэх чиглэлээр ахиц дэвшил гаргалаа.



Ингэснээр илүү орон тоог цалинжуулах, давхар цалин болон ажиллаагүй өдрийн цалинг олгох, илүү бодолт хийх зэрэг санхүүгийн санаатай болон санамсаргүй зөрчлийг бүрэн хяналтад авч чадсанаараа эдийн засгийн ач холбогдолтой болсон. Түүнээс гадна ажлын цаг бүртгэл, төрийн албан хаагчдын урсгал хөдөлгөөн, томилгооны зөрчлийг хянахаас гадна үр дүнд суурилсан хөлс, урамшууллын тогтолцоог нэвтрүүлж хэвшүүлэх, үндэс сүүрийг бүрдүүлсэн нь энэ

бүртгэл мэдээллийн шинэтгэлийн гол үр дүн юм. Бүртгэлийн төгөлдөржилт нь цаашдын шинэтгэлийн зорилт хэвээр байх болно.

7. Хяналт, мониторингийн шинэтгэл.

Хуулийн хэрэгжилтэд тавих хяналт шалгалт, шинжилгээ үнэлгээг сайжруулах замаар ТАХ-ын эрх ашгийг хамгаалах, зөрчигдсөн эрхийг сэргээх, төрд учирсан хохирлыг барагдуулах нь зөвлөлийн үйл ажиллагааны нэг үндсэн чиг үүрэг. Энэ талаар шинэчлэлийн тодорхой алхмуудыг хийж чадлаа.



Хяналтын чиг үүрэгтэй үйл ажиллагааны шинэтгэл хийж эхэлснээр албан тушаалтнууд хүний нөөцийн хөтөлбөртэй болж, шийдвэр гаргахдаа болгоомжтой хандаж хууль журамд нийцүүлэхийг эрмэлздэг болсон нь шинэтгэлийн нааштай эхлэл. Хууль хэрэгждэг соёл тогтох нь төрийн албаны шинэтгэлийн нэгэн гол зорилт байх ёстой.

8. Хандлага, соёл, ёс зүйн шинэтгэл

Дээр дурдсан сургалт хөгжил, бүртгэл хяналт, меритийн шинэтгэлийн үр дүн нь төрийн албан хаагчдын харилцаа хандлага, ёс зүй, соёлд тодорхой хэмжээний эерэг нөлөөлөл үзүүлж байгаа нь ажиглагдаж байна. УИХ, байнгын хороодтой хамтран Ёс зүйн үндэсний зөвлөгөөнийг зохион байгуулж, байгууллагын дэргэдэх Ёс зүйн зөвлөлүүдийн үйл ажиллагааг идэвхжүүлсэн нь төрийн албан хаагчдын ёс зүйн манлайллыг дээшлүүлэхэд зохих үр дүнгээ өгч байгаа гэж үзэж байна.



Шинэ хууль хэрэгжихээс өмнө төрийн албан хаагчдын талаар гарч байсан нийгмийн жигшил зэвүүцлийн бай болсон ёс бус үйлдлүүд эрс хумигдсан бөгөөд харин ч төрийн албан хаагчид нийгэмд ёс зүйн манлайлал үзүүлэх ёстой гэсэн үзэл ойлголт, эрмэлзэл нэмэгдэж байгаа нь эерэг өөрчлөлт. Энэ байдлыг нийгмийн тогтсон соёл болгон төлөвшүүлэхэд Ёс зүйн хариуцлагын тухай хуультай болох нь зохистой юм.

9. Олон талт хамтын ажиллагааны шинэтгэл

Төрийн албаны шинэтгэлийг үр дүнд хүргэхийн тулд дотоод гадаадын олон талын оролцогчдын хүчин чармайлт, хамтын ажиллагааг нэгтгэн зохицуулж, шинэтгэлийн зорилгод чиглүүлж үр өгөөж нэмэгдүүлэх нь бидний үйл ажиллагааны үндсэн стратегийн нэг байлаа. НҮБ-ын Хөгжлийн хөтөлбөртэй хамтран хэрэгжүүлж буй “Монгол Улсад мэргэжлийн, иргэн төвтэй төрийн албыг төлөвшүүлэх нь” төсөлтэй үйл ажиллагаагаа уялдуулах, төрийн албан хаагчдын сургалт хөгжилд дэмжлэг үзүүлдэг донор орнууд, төсөл хөтөлбөрийн хэрэгжилтэд үнэлгээ хийж, гадаадад суралцагчдын нэгдсэн бүртгэлийг гаргаж, бусад улс оронд гэрээний дагуу суралцаж, мэргэжил дээшлүүлсэн иргэдийг төрийн албанд томилуулах чиглэлээр цуврал арга хэмжээнүүдийг санаачлан зохион байгуулсан.

Санхүүжилт, төсөв, хөрөнгө оруулалт шаардахгүй боловч **бодитой, баталгаатай үр дүн** шууд гардаг ЁС ЗҮЙН асуудалд.

“Итгэл даах төрийн албаны төлөө” уриатай Төрийн байгууллагуудын ёс зүйн зөвлөлийн нэгдсэн зөвлөгөөн хийсэн. УИХ-ын Тамгын газар, НҮБ-ын


Хөгжлийн хөтөлбөр, Канад Улсаас Монгол Улсад суугаа ЭСЯ-тай хамтран зохион байгуулсан.



Хэний итгэлийг даах тухай ярьж байна-тэр бол ард түмний итгэл.
Хэн тэдний итгэлийг даах тухай ярьж байна-тэр бол төрийн алба.



Өнгөрсөн хугацаанд УИХ-ын дарга Г.Занданшатар, Ерөнхий сайд Л.Оюун-Эрдэнэ нар Төрийн албаны зөвлөлд ажиллаж, төрийн албан хаагчийн ёс зүйн асуудлыг хамарсан өргөн хүрээтэй асуудлыг оновчтой, шуурхай зохицуулах талаар үүрэг, чиглэл өгч, санал бодлоо хуваалцсан. Хийх ажлыг эрчийг нэмж, урам зориг ч өгсөн.



Шинэ хуулиар эхлүүлсэн төрийн албаны шинэтгэл 36 сар болж байна.

Шинэтгэлийн хүрээнд хийж байгаа, хийхээр төлөвлөсөн олон ажлуудыг УИХ, Засгийн газар бүхий л талаар дэмжиж ирлээ.

Парламентын бүтцэд Ёс зүй, сахилга хариуцлагын байнгын хороо байгуулагдсан нь УИХ-аас төрийн албаны шинэтгэлийг эрчимжүүлэхэд хүч нэмсэн, уг асуудалд өндөр ач холбогдол өгсөн хэрэг.

Нөгөө талаас ёс зүй, сахилга хариуцлагын асуудал төрийн албаны бүх шатанд, улс орны хэмжээнд ямар чухлаар тавигдаж буйн илрэл.

Өргөн цар хүрээтэй, бэрхшээл сорилт ихтэй төрийн албаны шинэтгэлийг хуулиар тогтоосон зарчмыг баримтлан Үндсэн хуулийн үзэл санаанд нийцүүлэн “Алсын хараа-2050” урт хугацааны хөгжлийн бодлого, үүнд үндэслэсэн шинэ Засгийн газрын мөрийн хөтөлбөртэй уялдуулан тууштай хэрэгжүүлнэ.

Ийм итгэл, урам зориг төрийн аль ч шатны байгууллага, албан тушаалтанд байгаа нь мэдрэгдэж байгаа.

Төрийн албыг мэдлэг, чадвартай төрийн албан хаагч авч явдаг бол тэр албан хаагч бүрд хувь хүнийх нь хувьд жирийн иргэдээс, бусдаас онцлогийг тусгай шаардлага тавигддаг нь эртний ч, өдгөөгийн ч жишиг хандлага.

Төлөвшил хүмүүжлээр олж авсан шулуун чигч нэг л зангаараа байх төрийн түшмэл эрдэнийн ёс зүйд бид хамгийн том найдлага тавьж байна.

Монгол төрийн албан хаагчдад бусдаас харьцуулж сурахын зэрэгцээ төрт ёсны эртний түүх, соёл, уламжлалаасаа авах зүйл олон бий, дагах зарчим ч хангалттай байгаа.

Төрийн албан хаагч бүр өөр өөрсдийн хийх ажил, гүйцэтгэх үүрэг, дор бүрнээ гаргах үр дүнгээрээ ялгардаг хэдий ч тэдний ажил, амьдралдаа хандах хандлага “Ёс зүй” гэдэг ганцхан цэг дээр яг ижилхэн давхацдаг, бас төвлөрдөг онцлогтой.

Төрийн байгууллагууд дахь Ёс зүйн зөвлөлийн гишүүдээ **Монгол төрийн албаны ёс зүйн элч** хэмээн дэмжиж, сургаж, дадлагажуулж ирлээ.

Төрийн албаны зөвлөл асуудал болгоны дэргэд зогсож, манаж байх боломжгүй нь ойлгомжтой. Харин төрийн албан хаагчийн ёс зүйн хэм хэмжээг сахиулахтай холбогдсон зөвлөгөө өгөх, арга зүйн удирдлагаар хангах, эдгээрийн хэрэгжилт, зөрчил, авах арга хэмжээний саналыг хуулиар хүлээсэн чиг үүргийнхээ дагуу цаашид улам эрчимтэй ажиллах болно.

Төр хэмээх үг ёс гэдэг утгаар хэрэглэгдэж байсан жишээ “Монголын нууц товчоо”-нд байдгийг эрдэмтэд нотолсон. Төр, ёс гэх хоёр үг эхэндээ ижил утгаар хэрэглэгдэж байгаад төрт ёсны хөгжлийн явцад утга салсан байх юм.

Аливааг ёс журамтай, хүндэтгэлтэй эзний ёсоор хийхийг “ёс төртэй” гэж бид хэлдэг. Тогтсон ёс зарчимтай түшмэлийн алба төрт ёсны чухал бүрэлдэхүүн, төрт ёсыг тээгч, уламжлуулагч юм.

--oOo---



Цогц чадамжид суурилсан хүний нөөцийн удирдлагын онлайн сургалтад зориулсан видео мэндчилгээ

2021.10.04

Эерэг өөрчлөлт, эерэг шинэтгэл явагдаж байгаа газарт л ахиц дэвшил, амжилт ололт гардаг цаг үед бид ажиллаж амьдарч байна. Та бүгд үүнийг сайн мэдэж байгаа. Өнөөдөр маш сайн гэгдэж байгаа зүйл маргааш биш юм гэхэд нөгөөдөр болж бүтэхгүй болох, бүр хөгжил дэвшлээс хойш чангаах жишээний.

Нийгмийн шаардлага, иргэдийн хүсэмжлэл, улс төрийн дэмжлэг хосолсон төрийн албаны шинэтгэлийн орон зайд улс орны хөгжил, иргэдийн сайн сайхны төлөө өөрсдийн оролцоо, хувь нэмрээ оруулж байгаа төрийн албан хаагчдаараа бид бахархах учиртай.

Энэ шинэтгэл Төрийн албаны тухай хуулиар эхэлж “Алсын хараа-2050” хөгжлийн бодлогоор баталгаажсан. Энэ шинэтгэл мерит, шатлан дэвших зарчмуудад тулгуурлаж байгаа. Энэ шинэтгэлийн уг суурь нь Монгол төрийн хүний нөөцийн чадавхыг дээшлүүлэхэд бүхэлдээ чиглэгдсэн.

Хуулиар тодорхойлсон төрийн албаны тулгуур зарчмууд чадварлаг төрийн албан хаагчгүйгээр хэрэгжих боломжгүй нь тодорхой.

“Нөхцөл байдлыг өөрчлөх боломжгүй бол өөрийгөө өөрчлөн сорих цаг болж гэдгийг ойлгоорой” гэсэн утгатай нэгэн ухаантны үг санаанд орж байна. (Viktor Emil Frankl-Австрийн философич, сэтгэл зүйч) Үнэн үг гэж би боддог. Төрийн албан хаагчид өөрсдөө шинэтгэлийн орчин нөхцөлд дасан зохицохуйцаар өөрчлөгдөж хөгжихөөс өөр гарц байхгүй нь.

Хувь хүний хүсэл зоригоор биш хууль, дүрэм, стандартын хүрээнд ажилладаг төрийн албан хаагчдад маань шаардагдах зүйл маш олон.

Эдгээрийн дотроос цогц чадамжийн сэдвийг онцолж байна. Цогц чадамжийг нэвтрүүлсний үр нөлөө, ач холбогдлыг таниулахыг зорьж байна.

Манай төрт ёсны түүхэнд мэдлэг чадвар, ур ухааныг эрхэмлэсэн жишээ олон бий. “Хаан төрийн түшмэл эрдэнэ” хэмээх ойлголтын ард төрийн албанд ямар олон шалгуур тавигдаж байсныг бүгд санаж байгаа.



Ажлын үр ашиг, гүйцэтгэлийг сайжруулах, бодитоор харуулах шинж чанар, ур чадварын бүрдэл болсон “чадамж” гэх энэ ойлголт төрийн албаны шинэтгэлийн нэгэн бүрэлдэхүүн хэсэг болж бодлогын түвшинд хэрэгжих болно.

Энэ ойлголт гүйцэтгэлийг сайжруулахад ашигладаг практик болон онолын мэдлэг, танин мэдэхүйн чадвар, зан байдал, үнэт зүйлсийн хослол болон хэрэглэгдэх болно.

Мөн тодорхой үүрэг гүйцэтгэх чадвар бүхий өндөр мэргэшсэн төрийн албан хаагчийн зайлшгүй эзэмшсэн байх, мөн тасралтгүй хөгжүүлж байх эрхэм чанар байх болно.

Системийн сэтгэлгээ, сэтгэл хөдлөл, зан үйл, нөлөөлөл, ойлголцол, хэлэлцээрийн чадвар зэргийг багтаасан менежментийн чадамж ялангуяа удирдах албан тушаалтнууд, хүний нөөцийн асуудал хариуцсан хүмүүст ямар их хэрэгтэйг бид өдөр тутмын үйл ажиллагаанаасаа олж хардаг.

Төрийн албан дахь энэ ойлголт монгол соёл, монгол хүний мөн чанар, арга барил, монголын нийгмийн сэтгэл зүйн онцлогт тохирсон байдлаар өвөрмөц, бас онцлог байдлаар томьёологдон нутагших үйл явцад энэ сургалт үр дүнгээ өгнө гэдэгт итгэж байна.

Өв тэгш мэдлэг, ур чадварыг эзэмшиж байж өнөөгийн шаардлагад нийцсэн төрийн албан хаагч бий болох тухай онцлог сэдвийг хөндсөн сургалтын үйл ажиллагаанд амжилт хүсье.

IV. ХҮНИЙ НӨӨЦ, ЦАХИМЖИЛТ

Парето зарчим:



хүний нөөцийн нөхөн сэлгэлт

HEAD HUNTING



ЗӨВ

- Хүнийг
- Аргаар шалгаруулж
- Ажилд томилж
- Үр дүнд хүрнэ

V. ИДЕА БАНК



САНААНЫ БАНК

---o0o---



Төрийн албан дахь Эмэгтэйчүүдийн Манлайллын хөтөлбөрийн нээлт дээр хэлсэн үг

2021.09.21

Монгол Улсын Их Хурлын гишүүн Д.Тогтохсүрэн, Канад Улсаас Монгол Улсад суугаа Онц бөгөөд Бүрэн эрхт Элчин сайд хатагтай Ивкофф, НҮБ-ын Хөгжлийн хөтөлбөрийн Суурин төлөөлөгч хатагтай Конкиевич, Либерал эмэгтэйчүүдийн оюуны сангийн ерөнхийлөгч хатагтай Бүжидмаа нар болон налгар намрын энэ сайхан өглөө санаагаа хуваалцаж, сэтгэлээ нээхээр хүрэлцэн ирсэн бүсгүйчүүд Та бүхэнтэй уулзаж байгаадаа баяртай байна.

Өнөөдрийн энэ арга хэмжээний хөтөлбөрийг уншихад зорилго, ач холбогдол нь хэн бүхэнд тодорхой байгаа болов уу. Сэдэв, агуулгын хувьд манай улсад өнөөдөр, эсвэл өчигдөрхөн хөндөгдөж байгаа асуудал биш, нэг өдөр гэнэт гарч ирээд хэрэгжүүлэх гэж байгаа ойлголт огт биш ээ.

Монгол төрийн түүхэнд Алунгуа тэргүүтэн ухаант хатад, эмэгтэйчүүдийн оруулсан хувь нэмэр, уран бэрийн нүүдлийн бахархам жишээ манайд чамгүй их бий.


Төрийн ордноос өгсүүлээд Та бидний ажлын газар, албан тасалгаа, халуун ам бүлийн голомт болсон гэр оронд маань монгол хүн, монгол төрийн цог золбоо, хийморийн бэлгэдэл болсон төрийн сүлд, төрийн далбаанд маань гүн хүндэтгэлтэй оршдог нэгэн үсгийг бүгдээрээ мэднэ. Тэр бол СОЁМБО үсэг.

Төрийнхөө сүлд, далбаанд СОЁМБО үсэгт байдаг арга билгийн эрхэм чанарыг тунхаглан дүрсэлсэн улс орон хэр олон байдгийг би хувьдаа мэдэхгүй.

Арга билгийн мөн чанарыг сүлд, далбаандаа эрхэмлэн залсан улс орны төрийн албыг жендерийн мэдрэмжгүй гэж бас хэн ч хэлэхгүй байх.

Би багш хүн. Аль ч шатны сургуульд хамгийн сайн сурдаг, хамгийн идэвхтэй байдаг, хамт олон, найз нөхдөө манлайлан явдаг тэр хүмүүс гол төлөв охид, бүсгүйчүүд байдгийг мэднэ. Нэр хичээнгүй, манлайлагч тэдний авьяас чадвар гэнэт алга болчихдоггүй нь дэндүү тодорхой.

Бид охид, бүсгүйчүүдийнхээ тэр сайн сайхан чанарыг насан туршид нь хадгалах ёстой. Улс орны хөгжил, хүн ардынхаа сайн сайхан аж амьдралын төлөөх төрийн албаны эрхэм үйлсийн гадна тэднийгээ бодлого, зорилготойгоор үлдээх, ардаа гэж орхих тийм явцуу, ахархан бодлого монгол төрд байгаагүй, цаашид ч байх учиргүй.



Жендер, арьс өнгө, хөгжлийн бэрхшээл, хүйсийн баримжааны улмаас бий болж тогтдог нийгмийн хуваагдал, тэгш бус байдалтай Монгол Улсын төрийн алба хэзээ ч эвлэрэхгүй гэдэгт би хатуу итгэдэг хүн. Болзошгүй энэ байдлаас урьдчилан сэргийлсэн, ухааран бодохуйц хуульчилсан төрийн бодлого бий. (Жендерийн эрх тэгш байдлыг хангах тухай хууль) Хуульчилсан төрийн бодлого хэлбэрэлтгүй, чанд хэрэгжих учиртай.

Нийгмийн төрөл бүрийн бүлгүүдийн ялгаатай байдлыг хүлээн зөвшөөрсний үндсэн дээр тэдний хэрэгцээнд чиглэсэн бодлого явуулах, нийгмийн шударга ёсыг тогтоох тухай үзэл баримтлалыг тууштай баримтлах хандлага олон улсад нэмэгдсээр байна.

Маш энгийнээр хэлэхэд, эрэгтэй, эмэгтэй хүмүүсийн тэгш байдал гэдэг тэр хүмүүсийг адил болгоно гэсэн утгаар бус, харин эрх, хариуцлага, боломж нь хүйсээс үл хамаарна гэсэн үг гэж би боддог. Жендерийн тэгш байдал бий болгох нь эрэгтэй, эмэгтэй хүмүүсийн сонирхол, хэрэгцээ, урьтлыг (эн тэргүүнд) харгалзан үзэх, эрэгтэй, эмэгтэй хүмүүсээс бүрдсэн төрөл бүрийн бүлгийн ялгаатай байдлыг хүлээн зөвшөөрөх явдал.

Бодлого, үйл ажиллагаанд жендерийг тусгах талаарх НҮБ-ын албан ёсны тодорхойлолтод “Хууль тогтоомж, бодлого, хөтөлбөр зэрэг бүх төлөвлөгөөт үйл ажиллагаанаас эмэгтэй, эрэгтэй хүмүүст тусах нөлөөллийг бүх салбар, бүх шатанд үнэлж байх үйл явц. Бодлого, хөтөлбөр боловсруулах, хэрэгжүүлэх, хэрэгжилтэд нь хяналт тавих, үнэлгээ хийх явцад эмэгтэй, эрэгтэй хүмүүсийн санаа бодол, туршлагыг зайлшгүй харгалзан үзэж байх стратеги” гэж тодорхойлжээ.

Улс оронд маань явагдаж буй төрийн албаны шинэтгэлийг талархан хүлээн авч бодлогын зөвлөмж, санхүүгийн дэмжлэг үзүүлж буй НҮБ-ын Хөгжлийн хөтөлбөр, Канадын Засгийн газарт Та бид нар зүй ёсоор талархах учиртай. Энэхүү хамтын ажиллагааны нэгэн гол чиглэл нь төрийн албаны жендерийн асуудал. Өнөөдрийн арга хэмжээ ч үүний нэгэн хэсэг гэж ойлгож болно.

Энэ сайхан уулзалтын үеэр нэгэн дурсамжаа хуваалцъя гэж бодлоо. Миний хувьд УИХ-ын гишүүнээр ажиллаж байхдаа 2003 оны 12 дугаар сарын 18-ны өдөр олны ярьж заншсан “Мартын-8”-ыг Олон улсын эмэгтэйчүүдийн өдөр болгон нийтээр тэмдэглэн өнгөрүүлэх баярын өдөр болгон хуульчилж байснаа дурсан санахад таатай байдаг. Эмэгтэйчүүдийнхээ төлөө хувь хүний зүгээс оруулсан бага ч атугай хувь нэмэр юм.

Та бүхэнд аз жаргал, амжилт бүтээлийн дээдийг Төрийн албаны зөвлөлийн нэрийн өмнөөс хүсэн ерөөе.

Шинэтгэлийг дэмжин хамтран ажиллаж байгаа байгууллагуудын удирдлага болох хатагтай Конкиевич, хатагтай Ивкоф, хатагтай Бүжидмаа нарын манлайлагч бүсгүйчүүд Та бидэнтэй сэтгэл санаа нэгдэн ажиллаж байгаад баярлахгүй байхын аргагүй. Нөгөө талаар төрийн албаны манлайлагч эмэгтэйчүүдийн тоо улам олон болж, ухаан бодол, ур чадвар нь төр улсын хэргийг удирдан явуулах сайн угтал хэмээн бэлгэддэг юм.

Ажил амьдралын өргөн замнал, амжилт ололтын урт замыг туулан яваа бүсгүйчүүд, төрийн албан хаагчдын төлөөлөл энэ уулзалтад оролцож байна.

Сургалтын үйл ажиллагаанд амжилт хүсье.

---o0o---



EXECUTIVE EDUCATION

UNDP-Mongolia Virtual Closing Ceremony

26 August 2021, Thursday
6pm to 7pm



Francesco Mancini
Vice Dean (Executive Education) and
Associate Professor in Practice,
Lee Kuan Yew School of Public Policy




UNDP Mongolia - Essentials of Policy Development
5 – 28 July 2021




UNDP Mongolia - Communications for Public Policy Delivery
4 – 28 August 2021


[Linkedin.com/school/lkysppee](https://www.linkedin.com/school/lkysppee)


[Facebook.com/lkysppee](https://www.facebook.com/lkysppee)


Ли Куан Юүгийн нэрэмжит Төрийн бодлогын сургуулийн сургалтад оролцогчдын төгсөлтийн үйл ажиллагаанд хэлсэн үг

2021.08.26

Төрийн албаны шинэтгэл маш олон талтай явагдаж байгааг энэ сургалтад оролцогчид хамгийн сайн мэдэж байгаа. Энэ шинэтгэлд оролцогч талууд бас олон. Нэг тал нь Та бүхэн өөрсдөө гэж болно.

Төрийн албаны шинэтгэлийн манлайлагчид бол шууд утгаараа Та бүхэн. Шинэтгэлийн хөдөлгөгч хүч, зүтгүүрийг бодлоготойгоор бэлтгэж байгаагийн тодорхой, бас хамгийн сүүлийн жишээ нь энэ сургалт. Та бүхний намтар зузаарахын хэрээр мэдлэг оюун тань түүнээс дутахгүй баяжсан гэдэгт итгэлтэй байна.

Зөв хүнийг зөв аргаар сонгон шалгаруулж төрд, түмэнд, улс оронд хэрэгтэй зөв ажлыг чадварлагаар хийх хүмүүс бидэнд хэзээ хэзээнээс илүү чухал байгаа үед энэ сургалт боллоо.

Тухайн асуудалд чиглэсэн бодлогын олон хувилбаруудыг дэвшүүлж чаддаг, хэрэгжилт, үр дүнд нь анализ хийдэг чадварыг Та бүхэн эзэмшсэн.

Хамгийн сүүлийн хуурай мэдээгээр ажлаа хийдэггүй баймаар байна. Бодлогын маш олон шатуудад, мэдээлэл, тоо баримт цуглуулахаас өгсүүлээд бодлого боловсруулах түвшин бүрд төрийн албан хаагч бүхэн хувь нэмрээ оруулдаг цаг үед бид ажиллаж амьдарч байна


Тоон өгөгдлийг холбогдох мэдээллийн сан руу оруулаад орхидог биш, бодлого боловсруулах шат шатанд анализ хийж чаддаг хүмүүс хэрэгтэй болохоор тал талаасаа өндөр ач холбогдол өгч энэ сургалтыг зохион байгууллаа. Үр дүн хүлээснээс илүү гараасай гэж бодож байна.

Төрд ус агаар мэт шаардагдаж буй бодлогын хувилбаруудаар шуурхай хангалт хийснээр төрийг “гал алдуулахгүй” байх ёстой Төрийн албаны зөвлөл ийм учраас л энэ хөтөлбөрийг эхлүүлсэн.

Дараагийн үеийн бодлого тодорхойлох үйл ажиллагааны эхний амжилтыг Та бүхнээр төлөөлүүлэн төсөөлж байна. Ур чадварын хөрөнгө оруулалтаар Монгол төрийн чадамж нэмэгдэж, бас сэлбэгдэж байгаад баяртай байна.

Өнөөдрийн төгссөн хүний амжилт ололтыг хэрхэн яаж үр бүтээлтэй ашиглах вэ гэдэгт байнгын анхаарал хандуулах нь хүмүүсээ сургасан байгууллагуудын эрх, бас үүрэг.

“Сургалтад хамрагдаад л лидер болчихсон хүнийг би мэдэхгүй юм байна” гэсэн утгатай Ли Куан Юү-гийн үг санаанд бууж байна. Сурах хэрэгтэй, гэхдээ хийж байж, сурсан мэдсэнээ ашиглаж байж амжилтад хүрдгийг хэлсэн байх. Та бүхэнд хийх ажлын талбар маш их байгаа, хийж, бүтээж төрийн албаны лидер болоорой гэж хүсье.



---o0o---



УИХ-ын удирдлага, гишүүдээс төрийн бодлогын тодорхой асуудлаар Төрийн албаны зөвлөлийн бүрэлдэхүүнийг хүлээн авсан уулзалт дээр хэлсэн үг

2021.08.24 Их тэнгэр

УИХ-ын удирдлага, гишүүдээс төрийн бодлогын тодорхой асуудлаар Төрийн албаны зөвлөлийн бүрэлдэхүүнийг хүлээн авч уулзаж буйд талархал илэрхийлье.

Оршил

Төрийн албаны шинэтгэлийг Төрийн албаны тухай хуулийн шинэчилсэн найруулгын хүрээнд явуулж ирлээ. Цар хүрээ өргөн, зарим талаар цаг хугацаа, эрч хүч шаардсан нийгмийн олон талын оролцоотой явуулж буй ажил гэдгийг Та бүхэн хамгийн сайн мэднэ.

УИХ-ын гишүүдийн зүгээс төрийн албаны шинэтгэлийн үйл явцад байнгын санаа тавьж, баталсан хуулийнхаа хэрэгжилт, гарч буй үр дүнгийн талаар асуулт тавьж ирсэнд талархалтай байдгаа илэрхийлье.

Энэ шинэтгэлийн үндсэн зарчмуудыг УИХ-аас баталсан томоохон баримт бичгүүд баталгаажуулсан гэж болно.

Ард иргэдийн санаа бодол, улс төрийн хүсэл зоригийн огтлолцол болсон.

Хүчин төгөлдөр хууль тогтоомжийг хэлбэрэлтгүй хэрэгжүүлэхийн зэрэгцээ тэдгээрийг боловсронгуй болгох, төрийн албаны шинэтгэлийн эрх зүйн зохицуулалтын хамрах хүрээг өргөтгөн шинээр төлөвлөж ирлээ.

Төрийн албаны төлөвшлийн олон улсын жишиг, чиг хандлага, нийгмийн эрэлт хэрэгцээнд тулгуурласан шинэтгэлийг тасралтгүй явуулах шаардлага зүй ёсоор тавигдаж байгаа нь ч ажил хийх явцад мэдрэгддэг.

Үндсэн хуулийн нэмэлт, өөрчлөлт, “Алсын хараа-2050” урт хугацааны хөгжлийн бодлого, Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хууль зэрэг бодлогын тулгуур баримт бичгүүд шинээр батлагдсан нь төрийн албаны шинэтгэлийг гүнзгийрүүлэх, шинэтгэлийн агуулгыг баяжуулах, хэрэгжилтийг хангах эрх зүйн нэн таатай нөхцөл болж байна.

Хамгийн товчоор төрийн албаны чанар, үр өгөөжийг дээшлүүлэх, хөгжлийн хөдөлгөгч хүч болгох үндсэн зарчмыг удирдлага болгосон төрийн албаны шинэтгэл гэж болно.

Энэ шинэтгэлийн бодлого, хэрэгжүүлэх арга зам, шийдэл гарцыг илүү тодорхой болгох баримт бичгүүдийн төслийг боловсруулж буй цаг үетэй энэ уулзалт давхцаж байна.



ТӨРИЙН АЛБАНЫ ЗӨВЛӨЛИЙН ДЭД АЖЛЫН ХЭСЭГ



“Төрийн жинхэнэ албанд чадахуйд үндэслэн сонгон шалгаруулах тухай” хуулийн төсөл;



“Төрийн албан хаагчийн ёс зүй, сахилгын тухай ” хуулийн төсөл;



Улсын Их Хурлын гишүүн С.Бямбацогт нарын 15 гишүүнээс өргөн мэдүүлсэн “Монгол Улсын Их Хурлын хяналт шалгалтын тухай” хуулийн төсөл;



Улсын Их Хурлын гишүүн Ё.Баатарбилэгээс өргөн мэдүүлсэн “Төрийн албаны тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай”;
Улсын Их Хурлын гишүүн Г.Тэмүүлэнгээс өргөн мэдүүлсэн “Төрийн албаны тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай” хуулийн төсөл.

Улсын Их Хурлын Төрийн байгуулалтын байнгын хорооны дарга, гишүүд Төрийн албаны зөвлөлд ажиллаж төрийн албаны шинэтгэлийг цаашид гүнзгийрүүлэх, шинэтгэлийн одоогийн үйл явцыг сааруулахгүй байх талаар өгсөн үүрэг чиглэл, Төрийн албаны зөвлөлийн үйл ажиллагааны тайланг Улсын Их

Хурлын Төрийн байгуулалтын байнгын хорооны хуралдаанаар хэлэлцэн гаргасан дүгнэлт зэргийг үндэс болгон ажлын тусгай төлөвлөгөө батлан ажиллаж байна.

Монгол Улсын Их Хурлын хяналт шалгалтын тухай, Төрийн жинхэнэ албанд чадахуйд үндэслэн сонгон шалгаруулах тухай, Төрийн албан хаагчийн ёс зүй, сахилгын тухай болон Төрийн албаны тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслүүдийг судалж, санал, дүгнэлт боловсруулах бие даасан 5 ажлын хэсгийг ТАЗ-ийн дарга, гишүүд ахлан ажиллаж байна.

Тухайлбал УИХ-ын эрхэм гишүүн Б.Баатарбилэгийн санаачилсан төрийн албаны ангилал хооронд дүйцүүлж, хөрвүүлж болох зохицуулалт, төрийн албаны шалгалтын давтамжийг нэмэх зэргээр санал болгож буй хуулийн төслийн үзэл баримтлалыг дэмжин улирал тутам зохион байгуулах программ хангамж, техникийн нөхцөлийг бүрэн шийдээд байна.

Англи, Солонгос, Канад зэрэг орнуудын холбогдох эрх зүйн зохицуулалт, жишгийг ч харьцуулан судаллаа.


Шийдэл, хувилбаруудын санал боловсруулсан талаараа гишүүд маань хариуцсан чиглэлээрээ мэдээлэл өгөх болно.



Нийт төрийн албаны статистик-тоо. Монгол төрийн албаны нөөц ийм байна. Бодлого, төлөвлөлтийн суурь индикатор нэгдсэн статистик, тоо мэдээлэл гаргах үйл явцад чанарын дэвшил гаргаж чадлаа.

Их өгөгдөл бүрдүүлэх, тэдгээрийг эргэлтэд оруулахад онцгой ач холбогдол өгч ажиллав.

Эхлүүлсэн ажлаа амжилттай явуулах суурь
Төрийн албыг цахимжуулах үйл явцад томоохон алхам хийлээ.
Төрийн албаны хүний нөөцийн санг бүрэн цахимжууллаа.
Энэ системээ Сангийн яамны цалингийн нэгдсэн системтэй холболоо.
“ХУР” системтэй ойрын хугацаанд холбогдож төрийн мэдээллийн их
өгөгдлийн бүрэлдэхүүн хэсэг болоод явах юм.



Төрийн албаны мэдлэг, мэдээлэл аажмаар блокчэйн технологид шилжих, дижитал шилжилтэд орох суурь ажлууд ийнхүү тавигдаж чадлаа.

Төрийн албаны улсын хэмжээний нарийвчилсан тоон мэдээллийг иж бүрэн агуулсан “Замын зураглал”-ыг анх удаа гаргалаа. Их өгөгдлийн суурийг нэгтгэсэн тоон хавтгай, ерөнхий зураглал төрийн албаны шинэтгэлийн луужин болж чадна.

Хаана, хэн, ямар ажилд томилогдож, чөлөөлөгдөж байгаа, хаана сул орон тоо үүсэж байгаа зэрэг хүний нөөцийн шилжилт хөдөлгөөнийг “Бодит цаг”-(Real time)-ийн хэмжүүрээр шуурхай мэдэх боломж орон даяар үүснэ.

Томилгооны зөрчил де факто арилна гэсэн үг.

Ийнхүү мэдээллийн царцанги байдал арилж, мэдээлэл эрэлт хэрэгцээнд, бас эргэлтэд орж байдаг нөхцөл бий болно.

Төрийн байгууллагуудад “Идей банк” бий болгож, идей генераторууд, инновацийн мастеруудыг төрүүлэх оновчтой мехнаизм бий болгохыг зорьж байна.

Уламжлалт бус сэтгэлгээ, инновацийн шийдлүүдийг төрийн албанд тасралтгүй нэвтрүүлэх талаар НҮБ-ын Хөгжлийн хөтөлбөртэй хамтран ажилласны дүнд 20 гаруй төслийг сонгон хэрэгжүүлж байна.

Хоёр. СОНГОН ШАЛГАРУУЛАЛТ



Сонгон шалгаруулалтын үйл явцыг бүхэлд нь цахимжуулснаар шалгалт авагчаас биш шалгуулагчаас өөрөөс нь үр дүн шалтгаалдаг системд орлоо.

Ашиглагдаж байгаа хүний нөөц буюу ажиллаж байгаа төрийн албан хаагчид 205.0 мянга, сул орон тоонд ажиллах хүсэлтэй, ерөнхий шалгалт өгч тэнцсэн 8 мянга гаруй хүнтэй байна.

Шалгалт цахимжиж, шударга байдал хангагдахын хэрээр мэдлэг оюунаа сорих, төрд ажиллах сонирхолтой шинэ залуу үеийн түрлэг нэмэгдсэн гэж болно.

Төрийн албаны нөөц буюу “Үндэсний хүний нөөцийн банк” ийнхүү бүрдлээ. Хувийн хэвшлийнхэн төрийн албаны нөөцөөс шилдэг залуу хүмүүсийг сонирхдог, ажилд авдаг болсон нь нөөцийн чанарын нэг гол үзүүлэлт юм.

Төрийн албаны мерит, шатлан дэвших тогтолцооны зэрэгцээ төрд зайлшгүй шаардлагатай хүний нөөцийн хэрэгцээ байгааг бид ойлгодог.

Бизнесийн салбарт түгээмэл байдаг “Headhunting” буюу монголчилбол толгойн ангуучийн ойлголт олон орны төрийн албанд нутагшжээ. Занданшатар дарга энэ талаар байр сууриа маш тодорхой илэрхийлж байсан билээ.

Англи Улсад байдаг нэн шаардлагатай мэргэжил, өндөр ур чадвартай хүмүүсийг шууд томилдог жишиг төрийн алба нь төлөвшсөн зарим орнуудад хэрэгждэг. Гэхдээ холбогдох яамнаас уг ажилд томилох хүний зайлшгүй чухал гэдгийг нотолсон хүсэлтийг Төрийн албаны комисстоо ирүүлж зөвшөөрөл авдаг, дараа нь аудитаар шалгуулдаг, зарим тохиолдолд тухайн хүнээ бүр мөсөн ажиллуулах шийдэлд хүрдэг байх жишээний. (Яамны хүсэлтийн хүснэгт)

Сонгон шалгаруулалтын тухай хуулийн төсөлд энэ асуудлыг оновчтой тодорхойлох нь олон улсын жишигт нийцнэ гэж үзэж байна. Түүнчлэн ерөнхий шалгалт авах давтамжийг нэмэгдүүлэх боломж бүрэн бүрдсэнийг хэлэх нь зүйтэй.



Гурав. ЁС ЗҮЙ

Юуг хийж болох вэ, юуг хийж болохгүй вэ? гэдэг хоёр ойлголтын зааг, тэнцвэр дээр оршдог ёс зүйн асуудал аль ч орны төрийн албанд маш чухалд тооцогддог.

Сүүлийн 2 жилийн хугацаанд Улсын Их Хурлын дарга болон Байнгын хорооны дарга нар, гишүүд Төрийн албаны зөвлөлд ажилласан, мөн Ёс зүйн хуулийн төслийн асуудлаар өргөн хүрээтэй уулзалт хэлэлцүүлэг хийсэн. Нийт төрийн байгууллагуудын Ёс зүйн зөвлөлийн нэгдсэн чуулган хийж, эрдэмтэн судлаачид, төрийн албан хаагчдаас маш олон санал санаачилга гарсан.

Үндсэн хуулийн нэмэлт, өөрчлөлтийн талаар зөвлөлдөх санал асуулгад оролцогчдын 95.5% нь төрийн албаны сахилга хариуцлагыг дээшлүүлэх, 89% нь шударга ёсыг бэхжүүлэх, 87% хувь нь мэдлэг чадварт суурилсан төрийн албыг төлөвшүүлэхийг хүсэмжилсэн байдаг. Ганц энэ жишээнээс харсан ч төрийн албаны ёс зүй, сахилга хариуцлагын асуудлыг өргөн хүрээнд авч үзсэн эрх зүйн зохицуулалт нэн шаардлагатай нь маш тодорхой байгаа.



Дөрөв. Хяналт шалгалт

Сонгон шалгаруулж авсан зөв хүнээ хэрхэн сайн ажиллуулж сайн үр дүн гаргуулах вэ гэдэг асуудал чухал.

Хуулийн хэрэгжилтийг хангах, маргаан хянан шийдвэрлэх ажлыг цахим технологи ашиглан шийдвэрлэх чиглэлээр ажиллаж эхэллээ. Мөн төрд учирсан хохирлыг буруутай этгээдээр нөхөн төлүүлэх төрийн байгууллага хоорондын ажлын уялдаа холбоог Хүний нөөцийн удирдлагын нэгдсэн системээр дамжуулан хангана.

Хяналт шалгалт, эдийн засгийн агуулгаар баяжуулахыг зорьж ирлээ. Ажлын үр дүн ч гарч байна.

Төрийн албан хаагчдын бодол санааг зөв байлгахаас өгсүүлээд боловсрол, мэдлэгийг нь хэрхэн байнга дээшлүүлэх вэ?

УИХ-ын хяналт шалгалтын бүрэн эрхийг хэрэгжүүлэхэд Төрийн албаны зөвлөл чиг үүргийн хүрээнд идэвхтэй ажиллах болно.

Хүний нөөцийн аудитаар дамжуулан төрийн албаны томилгооноос эхлэн тэтгэвэрт гарах хүртэлх хүний нөөцийн бүрэлдэхүүн хөдөлгөөний бүхий л үйл явцад аналитик дүн шинжилгээ хийх чадвартай боллоо.

---o0o---

**Сингапурын Үндэсний их сургуулийн харьяа Ли Куан
Юүгийн нэрэмжит Төрийн бодлогын сургуулийн
сертификаттай тэтгэлэгт цахим хөтөлбөр**



**Сингапурын Үндэсний их сургуулийн харьяа Ли Куан
Юүгийн нэрэмжит Төрийн бодлогын сургуулийн
сертификаттай тэтгэлэгт цахим хөтөлбөрт
оролцогчидтой хийсэн уулзалт дээр хэлсэн үг**

2021.07.09

Ажил амралтаа хослуулан төрийн бодлогын чиглэлээр нэр хүндтэй сургуулийн сургалтад оролцож буй төрийн албан хаагчид Та бүхэнд энэ өглөөний мэнд хүргэе!

Улс оронд явагдаж буй төрийн албаны шинэтгэлийн утга учир, зорилгыг хамгийн сайн мэдэх хүмүүс бол төрийн албан хаагчид.

Энэ шинэтгэлээр хийгдэж буй олон ажлын магадгүй хамгийн чухал нэг хэсэг нь хүний хөгжил, тэр дундаа төрийн албан хаагчийн сургалт хөгжлийн асуудал.

Гадаадын нэр хүнд бүхий их, дээд сургуулиудад урт, богино хугацаагаар суралцуулж төрийн албан хаагчдадаа шинэ мэдлэг, ур чадвар эзэмшүүлэх бодлого баримталж байна.

Энэ бодлого илүү идэвхжиж, ахиц дэвшил, үр дүн гарч байгаа. Сүүлийн богинохон хугацааны зарим жишээг хэлье.

Саяхан Засгийн газар, олон улсын байгууллагуудын тэтгэлэгт хөтөлбөрт хамрагдсан төрийн албан хаагчдын уулзалтыг анх удаа хийлээ.

Донорууд, олон улсын байгууллага, мөн гадаад орнуудаас манай улсад суугаа Элчин сайдын яамд оролцсон. Санал бодлоо солилцож, илүү үр дүнд хүрэх гарц гаргалгаа ярьсан.

Турк Улсын тэтгэлгээр 10 төрийн албан хаагчийг 6-10 сарын хугацаагаар сургаж, хөгжүүлэх хөтөлбөр хэрэгжүүлэхээр боллоо.

ЖАЙКА-гийн шугамаар Япон Улсад магистрантурт сургах хүмүүс явах бэлтгэлээ хангаж байна.

Хамгийн сүүлийн жишээ бол Ли Куан Юүгийн сургуулийн хөтөлбөрт оролцож байгаа Та бүхэн (20 хүн).



Төрийн албаны шинэтгэлийнхээ гол хөдөлгөгч хүч болсон төрийн албаны хүмүүн капиталд хөрөнгө оруулж буй бидний нэг ажил.

Төрийн албаа ийнхүү чадавхжуулна гэдэг төр **хүмүүн капиталдаа хамтарсан хөрөнгө оруулалт хийж** “Хүний нөөцийн банк”-аа бүтээж байгаа хэрэг. Энэ “банк” байнга чанаржин баяжиж, үр дүнд нь төрийн ажил орчин цагийн шаардлагад нийцэж, улс орны хөгжлийг түүчээлдэг байх учиртай.

Канад Улсын санхүүжилтээр Нэгдсэн Үндэсний байгууллагын Хөгжлийн хөтөлбөрөөс “Монгол Улсад мэргэжлийн, иргэн төвтэй төрийн албыг төлөвшүүлэх нь” төслийг Төрийн албаны зөвлөл, Засгийн газрын Хэрэг эрхлэх газар, Удирдлагын академитай хамтран хэрэгжүүлж байгаа.

Уг Төслийн дэмжлэгээр Сингапурын Үндэсний их сургуулийн харьяа Ли Куан Юүгийн нэрэмжит Төрийн бодлогын сургуулийн сертификаттай тэтгэлэгт цахим хөтөлбөрт Төрийн албан хаагч та бүхнийг оролцож байгаад баяртай байгаа.

Канадын татвар төлөгчдийн мөнгө Монголын төрийн албан хаагчдын оюуны хөрөнгө оруулалт болж байна гэдгийг бүгдээрээ ухамсарлан ойлгож байгаа гэдэгт найдаж байна.

Хүлээлт их байгааг хэлье.

Ямар ч хөрөнгө оруулалт үр ашиг, үр дүнгийн төлөө байдаг. Энэ хөрөнгө оруулалтын үр дүн Монгол Улсын төрийн албаны шинэтгэлд хувь нэмэр оруулах учиртай.

Сургалтын дараа сурсан мэдсэнээ бусадтайгаа хуваалцах хэрэг гарна, тэгэх ч шаардлагатай.

Бодлогын анализ дүгнэлт хийдэг төрийн албаны шинэтгэлийн түүчээнүүд бэлтгэгдэж байна гэж ойлгож байгаа шүү.

Төрийн бодлого боловсруулах, тэр бодлогоо нийтэд таниулах арга, хэлбэрийг эзэмших сургалт судалгааны ажилд нь амжилт хүсье.



---o0o---



“Анхаарч сонсъя, анзаарч өөрчилъе” сошиал медиа нөлөөллийн аяны хаалт дээр хэлсэн үг

2021.07.08

Нийгэмд нөлөөллийг хэрэгжүүлэх арга хэлбэр, төрөл улам олон янз болж байна. Үүний нэг нь хүн бүрийн шахуу хэрэглээ болсон СОШИАЛ МЕДИА нөлөөлөл.

Сошиал медиа нийгэмд асар их нөлөө үзүүлж буй нь тодорхой.

Манай улсын интернэт хэрэглэгчийн тоо энэ жилийн 1 дүгээр улирлын статистикаар давхардсан тоогоор 3,9 саяд хүрсэн байна. Манай улсын нэг иргэн сард дунджаар 5 сэтгэгдэл бичиж, 16 пост дээр like дарж, 3 пост share хийдэг гэсэн судалгаа ч байна. “Facebook”-ээр зар сурталчилгаа дамжуулахад дунджаар 2.1 сая хүнд хүрэх боломжтой гэсэн тооцоо бас байна.

Ийм том орон зайд нийгэмд, иргэдэд хүргэх ёстой, хүлээлт үүсгэж буй тэр мессеж болох “АНХААРЧ СОНСЪЁ, АНЗААРЧ ӨӨРЧИЛЪЕ” сошиал медиа аяныг хамтран зохион байгуулсан Та бүхэнд талархаж байгаа.

Төрийн албаны шинэтгэлд орж ирсэн энэ шинэ уур амьсгалыг дэмжиж, тал талын оролцоо, санаачилга гарч ирсэн.



Манай Төрийн албаны зөвлөл гадаад орон, олон улсын байгууллагын тэтгэлэгт хөтөлбөрт хамрагдан суралцаж байгаа, суралцаж төгссөн төрийн албан хаагчдаа сонссон цахим чуулга уулзалт хийлээ.


Төрийн албаны хөгжилд дэмжлэг үзүүлэн ажилладаг донорууд, Монгол Улсад суугаа гадаад орнуудын Элчин сайд нар, олон улсын байгууллагын тэргүүнүүдтэй уулзаж, уг ажлын явцыг үнэлж дүгнэж, цаашид өргөжүүлэх талаар санал солилцлоо.

Иргэдээ ☒

АНХААРЧ СОНСЪЁ!

Үг, үйлдлээ ☒

АНЗААРЧ ӨӨРЧИЛЪЕ!




Иргэдээ ☒

АНХААРЧ СОНСЪЁ!

Үг, үйлдлээ ☒

АНЗААРЧ ӨӨРЧИЛЪЕ!





Сонсож ойлгож байж өөрчлөх ёстой, сайжруулах ёстой, дүгнэж цэгнэх ёстой. Бидэнд анхаарал хандуулах, анхаарвал зохих маш олон зүйл байгаа. Бид тэдгээрийгээ эрэмбэлэх ёстой.

Эрэмбийн дээр байгаа зүйлээ анзаарч чадвал өөрчлөх, шинэчлэх үйл, үйлдэл хийх ёстой. Ийм ч учраас энэ аяныг анх удаа явуулсанд баяртай байгаа. Цаашид үргэлжилж, шинэ сэдэв чиглэлээр үргэлжлэн яваасай гэж бодож байна.

---o0o---

Япон Улсын Засгийн газрын дэмжлэгтэйгээр, НҮБ-ын Хөгжлийн хөтөлбөр, Төрийн албаны зөвлөлөөс багш, нийгмийн ажилтан, эмч, эрүүл мэндийн ажилтан зэрэг төрийн албан хаагчдын хүний эрх, ёс зүйн мэдлэг мэдрэмжийг дээшлүүлэхэд чиглэсэн цуврал видео контентыг бүтээн НҮБХХ-ийн албан ёсны сошиал хуудсаар түгээсэн. Одоогоор эдгээр цуврал контентыг 50,000 гаруй иргэд хүлээн авч, үзээд байна.

Энэхүү аяныг төрийн албан хаагчдын ёс зүйн хэм хэмжээг тодорхойлон, хэрэгжилтийг ханган ажилладаг Төрийн албан зөвлөл дэмжин ажиллаж байна. Цуврал контентоо өргөжүүлэн “10 хоногийн сошиал аян” зохион байгуулж, аяны нээлтийн үйл ажиллагааг цахимаар зохион байгуулав.

Аяны хүрээнд төрийн албан хаагчид, ялангуяа дээр дурдсан салбар мэргэжлийн албан хаагчид, болон олон нийтэд хандсан хүний эрхийн мэдлэг, мэдрэмж болон ёс зүйн хэм хэмжээгээ дээшлүүлж зан үйлийн эерэг өөрчлөлт авчрахыг сэдэлжүүлсэн видео контент, зурагт хуудас, мессежийг түгээхийн зэрэгцээ энэхүү сэдвийн хүрээнд хэлэлцүүлэг өрнүүлж, хэвлэл мэдээллийн хэрэгслүүдээр сурвалжилга, мэдээ цацахаар төлөвлөж байна.

Аян 6 сарын 17-нд нээлтээ хийж 6 сарын 26 хүртэл үргэлжилнэ.



Улсын их хурлын
Төрийн байгуулалтын
байнгын хороо



Төрийн Албаны Шинэтгэл

УУЛЗАЛТ - ХЭЛЭЛЦҮҮЛЭГ

**УИХ-ын ТББХ-ны дарга, гишүүдийн
Төрийн албаны зөвлөл дээр хийсэн
уулзалт дээр хэлсэн үг**

2021.07.03

Улсын Их Хурлаас баталсан Төрийн албаны тухай хууль /шинэчилсэн найруулга/ хүчин төгөлдөр мөрдөгдөж эхлээд 2 жил 6 сар 6 өдөр, Төрийн албаны зөвлөлийн шинэ бүрэлдэхүүн бүрдээд 2 жил 5 сар болж байна.

Шинэ хууль нь меритийн зарчимд суурилсан төрийн албыг төлөвшүүлэх агуулгаараа шинэтгэлийн шинэ үе шатыг эхлүүлсэн юм.

Аливаа хуулийг баталсан хүмүүс парламентын хоёр бүрэн эрхийг дамжин ажиллах нь тухайн хуулийн хэрэгжилтэд эерэг нөлөө үзүүлдэг гэдэг. Энэ хуулийг баталсан хүмүүс УИХ-д олон байгаа нь манай төрийн албаны шинэтгэл эрч хүчээ алдахгүй, үр дүнтэй үргэлжлэх хамгийн таатай нөхцөлийн нэг юм.

Өнгөрсөн хугацаанд энэхүү шинэтгэлийг эрчимжүүлэхэд УИХ-ын зүгээс улс төрийн манлайлал, дэмжлэг үзүүлж ажилласныг онцлон тэмдэглэж байна. Тухайлбал, УИХ-ын Төрийн байгуулалтын байнгын хороо өнгөрсөн оны 10 дугаар сард Төрийн албаны зөвлөлд ажиллаж, төрийн албаны шинэтгэлийн үйл явцтай танилцсан. Ёс зүй, сахилга хариуцлагын байнгын хороо, Нийгмийн бодлогын байнгын хороо, Инновац, цахим бодлогын байнгын хороо хамтран оролцсон.

2020 онд төрийн албаны ёс зүйн асуудлаар УИХ-ын дарга, байнгын хороодын дарга, гишүүдийн оролцоотойгоор УИХ-тай хамтран улсын зөвлөгөөн

зохион байгуулсан. Төрийн албан хаагчийн ёс зүйн асуудлаар төрийн албаны бүх шатанд нэг ойлголттой болж, хийх ажил, анхаарах асуудлаа тодорхойлж чадсан.

Ийнхүү УИХ-ын гишүүд баталсан хуулийн хэрэгжилт, төрийн албаны шинэтгэлийн үйл явцад онцгой анхаарал хандуулж ирсэн нь онцлог байлаа. Албан бичгээр асуулга тавьж, мэдээлэл, тодруулга байнга авч байна.

Та бүхэн Төрийн албаны зөвлөлд өнөөдөр ажиллаж буй нь ч төрийн албаны шинэтгэлд парламентаас үзүүлж буй дэмжлэгийн нэг илрэл гэж үзэж байна.

Шинэ хуулийг хэрэгжүүлэх эрх олгож, үүрэг хариуцлага хүлээлгэсэн олон субъект бий. Тэдгээрийн дотор төрийн албаны төв байгууллагын хүлээсэн чиг үүрэг маш тодорхой, бас өөрийн гэсэн хүрээ хязгаартай.

Төрийн албаны төв байгууллага дэлхийн улс орнуудад хараат бус, бие даасан байдлаар ажилладаг нийтлэг жишиг тогтоод уджээ. Зарим орнуудынх 100 гаруй жилийн түүхтэй. НҮБ-ын гишүүн орнуудын 2/3 орчимд төрийн албаны комисс, хороо, зөвлөл ажиллаж байна.

Монгол Улс дахь төрийн албаны байгууллагын түүх 26 жил. Энэ хугацаанд үйл ажиллагаа нь аажмаар төлөвшиж, үүрэг хариуцлага нь байнга нэмэгдэж ирсэн.

Төрийн албаны тухай хуулийн шинэчилсэн найруулгаар Төрийн албаны зөвлөлийн хариуцах ажил, цар хүрээ эрс өргөжсөн. Үүнтэй уялдаад Төрийн албаны зөвлөл, түүний Ажлын алба, салбар зөвлөлийг бүтэц, зохион байгуулалтын хувьд бэхжүүлж, чадавхжуулахад онцгой анхаарч, тодорхой ахиц дэвшил гаргалаа.

Харьцуулсан зарим тоо баримт хэлье.

2018 оны байдлаар орон тоо 18 байсан бол одоо 54 болсон.

Зарцуулдаг төсөв 700 сая орчим төгрөг байсан бол одоо 3.7-4 тэрбум төгрөг.

Үндсэн үйл ажиллагаанд шаардагдах байр танхим, тоног төхөөрөмж, ажиллах орчин шаардлагын түвшинд хүрсэн.

Орон тоон, цалин хөлс, бүтэц зохион байгуулалтын **механик өсөлт бус ажил, ачаалалдаа зохицсон хэмжээ** гэж болно. УИХ-аас үүнийг хянаж нягтлан баталсан.

Өнгөрсөн хугацаанд Зөвлөл төрийн албаны шинэтгэлийг эрчимжүүлэх суурь хөрсийг баттай тавьж, доорх хэдэн чиглэлээр үр дүн гаргаж ажиллалаа. Үүнд:


2. Төрийн алба сургалтын хуульчилсан тогтолцоотой болсон.

Ажиллаж буй төрийн албан хаагчдаа тасралтгүй сургах, хөгжүүлэх явдал хэвшлээ. Удирдлагын академийн сургалтын агуулгыг баяжуулах, хөтөлбөрийг нь боловсронгуй болгох ажил тасралтгүй хийгдэж байна.

Алсын зайн сургалт, вебинарыг хэвшил болголоо. 7:4:10 сургалтад оны эхний хагас жилийн байдлаар 19 мянга гаруй төрийн албан хаагч оролцлоо. Оролцогчдын тоо байнга нэмэгдэж байгаа нь үр дүнгийн илэрхийлэл болж байна. Үндэсний эрдэмтэн судлаачид төдийгүй олон улсын экспертүүдийн лекц, сургалтыг цахимаар авдаг болж чадлаа.

Үндсэн сургалтыг мэргэшүүлэх багц сургалт, албан тушаалын ажлын байрны сургалт гэсэн хоёр чиглэлээр явуулдаг.

Мөн хамтарсан болон захиалгат сургалт, төлөвлөгөөт сургалт зохион байгуулж байна. Пүрэв гарагийн вебинар 7.4.10 тогтмолжлоо. Хэрэглэгчийн тоо тогтмол өсөж нэг удаад 1000 орчим хэрэглэгч оролцдог, хагас жилд энэ тоо 19000-д хүрсэн.



Сургалтыг цахимжуулснаар үндэсний эрдэмтэн судлаачид, гадаадын экспертүүдийн мэдлэг мэдээллийг хуваалцдаг болсон.

Судалгааны ажилд анхаарч 2013 оноос хойш төрийн албаны чиглэлээр хийгдсэн эрдэм шинжилгээ, судалгааны ажлын иж бүрэн санг бүрдүүллээ.

Төрийн байгууллагын хүний нөөцийн суурь судалгааг орон нутагт Дундговь аймгийн жишээн дээр хамтран хийлээ.

3. Шинэ хандлага, соёлыг төрийн албанд нэвтрүүлэхэд онцгойлон анхаарч байна. Бодлогын инновац нэвтрүүлэх төсөл сонгон шалгаруулж төв, орон нутгийн төрийн 20 гаруй байгууллагад нэвтрүүлэн хэрэгжүүлж байна.

Инновац, шинэ технологи нэвтрүүлэхэд шилдэг боловсон хүчин хэрэгтэй.

Энэ чиглэлээр оюуны потенциал өндөртэй, ур чадвартай хүмүүсийг “Хиэд хантинг” хийж төрийн албанд урин ажиллуулах чиглэлээр бодлогын хувилбарууд дэвшүүлэн ажиллаж байна.



Санхүүжилт, хөрөнгө бага шаарддаг зөөлөн арга болох ёс зүй, зан үйлийн менежментийг төрийн албанд төлөвшүүлэх талаар цуврал ажил системтэйгээр хийж ирлээ.

Ийнхүү шаардаж шахахын зэрэгцээ ойлгуулан ухамсарлуулах талаар баримталж буй олон улсын жишгийг төрийн албанд нэвтрүүлэх ажлыг байнга хийж байна.

4. Шударга, ил тод сонгон шалгаруулалтыг төрийн албанд төлөвшүүлэх ажил хийж чадлаа.


Төрийн албаны ерөнхий шалгалтын үйл явц хүнээс үл хамаардаг болж, хөндлөнгийн нөлөөллийг байхгүй болгож бүрэн хязгаарлаж чадлаа. Цахимжилт, технологийн шинэчлэлийг 100 хувь нэвтрүүлсэн. Олон улс оронд явагддаг IELTS, TOEFL-ийн шалгалтын горимд шилжүүлсэн.

e-taz аппликэйшн хөгжүүлж, төрийн албаны шалгалтын сорил, онлайн тест, төрийн албаны холбогдох мэдээллийг гар утсаар авах боломжтой болголоо. Энэ ажлыг “e-Mongolia” (и-Монголиа) системийн нэгэн бүрэлдэхүүн хэсэг болгон цаашид хөгжүүлээд явна.

Төрийн албаны чанартай нөөцөөс хувийн хэвшил сонголт хийх практик гарч байна. Энэ нь төрийн албаны нөөц үндэсний хүний нөөцийн банк болон чанаржих хандлага руу орж байна гэж дүгнэж болно.

5. Шинэтгэл-эдийн засгийн агуулга

“Хүний нөөцийн удирдлагын мэдээллийн тогтолцоо” цахим системийг Сангийн яамны цалингийн нэгдсэн систем, бүртгэлийн байгууллагатай холбосон. Үүнд төрийн 4147 байгууллагын 163190 албан хаагчийн мэдээллийг нэгтгэлээ.



Томилгооны зөрчлийг цалин хөлсний системээр дамжуулан арилгах тогтолцоо бүрдэж буй нь энэ ажлын гол үр дүн.

Томилгооноос үүдэлтэй төрд учруулсан хохирлыг буруутай этгээдээр төлүүлж байна.

Хууль хэрэгжиж эхэлснээс 380 орчим сая төгрөг олгох шүүхийн шийдвэр гарч, 29 сая төгрөгийн нэхэмжлэл шүүхэд гаргаснаар төрд учруулсан 7 сая орчим төгрөгийг буцаан төлүүллээ.

Үүний дүнд албан тушаалтан шийдвэр гаргахаасаа өмнө хууль нягтлан үзэх соёл төлөвшиж байна.

6. Албан тушаалын тодорхойлолтыг төрийн захиргааны 21000 гаруй албан хаагч нэг бүрээр хянан гаргаж амжлаа. Тодорхой хүнд зориулсан ажлын байрны тодорхойлолтыг тухайн ажилд нь тохирсон албан тушаалын тодорхойлолт болгосон механизмыг бүрдүүллээ.

7. Манай төрийн албаны шинэтгэлийг гадаад орон, олон улсын байгууллагууд талархан дэмжиж байгаа.

Та бидний нэвтрүүлж буй мерит зарчим, шатлан дэвших тогтолцоотой мэргэшсэн, чадварлаг төрийн албыг хөгжлийн гол хүчин зүйлийн нэг гэж тэд дэмжиж байна.

Бид НҮБ-ын төрийн албаны олон улсын интеграцид нэгдэн идэвхтэй ажиллаж байна.



8. Та бид нөхцөл байдал хурдан өөрчлөгддөг ВУКА орчинд ажиллаж амьдарч байна. (КОВИД-19 ч үүний нэг жишээ)

Олон улсын эрдэмтдийн ингэж тодорхойлсон энэ цагт төрийн албаны зохицуулалтыг боловсронгуй болгох ажил тасралтгүй хийгдэх нь тодорхой.

“Алсын хараа-2050”-ын дэвшүүлсэн зорилтын хүрээнд төрийн албаны шинэтгэлийг гүнзгийрүүлэх, эрчимжүүлэх ажил цаашид үргэлжилнэ.

Засгийн газартай хамтран төрийн албаны шинэтгэлийн замын зураглал, мөн стратегийн зорилтот хөтөлбөрийн төслийг боловсруулсан.

Амьдрал баян учраас хуультай уялдуулан гаргасан дүрэм, журмуудыг боловсронгуй болгох, шинэ утга агуулгаар баяжуулах санал дүгнэлт гаргаад байна.

Эрх зүйн орчин ч илүү сайжирч, эдийн засгийн агуулга нь, санхүүгийн баталгаа нь улам сайжрах тийшээ явна гэж бодож байна.

Тухайлбал, төрийн албаны шинэтгэлийн эдийн засгийн баталгааг хангах чиглэлээр Дэлхийн банктэй хамтран судалгааны ажил эхлүүлээд байна.

Ижил ажил, ижил албан тушаал эрхэлж буй хүн ижил цалин хөлстэй байх, гүйцэтгэл, ажлын чанар, үр өгөөжид нь тохирсон цалин хөлс олгодог байх жишиг тогтоох чиглэл рүү ажиллаж байна.

Төрийн албаны ангилал, зэрэглэлийн асуудлыг энд мөн давхар хөндөж, судалгаа шинжилгээний үндсэн дээр санал дүгнэлт гаргана.

Нийгэмд гарч буй сөрөг үзэгдэл, тохиолдож буй сорилт бэрхшээлийг гарц гаргалгаа олох шаардлага, боломж хэмээн үзэж ажиллаж ирлээ.

“Хагархай цонхны онол” гэж байдгийг Та бүхэн мэднэ байх. Нэг цонх хагархай байгаад байвал бусад нь хагарах эрсдэлд амархан орчихдог.

Үүнтэй адил төрийн албаны шинэтгэлд шаардлагатай, зайлшгүй зүйлийг нь орхигдуулахгүй талаас нь байнга анхаарч, “хагархай, цоорхой” үүсгэхгүйгээр явахыг хичээж байна. Тийм байлгах итгэл үнэмшил Төрийн албаны зөвлөлд бас байна.

Үүнд системийн анализ хийж, нийгэм, эдийн засаг, улс төрийн үйл явцад аналитик сэтгэлгээгээр хандан ажиллахыг үйл ажиллагаандаа мөрдлөг болгон ажиллаж байна.

9. Дүгнэлт

Хийсэн, хийж буй ажлын дүнд харьцангуй тогтвортой, мэргэшсэн төрийн алба бий болох үйл явц эргэлт буцалтгүй явж байгаа гэж бодож байна.

Иргэд рүү чиглэсэн, иргэдэд үйлчилдэг, иргэн төвтэй ийм төрийн алба бий болох хандлага бий болсон.

“Зөв хүнийг зөв ажилд нь томилоод явахад зөв үр дүн гарна” гэсэн зарчмыг баримталж байна.

Төрийн албаны тогтвортой байх зарчим хариуцсан ажлаа үр дүнтэй хийж байгаа хүнд үйлчлэх, хариуцлага алдаж, ажил үүргээ хангалтгүй гүйцэтгэсэн хүнд үл үйлчлэх тэнцвэрт байдлын ойлголт төлөвшиж байна.

Төрийн албаны зөвлөл ТББХ-нд жилд ганцхан удаа тайлан тавьдаг биш байа гэж бодож байна.

Тодорхой хугацааны давтамжтайгаар, болж өгвөл улирал тутамд холбогдох асуудлаар, тухайлбал хүний нөөцийн аудитын сэдвээр ТББХ-д тогтмол мэдээлэл өгдөг болох нь зүйтэй гэж үзэж байгаа.


Төрийн албаны зөвлөл хамтын удирдлагын зарчмыг сонгодог утгаар нь хэрэгжүүлэхийг эрмэлзэж, гишүүд, Ажлын албаны албан хаагчид ачаалал ихтэй, амралт багатай ажиллаж ирсэн товч танилцуулгыг Та бүхэнд толилууллаа.

Төрийн албаны зөвлөлийн гишүүд эрхэлсэн чиг үүргийнхээ хүрээнд дэлгэрэнгүй, нарийвчилсан танилцуулга хийхэд бэлэн байгаа.

Бодлогын аливаа шинэтгэл бодит ажил хэрэг болоход нийгэм, сэтгэл зүй, цаг хугацааны олон хүчин зүйл шаардагдах нь зүйн хэрэг.

Өнгөрсөн 2 жил хагасын хугацааны ажлын үр дүнд төрийн албаны шинэтгэлийн гарааны болон шилжилтийн үйл явц дууслаа. Энэ хүрээнд хийх ажлаа хийсэн гэж үзэж байна. Бид ийм итгэл үнэмшилтэй байгаа.

Шилжилт дуусаж, шинэтгэлийн бодит үр дүн гарч эхэлсэн. Цаашид шинэтгэлийг гүнзгийрүүлэн ажиллах болно.



---o0o---



НЭГДСЭН ҮНДЭСНИЙ БАЙГУУЛЛАГЫН ТӨРИЙН АЛБАНЫ ӨДӨР

“Ирээдүйн төрийн албыг цогцлоох нь”

Төрийн албаны зөвлөлийн дарга Б.Баатарзориг

2021.06.23

***НҮБ-ын төрийн албаны өдөрт
зориулсан уулзалтыг нээж хэлсэн үг***

Та бүхэнд Нэгдсэн Үндэстний Байгууллагын төрийн албаны өдрийн мэнд дэвшүүлж буйг хүлээн авна уу.

Бидний урилгыг хүлээн авч өнөөдрийн уулзалтад оролцож буй НҮБ-ын Монгол Улс дахь Суурин зохицуулагч ноён Тапан Мишра, НҮБ-ын Хөгжлийн хөтөлбөрийн Суурин төлөөлөгч хатагтай Илэйн Конкиевич, ОХУ, БНХАУ, Япон, БНСУ, БНТУ, БНКУ-ын ЭСЯ, Жайка, Койка, Австралийн тэтгэлэгт хөтөлбөрийн төлөөлөлд чин сэтгэлийн гүн талархал илэрхийлье.

1. НҮБ-ын төрийн албаны өдөр



НҮБ-ын Ерөнхий Ассамблейн тогтоолоор 6 дугаар сарын 23-ныг “Төрийн албаны өдөр” болгон тэмдэглэж байхаар 2003 онд шийдвэрлэсэн. Энэ өдөр хөгжлийн үйл явцад оруулах төрийн албаны хувь нэмрийг онцгойлон

авч үзсэн арга хэмжээнүүдийг зохион байгуулж байхыг гишүүн орнууддаа уриалсан байдаг.

Тэгэхлээр энэ бол баяр наадам биш. Харин тулгарч байгаа сорилт бэрхшээлийг тодорхойлдог өдөр. Асуудал шийдвэрлэх арга замыг олохын төлөө оюун ухаанаа уралдуулж, шинэ санаа, шийдэл гарц ярьдаг өдөр.

Шинэчлэн найруулсан Төрийн албаны тухай хуулиар Монгол Улсад эхлүүлсэн төрийн албаны шинэтгэлийн гарааны жил 2019 оноос энэ өдрийг бид эх орондоо тэмдэглэж эхэлсэн.

Өнгөрсөн жил цар тахлын тэргүүн фронтод ажиллаж байгаа төрийн албан хаагчдынхаа ажил үйлсийг ойлгон, сэтгэл санааны нэгдлээ илэрхийлсэн.

НҮБ-ын төрийн албаны хүндтэй шагналд Монгол Улсын төрийн байгууллагыг нэр дэвшүүлэх, НҮБ-ын төрийн албаны форумд төлөөллөө оролцуулах зэргээр НҮБ-ын төрийн албаны чиглэлээр явуулах интеграцид идэвхтэй хамрагдаж байна.ч

Гадаад орнуудын төрийн албаны сайн туршлага, шилдэг менежментийг судлах, өөрийн орны онцлогт тохируулан нутагшуулах чиглэлээр идэвхийлэн ажиллаж байна.

Онцолж нэг жишээ хэлье. Канад Улс, канад иргэдийн сайн санааны дэмжлэг, хөрөнгө оруулалтаар НҮБ-ын Хөгжлийн хөтөлбөртэй хамтран хэрэгжүүлж буй “Монгол Улсад мэргэжлийн, иргэн төвтэй төрийн албыг төлөвшүүлэх нь” төсөл, “Мерит” төслийн оролцоог өнөөдөр онцлон тэмдэглэхийг хүсэж байна.

Энэ тэмдэглэлт өдрийг тохиолдуулан Монгол Улсын төрийн албаны шинэтгэлийг талархан дэмжиж, хамтран ажиллаж байгаа гадаад орны төр, засгийн газар, олон улсын байгууллагуудад талархал илэрхийлье.

2. Төрийн хүмүүн капитал

Хөгжил дэвшилд хэрэгтэй хамгийн чухал **эрхэм баялаг** нь хүн. Хүний эрүүл мэнд, боловсрол, мэдлэг чадвар, дадлага туршлагыг багтаасан, хөгжлийн хөдөлгөгч гол хүчин зүйл нь **хүмүүн капитал**.

Хүмүүн капиталыг нийгмийн харилцаанд оролцогч бүх тал хүлээн зөвшөөрч, хүний хөгжилд гол анхаарлаа төвлөрүүлдэг тийм л цаг үе, нийгэмд бид бүгдээрээ амьдарч, бас ажиллаж байгаа. Иймээс л төрийн албан хаагчдаа сурган чадавхжуулах асуудалд онцгой ач холбогдол өгч байгаа юм.

Төрийн албаны нөөцийг шаардлага хангасан хүнээр бүрдүүлнэ гэдэг төр **хүмүүн капиталынхаа суурийг** тавьж, “Хүний нөөцийн банк”-аа бүтээж байгаа хэрэг. Энэ “банк” байнга чанаржин баяжиж, үр дүнд нь төрийн ажил орчин цагийн шаардлагад нийцэж, улс орны хөгжлийг түүчээлдэг байх учиртай.

Хувийн хэвшлийнхэн маань ч төрийн албаны нөөцөөс сонголт хийдэг, ажилд урьдаг болж байна. Тиймээс энэ нөөцийг зөвхөн төрийн албаны төдийгүй **“улс орны хөгжлийн нөөц”** гэж би боддог.

Гадаадын нэр хүнд бүхий их, дээд сургуулиудад урт, богино хугацаагаар суралцуулж тэдэндээ шинэ мэдлэг, ур чадвар эзэмшүүлэх бодлого баримтлан ажиллаж байна.

Гадаад орны Засгийн газрын болон олон улсын байгууллагын тэтгэлэгт хөтөлбөрт зөвхөн сүүлийн 4 жилд 1195 төрийн албан хаагч хамрагдсаны 38 хувь буюу 455 албан хаагч сургуулиа төгсөж Монгол Улсынхаа хөгжилд хувь нэмэр оруулан ажиллаж байна.

Төрийн албаны зөвлөлийн нийт албан хаагчдын 12 хувь гадаадын их, дээд сургуульд тэтгэлгээр суралцаж эзэмшсэн мэдлэг, чадвараа төрийн албаны шинэтгэлд зориулан ажиллаж байна.

Найрсаг харилцаа, хамтын ажиллагаатай улс орнуудаас Монгол Улсын төрийн албаны хүний нөөцийн чадавхыг бэхжүүлэхэд оруулж буй хөрөнгө оруулалтын үр өгөөжийг дээшлүүлэх, хамтын ажиллагаагаа улам өргөжүүлэн хөгжүүлэх зорилгоор НҮБ-ын төрийн албаны өдрийг тохиолдуулан өнөөдрийг уулзалтыг зохион байгуулж байгаа нь ийм учиртай.

3. Хүний нөөцийг чадавхжуулах бодлого

Хамтын ажиллагаатай улс орнуудын татвар төлөгчдийн мөнгөөр суралцуулсан төрийн албан хаагчдынхаа мэдлэг, чадварыг эх орныхоо хөгжил, бүтээн байгуулалтад бүрэн дүүрэн ашиглахыг Төрийн албаны зөвлөл эрхэмлэж байна:

- “Алсын хараа-2050” Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлогод туссан эдийн засгийн тэргүүлэх чиглэлийн мэргэжлүүдээр төрийн албан хаагчдыг гадаадын тэтгэлэгт хөтөлбөрт түлхүү хамруулна;

- Гадаад орнуудын Элчин сайдын яам, тэтгэлэгт хөтөлбөрийн газруудтай хамтын ажиллагаагаа тогтмолжуулж, мэдээлэл солилцоог идэвхжүүлнэ;

- Тэтгэлгээр суралцаж төгссөн төрийн албан хаагчдыг албан тушаалд нь 100 хувь буцаан томилуулж, тэдний шинэ мэдлэг, ур чадварыг ашиглах нөхцөлийг бүрдүүлнэ. Үр дүн гаргасан чадварлаг албан хаагчдыг шатлан дэвшүүлж, бодлого тодорхойлох, шийдвэр гаргах түвшинд ажиллуулна;

- Гадаад орны Засгийн газар, олон улсын байгууллагаас зарласан тэтгэлгийн мэдээллийг шуурхай, хүртээмжтэй түгээж, нөөц боломж, тэтгэлгийг бүрэн дүүрэн ашиглана;

- Төрийн байгууллагуудад шинэ санаа, шийдэл, гаргалгааны “Идеа банк” бий болгоё гэж би уриалж байгаа. Өөрийнхөө ажилд, байгууллагынхаа ажилд, салбар, улс орны хэмжээнд гарч буй асуудлыг шийдэх инновацлаг санаачилгуудыг бид тууштай дэмжинэ.

- Оюун ухааны бяд суусан оюунлаг, шинэлэг сэтгэлгээтэй төрийн албан хаагчдаас маань “Инновацийн мастерууд” (Иновэйшн чемпионууд) олноороо төрөн гараасай гэж бодож байна. Үүнийг ажлын үр дүн, гүйцэтгэлийг нь үнэлэх шалгуур үзүүлэлтийн нэг гол хэсэг болгохыг зорино.

- Гадаадад суралцагчдын төгссөн сургууль, улс орнуудаараа нэрлэсэн сүлжээ олон бий. Мэдлэг, мэдээллээ хуваалцах, сурч эзэмшсэнээ түгээн дэлгэрүүлэх нэгдсэн сүлжээ, сүлжээнүүдийн сүлжээг цаашид бий болгоно.

4. Гадаад суралцаж төгсөгчид:

Төрийн албаны ур чадварын хүрээ, цогц чадамжийн асуудал хүний нөөцийн менежментэд онцгойлон орж ирж байна. Та бүхнийг олон олон чадамж, ур чадварын “цуглуулга” гэж би боддог.

Төрийн албаны шинэтгэлийг манлайлан ажиллахыг Та бүхнээс хүсэж байна. Тийм хүлээлт нийгэмд ч маш өндөр байгааг дор бүрнээ мэдэрч байгаа гэдэгт эргэлзэхгүй байна.

Дотоод, гадаадад төгссөн хүмүүсийн ур чадвар, ажлын бүтээмж, гүйцэтгэлээр харьцуулсан судалгаа хийдэг механизм бий болгоход ч болохгүй гэх зүйлгүй.

Та бүхнийг сонгон шалгаруулж явуулдаг шигээ эргэн ирэхэд нь ажлын байраар баталгаатай хангахын зэрэгцээ ажлын үр дүн “нэхэх” чиг хандлага руу бид тууштай явах болно.

Та бид гадаад орон, олон улсын байгууллагын тэтгэлгээр сурч мэргэшиж байна гэдэг тухайн орны жирийн иргэдийн цалингаасаа суутгуулж байгаа, бизнесээсээ төлж байгаа татварын мөнгө гэдгийг бүгдээрээ ойлгож байгаа.

Сайн санааны энэ их хөрөнгө оруулалтын ширхэг цент бүр эцсийн дүндээ улс орны маань хөгжил дэвшил, хүн ардын минь сайн сайхны төлөө зарцуулагдаж байгаа гэдгийг байнга санаж явах хэрэгтэй шүү.

Ингэж бодож чадаж гэмээнэ үүрэг хариуцлагаа илүү ухамсарлана, үүрэгт ажилдаа илүү үр дүн гаргана. Үр дүнд нь Таны ажил үйлс өөдлөн дэвшиж, түмний хэрэг бүтэж явдаг учиртай. Том зургаараа Монгол төр, Монгол Улс хожно, бас хөгжинө.

Хүн төрөлхтний мэдлэг оюуны дээжээс хүртэж, сурч мэдсэнээ эх орныхоо хөгжил дэвшилд зориулж ирсэн олон сайхан жишээ бидэнд бий. Өнгөрсөн зууны эхээр Европт боловсорсон Д.Нацагдорж, Д.Намдаг, Н.Наваан-Юндэн, О.Намнандорж тэргүүтэй орчин үеийн сэхээтнүүдээс улбаалсан олон арван мянган хүнийг энд дурдаж болно.

Шинэ зуун дахь тэдний үргэлжлэл бол Та нар.

Та нар бол их зохиолчийн маань шүлэглэсэнчлэн “Хээрийн галуу нисэн үл хүрэх газраас...” эрдэм өвөрлөн ирсэн, бас ирж буй хүмүүс.

Та бүхэн бол байнга хувьсан өөрчлөгдөж буй VUCA ертөнц дэх нийгэм, эдийн засгийн нэн сонирхолтой цаг үед өөрийн мэдлэг, боловсрол, оюун ухаанаа иргэд, олон түмнийхээ төлөө зориулах хүмүүс.

Хүн ам, демографийн бүтэц ч өөр болж байна.

Энэ оны төрийн албаны ерөнхий шалгалтад шинэ үеийнхний шинэ түрлэг орж ирсэн. 13 мянга гаруй хүн бүртгүүлсний 50 гаруй (52.4) хувь нь 30 хүртэл насныхан буюу **Z үеийнхэн** байна.

Дижитал шилжилтийн орчинд хиймэл оюун ухаантай хүч хавсран ажиллах хүмүүс бол Та бүхэн.

Улс орны хөгжлийн ирэх 30 жилийг нарийвчлан тодорхойлсон “Алсын хараа-2050” түүхэн баримт бичгийг гардан хэрэгжүүлэх шинэ үеийн төрийн албан хаагчид бол Та бүхэн.

Та нар бол “e-Mongolia” хэрэгжиж эхэлсэн, аж үйлдвэрийн (технологийн) 4 дүгээр хувьсгалын үе дэх цахим шилжилтийн төрд ажиллах, бас ажиллаж буй хүмүүс.

Та бүхэнд Монгол төрийн эрхэм үйлсэд чин шударгуу зүтгэхийн сайны ерөөл өргөө.

“Ирээдүйн төрийн албыг цогцлоох нь” уриа дор өнөөдөр тэмдэглэж буй НҮБ-ын төрийн албаны өдрийн мэндийг Та бүхэнд дахин дэвшүүлж, монгол төрийн хүний нөөцийн чадавхыг бэхжүүлэх хамтын ажиллагаанд амжилт хүсье.

--oOo--



“Анхаарч сонсъё, анзаарч өөрчилъё” сошиал медиа нөлөөллийн аяны нээлт дээр хэлсэн үг

2021.06.17

Асуултаар яриагаа эхэлье. Дор бүрнээ тунгаагаарай.

Найз нөхөд чинь буяны сайн үйлсэд хандив өгсөн болохоор Та ч мөн адил хандив өгч байв уу? Эсвэл таны дуртай “од” сурталчилдаг болохоор бараа бүтээгдэхүүн худалдаж авдаг уу?

Та бид нийгмийн гишүүнийхээ хувьд хэзээ нэгэн цагт, ямар нэг нөхцөлд бусад хүмүүсийн нөлөөнд ямар нэг хэмжээгээр “автдаг” нь бодит үнэн. Үүнийг “нөлөөллийн сэтгэл зүй” гэж болох. Ийм маркетинг, аян байнга л явагдаж байдаг.

Тэгэхлээр нөлөөлөл үзүүлэх үзэгдэл шинэ зүйл биш ээ. Бүтээгдэхүүн, үйлчилгээ, чиг хандлагыг сурталчлах, тодорхойлох зорилгоор нөлөө бүхий хүмүүсийн үг үйлдлийг ашиглах арга олон арван жил хэрэгжиж ирсэн.

Харин одоо өөрчлөгдсөн зүйл гэвэл түүнийг хэрэгжүүлэх арга хэлбэр, нөлөөллийн төрөл олон янз болж. Түүний нэг нь бараг хүн бүрийн хэрэглэх болсон СОШИАЛ МЕДИА нөлөөлөл. Хүн бүр шахуу “сэтгүүлч” болсон цаг үеийн онцлог.

Сошиал медиа орчин үеийн нийгэмд асар их нөлөө үзүүлж буй нь маш тодорхой. Урд өмнө дэлхийн нийтийг хамарч, гайхалтай хурдтай өсч буй ийм үзэгдэл ховор гэдэг.

2017 онд 2.5 тэрбум сошиал медиа хэрэглэгчид байсан бол 2021 онд гэхэд 3 тэрбум гаруй болж өссөн нэг статистик харсан.

Ийм л том орон зайд нийгэмд, иргэдэд хүргэх ёстой, хүлээлт үүсгэж буй тэр мессежийг бид хүргэхийг зорьж байгаа.

Тэр мессеж бол “**АНХААРЧ СОНСЪЁ, АНЗААРЧ ӨӨРЧИЛЪЕ**”.

Бидэнд анхаарал хандуулах, анхаарвал зохих маш олон зүйл байгаа. Бид тэдгээрийгээ эрэмбэлэх ёстой.

Эрэмбийн дээр байгаа зүйлээ анзаарч чадвал өөрчлөх, шинэчлэх үйл, үйлдэл хийх ёстой. Энэ л үүднээс энэ аяныг эхлүүлж байгаа хэрэг.

---o0o---



ТӨРИЙН АЛБАНЫ ШИНЭТГЭЛ: САНГИЙН ЯАМ

Сангийн яаманд хийсэн уулзалт дээр хэлсэн үг

2021.06.15

Төрийн албаны шинэтгэлийн нэг шинэ үе шат 2019 оноос эхэлснийг Та бид бүгдээрээ мэдэж байгаа. Энэ бол улсын хэмжээнд төрийн албаны институцэд нэвт үйлчилж буй өргөн хүрээний шинэтгэл.

Бүх нийт заавал дагаж мөрдөхөөр төрөөс батлан гаргаж, эрх зүйн хэм хэмжээ тогтоосон дээд хүчин чадал бүхий баримт бичгээр **хуульчилсан шинэтгэл**.

Хуульчилсан шинэтгэлийг “Алсын хараа-2050” урт хугацааны бодлогын баримт бичгээр **баталгаажуулсан**. Одоо энэ бодлогын эхний 10 жилд **стратегийн**

ямар **төлөвлөлт** хийж хэрэгжүүлэх асуудлыг төслийн хэмжээнд боловсруулсан. (Төрийн албаны зөвлөлийн хуралдаанаар хэлэлцсэн).

Шинэтгэл гэдэг буруу зөрүү, болж бүтэхгүй байгаа (авлигад автсан гэх мэт), бас сэтгэл ханамжгүй байгаа зүйлийг **засаж сайжруулах, төгөлдөржүүлэхийг** хэлдэг суурь ойлголт бий.

Төрийн албаны шинэтгэл маань ямар нэг зүйлийг хэвэнд хийж, тэнийлгэж, муруйлгаж өөр хэлбэр дүрстэй болгох **дүрс, хэлбэрийн төдий шинэтгэл биш**. Үүнийг иргэд ч, төрийн албан хаагчид ч ойлгосон гэж болно. Нийгмийн хүлээлт, хүсэмжлэл, шаардлага ч бүгдэд мэдэгдэж, мэдрэгдэж байгаа.

Аливаа **шинэтгэлийн хувь заяа, үр дүн** олон тулгуур, олон хүчин зүйлээс хамааран **амжилтад хүрэх эсэх нь** шийдэгддэг.

Энэ маань **уламжлалт нийгэмд, урсгал байдлаар** явагдаж байгаа шинэтгэл биш. Харин нийгмийн **ВУКА орчинд хийгдэж байгаа шинэтгэл**.

Шинэтгэлийн энэ олон хүчин зүйлийн маш чухал бүрэлдэхүүн хэсэг нь санхүү, төсөв, эдийн засгийн баталгаа.

Төрийн албаны төв байгууллага үйл ажиллагаагаа 25 жил гаруй явуулж ирж. Харин шинэтгэлийн энэ шатанд ТАЗ-ийн үйл ажиллагааны хамрах хүрээ (цараа), хариуцах ажил, хүлээх үүрэг эрс нэмэгдсэн.

Ажлын энэ онцлогт тохирсон бүтэц, орон тоог УИХ баталж өгсөн. Харин бодит ажил хэрэг болох учиртай төсөв, санхүүгийн төлөвлөлтийг хянан баталгаажуулахад **Сангийн яам маш сайн ажилласан**. Үүнийг төрийн албаны шинэтгэлд Сангийн яамны оруулж буй гэж **бодит хувь нэмэр** хэмээн үзэж болно.

Шинэтгэл эдийн засагжиж, эдийн засгийн утга агуулгаар баяжиж байж үр дүнд хүрэх нь маш тодорхой. Та бидний хийсэн, одоо хэрэгжүүлж буй дараагийн том алхам бол **төрийн албан хаагчийн цалин хөлсний системийг хүний нөөцийн удирдлага, мэдээллийн сантай холбож чадсан** амжилт.

Тогтоосон цалин, хуулийн зөрчилгүй томилгоо жингийн хоёр таваг дээр тэнцэж байх нөхцөл төрийн албанд бүрдэж буй нь **амжилт** гэхээс өөрөөр хэлэх аргагүй.

Энэ бол **их өгөгдөл** дээр амжилттай ажиллах, өгөгдөл мэдээллээ шинэчлэн боловсронгуй болгох, өгөгдөл шуурхай солилцох, өгөгдлийн санг эргэлтэд оруулах чиглэлээр хийсэн томоохон ажил.

Төсвөөс цалинждаг байгууллага, төрийн болон орон нутгийн өмчит үйлдвэрийн газар, хуулийн этгээд, тэдгээрийн албан хаагч, ажилтнуудын мэдээллийг төр нэгтгэн гаргасан. Та бүхэнд, мөн Засгийн газрын ХЭГ-т хүргүүлсэн.

Дэлхийн банкнаас төрийн албаны шинэтгэлийн гарааны нөхцөл байдалд судалгаа хийсэн. Судалгааны үр дүнг хэлэлцэх явцад төрийн албаны цалин хөлс, ангилал, зэрэглэлийн суурь судалгааг хийх тохиролцоонд хүрсэн.

Зөв тоонд үндэслэсэн зөв мэдээлэл дээр бодлогын хувилбарууд явагдах учиртай.


Гэх мэтчилэн ажлын сайн эхлэл, хамтын ажиллагааны үр дүн багагүй байна.

Эхлүүлсэн ажлаа улам эрчимжүүлэх, шийдсэн асуудлаа улам боловсронгуй болгоод явахад үр дүн гарч байна, үр дүнгийн илүү хүлээлт ч цаашид гарах нь.

Төрийн албаны шинэтгэл салбар бүрд тэгш хэрэгжээсэй гэж, хамтын ажиллагаа, хамрах хүрээний сул орон зай битгий үлдээсэй гэж түншлэл, ойлголцол, төлөвлөлтийн ийм уулзалтуудыг яамдад хийж байгаа юм.

Харах зүгээ нэг болгож, харагдах өнцгөө илүү өргөн болгох ийм уулзалтыг хийж байгаа хэрэг. Үр дүн нь ч эхнээсээ гарч байна.

--oOo--



"Төрийн албаны хүний нөөцийн удирдлагад цогц чадамжийн хүрээг нэвтрүүлэх нь" сургалтыг нээж хэлсэн үг

2021.06.09

1. Шинэтгэлийн орчин

Хаана өөрчлөлт шинэтгэл явагдаж байна, тэр газар ахиц дэвшил, ололт амжилт гардаг цаг үед бүгдээрээ ажиллаж амьдарч байгааг Та бүхэн сайн мэднэ.

Төрийн албаны зөвлөлийн дарга Б.Баатарзоригийн хэлсэн үг, илтгэлээс...

Шинэтгэл явагдахгүй байгаа аль ч газар, салбар, улс оронд өнөөдөр маш сайн гэгдэж байгаа зүйл маргааш биш юмаа гэхэд нөгөөдөр нь болж бүтэхгүй болох, бүр хөгжил дэвшлээс хойш чангаах жишээний.

Нийгэм, цаг үеийнхээ шаардлагад нийцэж чадахгүй, хөл нийлүүлж алхаж чадахгүй байгаа хүн ч тэр, салбар ч тэр нэг бол инээдтэй, нөгөө бол эмгэнэлтэй байдалд ордгийг олон улс орны амьдрал нотлох.

Манай улсад явагдаж буй төрийн албаны шинэтгэлийн үйл явц Төрийн албаны тухай хуулиар **хуульчлагдсан** онцлогтой.

Хэн нэгний хүсэл зоригоор биш, нийгмийн шаардлага, иргэдийн хүсэмжлэл, улс төрийн дэмжлэгээр энэ шинэтгэл явагдаж байгаа.

Энэ шинэтгэл “Алсын хараа-2050” урт хугацааны хөгжлийн бодлогоор **баталгаажсан**.

Арван жилийн гурван мөчлөгөөр хэрэгжүүлэх энэ бодлогыг **зорилтот хөтөлбөр** болгон нарийвчлан тодорхойлж, хийж хэрэгжүүлэх үйл ажиллагааны **стратегийн төлөвлөлтийг** төслийн хэмжээнд тодорхойлоод байна.

2.Төрийн албаны зарчим-шинэтгэлийг хэрэгжүүлэх тулгуур багана

Хуульчилсан, баталгажуулсан төрийн бодлогыг хэрэгжүүлэх тулгуур баганууд нь төрийн албаны зарчмууд.

Зарчмаа баримталж мөрдөнө гэдэг замаа заасан луужинтай явж байна гэсэн үг. Төөрөхгүй гэсэн үг. Төөрөхгүй явж чадвал зорьсон газартаа хүрэх нь тодорхой.

Тэр зорьсон газарт хүргэх луужин буюу **төрийн албаны зарчмууд** маань:

- ард түмэнд үйлчлэх төрийн алба;
- мэргэшсэн, тогтвортой төрийн алба;
- улс төрийн нам, эвслийн үйл ажиллагаанаас ангид төрийн алба;
- иргэдийг төрийн алба хаах адил тэгш боломжоор хангасан төрийн алба;
- чадахуйн болон шатлан дэвших зарчмыг баримтлан томилогдсон төрийн жинхэнэ албан хаагч;
- ил тод, ашиг сонирхлын зөрчлөөс ангид төрийн алба;
- захирах, захирагдах ёсыг баримталсан төрийн алба.

Энэ тулгуур зарчмуудыг харахаар төрийн албаны мөн чанар маш ойлгомжтой. **Чадварлаг төрийн албан хаагч** энэ бүхний ард байхгүйгээр зарчим хэрэгжих боломжгүй нь харагдаж байгаа биз.

“Нөхцөл байдлыг өөрчлөх боломжгүй бол өөрийгөө өөрчлөн сорих цаг болж гэдгийг ойлгоорой” гэсэн утгатай үг бий. (Viktor Emil Frankl-Австрийн философич, сэтгэл зүйч)

Үнэн үг гэж би боддог. Төрийн албан хаагчид өөрсдөө шинэтгэлийн орчин нөхцөлд дасан зохицохуйцаар өөрчлөгдөх, хөгжихөөс өөр гарц байхгүй нь.

3. Чадварлаг төрийн албан хаагч-чанартай төрийн үйлчилгээ

Төрийн алба гэдэг маш товчоор хэлбэл төрийн зорилт, чиг үүргийг хэрэгжүүлэх, төрийн бодлого боловсруулах, төрийн үйлчилгээг нийтэд хүргэх үйл ажиллагаа, бүтэц, зохион байгуулалт.

Тэгэхээр төрийн албаны шинэтгэлийн эцсийн зорилго нь иргэдэд хүргэх төрийн үйлчилгээ чанартай байх явдал. Мэргэжлийн, иргэн төвтэй төрийн алба энэ зорилгыг биелүүлж чадна гэдэг нь тодорхой. Төрийн албаны төлөвшил, хөгжил нь олон улсад үнэлэгдэж буй улс орнуудын туршлага үүнийг баталдаг.

Мерит, шатлан дэвшүүлэх зарчим энэ бүхний хамгийн таатай хөрс суурь болдог байна.

Та бид хамтран улс орондоо хэрэгжүүлж буй төрийн албаны шинэтгэл энэ голдирлоор явж байгаа. Тиймээс энэ шинэтгэл амжилтад хүрнэ гэдэгт би эргэлздэггүй. Шинэтгэлийн үр дүн гарна гэдэгт итгэлтэй байдаг.

4. Төрийн албаны шинэтгэлийн хүрээ

Төрийн албаны шинэтгэл нь баг, хорооноос эхлүүлээд төрийн байгууллагуудын бүхий л шатанд хэрэгжиж байж үр дүн нь гарна.

Шинэтгэлийн тойргийн гадна үлдэх төрийн байгууллага, албан хаагч байх ойлголт үгүй.

Энэ сургалтад Улсын Их Хуралд ажлаа шууд хариуцан тайлагнадаг байгууллагуудын төрийн захиргаа, хүний нөөцийн асуудал хариуцсан нэгжийн удирдлага, хүний нөөцийн мэргэжилтнүүдийг оролцуулж байгаа нь тохиолдлын хэрэг биш.

Хуулиар эхлүүлсэн шинэтгэлийг хууль тогтоох дээд байгууллагын харьяа байгууллагууд илүү манлайлж, илүү эрчимтэй, илүү үр дүнтэй хэрэгжүүлэх учиртай болохоор Та бүхнийг ийнхүү урьсан хэрэг.

Шинэ зүйлийг хийхийнхээ өмнө зарим хүмүүс тээнэгэлздэг, бусдыгаа яахыг нь ажигладаг, бас тодорхой хүнийг дагадаг.

Яг л үүн шиг төрийн албаны хууль тогтоомж УИХ-аас удирдлага нь томилогддог байгууллагууд дээр хэрхэн хэрэгжиж байна, зөрчил доголдол гарч байна уу, үгүй юу гэдгийг төрийн олон байгууллага, албан хаагчид анхааралтай ажиглан харж байгаа гэдгийг би мэдэрдэг.

5. Шинэтгэлийн цөм-төрийн албан хаагч

Шинэтгэл төрийн албаны эд эс бүхэнд нэг дүрэм, нэг ойлголтоор хэрэгжихгүй бол үр дүнгийн талаар ярих, төсөөлөх боломжгүй. Олон улсын туршлага ч нотолдог.

Төрийн албан хаагчид маань хүн л болсон хойно өндөг шиг өөгүй төгс хүмүүс биш. Гэхдээ хуулийн шаардлагыг хүлээн зөвшөөрч, эх орон, иргэдийнхээ төлөө ажиллах тангараг өргөсөн хүмүүс. Товчоор хэлбэл, төрийн албаны болзол, нөхцөлийг хүлээн зөвшөөрсөн гэсэн үг.

Хувь хүний хүсэл зоригоор биш хууль, дүрэм, стандартын хүрээнд ажиллахаар шийдсэн төрийн албан хаагчдад шаардагдах зүйл маш олон, хэрэгтэй зүйл ч их бий.

Тэдгээр шаардлагатай, хэрэгтэй зүйлсийн дотроос цогц чадамжийг сэдвийг өнөөдөр онцлон ярих гэж байна. Энэ чадамжийг нэвтрүүлснээр бий болох үр нөлөө, ач холбогдлыг таниулахыг зорьж байна. Мерит зарчим, ёс зүйг үйл ажиллагаанд цогцоор хэрэгжүүлэх талаар мэдлэг, мэдээлэл олгохыг зорьж байна.

6. Уламжлал ба орчин үе

Монголын төрт ёсны түүхэнд мэдлэг чадвар, ур ухааныг эрхэмлэсэн жишээ олон бий.

Нэлээд түрүү үеийн түүхээ сөхвөл “Хаан төрийн түшмэл эрдэнэ” хэмээх ойлголтын ард төрийн албанд ямар олон шалгуур тавигдаж байсныг бүгд санаж байгаа.

“Цувж явсан барнаас цуглаж суусан шаазгай дээр” гэж багаар ажиллах, харилцан бие биеэ нөхөх өнөөгийн ойлголтыг бэлээхэн хэлчихсэн хэрэг.

Тэгэхлээр бид өнөөдөр уламжлалгүй, ор хоосон газар шинээр үүсгэх гэж байгаа ойлголтыг ярьж байгаа хэрэг биш ээ.

Харин энэ ойлголтыг системчилсэн, төлөвшсөн, онолын шаардлага, шалгуурыг шингээсэн тэр талаас нь орчин үеийн менежментийн ухааны үүднээс ярьж байгаа хэрэг.

“Цогц чадамж” хэмээх өнөөдрийн гол сэдвийг өв тэгш мэдлэг, ур чадвар гэж ойлгож болох юм.

Удирдах ажилтны манлайлал ЧАДАМЖ-ийн хүрээнд ямар их нөлөөлөл, ач холбогдолтойг бид онцгойлон авч үзэхээс аргагүй.

Ажлын гүйцэтгэл, урамшууллыг хавтгайруулахгүй байх, ажилтнууддаа мотивацжуулах, шагнал болон шаардлага шахалтын тэнцвэрийг хэрхэн олох гээд тан тунг нь тааруулах учиртай, ийм чадамжтай байх хүмүүс бол та бүхэн.

Зарим хүн бодож боловсруулахдаа гойд байдаг бол зарим нь хэрэгжүүлэхдээ, дүн шинжилгээ хийхдээ илүү байдаг. Миний удирдлагад байдаг хүнд ийм тохиолдол гарч байсан (жишээ дурдах)

Буруу сонголт хийх, зөв ажлын байранд зөв хүнээ ажиллуулж чадаагүйгээс зөв үр дүн гаргахгүй байдаг явдал бидэнд байдаг шүү.

Сагсан бөмбөгийн нэг багт тоглож буй довтлогч нь хамгаалаад, хамгаалагч нь гоол хийх гэж оролдоод байгаатай л адил.

Тэгэхлээр өнөөдрийн сэдэв албан тушаалын тодорхойлолтыг боловсронгуй болгоход хэрэгтэй төдийгүй тухайн албан тушаалд ямар хүнийг шалгаруулж, сонгож авах вэ гэдэг асуултад хариу өгөх ач холбогдолтой.

Төрийн албаны зөвлөл ахмадууд, төр нийгмийн зүтгэлтнүүдийг урьж сургаал үгийг нь сонсдог уламжлал тогтоогоод байгаа юм.

Х.Шаандар гэж төрийн албаны бүх шатанд ажиллаж Төрийн захиргааны албаны зөвлөлийн (одоогийн Төрийн албаны зөвлөл) анхны гишүүн байсан сайхан буурал өнгөрсөн долоо хоногт лекц уншихдаа хэлсэн нэг санааг дурдъя.

Төрийн албан хаагч гэдэг бол:

Өөрийнхөө ажлыг **ТӨГС МЭДДЭГ**

Өрөөл бусад хамт ажиллагсадынхаа ажлыг **САЙН МЭДДЭГ**

Бусад салбар, байгууллагуудын ажлыг **МЭДДЭГ** хүн байх ёстой гэж.

7. Чадамжаас цогц чадамж руу

Ажлын үр ашиг, гүйцэтгэлийг сайжруулах, бодитоор харуулах шинж чанар, ур чадварын бүрдэл болсон “чадамж” гэх энэ ойлголт төрийн албаны шинэтгэлийн нэгэн бүрэлдэхүүн хэсэг сургалт, судалгааны ажлын нэг хэсэг болж бодлогын түвшинд хэрэгжиж явах болно.

Гүйцэтгэлийг сайжруулахад ашигладаг практик болон онолын мэдлэг, танин мэдэхүйн чадвар, зан байдал, үнэт зүйлсийн хослол болон хэрэглэгдэх болно.

Мөн тодорхой үүрэг гүйцэтгэх чадвар бүхий сайтар мэргэшсэн төрийн албан хаагчийн зайлшгүй эзэмшсэн байх, мөн тасралтгүй хөгжүүлж байх эрхэм чанар байх болно.

Системийн сэтгэлгээ, сэтгэл хөдлөл, зан үйл, нөлөөлөл, ойлголцол, хэлэлцээрийн чадвар зэргийг багтаасан менежментийн чадамж ялангуяа удирдах албан тушаалтнууд, хүний нөөцийн асуудал хариуцсан хүмүүст ямар их хэрэгтэйг бид өдөр тутмын үйл ажиллагаанаасаа олж хардаг гэж боддог.

Чадамж гэдэг харьцангуй төвөгтэй ч гэж болох өргөн цар хүрээтэй ойлголтын талаар эрдэмтэд судлаачид янз бүрийн цаг үед өөр өөр тодорхойлолт гаргаж ирсэн гэдэг.

Төрийн албан дахь энэ ойлголт монгол соёл, монгол хүний мөн чанар, арга барил, монголын нийгмийн сэтгэл зүйн онцлогт тохирсон байдлаар өвөрмөц, бас онцлог байдлаар томъёологдон нутагших үйл явцад энэ сургалт үр дүнгээ өгнө гэдэгт итгэж байна.

Өв тэгш мэдлэг, ур чадварыг эзэмшиж байж өнөөгийн шаардлагад нийцсэн төрийн албан хаагч бий болох тухай онцлог сэдвийг хөндсөн энэ удаагийн сургалтын үйл ажиллагаанд амжилт хүсье.

---o0o---



ХӨДӨЛМӨР, НИЙГМИЙН ХАМГААЛЛЫН ЯАМ



**Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яаманд хийсэн
уулзалт дээр хэлсэн үг**

2021.06.08

Төрийн албаны тухай хуулийн шинэчилсэн найруулга хэрэгжиж эхлээд хоёр жил хагасын хугацаа өнгөрлөө.

Энэ хугацаанд “Алсын хараа-2050” улс орны хөгжлийн урт хугацааны томоохон баримт бичгээс өгсүүлээд Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хууль, Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөр, Нийгэм, эдийн засгийг хөгжүүлэх үндсэн чиглэл зэрэг бодлого, төлөвлөлт, хэрэгжүүлэх үйл ажиллагааны томоохон баримт бичгүүд батлагдан гарсан.

Эдгээр бүх баримт бичгүүдэд төрийн албаны шинэтгэлийн суурь зарчмууд, тэдгээрийг хэрэгжүүлэх үйл ажиллагаа нарийвчлагдаж, баталгаажсан гэж болно.



Шинэтгэлийн бодлого, зорилт, хэрэгжүүлж буй үйл ажиллагааны талаар Та бүхэнд нуршин ярих хэрэггүй байх. Учир нь Салбар зөвлөл, яам, агентлагууд өдөр тутмын харилцаа холбоотой ажиллаж, мэдээлэл солилцон ажиллаж байгаа.

Төрийн албаны шинэтгэл нэгдсэн бодлого, зохион байгуулалтаар явагдаж байж үр дүнд хүрэх нь ойлгомжтой.

Шинэтгэлийн талаарх ойлголтын зөрүү төрийн институц, тэдгээрийг бүрдүүлж буй төрийн албан хаагчдад байхгүй гэж бодож байна.

Өргөн сэдэв, олон чиглэлээр судалгаа, хэрэгцээнд суурилсан сургалтууд тасралтгүй явагдлаа.

Ганц жишээ дурдахад 7:4:10-т төрийн бүх байгууллагуудын 19 мянга гаруй албан хаагч хагас жилийн хугацаанд хамрагдлаа.

Суурь баримт бичиг, дүрэм, журам бүгд гарсан, батлагдсан. Шинэтгэлийн бодлогыг хэрэгжүүлэх нарийвчилсан стратегийн төслийг ч бэлтгэж байна. Засгийн газартай хамтран төрийн албаны шинэтгэлийн замын зураглалыг томъёоллоо.

Яагаад ХНХЯ-аас танилцах уулзалтыг онцлон эхлэв?

Тохиолдлоор, эсвэл таамгаар сонгоогүй ээ.

1. Төрийн албаны шинэтгэлийн зорилтуудыг хэрэгжүүлэгч хөдөлгөгч хүч-engine буюу хөдөлгүүр нь төрийн албан хаагчид.

Төрийн албан хаагч гэдэг нэг талаасаа олон шаардлага, шалгуурыг хангасан, төр, иргэдийнхээ төлөө ажиллахаар санаа зориг шулуудсан иргэн.

Нөгөө талаас төрийн албан хаагч бол 3 сая гаруй иргэдийн маань л нэг хэсэг. Тэд нар гэр бүлийн түшиг тулгуур эхнэр, нөхөр, үр хүүхдүүдийнхээ аав ээж нь.

Тэгэхлээр төрийн албан хаагч-иргэдийн хөдөлмөр эрхлэлт, нийгмийн хамгааллын асуудал ямар түвшинд тавигдах вэ?

Иргэн төвтэй төрийн албыг төлөвшүүлэхэд “иргэн-төрийн албан хаагч”-ийн нийгмийн суурь эрхийн баталгаа хэрхэн хангагдах вэ?

Эдгээр асуудлууд төрийн албаны шинэтгэлийг амжилттай явуулахад гол гогцоо асуудлын нэг яах аргагүй мөн.

2. Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яам бол гүйцэтгэх засаглалын хүрээнд “хөдөлмөр, хүн амын хөгжил, нийгмийн хамгааллын цогц бодлогыг хэрэгжүүлж, иргэдийн хөдөлмөрлөх, хөгжих таатай орчин бий болгох, нийгмийн баталгааг дээшлүүлэх замаар хүний хөгжлийг хангах” **эрхэм зорилт тавин ажиллаж буй яам.**

Энэ маш том, нийгмийн эд эс бүхэнд хамаарах зорилтыг хэрэгжүүлэх Та бүхний үйл ажиллагаа төрийн албаны шинэтгэлийг үр дүнд хүргэх маш чухал суурь болох учиртай.

Ийм л учраас ХНХЯ-наас хариуцсан салбарынхаа хэмжээнд төрийн албаны шинэтгэлтэй уялдуулан хэрэгжүүлэх бодлого, үйл ажиллагааны танилцах уулзалтаа эхэлье гэж шийдсэн юм.

Дараа дараагийн яамдын үйл ажиллагаатай танилцах үйл ажиллагааны эхлэл, эталон хэмжүүр, харьцуулах суурь нь болно гэж үзсэн юм.


Танилцах уулзалтад Төрийн албаны зөвлөл өндөр ач холбогдол өгч байгаа. Өргөн бүрэлдэхүүнээр ирж ажиллаж байна.

Танилцах уулзалтын богино хугацаагаар энэ үйл ажиллагаа дуусахгүй.

Цаашид төрийн албаны шинэтгэлийн хүрээнд салбарт тань хийх ажил, хэрэгжүүлэх арга хэмжээний гарааны нөхцөлөө нарийвчлан тодорхойлно.

Төрийн албаны зөвлөл болон тус яаманд дахь Салбар зөвлөлийн хоорондын үйл ажиллагааны уялдаа холбоог хэрхэн яаж сайжруулах оновчтой арга замыг тодорхойлно.

Үр дүнд нь төрийн албаны шинэтгэлийн үйл ажиллагааны нэгдмэл, тууштай байдлыг хангаж, хууль тогтоомжийг хэлбэрэлтгүй хэрэгжүүлэх тал дээр ахиц дэвшил гаргана.



Энэ бүхний дүнд төрийн албаны тухай хууль, бодлого бүрэн утгаараа хэрэгждэг, зөрчилгүй салбар болно. Та бид үүнийг хэрэгжүүлэх ёстой, бас чадах ёстой. Өөр арга, зам байхгүй.

---ооо---



“НАСАН ТҮРШИД ҮЛДЭХ УР ЧАДВАР”

“Төрийн албан дахь эмэгтэйчүүдийн манлайллын хөтөлбөр”-ийн цахим төгсөлтийн баярт зориулан хэлсэн үг

2021.05.18

Канад Улсаас Монгол Улсад суугаа Элчин сайд Катерин Ивкович болон вебинарын оролцогч Та бүхэнд зуны тэргүүн сарын энэ сайхан өглөөний мэнд хүргэе.

Цаг хугацааны сорилт бэрхшээлийг улс орон, дэлхий нийтээрээ даван туулж байна. Дор бүрийнхээ ажил амьдралыг өвөрмөц, сонин шийдлүүдээр зохион байгуулж ирлээ.

Цар тахлын дараах төрийн алба гэдэг ойлголт олон улсад тод томруун яригдаж эхэлсэн. Яг одоо бол вакцинжуулалт, дархлаажуулалтын дараах төрийн албаны үйл ажиллагаа руу манай улс орж байгаа үед бүгдээрээ уулзаж байна.

Манай орон дахь төрийн албаны шинэтгэлийн хамрах хүрээ харьцангуй өргөн явагдаж байгааг Та бүгд мэднэ.

Жендерийн мэдрэмжтэй төрийн албыг төлөвшүүлэх явдал энэ шинэтгэлийн магадгүй нэг “сувдан сондор”, тод шигтгээ нь гэж би хувьдаа боддог.

Ерөнхий сайдаар ахлуулсан Жендерийн Үндэсний хорооны бүрэлдэхүүнд Төрийн албаны зөвлөлийн гишүүн орж ажиллаж эхэллээ.

Төрийн албан дахь жендерийн асуудлаар томоохон судалгаа хийгдсэн. Судалгаагаар бүгдийг шийдэхгүй ч судалгаа шинжилгээнд үндэслэсэн бодлого

төлөвлөж, үйл ажиллагаа явуулахад тус дэмтэй болно гэдэг нь эргэлзээгүй. Авах гээхийн ухаанаар хандаж ажил үйлсээ хэрэгжүүлэхдээ бодох, санах юм ихийг анзаарсан.

Хүний насан туршийн “өмч хөрөнгө” болсон, бусдад хэзээ ч алддаггүй, бас тээр саад болдоггүй цөөхөн зүйл бий гэдэг. Тэр бол мэдлэг, ур чадвар.

Ялангуяа манлайлагч, удирдагч хүнд зайлшгүй чухал нь ойлгомжтой.

Манай төр улсын түүхэнд ухаант эмэгтэйчүүдийн оруулсан хувь нэмэр, уран бэрийн нүүдлийн бахархам жишээ чамгүй их бий.



Та бүхэн анзаардаг л байх. Төрийн ордноос өгсүүлээд Та бидний ажлын газар, албан тасалгаанд бэлгэдэл болон байршдаг Монгол төрийн сүлд, төрийн далбаанд маань гүн хүндэтгэлтэй оршдог нэгэн үсэг байдаг. СОЁМБО үсгийг хэлж байна.

Төрийнхөө сүлд, далбаанд арга билгийн эрхэм чанарыг тунхаглан дүрсэлсэн улс орон өөр хэр олон байдгийг би хувьдаа мэдэхгүй.

Тэгэхээр арга билгийн мөн чанарыг сүлд, далбаандаа агуулсан улсын төрийн албыг жендерийн мэдрэмжгүй гэж хэн ч хэлэхгүй байх гэж боддог.

Агуулга, хэлбэрийн нэгдэл болж ажил урагшлан дэвжээсэй гэж үүнийг дурдаж байгаа юм.

Бага, дунд сургуульд хамгийн сайн сурдаг, хамгийн идэвхтэй байдаг, хамт олон, ангийн найз нөхдөө манлайлан явдаг хүүхдүүд их төлөв охид байдаг. Хичээнгүй, манлайлагч тэр охидын авьяас чадвар нь нас биед хүрээд гэнэт алга болчихдог гэдэгт хэн ч үнэмшихгүй.

Бид охид, бүсгүйчүүдийнхээ тэр сайн сайхан чанарыг насан туршид нь хадгалахаас энэ ажлын өнгө гараа, үр дүн хамаарна.

Төрийн албаны эрхэм үйлсийн гадна тэднийгээ бодлого, зорилготойгоор үлдээх, ардаа гэж орхих тийм явцуу, ахархан бодлого монгол төрд байгаагүй, цаашид ч байх учиргүй.

Өглөө ажилдаа ирэхдээ шийдэл, гаргалгаа өвөрлөж инээмсэглэн ирдэг, орой ажлаа дуусган гэртээ харихдаа магнай тэнэгэр, сэтгэл хангалуун явдаг тийм аз жаргалтай төрийн албан хаагчдаас бүрдсэн төрийн албыг төлөвшүүлэх нь Та бидний том зорилго.



Эмэгтэйчүүдийн манлайллын хөтөлбөр, төрийн албан хаагчийн ур чадварын хүрээг боловсруулан, өнөөгийн нөхцөлд шаардагдаж байгаа цогц чадамж бүхий ур чадварыг эзэмшүүлэн, хөгжүүлэх арга хэмжээ цаашид тасралтгүй үргэлжилнэ.

Мэргэшсэн, олон талт ур чадваруудыг эзэмшин, тодорхойгүй нөхцөл байдалд оновчтой шийдвэр гарган зохистой хандлага, үйлдлийг гүйцэтгэгч төрийн албан хаагч байж, иргэн төвтэй төрийн албыг хамтдаа бэхжүүлцгээе.

Та бүхэнд аз жаргал, амжилт бүтээлийн дээдийг Төрийн албаны зөвлөлийн нэрийн өмнөөс хүсэн ерөөе.

---o0o---



Яамдын Төрийн нарийн бичгийн дарга, агентлагийн дарга, аймаг, нийслэлийн Засаг даргын Тамгын газрын дарга нартай хийсэн цахим уулзалтыг нээж хэлсэн үг

2021.05.12

Уулзалт маань амжилттай болж өндөрлөж байна.

Төгсгөлд нь зарим асуудлыг нэгтгэн дүгнэе.

Цаг үеийн сорилтуудын нэг болох цахим орчинд ажиллахад үүсэж байгаа эрүүл мэндийн асуудал, ялангуяа стрессийг хэрхэн удирдах асуудлаар сонирхолтой мэдээлэл өглөө.

Цаг наргүй, хариуцлагатай өндөр алба хашиж буй Та бүхэнд энэ эрсдэл, сорилт их бага тодорхой хэмжээгээр үүсэж байгаа нь тодорхой.

Тэдгээрийг даван туулах, стрессээс үүдэлтэй таагүй хүчин зүйлс, нөлөөллийг бууруулахыг зорьсон хэрэг.

Эрч хүчтэй, бүтээмж өндөртэй ажиллахад дэм болох зорилгоор энэ сэдвийг уулзалтын нэг хэсэг болгосон юм.

Ингээд өнөөдрийн уулзалтаас бүгдээрээ ямар үр дүн хүлээж байгаа талаар товч чиглэл өгье. Анхаарал хандуулна уу.

Нэг. “Тооно” загварт тусгагдсан салбар, байгууллагын тоо, тэдгээрийн албан хаагчдын тоон мэдээлэл бүрийг нягтлан тодруулж, баталгаажуулаарай.

Энэхүү загварт орсон тоон үзүүлэлтийн анхдагч эх үүсвэр буюу мэдээллийг Хүний нөөцийн удирдлагын системд бүртгэж, оруулсан хүмүүс Та бүхэн, танай ажил хариуцсан төрийн албан хаагчид байгаа гэдгийг дахин хэлье.

Иймээс тухайн мэдээллийг дахин төрийн албан хаагч нэг бүрээр тодруулж, байгууллагын орон тоо, төрөл, үйл ажиллагааны холбогдох мэдээллүүдийг шалгах шаардлагатай.

Тайлан гаргасан хугацаа буюу 2020 оны 12 дугаар сарын эцсийн байдлаар гаргаж нэгтгэсэн гэдгийг дахин анхааруулах нь зөв байх.

Хоёр. Хүний нөөцийн удирдлагын мэдээллийн системийг үе шаттайгаар хөгжүүлээд явж байгаа, төрийн бусад байгууллагуудын мэдээллийн санд ч холбох нөхцөлүүд бүрдсэн.

Төрийн албаны бүх тоон мэдээлэл, бүртгэл энд хадгалагдаж байна. Гол асуудал бол мэдээлэл бодит байх, үнэн байх, алдаагүй байх, чанартай байх явдал.

Хүний нөөц, мэдээллийн технологи, санхүүгийн асуудал хариуцсан ажилтнууд мэдээлэл оруулж байгаа. Үүнд сайн анхаарах шаардлагатай байна.

Тухайн ажлын байруудад ажиллаж байгаа ажилтангүй, ажилтнууд богино хугацаанд солигддог зэрэг нийтлэг шалтгаануудын улмаас мэдээлэл бүрэн орохгүй байх асуудал үүсч байна. Үүнийг онцгой анхаараарай.

Мөн уг мэдээллийн санд өгөгдөл оруулах, шинэчлэх, өөрчлөх, баталгаажуулах үйл явцыг журамласан журмын хэрэгжилтийг хангаж ажиллахыг зөвлөө.

Гурав. Төрийн албаны шинэтгэлийн голлох асуудлуудаар дурдсан бүхий л чиглэлийг анхааран үзэж хэрэгжүүлэх.

Төрийн албаны тухай хууль тогтоомжийг боловсронгуй болгох чиглэлээр санаачилга гарган хамтран ажиллах:

1. Төрийн албаны тухай хуульд нийцүүлэн салбарын **хууль тогтоомжийг боловсронгуй болгох** өөрчлөх санал боловсруулж Засгийн газар, Улсын Их Хуралд хүргүүлсэн. Хууль тогтоомжийг боловсронгуй болгох чиглэлээр хийж, хэрэгжүүлж буй болон шинэчлэх шаардлагатай байгаа хууль тогтоомжийн талаар мэдээлэл солилцож хамтран ажиллах;

2. Төрийн албан дахь **ёс зүйн асуудал** ихээхэн анхаарлын төвд байгаа асуудлуудын нэг. Иймээс төрийн албанд нийтлэг мөрдөх ёс зүй, зан үйлийн дүрмийн төслийг боловсруулаад байгаа. Энэхүү нийтлэг дүрэмтэй уялдаад олон стандартууд ч гарах хэрэгцээ шаардлага бий.

Ялангуяа, төрийн үйлчилгээ үзүүлэх, төрийн бодлого шийдвэр боловсруулж байгаа үйл явц, ажил хэргээр томилолтоор явахтай холбоотой, албан е-мэйл буюу цахим шууданг ашиглаж хэвших, иргэдээс ирсэн санал, асуулт, хүсэлтийг шийдвэрлэхэд тавьж буй хяналтыг сайжруулах олон зүйлийг бид өндөр жишиг, стандарттайгаар хүргэж ажиллах, мөн тэгж ажиллахыг шаардах цаг болсон;

3. Төрийн албаны ёс зүйн асуудал зөвхөн төрийн жинхэнэ албан хаагчдын хүрээнд хязгаарлагдахгүй, улс төр, үйлчилгээний албанд ч үйлчлэх, мөрдөх, шаардагдах зүйл. Иймээс Төрийн улс төрийн албан хаагчдын ёс зүйн хууль, дүрэм, нарийвчилсан зохицуулалтууд бий болгох санал, санаачилгуудыг гарган явж байгааг Та бүхэн мэдэж байгаа байх. Үүнийг төрийн албан хаагчдын, төрийн албаны нэгдсэн зарчим, стандарт бий болгох бодлогын хүрээнд дэмжиж хамтран ажиллаарай.

4. Төрийн албан тушаалын ангилал, зэрэглэлийг оновчтой тогтоож боловсронгуй болгох, улмаар цалин хөлсний тогтолцоог шинэчлэхээр ажиллаж байна. Үүнд салбар хоорондын болон олон улсын байгууллагуудын хамтын ажиллагаа, олон талын оролцоо чухал.

5. Төрийн байгууллагын ерөнхий бүтцийг оновчтой тогтоох, арга зүй, аргачлалыг шинэчлэх, ажлын байр бүрд нийтлэг удирдамж, чиглэл ашиглан үнэлгээ хийж, төрийн албыг үр ашигтай байлгах.

Нөгөө талаар цалин хөлсийг адил ажилд ижил үнэлгээтэй байх зарчимд суурилан тогтоодог байх зарчмуудыг баталгаажуулах, төр, хувийн хэвшлийн цалингийн хэт ялгааг бууруулах, ажил мэргэжлийн онцлог, хэрэгцээ шаардлагад нийцүүлэн өндөр ур чадвартай, нарийн мэргэжлийн хүмүүсийг төрийн албанд ажиллуулах бололцоо нөхцөлийг бүрдүүлэх зэрэг олон талын ач холбогдолтой арга хэмжээ.

Иймээс салбар бүр үүнд санаачилгатай хандан, хэрэгжүүлж байгаа төсөл, хөтөлбөрийн хүрээнд ч хувь нэмрээ оруулах, үйл ажиллагаагаа уялдуулах шаардлагатай байна.

6. Төрийн албан хаагчдын хандлага, ур чадварыг дээшлүүлэхэд бүх байгууллага анхаарал хандуулж, хөгжлийн арга хэмжээг хэрэгжүүлж байгаа. Гэхдээ анхаарах гол асуудал нь хандлагын өөрчлөлт гэдэг танхим, эсвэл сургалтаар бүрэн олж авч, өөрчлөгддөг зүйл биш.

Өдөр бүр, цаг тутам бодож боловсруулж, хийж байж тогтох, бий болох зан үйл. Иймээс төрийн албан хаагчдад тавигдаж буй зөөлөн ур чадварын шаардлагыг хангаж, өөрчлөлт авчрах арга зүйг байгууллага бүр туршин нэвтрүүлэх, инновацыг дэмжиж төрийн үйл ажиллагааг сайжруулах чанаржуулах нь чухал байна.

Тухайлбал, аналитик сэтгэлгээ, сэтгэл хөдлөлөө удирдах, ил тод, гүйцэтгэл үр дүнгээ тайлагнах, үнэлүүлэх оролцооны арга, аргачлалыг нэвтрүүлэх зэрэг шинэлэг байдлаар ажиллах, санаачилга гаргах нь зүйтэй.



7. Төрийн албаны зөвлөлөөс төрийн албан хаагчдын сургалт, хөгжлийн үйл ажиллагааг тогтмол явуулж байгаа. Пүрэв гараг бүр тогтмол, цахимаар сургалт зохион байгуулж, түүнд улсын хэмжээнд 500 гаран хэрэглэгч, цаана нь үүнээс олон төрийн албан албан хаагчид оролцож, интернэтэд байршуулсан линкээр үзэж судалж ажилладаг болсон.

Сар, улирлаар төлөвлөн бэлтгэж, хэрэгцээнд суурилсан хэлбэрээр шинэ мэдээлэл, мэдлэг олгож байгаа үйл ажиллагааг дэмжиж оролцоог илүү өргөжүүлэх, олж авсан мэдээлэл, мэдлэгээ ажилдаа санаачилга болгон хэрэгжүүлэхэд дэмжиж ажиллахыг хүсье.

8. Төрийн албаны зөвлөл мэдээ, мэдээллийг тогтмол гаргаж, үйл ажиллагааны ил тод байдлаа хангаж, төрийн албаны шинэтгэлийг олон нийтэд сурталчлан таниулах үйл ажиллагаа хийж байна.

Энэ нь зөвхөн нэг байгууллагын хийх ажлын хүрээгээр хязгаарлагдаж болохгүй. Төрийн албаны зөвлөлийн салбар зөвлөлийн дарга, ажилтнууд Та бүхэн энэ мэдээллийг түгээх, албан хаагчдад хүргэх, улмаар иргэдэд таниулах ажлыг байнга хийж ажиллах нь зүйтэй байна.

Мөн бидэнд ч салбарынхаа бодлого, шийдэл, санаачилга төрийн албаны шинэтгэлтэй холбогдох асуудлаар гарч буй ахиц, үйл явцыг мэдээлэх эргэх урсгалыг бий болгож ажиллаарай.

1. Цар тахлын нөхцөл байдлыг харгалзан, боломжтой цаг хугацааг судалж байгаад Төрийн албаны зөвлөлийн салбар зөвлөлүүдийн үйл ажиллагаа, тухайн салбарын бодлого, үйл ажиллагааг таниулдаг, мэдээлдэг “Салбар зөвлөлүүдийн мэдээллийн цаг”-тай болохоор төлөвлөж байна.

Бид хоосон хуурай цаасан тайлан авдаг биш, үйл явдлыг цаг тухайд нь хүлээн авч зөвлөн дэмждэг, үр дүнг үнэлдэг хамтын ажиллагааг энэ жил онцлон бий болгоно.

Санаачилгаараа энэ ажлыг эхлүүлэхийг урья.

---o0o---



Яамдын Төрийн нарийн бичгийн дарга, агентлагийн дарга, аймаг, нийслэлийн Засаг даргын Тамгын газрын дарга нартай хийсэн цахим уулзалтыг нээж хэлсэн үг

2021.05.12

1. Эхлэл

Яамдын Төрийн нарийн бичгийн дарга, агентлагийн удирдлагуудтайгаа буюу Төрийн албаны зөвлөлийн Салбар зөвлөлийн дарга нартайгаа уулзаж байгаадаа талархалтай байна.

Төрийн албаны топ менежерүүд Та бүхэнтэй саяхан 3 сарын 26-нд уулзсанаас хойш 47 хоног өнгөрсөн байна. Үйл явц, цаг хугацаа хурдацтай өрнөж байна.

Өнөөдөр зуны тэргүүн сарын **шинийн нэгний өдөр** юм байна. Уулзалт энэ өдөртэй давхцаж буй нь **тохиолдол** байж болох ч бас **бэлгэшээж** байна. Шинэ зуны эхний өдөр шинэтгэлийн зарим чухал сэдвүүдийг өнөөдөр ярилцана.

Цар тахалтай тэмцэх, эрсдэлийг бууруулах чиглэлээр шат шатандаа, тал талаасаа идэвхийлэн ажиллаж байна. **Өнгөрсөн сарын** хувьд:

-**Нэг талаас**-иргэдийн хувьд урт хугацааны хатуу хөл хорио,

-**Нөгөө талаас**-төрийн албан хаагчдын хувьд шөнө өдрийг үл ялгасан нүсэр ажлын сар болж өнгөрлөө.

Төрийн албаны зөвлөл, салбар зөвлөлүүдийн үйл ажиллагаа доголдолгүй, тасралтгүй, зарим талаар илүү идэвхтэй, ачаалалтай явж ирсэн гэж бодож байна.

Төрийн албаны зөвлөлөөс хэвшил болгосон Пүрэв гараг бүрийн сургалтын сэдэв сонирхолтой, оролцогчдын идэвх оролцоо өндөр явж байгаа.

2. Цар тахлын дараах төрийн алба

Дэлхийн улс орнууд дахь цар тахлын нөхцөл байдал харилцан адилгүй байгааг бид бүгдээрээ мэдэж байгаа. Энэ өвчний эрсдэл буурч, эгэл жирийн амьдралын төлөвт шилжих нь цаг хугацааны асуудал гэдэг нь ойлгомжтой.

Тийм ч учраас **КОВИД-19-ийн дараах төрийн алба** гэдэг сэдэв олон улс орны төр засгийн байгууллагуудын хувьд бодлогын томоохон асуудал болж байна. **Нью нормал** (new normal) буюу **шинэ энгийн** гэдэг **үе шат** руу шилжих нь.

Цар тахлын өмнөх үедээ **буцаж орох** талаар ярихгүй, бас төлөвлөхгүй байна. Энэ жил гаруйн хугацаанд үйл ажиллагаанд олсон амжилтаа **бататгах** тухай ярьж байна. Товчдоо ажлын арга хэлбэрийн ахисан түвшнээ **хадгална** гэсэн үг.

Манай улсын хувьд **цар тахлын дараах төрийн албаны хэв шинж** рүү орох төлөв ажиглагдаж байна. Онцолбол **вакцинжуулалтын дараах төрийн алба, дархлаажуулалтын дараах төрийн албаны** үе шатанд үндсэндээ орчихлоо.

3. Засгийн газар ба Төрийн албаны зөвлөл

Засгийн газрын үйл ажиллагааны эхний 100 хоног энэ долоо хоногт боллоо.

Энэ 100 хоногийн 51 дэх өдөр төрийн албаны шинэтгэлийг гүнзгийрүүлэх, шинэ утга агуулгаар баяжуулах талаар Засгийн газар, Төрийн албаны зөвлөл санал солилцсон, хийж хэрэгжүүлэх арга хэмжээгээ томьёолсон.

Ерөнхий сайд Л.Оюун-Эрдэнэ Төрийн албаны зөвлөлийн дарга, гишүүдтэй дээрх чиглэлээр маш тодорхой, нухацтай ярилцсан.

Үүнийг Ерөнхий сайдын зүгээс Та бидний хэрэгжүүлж буй төрийн албаны шинэтгэлд хэр зэрэг өндөр ач холбогдол өгч буйн илэрхийлэл гэж болно.

Бодлого шийдвэр төлөвлөн гаргахаас эхлүүлээд бодитой хэрэгжилт, зэрэг үр дүнгийн бүтэн циклийг энд ярьсан.

Бодлого төлөвлөлтийн уялдаа холбоог ямар арга замаар хангах вэ?

Салбар хоорондын үйл ажиллагааны уялдаа холбоог яаж хангах вэ?

Бодлогын хэрэгжилтийн уялдаа холбоог хэрхэн хангах вэ?

Эдгээр асуултад оновчтой хариу өгч ажиллахыг Засгийн газар, Төрийн албаны зөвлөл хамтран эрэлхийлж байна.

4. Уулзалтын зорилго

Та бидний уулзалтаас уулзалтын хооронд тодорхой эерэг үр дүн гарч байх учиртай.

Өмнөх уулзалтаас дараагийн уулзалтын хооронд өөрчлөлт, ахиц дэвшил гарч байгаа гэдэгт итгэлтэй байгаа.

Өнөөдрийн уулзалтыг **төрийн албаны шинэтгэлийн замын зураглал** дээр төвлөрөн хийх гэж байна.

Монгол төрийн албаа том зургаар харъя.

Стратегич, аналитик байдлаар үнэлэн цэгнэе.

Үзүүлэлт мэдээлэл бүрийг үнэ цэнтэй болгоё.

Үнэ цэнтэй тэр мэдээллүүдээ баталгаажуулъя.

Өгөгдөл датад суурилсан бодлого, үйл ажиллагаанд төвлөрье гэж.

Технологийн дэвшил, цахимжилтад суурилсан үйл ажиллагаанд шилжье гэсэн зорилгоор өнөөдрийн уулзалтыг хийж байна.

- Өгөгдөл, тоон мэдээллийг **өнгөрсөн ба одоо цаг** дээр үндэслэн гаргах гэж байна.

- Энэ бүхэн дээрээ анализ хийж ирээдүйд гарч ирэх сорилт, боломжийг тодорхойлох гэж байна.

- Сорилт боломжийг тодорхойлсны үндсэн дээр бодлогын шийдвэрүүдийг гаргаж Засгийн газартай хамтран ажиллана.

Энэ чухал тоон мэдээллийг хадгалчхаад **тоочих, тайлбарлах байдлаар ашигламааргүй** байна. Харин эдгээр чухал тоон мэдээллийг ашиглан **чиг хандлагыг** олж харж, эрсдэлийг тодорхойлж, бодлогын хувилбарын зөвлөмжөөр Засгийн газрыг хангах хэрэгтэй байна.


Дэлхийн улс орнуудын Засгийн газар өгөгдөл буюу тоон дээр суурилсан бодлогын шийдвэр гаргаж байна. Монгол Улсын Засгийн газрын шийдвэрүүдийг Та бүхэн хамгийн сайн мэдэж, хэрэгжүүлж байгаа хүмүүс.

Эрдэмтдийн **тооцоолсноор** гэдэг нь өвчлөлийн **өнгөрсөн болон одоо байгаа тоон** дээр үндэслэн ирээдүйд илрэх **халдварын тоог тооцоод** бодлогын шийдвэр гаргаж байгаа хэрэг.

Бид тэгвэл маш их өгөгдөл тоон дээр ажилладаг үүнийгээ бодлогын шийдвэрийн хувилбартаа ашиглах хэрэгтэй байна.

5. Уулзалтын сэдвийн ач холбогдол

Төрийн албаны шинэтгэлийн замын зураглал, бүтцийн ерөнхий тойм



Бэлгэдлийг бодож **“монгол гэрийн тооно”**-ыг эх загвар болгон сонгосон.

Энэ бол Монгол Улсын төрийн албаны бүтэц, тогтолцоо, үйл ажиллагааны цогц зураглал.

Энд дурдагдсан үсэг, тоо, нэр бүрийн цаана бүтцийн өргөн агуулга, салбарын үйл ажиллагааны үнэ цэн харагдах учиртай.

Төрийн албаны шинэтгэлийн талаар Та бидний явуулах үйл ажиллагааны луужин, газрын зураг, замын зураг (рөүд мап) гэж болно.

Энэ нь ганц Төрийн албаны зөвлөлийн бүтээл, бүтээгдэхүүн биш, Та бидний хамтын ажиллагааны нэгдмэл үр дүн болж гарах ёстой.

Тийм ч учраас бүгдээрээ тал талаасаа нягталж, яам, салбар, аймгаасаа хамаарах тоо өгөгдөлд туйлын нухацтай хандах хэрэгтэй байна.

Буруу өгөгдөл, алдаатай тоон мэдээлэл зам төөрүүлж, бартаатай газар луу хөтөлнө шүү! Онцгойлон анхаараарай!

Энэ зураглалыг эцэслэн хэвлэх үедээ нэг хувь дээр нь Та бүхний гарын үсгийг зуруулъя гэж бодож байгаа. Үнэн мөний баталгаа ч болог, бас түүхийн нэг баримт ч болог. Ингээд уулзалтаа эхлүүлье.

---o0o---



***Төрийн албаны ерөнхий шалгалтын
нээлт дээр хэлсэн үг***

2021.03.12

Төрийн албанд анх орох иргэний шалгалт өгөхөөр догдлон суугаа Та бүхэнд энэ өглөөний мэнд хүргэе.

Хүн ирээдүйн амьдралаа баталгаатай байлгахыг хүсэж, ирж буй цаг хугацааг илүү утга учиртай байлгахын төлөө бага балчраасаа цэцэрлэг, сургуулиар дамжин олон жил сурч бэлтгэгддэг. Хамгийн товчоор хүний амьдралыг тодорхойл гэвэл би “**шалгалт**” гэж хэлнэ. Эргээд харахад Та бид маш олон төрлийн шалгалтыг давж туулсан байгаа биз.

Тэдгээрийн дотроос дэлхийн улс орнуудад хамгийн түгээмэл байдаг, хамгийн үнэ цэнтэй шалгалтуудын нэг нь Та бүхний өнөөдөр өгөх гэж буй **төрийн албаны шалгалт**.

Ийм шалгалт өгөх нь хүн зөвхөн өөрийнхөө төлөө гэхээс илүүтэй нийт иргэд, төр улс, эх орныхоо төлөө ажиллаж амьдрахын утга учраа ухамсарласны нэг илрэл гэж болно. Учир нь Таны төрийн жинхэнэ албан хаагч болох замнал эндээс эхэлнэ.

Өнөөдөр манай улсад явагдаж буй төрийн албаны **шинэтгэлийн цөм** нь өндөр мэдлэг боловсрол, ур чадвар, ёс зүйтэй хэн боловч ижил тэгш боломж, нөхцөлөөр төрийн албанд ажиллах явдал. Үүний тулд төрийн алба өөртөө хүний сайн нөөц бүрдүүлж, ажлын сул орон тоо гармагц тусгай шалгалт зарлан нөөцөө ашигладаг тогтолцоонд шилжсэн.

Улс орны хөгжилд хамгийн чухал эрхэм баялаг нь хүн. Хүний эрүүл мэнд, боловсрол, мэдлэг чадвар, дадлага туршлагыг багтаасан, хөгжлийн хөдөлгөгч гол хүчин зүйл нь **хүмүүн капитал** гэдгийг нийгмийн харилцааны оролцогч бүх талууд хүлээн зөвшөөрч, хүний хөгжилд нийгмийн анхаарлыг төвлөрүүлдэг тийм цаг үе, нийгэмд бид бүгдээрээ амьдарч, ажиллаж байна.

Төрийн албанд анх орон иргэний нөөцийг бүрдүүлнэ гэдэг төрийн хүмүүн капиталын суурийг тавьж байгаа хэрэг. Орчин цагийн мэдлэг чадвартай, ёс зүйтэй хүмүүсээр төрийн албаны хүний нөөц байнга сэлбэн баяжиж, үр дүнд нь төрийн ажил орчин цагийн шаардлагад нийцэж, улс орны хөгжлийг түүчээлдэг байх учиртай.

Хувийн хэвшлийнхэн ч төрийн албаны нөөцөөс сонголт хийдэг, ажилд урьдаг эхлэл тавигдаж байна. Тиймээс энэ нөөцийг зөвхөн төрийн албаны төдийгүй **“хөгжлийн нөөц”** гэж хэлж болно.

Энэ удаагийн шалгалтад шинэ үеийнхэн хүч түрэн орж ирж байна. 13 мянга гаруй хүн бүртгүүлсний 52.4 хувь нь 30 хүртэл насныхан буюу **Z үеийнхэн**. Төрийн албаны ерөнхий шалгалт **100 хувь цахимд** шилжиж, шалгалтын дүн хэн нэгнээс биш зөвхөн өөрсдөөс тань хамаардаг болсонд, **зөвхөн** хэн сайн хичээж бэлдсэн нь шалгалтад өндөр оноо авах нөхцөл бүрдсэнд би баяртай байгаа.

Дижитал шилжилтийн орчинд хиймэл оюун ухаантай хүч хавсран ажиллах ирээдүйн төрийн албан хаагчид Та нар “e-taz” гар утасны аппликэйшнд сорил даалгаврууд бүрэн орсон, цахимжсан орчинд өөрийгөө сорих гэж байна. Та бүгд өөртөө итгэлтэй байгаарай, боломж нөхцөл өмнө чинь байгаа гэдгийг би хэлж чадна.

Улс орныхоо хөгжлийн ирэх 30 жилийн хөгжлийн дүр зургийг бүхий л талаас нь тодорхойлсон **“Алсын хараа-2050”** урт хугацааны хөгжлийн бодлогыг Улсын Их Хурал өнгөрсөн онд баталсан.

Энэ бодлогын баримт бичгийг гардан хэрэгжүүлэх шинэ үеийн төрийн албан хаагчид энд шалгалт өгөхөөр сууж байгаа гэдэгт итгэлтэй байна. Та бүхний хийх ажил маш тодорхой.

Та нар бол “e-Mongolia” хэрэгжсэн, цахимжсан төрд ажиллах хүмүүс. Та бүхэн бол байнга хувьсан өөрчлөгдөж буй нийгэм, эдийн засгийн сонирхолтой цаг үед өөрийн мэдлэг, боловсрол, оюун ухаанаа иргэд, олон нийтийнхээ төлөө зориулах хүмүүс.

Төрд ажиллах эхний шалгуурыг амжилттай давж, хөгжлийг түргэсгэх, мөрөөдлөө биелүүлэх хөлгийн залуур дээр гараа тавих монгол төрийн ирээдүйн залуу халаа Та нарт амжилт хүсэж, төрийн албаны ерөнхий шалгалтыг орон даяар эхлүүлж байгааг мэдэгдье.

--oOo--



Төрийн албаны ерөнхий шалгалтын бэлтгэл ажлын хүрээнд сэтгүүлчидтэй хийсэн уулзалт дээр хэлсэн үг

2021.03.10

Ажлын цаг боломжоо зохицуулан байгууллага дээр маань хүрэлцэн ирсэн Та бүхэнд баярлалаа.

Цар тахалтай тэмцэх ажлын тэргүүн эгнээнд явж буй хүмүүс хэн бэ гэвэл эрүүл мэнд, онцгой, цагдаагийн албан хаагчид гэж захын хүн хэлнэ байх.

Миний бодлоор сэтгүүлчид тэр хүмүүсээс огт дутахгүй, хаана ямар шийдвэр гарч байна, хаана халуун цэг байна, хэзээ яаж ажил, амьдралын горимыг хэрхэн зохицуулах нь вэ гээд мэдлэг, мэдээлэл түгээх бүхий л ажлын **тэргүүн фронтод** явж байгаа гэж боддог. Тийм л тэргүүн фронтын хүмүүстэйгээ өнөөдөр уулзаж байна.

Бидний амьдарч байгаа цаг үеийг судлаач эрдэмтэд ВУКА гэж нэрлэдэг болж, Та нар сайн мэдэж байгаа. Энэ цаг үе **“нэргүй”** болчихоод ийм нэг нэр гаргаж ирсэн хэрэг биш юм билээ.

Төвөгтэй, хувьсамтгай, эргэлзээтэй, тодорхойгүйн энэ үзэл баримтлал төлөвлөлт хийх, үйл ажиллагаа явуулах чадварыг сэдэлжүүлэх зорилгоор бий болж. Ийм орчинд зохицон ажиллах чадвартай байх нь ямар мэргэжилтэн аль салбарт юу хийдгээс үл хамаарна гэсэн санаа.



Үүнийг хамгийн сайн ойлгодог хүмүүсийн нэг нь сэтгүүлчид гэж би боддог. Хаана ямар үйл явдал өрнөх нь ихэнхдээ тааж төсөөлшгүй, тэр үйл явдлын үнэн бодит мэдээллийг олон нийтэд хүргэж чадна гэдэг үнэхээр сайхан ажил. Зөвхөн мэдээлэл төдийгүй **анализ дүгнэлт бэлддэг**, тухай тухайн салбаруудын **топ мэргэжилтнүүдтэй** болох замаар сэтгүүл зүй төлөвшиж байна.

СЭТГҮҮЛ ЗҮЙ



-  ҮНЭН, БОДИТ МЭДЭЭЛЭЛ
-  АНАЛИЗ, ДҮГНЭЛТ
-  ТОП МЭРГЭЖИЛТНҮҮД

“Төрийн албаны шинэтгэл” гэдэг үгийг төрийн албан хаагчид төдийгүй иргэдэд хүргэж, энэ томоохон ажлын ард ямар зүйл төлөвлөж, юу өрнөж, юу хийгдэж, цаашид яах гэж байгаа тухайд **олон нийт нэлээд сайн мэдээлэлтэй** болсон нь мэдрэгддэг. Та бүхний **дэмжлэгээр** гэсэн үг.


Шинэтгэлийн хүрээнд бий болгохыг зорьж буй “**мэргэшсэн төрийн алба**” гэдэг маань товчоор хэлбэл мерит зарчмыг мөрддөг, шатан дэвших тогтолцоог үндэс сууриа болгосон бүхэл бүтэн **институцийн** асуудал юм.

Үүний суурийн суурь нь мэргэшсэн, чадварлаг төрийн албан хаагч байх нь ойлгомжтой. Тэр мэргэшсэн төрийн албан хаагчийг хэрхэн **сонгож** ажиллуулах нь “**ямар үр тарьж ямар ургац хураах вэ?**” гэдэгтэй утга нэг.

Монгол төр өөрөө **хүний сайн нөөцтэй** байж, тэр нөөцөө үр дүнтэй ашиглаж чадах эсэхээс бидний зорьж буй шинэтгэлийн үр дүн шууд хамаарна. Тийм учраас төрийн албан хаагчийн нөөц бүрдүүлэх **ерөнхий шалгалтыг** зохион байгуулдаг. Тэр шалгалтыг хэрхэн яаж авах нь вэ гэдэг талаар Та бүхэнд мэдээлэл өгөх гэж урьсан хэрэг.

Шалгалтын сорил даалгаврыг **эрдэмтэн судлаачдыг** өргөн хүрээнд оролцуулан боловсронгуй болгож чадлаа. Шалгалтын сорилын ном хэвлэхийн зэрэгцээ **онлайнаар өөрийгөө сорьж** шалгалтад бэлтгэх боломжийг сүүлийн хагас жил бүрдүүллээ. **Гар утасны аппликэйшн** хөгжүүлж, өчигдрөөс хэрэглээнд гаргалаа. Ерөнхий шалгалт хүн бүрийн **гарын алга, хурууны үзүүрт** очсон гэсэн үг.

ШАЛГАЛТЫН СОРИЛ ДААЛГАВАР



Хөндлөнгийн хэн нэгнээс огт хамааралгүй, зөвхөн өөрөөс нь хамаардаг шалгалтын үр дүнг бодитой болгож чадсан гэж болно

Өнгөрсөн жилийн 11 сард төрийн албаны ерөнхий шалгалтын бэлтгэл ажилтай сэтгүүлчдийг танилцуулсан. Зарим нь энд байгаа байх.

Төрийн албаны зөвлөлөөс “Төрийн албаны шинэтгэл” ерөнхий сэдвийн хүрээнд **ярилцлага, нийтлэл бичих уралдааныг** сэтгүүлч, хэвлэл мэдээллийн ажилтнуудын дунд явуулсан. Тэд нараас сонин содон санаа, шийдлүүд гаргаж ирсэнд талархахгүй байхын аргагүй.

Өнөөдөр нэг талаар **хүн болгон “сэтгүүлч”** болчихсон, Фэйсбүүк, Твийтэр, Инстаграмын нэг байтугай акаунттай хүмүүс нийгэмд мэдээлэл түгээж, үзэл бодлоо илэрхийлдэг болсон цаг үе. Нөгөө талаас тухайн чиглэл, салбараар **мэргэшсэн аналитик (аниалист-analyst) сэтгүүлчдийн** үнэ цэн улам бүр өсөж

байгаа цаг үе. **Төрийн албаар мэргэшсэн сэтгүүлчид** байсан, байгаа, цаашид улам олон болно гэдэгт эргэлздэггүй.




ХҮН БҮР “СЭТГҮҮЛЧ”

МЭРГЭШСЭН АНАЛИТИК СЭТГҮҮЛЧ

Бодож төлөвлөсөн ажил нийгэмд бодитой хүрч, үр дүнд хүрнэ гэдэг хэвлэл мэдээллийн салбаргүйгээр төсөөлөгдөшгүй.

Амжилт ололтоо ч, алдаа оноогоо ч олж харах “**толь**”-ийг бүтээгч Та нарт сайн сайхныг хүсье.

---o0o---



“Монгол төрийн түшмэдийн уламжлал, ёс суртахууны асуудал” сургалтыг дүгнэж хэлсэн үг

2021.01.21

....Мэдлэг ухаанаа хуваалцаж байгаа багш болоод сонсож ухаарч байгаа бид нарын хэн хэн нь төрийн албаны шинэтгэлийн нэг шинэ үе шатанд ажиллаж байгаа хүмүүс.

Энэ шинэтгэлийн үйл явцад зарим нэг үг чамгүй олон давтагдаж байгаа.

“Олон хэлбэл улиг” гэдэг ч ямар нэг үг хэллэг олон давтагдаж байна гэдэг бас учиртай. Тэр үг дутагдаад байгаадаа биш хэрэгтэй байгаадаа хэргийн учир бий.

Дөрөв дэх өдрүүдийн сургалтад ёс зүй, ёс суртахууны сэдэв олон давтагдаж ирлээ. Энэ талын доголдол, дутагдал багагүй байгаа болохоор л олон дурдагдаж байгаа хэрэг.

Магадгүй ёс зүйт төрийн алба төлөвшсөн цагт сургалтын агуулга, чиглэл өөр зүйлд илүү төвлөрөх биз.

Парламентын бүтцэд Ёс зүй, сахилга хариуцлагын байнгын хороо шинээр байгуулагдаж, төрийн байгууллагууд Ёс зүйн зөвлөлтэй болсон.

Төр, засгийн бүхий л түвшинд энэ чиглэлд анхаарал хандуулж олон талын оролцоотой томоохон зөвлөгөөн хийснээс хойш удаагүй байна.

Энэ бүхэн ёс зүй, сахилга хариуцлагын асуудал хэр чухалд үзэгдэж буйн илрэл.

Жил бүрийн ажлын эхний өдөр ТАЗ төрийн ахмад зүтгэлтнүүдээс урьж сургаал номыг нь сонсдог юм.

Энэ сарын эхээр хөдөлмөрийн баатар, гавьяат тээвэрчин, төр нийгмийн зүтгэлтэн Р.Раш гуай уригдахдаа нэгэн малчны үгийг эш татаж байсан.

“Ёс суртахуунгүй боловсрол ишгүй хутгатай адил” гэж... айхтар үг шүү.

Тэр уулзалтын төгсгөлд сайд асан Д.Тэрбишдагва гуай “Төрийн албыг ёс суртахуун чимнэ, ёс суртахуунлаг төрийн алба улс орноо чимнэ” гэж хэлснийг давтъя.

Хоёр зууны зааг дээр монгол төрд өндөр алба хашсан буурлуудын амнаас буусан үгс. Тогтоож аваад санаж явахад илүүдэхгүй, бодууштай үгс.

Өнөөдрийн сургалтаар төрийн ахмад түшээ Я.Долгоржав багш Монгол төрийн түшмэдийн уламжлал, ёс суртахууны талаар гайхалтай гоё хичээл заалаа.

Аливаа зүйл зүгшрэн төлөвшиж, амжилтын оргил, бүтээлийн шедевр болтлоо ихээхэн цаг хугацаа шаарддаг гэсэн утгатай **“Ром нэг өдөрт үүсээгүй”** хэмээх 1000-аад жилийн тэртээх Европ зүгийн алдартай үг байдаг. Бүгдээрээ мэднэ.

Уламжлалгүй шинэчлэл байхгүй гэсэн өнөөдрийн сургалтын санаа ч энд байгаа биз.

Монгол төр үүсэн бий болсноосоо хойш өөрөө өөрийгөө төлөвшүүлэхийн нэг гол гогцоо нь төрийн түшмэдийн ёс суртахуун гэдгийг үеэс үед сургамжлан мөрдөж ирж.

Эртний сургаал зохиол “Оюун түлхүүр”-ийн хэдэн мөрийг энэ сургалтын сэдэвтэй холбогдуулаад өчигдөр гэртээ харсан юм. Онцолж уншъя гэж бодлоо:

“Төр ёсыг төв шударга дагаж явах түшмэл хүний 9 эрдмийн дотор түвшин сэтгэл нэн эрдэм” гэж... айхтар хэлж шүү.

Төр гэдэг үг **ёс** гэдэг утгаар хэрэглэгдэж байсан жишээ “Монголын нууц товчоо”-нд байдагчлан төр, ёс гэх хоёр үг эхэндээ ижил утгаар хэрэглэгдэж байгаад төрт ёсны хөгжлийн явцад утга салсан гэдэг. Сонин гаргалгаа байгаа биз.

Тогтсон ёс зарчимтай түшмэлийн алба төрт ёсны чухал бүрэлдэхүүн, төрт ёсыг тээгч, уламжлуулагч юм байна.

Олон өдөр, цагийн хичээл, сургаалыг өнөөдөр бид богинохон хугацаанд хураангуйлан сонслоо. Сайхан байна.

Санхүү, төсөв шаардагдахгүй боловч бодитой, баталгаатай үр дүн гардаг сэдэв.

Өчигдөр Засгийн газрын 2 гишүүн уучлал гуйж огцорлоо (чөлөөлөгдөх өргөдлөө өглөө). Учир явдлыг бүгдээрээ мэдэж байгаа байх.

Болсон үйл явдалд хэн буруутайг би энд ярихгүй. Гар, биеэр шууд оролцсон зүйл байгаа эсэхийг ч би мэдэхгүй.

Гэхдээ эрхэлсэн ажил, хариуцсан салбарынхаа хүрээнд бусдын өмнөөс уучлал гуйж чаддаг, ёс суртахууны хариуцлага хүлээж чаддаг жишиг, эерэг хандлага нийгэмд бий болж буйн бодит хүчтэй дохио гэж хэлж болно байх.

Сургалтад оролцогчдын хүрээ өргөжиж өнөөдөр хилийн чанадаас хамрагдлаа.

Монголчууд эрт цагаас элчин харилцаа-дипломат албыг Монгол төрийн алтан аргамж хэмээн эрхэмлэж ирсэн уламжлалтай. Энэ алтан аргамжийг энэ цагт “авч яваа” дипломатууд маань манай сургалтад оролцож байна.

БНХАУ-ын Өвөр Монголын Өөртөө засах орны Хөх хотод суугаа ерөнхий консул С.Батхуяг тэргүүтэй консулын газрынханд талархал илэрхийлж, амжилт хүсье.

Сургалт явуулах талаар санаачилга гарган ажиллаж буй Сургалт, судалгаа, мэдээллийн нэгдсэн сангийн газрынхандаа болон Д.Зүмбэрэллхам гишүүндээ, мөн уригдан ирж мэдлэг, мэдээллээ хуваалцсан Я.Долгоржав багшдаа талархал илэрхийлье.


Сургалтаас ойлгож мэдсэнээ үйл ажиллагаа, амьдрал ахуйдаа шингээж чадвал хувь хүнд, байгууллага, салбарын ажилд, том зургаараа шинэтгэлд маань тус дэмтэй.

Төрийн албан хаагчийн ёс зүйн хэм хэмжээг хууль, дүрэм журмаар зохицуулж болох боловч хүний итгэл үнэмшил, зан төлөвөөр дамжин хэрэгжих нь тодорхой.

Төрийн албаны ёс зүйн хэм хэмжээг сахиулахын тулд хуулийн заалтыг мөрдөн ажиллах, ёс зүйн дүрмийг сахин мөрдүүлж, сахилгын арга хэмжээ авч болно.

Гэхдээ байгууллагын соёл, удирдлагын манлайлал, албан хаагчдын зан төлөвт тулгуурласан **ёс зүйн менежментийг** хэрэгжүүлэх нь хамгийн чухал гэдэг юм билээ шүү.

---o0o---



“Төрийн байгууллагад зан үйлийн менежментийг хэрэгжүүлэх нь” сургалтыг хааж хэлсэн үг

2021.01.14

....Төрийн албан хаагчдыг ёс зүйн зөрчлөөс урьдчилан сэргийлэх, байгууллагуудын ёс зүйн зөвлөлийн чадавхыг сайжруулах арга зүйн цуврал сургалт явагдаж байгааг бүгдээрээ мэднэ.

Эдгээрийн нэгийг А.Алтанзул багш Төрийн албаны зөвлөлийн Ажлын албаныханд хийснээс хойш яг нэг долоо хоногийн дараа өнөөдрийн сургалт болж өнгөрлөө.

Байгууллагынхаа хүмүүст ажлын байран дээрээ сурах, мэдэх, санаж бодох боломж олгох талаар санаачилга гарган ажиллаж буй Сургалт, судалгаа, мэдээллийн нэгдсэн сангийн газрынхандаа болон Д.Зүмбэрэллхам гишүүндээ, мөн уригдан ирж мэдлэг, мэдээллээ хуваалцсан Ч.Эрдэнэчимэг багшдаа талархал илэрхийлье.

Сургалтын үеэр нэг зүйл санаанд орлоо.

Жил хагасын өмнө Энэтхэгийн Холбооны Төрийн албаны зөвлөлийн урилгаар тус улсад ажиллаад буцах үедээ онгоцонд хамт зорчиж явсан нэг хүнтэй танилцсан юм. Швейцарын “Би Эс Си” гэдэг зан төлөвийн шинжлэх ухааны зөвлөгөө өгдөг компанийн сургагч багш байсан.

Энэтхэгийн 2 байгууллагад 3 хоногийн сургалт явуулаад Хятад руу очиж 2 хоног ажиллахаар буцаж байгаа нь тэр аж. Хийсэн ажил, явуулсан сургалт, өгсөн зөвлөгөөнийх нь агуулга, ач холбогдол тодорхой.

Ярианы явцад 3 хоног ажилласных нь төлбөр ойролцоогоор 8-9 мянган доллар гэдгийг мэдэж авч билээ.

Та бид нар ийм л үнэ цэнтэй байдаг сургалт, зөвлөгөөний нэг хэсгээс өнөөдөр сонслоо, кэйс дээр ажиллаж илүү мэдэрлээ.

Зан төлөвийн үнэ цэнтэй сургалтыг үйл ажиллагаа, амьдрал ахуйдаа шингээж чадвал юуны өмнө тухайн хувь хүнд, цаашлаад байгууллага, салбарын ажилд, том зургаараа бол хийж хэрэгжүүлж байгаа шинэтгэлд маань тус дэмтэй гэж ойлгож байгаа.

Бихайвориал сайнс (behavioral science) буюу зан төлөвийн шинжлэх ухаан, үүнтэй холбоотой ойлголт, нэр томъёо 1950-аад оноос бизнесийн байгууллагуудад нэлээд нэвтэрч, системтэй судалгаа шинжилгээ хийгдэж ирсэн гэдэг юм билээ.

Би энэ талаар нарийн судлаагүй. Гэхдээ “зан үйл” гэхээр, тухайлбал бэр буулгах, уул овоо тайх, хүүхдийн даахь үргээх гэх мэт уламжлалт соёлын ойлголтууд санаанд ороод байдаг. Тэгэхлээр “зан төлөв” гэдэг үг илүү тохиромжтой юм шиг санагддаг, хувийн л бодол шүү.

Англичууд “Бихайв ёоо сээлф” (Behave yourself) гэж хүүхдэдээ хэлдэг гэдэг, манайхаар бол “томоотой байгаарай” гэсэн санаа.

Найранд явж байгаа найз нөхдөдөө ч ингэж хэлдэг гэсэн, ууж идэхдээ, баярлаж хөөрөхдөө бусдад садаа болохгүй байж, бас өөрийгөө эвгүй байдалд бүү оруулаарай гэсэн утгатай юм уу даа.

Манайханд энэ талын ойлголт, сургаал үг, зүйр цэцэн үгийн эртний уламжлал бий.

Бидний багад «Номыг нь сурахгүй юм бол номхныг нь сур» гэх хүүхдээ “зэмлэсэн” үг чих шүргэдэг л байсан. Ухаандаа бол хичээлээ таслахгүй, бусдыг үймүүлэхгүй, сурах гэсэн нэгэндээ төвөг учруулахгүй бай гэсэн үг л дээ.

“Хүний номыг үзсэн хүнд номын номыг үзүүл. Хүний номыг үзээгүй хүнд номын номыг бүү үзүүл” гэсэн үг ч байдаг.

Хаа байгаа газраа хүн шиг хүн байж ажиллаж, амьдрах гэдэг аль ч цаг үед байж.

Тэгэхлээр хэн боловч, тэр дундаа төрийн албан хаагч хүн харилцаа, хандлага, биеэ авч явах байдал гээд хэн хүн нэг их анзаарамгүй хэрнээ их чухал ойлголтыг дэлхий нийтээрээ төр, хувийн хэвшил ялгаагүй “зан төлөв” гэдэг үгээр дамжуулан хэрэглэж, хэрэгжүүлж байгаа нь тохиолдлын хэрэг биш биз.

Шинэ ойлголт биш нь ойлгомжтой, гэхдээ шинэ юм гэж сайтар хуучирсан зүйлийг хэлдэг гэдэг.

Төрийн албаны шинэтгэлийн хүрээнд хэрэгжүүлж буй олон арга хэмжээний нэг нь сургалт. Сургалтын арга, хэлбэрүүд улам боловсронгуй, илүү сонирхолтой, шинэлэг болсоор байна.

Нэг нь номлодог, нөгөө нь идэвхгүй сонсож өнгөрөөдөг байдлаас улам бүр алсарч байгаа байдал энэ сургалтаас ч мөн адил мэдрэгдэж байна.

Төрийн албан хаагчийн ёс зүйн хэм хэмжээг хууль, дүрэм журмаар зохицуулж болох боловч төрийн албан хаагчдын итгэл үнэмшил, зан төлөв, биеэ авч явах байдлаар дамжин хэрэгжих нь тодорхой.

Иймээс төрийн албаны ёс зүйн хэм хэмжээг сахиулахын тулд хуулийн заалтыг мөрдөн ажиллах, ёс зүйн дүрмийг сахин мөрдүүлэх, сахилгын арга хэмжээ авахаас гадна байгууллагын соёл, удирдлагын манлайлал, албан хаагчдын зан төлөвт тулгуурласан **ёс зүйн менежментийг** хэрэгжүүлэх хэрэгцээ, шаардлага нэмэгдсээр байна.

Ялангуяа албан хаагчдын зан төлөвт тулгуурласан үйл ажиллагааг зохион байгуулах зорилгоор системийн хэмжээнд зарим арга хэмжээг хэрэгжүүлэх, байгууллагын соёлыг өөрчлөх зэрэг үйл ажиллагааг гадаад улс орнууд авч хэрэгжүүлэх болжээ.

Өртөг зардал бага шаардагддаг, үр дүнтэй арга хэмжээг авч хэрэгжүүлэх нь ухаалаг, бас тогтвортой засаглалыг бий болгох, төрийн албыг төлөвшүүлэх, хүний эрхийг дээдлэх, иргэдийн төрд итгэх итгэлийг нэмэгдүүлэх, шударга ёсны тогтолцоог бүрдүүлэхэд чухал ач холбогдолтой.

Сургалт, хөгжлийн асуудал ямагт эн тэргүүнд тавигдах учиртай. Сурсан, мэдсэн, хөгжсөн хүн ажилдаа амжилт гаргаж, сайн зан төлөвтэй хүн өөртөө болон эргэн тойрондоо эерэг уур амьсгал төрүүлнэ. Үр дүнд нь байгууллагын сайн соёл тогтох нь дамжиггүй.

Эрүүл мэнд, амжилт бүтээлийн эхний, бас зайлшгүй эзэмших шат дамжлагад богино хугацаанд ч болов суралцлаа, бүгдээрээ.

---o0o---



2021 ОН ТӨРИЙН АЛБАНЫ ШИНЭТГЭЛД ТУЛГАМДАЖ БУЙ АСУУДАЛ, СОРИЛТЫГ ШИЙДВЭРЛЭХ ЖИЛ

2021 онд төрийн албаны шинэтгэлийн хүрээнд Төрийн албаны зөвлөлийн тавьж буй зорилт, төсөөлөл²


Төрийн албаны тухай хуульд заасан зарчмыг мөрдүүлэх хүрээнд сахилга хариуцлага, ёс зүйг төрийн байгууллагын бүх шатанд чанд мөрдүүлж, мэргэшсэн, чадварлаг, ил тод, хариуцлагатай төрийн албыг бэхжүүлэх талаар Төрийн албаны зөвлөлөөс 2021 онд дараах зорилт, үйл ажиллагааг төлөвлөн хэрэгжүүлнэ.

Иргэдээ дээдэлсэн төрийн үйлчилгээг төлөвшүүлэх хүрээнд



- Төрийн үйлчилгээг иргэдэд хүргэх үйл ажиллагааг судалгаанд суурилан боловсруулж чанарын ахисан түвшинд хүргэнэ.
- Төрийн албаны үйлчилгээний чанар, хүртээмж, үр нөлөөнд олон нийтийн хяналтыг хэрэгжүүлэх зөвлөлийн дүрмийг батлан үйл ажиллагааг эхлүүлнэ.

Мэргэшсэн, чадварлаг төрийн албыг бэхжүүлэх хүрээнд



- Төрийн албан хаагчийн томилгоотой холбоотой шийдвэрийг байгууллага, хүн бүрээр хянан шалгаж, зөвхөн хуульд нийцсэн шийдвэр хэрэгжих нөхцөлийг бүрдүүлнэ.
- Чадварлаг, үр дүнтэй ажиллаж байгаа төрийн албан хаагчийн эрхийг хамгаалж, тогтвортой ажиллуулна.
- Төрийн албан хаагчдыг зохих шатны мэргэшүүлэх сургалтад хамруулж буй байдалд хяналт тавьж, сургалтын тогтолцооны үйл ажиллагааг жигдрүүлнэ.
- Төрийн албаны хүний нөөцийн мэдээлэл, цалингийн нэгдсэн системийг холбох ажлыг бүрэн дуусгаж, төрийн албан хаагчийн мэргэшсэн, тогтвортой байдалд байнгын хяналт тавих бололцоог бүрдүүлнэ.


² Төрийн албаны зөвлөлийн 2020 оны үйл ажиллагааны тайлан

Улс төрийн нөлөөллөөс ангид төрийн алба байх хүрээнд



- Төрийн албаны үйл ажиллагаанд улс төрийн зүй бус нөлөөлөл үүсэхээс урьдчилан сэргийлэх, таслан зогсоох арга хэмжээг өргөжүүлэн зохион байгуулна.
- Төрийн албан хаагч улс төрийн аливаа нөлөөллөөс ангид байх үүрэг, хариуцлагын хэрэгжилтэд тавих хяналтыг чангатгана.

Төрд чин үнэнчээр зүтгэх иргэдийн тэгш боломж олгох хүрээнд



- Төрийн албаны сонгон шалгаруулалтын үйл ажиллагааг бүрэн цахимжуулж хөндлөнгийн нөлөөллөөс ангид, ил тод, нээлттэй явуулах нөхцөлийг хангана.
- Төрийн албаны шалгалтад иргэдийн оролцох боломжийг хуулийн хүрээнд тэгш нөхцөл бүрдүүлнэ.
-

Чадахуй (мерит)-н зарчимд суурилсан томилгооны хүрээнд



- Төрийн байгууллагуудын үйл ажиллагаанд хүний нөөцийн аудит хийж чадахуйн зарчмыг мөрдүүлэх ажлыг жигдрүүлнэ.
- Төрийн захиргааны удирдах, гүйцэтгэх албан тушаалд тавигдах ур чадварын шалгуур үзүүлэлтүүдийг олон улсын чиг хандлагад нийцүүлэн боловсруулж албан тушаалын тодорхойлолтод тусган батална.
- Сэтгэл зүйн тестээр хувь хүний ёс зүй, зан төлөв, харилцаа, хандлагыг тодорхойлох арга, аргачлалыг төрийн албаны удирдах албан тушаалтны сонгон шалгаруулалтын үйл ажиллагаанд туршин нэвтрүүлнэ.
- Төрийн албаны зөвлөлөөс сонгон шалгаруулалтын дүнгээр 2019- 2021 онд нэр дэвшүүлж томилуулсан удирдах албан тушаалтны манлайллын байдалд судалгаа хийж, холбогдох арга хэмжээ авна.

Нээлттэй, ил тод төрийн албыг төлөвшүүлэх хүрээнд



- Төрийн албаны хууль, тогтоомж зөрчиж томилогдсон болон төрийн албанд ажиллах эрх хасагдсан хүмүүс, хүний нөөцийн асуудлаар хууль бус шийдвэр гаргасан албан тушаалтны талаар нийтэд ил тод мэдээлэх ажлыг хэвшүүлнэ.
- Төрийн албан хаагч, иргэдийн мэдээлэл авах, ашиглах боломжийг нэмэгдүүлэх замаар Төрийн албаны зөвлөлийн тогтоол, шийдвэр, үйл ажиллагааг олон нийтэд хүргэх тогтолцоог бүрдүүлнэ.

Ашиг сонирхлын зөрчлөөс ангид төрийн албыг төлөвшүүлэх хүрээнд



- Төрийн албаны сонгон шалгаруулалтын дүнгээр нэр дэвшүүлсэн хүний хувийн ашиг сонирхлын урьдчилсан мэдүүлгийг хянан зөвшөөрөл олгох хамтын ажиллагааг өргөтгөнө.
- Төрийн албаны зөвлөлийн хяналт шалгалтаар тогтоогдсон хууль бус шийдвэр бүрийг АТГ-т хүргүүлэн ашиг сонирхлын зөрчилтэй холбоотой эсэхийг шалгуулж хариу авдаг хамтын ажиллагааг хэвшүүлнэ.

Хариуцлагатай төрийн албыг төлөвшүүлэх хүрээнд



- Төрийн албан хаагчийн гүйцэтгэлийн үнэлгээнд болон сахилгын зөрчилд үндэслэн тухай бүр үр дүнд тохирсон хариуцлага тооцно.
- Ёс зүйн зөрчлийн мэдээллийн нэгдсэн тогтолцоог бий болгож, соён гэгээрүүлэх үйл ажиллагааг идэвхжүүлнэ.
- Төрийн албаны хууль, тогтоомж зөрчсөн удирдах ажилтанд зохих арга хэмжээ тооцуулах ажлыг үргэлжлүүлэн зохион байгуулж, иргэдийн төрд итгэх итгэлийг нэмэгдүүлнэ.

---o0o---



ТАЗ-ийн Салбар зөвлөлийн нарийн бичгийн дарга нарт зориулсан мэдээллийн цагийг хааж хэлсэн үгнээс

...Та бүхэн санаж байгаа байх, өнгөрсөн жил хагасын хугацаанд миний явсан газар болгондоо хэлж байсан нэг үг бий, тэр бол “ВУКА” ертөнц/орчин.

Хувьсамтгай, тодорхойгүй, төвөгтэй, эргэлзээтэй байдал



Сая шинээр томилогдсон Засгийн газрын гишүүдэд ч миний зүгээс үүнийг онцгой анхааруулсан.

Ингээд та бүхэнд хэдэн зүйл дээр анхаарч ажиллахыг сануулъя.

2. Салбар зөвлөлийн нарийн бичгийн дарга нар орон тооны болж, эрхлэх ажил, чиг үүрэг нь тодорхой болсон цаг үед бид нар уулзаж байна. Ажилдаа идэвхтэй, маргаашдаа итгэлтэй байгаа дүр зургийг бид харж байгаа.
3. Орон нутагт өнгөрсөн жил бүрэн ажилласан. Энэ жил түүвэр байдлаар зарим аймаг, сумдад ажиллаж КОВИД-19-ийн үе дэх онцлог цаг үед хэрхэн ажиллаж буй талаар газар дээр нь танилцсан. Эерэг нааштай сэтгэгдэлтэй байгаа.
4. Өнөөдрийнх шиг ажил хэргийн уулзалт, мэдээллийн цагийг тогтмолжуулъя

5. Салбар зөвлөл хоорондоо мэдлэг, туршлагаа солилцох цаг гаргаж, салбар зөвлөлүүдийн шинэлэг ажил, шийдлүүдийн талаар урьдчилсан хуваарь гаргаж сонсож байя.
6. Төрийн албаны ерөнхий шалгалт хэзээ болох талаар их асууж байна. Улсын онцгой комисс шийдвэр гаргавал хэзээ ч авахад бэлэн байгаа бөгөөд нэмэлт бүртгэл хийж, шинэ төгссөн, амжиж бүртгүүлээгүй хүмүүст боломж олгоё гэсэн байр суурьтай байна.
7. Хууль, дүрэм журмуудаа дахин нэг сайн уншаарай, орон нутаг дахь төрийн албаны шинэтгэлийн “нэвтэрхий толь” нь та нар шүү. Асуудал өдөр бүр тохиолдоно, мухардалд орохгүй байх, гарц, шийдлүүдийг санал болгох хамгийн чухал хүмүүс бол та нар.
8. Та бүхэн Төрийн албаны зөвлөлийн халуун бүлийн хүмүүс. ТАЗ-ийн ажилтан, албан хаагчидтай байнгын холбоо харилцаатай байгаарай. Та бүхэн орон нутагт бидний “түшиц” бол ТАЗ та бүхний нийслэл дэх “түшиц” юм. ТАЗ, Салбар зөвлөл байнгын холбоотой байх сувагтай болно. Одоогийн фэйсбүүк групп, хааяа цахим шуудан солилцдог, утсаар ярьдгаас илүү шуурхай, халуун шугам (hotline) холбооны шугамтай больё.
9. Төрийн албаны зөвлөл үндсэндээ амралтгүй ажиллаж байгаа. Сонгон шалгаруулалт, шалгалттай холбоотой асуудлууд харьцангуй бага байгаа цагийг ашиглаж хүний нөөцийн аудит, хүний нөөцийн систем, программ хангамжийн хөгжүүлэлт зэрэг ажлууддаа цаг, хүчээ төвлөрүүлэн ажиллаж байна. Шалгалтын сорил, даалгавруудаа улам боловсронгуй болгож байна. Сургалтын танхимаа ч тохижуулж байна. Цаг хожиж, цаг ашиглах тал дээр илүү шаргуу, шуурхай ажиллаж байна.
10. Салбар зөвлөлийн нарийн бичгийн дарга нараа илүү боловсруулах, мэдээлжүүлэх, гадаад, дотоодын томилолт, сургалтад хамруулах талаар та бүхний хэрэгцээнд суурилсан баримт бичиг гаргах чиглэлээр ажиллая.

Ажил, амралтаа зохицуулаарай. Эрүүл мэнд, ажлын ачааллаа байнга бодож яваарай. Та бүхэндээ сайныг хүсье.

---o0o---



Төрийн албаны зөвлөлөөс яамдын дэргэдэх Салбар зөвлөлийн дарга, нарийн бичгийн дарга нартай хийсэн цахим уулзалт дээр хэлсэн үг

2020.12.22

...Хамгийн урт шөнө, хамгийн богино өдөр давхардсан, балчир ес эхэлж байгаа байгаль ертөнцийн тохиолтой бидний уулзалт давхцаж байна.

....Нөхцөл байдал тийм ч таатай бус, ажил үйлс, эрүүл мэнддээ санаа тавьсан, цаг зав багатай үеийг бүгдээрээ туулж байна. Цаг үеийн хүндрэл бэрхшээлийг улс нийгмээрээ хохирол багатай даван туулахад Та нарын оролцоо, чармайлт онцгой чухал байгааг онцлон тэмдэглэе.

Төрийн албаны зөвлөлийн гишүүд маань чиглэл чиглэлээр дэлгэрэнгүй мэдээлэл, чиглэл өглөө. Ойлгомжтой, тодорхой зүйлсийг хийж хэрэгжүүлэхэд дөхөмтэй, бас урамтай байдаг.

Та бүхэнд тийм мэдрэмж төрсөн гэдэгт эргэлзэхгүй байна.

Ингээд өмнөх хүмүүстэй давхардуулалгүйгээр зарим зүйлийг хэлье.

Нэг. Бид өмнө болж байсан уулзалт, хурал, сургалтын үеэр Салбар зөвлөлүүдээс тавьж ирсэн, санал болгосон асуудлуудыг шуурхай шийдвэрлэхийн төлөө ажиллаж ирлээ.

1. Дэс түшмэлийн албан тушаалд томилоход гардаг байсан нэг “гацаа”-г бүгдээрээ мэднэ. Туслах түшмэлээр 2 жил ажилласан байх энэ шаардлагыг болиуллаа.

Хууль зүй, дотоод хэргийн яаманд бүртгүүлсэн учир энэ ажил хэрэгжих боломжтой болсон. Томилгоонд эерэг нөлөө үзүүлнэ.

2. Ерөнхий шалгалтыг энэ 11 сард 100 хувь цахимаар зохион байгуулж, төрийн албаны нөөцөө хангалттай бүрдүүлсэн.

Нөөцөд байгаа хүмүүс тусгай шалгалт өгөөд л ажилд орох эрх нь нээгдэж байна гэсэн үг.

3. Байгууллага хооронд ижил албан тушаалд хүмүүсээ шилжүүлж болоод байдаг хэдий ч байгууллага дотроо шилжүүлэхэд гацаа үүсдэг байсныг арилгах шийдэлд бид хүрч байна.

Засгийн газрын ХЭГ-тай хамтран гаргадаг журамд оруулах санал дүгнэлтээ Төрийн албаны зөвлөл гаргасан. Ойрын хугацаанд эцэслэн шийднэ.

4. Төрийн албанд туршлага, мэдлэг, ур чадвартай тэтгэврийн насныхнаа ажиллуулахад ямар бодлого баримтлах юм?

Нөгөө талаас нөөцөд байгаа эрч хүчтэй, өндөр боловсролтой залуучуудаа яаж идэвхтэй ажиллуулах вэ?

Дээрх эмзэг ч гэмээр асуудал аль ч орны төрийн албанд тохиолддог юм билээ.

Үүнийг асуудал гэхээсээ илүүтэй шийдэл гэж харж, ахмад, залуу үеийн хэлхээ холбоонд тулгуурласан тэнцвэр балансыг нь оновчтой барих бодлого гаргахыг эрмэлзэж байгаа. Зөвлөмж боловсруулж, яамдаас санал авч байна.

5. Шинэ цаг үе, шинэ орчинд шинэ шинэ сорилтуудыг даван туулах учиртай төрийн албан хаагчдад ямар ямар ур чадвар шаардагдах ёстой эсэхэд хариулт өгөх Ажлын хэсгийг Төрийн албаны зөвлөлөөс томилон ажиллуулж байна.

Монгол төрийн уламжлал, улс орны онцлог нөхцөл байдал, соёл дээр суурилсан орчин үе, олон улсын шаардлага, чиг хандлагад нийцсэн баримт бичиг гарна. Үндэсний болон олон улсын өндөр түвшний экспертүүдтэй хамтран ажиллаж байгаа.

Ямар ямар ур чадвар, ямар хандлагатай хүн аль түвшний, аль ангилалд нийцэж ажиллах вэ гэдгийг тодорхойлох томоохон ажлыг ийнхүү эхлүүлээд байна. 2021 онд ур чадвар, хандлагын энэ баримт бичгийг баталгаажуулна.

Удирдах албан тушаалтнуудад сэтгэл зүйн тест нэвтрүүлэх ажлыг мөн туршин нэвтрүүлнэ. Төрийн байгууллагын эд эс бүхэнд нэвтрүүлэх энэ ажлыг Та бүхэн манлайлан хэрэгжүүлнэ.

Хоёр. Цаашид анхаарах асуудлуудын талаар

1. Томилох эрх бүхий албан тушаалтнууд албан тушаалын тодорхойлолтын болзол, шаардлага хангаагүй хүнийг томилох санал гаргамагц Авлигатай тэмцэх газраас лавлаж тодруулсан бичиг Төрийн албаны зөвлөлд байн байн ирүүлэх боллоо.

Шаардлага хангаагүй хүнийг шаардлага хангасан мэтээр томилно, томилохоор төлөвлөнө гэдэг хар сэр үүсгэх зайлшгүй нөхцөл.

Үүний ард өгөө авааны цонх нээгээд байгааг ч үгүйсгэхгүй. Үүнд онцгой анхаарах хэрэгтэй.

2. Тусгай шалгалтууд зохион байгуулагдаж, сул орон тоог нөхөх ажил байнга хийгдэж байгаа. Үүнтэй холбогдуулж “нэг юм” онцлон анхааруулъя.

Үндэсний хэмжээнд асуудлыг харж, олон улсын хэмжээнд сэтгэх учиртай ажил хийхээр шалгалт өгч буй хүмүүс заримдаа “андуураад” өөр оноо авчих гээд байна.

Шалгалт авч байгаа нь ч, шалгалт өгч байгаа нь ч аль аль нь маш сайн бэлтгэж байх хэрэгтэй байна.

3. Бид хуулийг ойлгуулах, хэрэгжүүлэх ажлыг чамгүй хийлээ, хийсээр байна. Одоо энэ бүхнийгээ дадал хэвшил болгож, үр дүнд хүргэх цаг болсон.

Яг энэ цаг үед Салбар зөвлөлүүд тайлангаа ирүүлж байгаа.

Жишээ нь, тийм чиглэлээр төдөн хүнийг оролцуулсан сургалт зохион байгууллаа гээд л тайлан ирж байх.

Харин хандлага, соёл яаж өөрчлөгдөж, ямар үр дүнд хэрхэн хүрч байгааг ор тас орхичих юм.

Одоо хууль тогтоомжийг ойлгуулах гэхээсээ илүүтэйгээр хэрэгжилтийг нь ажил амьдралдаа нэвтрүүлсэн тухай асуудлыг хөндөж байяа аа.

4. Төрийн албанд хийгдэж буй шинэтгэлийн суурь баримт бичиг Төрийн албаны хуульд 8 зарчим бий.

Үүнийг Та бүхэн бүгдээрээ үг үсгээр нь мэдэж байгаа. Ирэх 2021 оныг энэ 14 зарчмуудыг бүрэн хэмжээгээр нь хэрэгжүүлэх жил болгохын төлөө ажиллана. (Үндсэн хуулийн 6 зарчим+Төрийн албаны тухай хуулийн 8 зарчим)

5. Хүний нөөцийн бодлого хэрэгжүүлэх суурь бүтэц нь Салбар зөвлөл.

Салбар зөвлөлийн чадавхыг дээшлүүлэх, үүрэг хариуцлагыг нь өндөржүүлэх ажилд 2021 онд мэдэгдэхүйц ахиц гаргая.

Сургалт, мэдээлэл солилцооны боломжит бүхий л хувилбаруудыг ашиглан орчин цагтайгаа хөл нийлүүлж, “хүний нөөц”-ийн талбарт амжилттай ажилладаг хүний нөөцийн менежерүүд бидэнд маш чухал байна.

Аливаа ажлыг ХҮН л хийх учиртайгаас хойш хүний нөөцийн бодлого боловсруулагч, хэрэгжүүлэгч хүмүүс байгууллагын гол түшиг тулгуур болж явдаг цаг үеийнхээ шаардлагыг бүгдээрээ дагая.

6. Энэ онд шинэ дүрэм, бүрэлдэхүүнтэй ажиллаж эхэлсэн Ёс зүйн зөвлөлүүдийн үйл ажиллагааг тогтмолжуулж, үйл ажиллагааг нь бэхжүүлэх талаар 2021 онд онцгой анхааръя.

Уг ажилд хяналт тавих, шахаж шаардах субъект нь ганцхан Төрийн албаны зөвлөл биш.

УИХ-ын удирдлага, Төрийн байгуулалтын байнгын хороо, Ёс зүй, сахилга хариуцлагын байнгын хороо онцгой анхаарал хандуулж байгааг 10 сард болсон зөвлөгөөнөөс бүгдээрээ санаж байгаа.

Дараа нь 3 байнгын хорооны удирдлага Төрийн албаны зөвлөлд ажилласан, хийж хэрэгжүүлэхээр төлөвлөсөн ажлуудыг улс төрийн дэмжлэгээр идэвхжүүлэхээр тохирсон.

Ёс зүйгүй байдал, хандлага, үйлдлийг үл тэвчих соёлыг байгууллага бүртээ хэвшүүлэх талаар тодорхой, барьцтай ажил хийе, 2021 онд.

Ёс зүйн зөвлөлүүдийн сайн ажлын туршлагыг хуваалцъя.

Аль аль чиглэлээр мэдлэг, туршлагаа хуваалцах ажилд ахиц гаргая. Дэм дэмэндээ гэдэг байх аа.

Хийж чадахгүй бол нэрэлхэж зоволгүй бусдаасаа суралцах, хийж чадаж байгаа бол бусадтайгаа хуваалцахыг хичээж ажиллая.

7. Төрийн албанд жендерийн эрх тэгш байдлыг хангах талаар эрх зүйн зохицуулалт бидэнд багагүй бий.

Гүйцэтгэх түвшинд хуулийн шаардлага, олон улсын жишиг хангалттай хэрэгжээд байдаг ч удирдах албан тушаал дээр арай өөр статистик гараад байдаг.

Хэдийгээр сонгон шалгаруулалт ямар нэг алагчлалгүй, эрх тэгш явагдах ёстой ч удирдах албан тушаалын сул орон тоонд эмэгтэйчүүд эргэлзээ тээнэгэлзэлгүй ордог байх тийм уур амьсгал, соёлыг хэвшүүлэх талаар идэвхтэй ажиллацгаая.

Товчхондоо эрхэлсэн, тэргүүн түшмэлийн ажилд эмэгтэйчүүдийн эзлэх хувийг нэмэгдүүлэх ажлыг дэмжсэн бодлогыг хөтөлбөрөөр хэрэгжүүлье. Энэ тал дээр та бүхэнд анхаарч, ажил хэрэг болгох зүйл их бий.

8. 2021 оныг “Бийд нэмэргүй, үгүйд гарзгүй” тийм нэг дундаж хүн төрийн албанд байх орон зай улам бүр хумигдаж байгаа нийгмийн орчин, нийгмийн уур амьсгалыг дор бүрнээ мэдэрч ажиллах жил болгоё.

Үгийн эхэнд хэлсэн, төр, иргэд хамтраад сорилт давааг гэтэлж л явна гэж.

9. Идэвхтэй ажиллаж байгаа, 2020 онд үр дүнтэй ажилласан хүмүүсээ урамшуулж, сайн нэгжээ алдаршуулах, үйл ажиллагааг нь, үр дүнг нь нийтийн хүртээл болгох тал дээр анхаараарай.

Урам дэм, сахилга хариуцлагын дэнс, тэнцвэр дээр хүний амьдрал өрнөдгийг хамгийн сайн мэдэх улс бол та бүхэн шүү. Төрийн албанд дандаа л саар юм харагдаад байдаг, гэтэл болж бүтээж, хийж хэрэгжүүлж байгаа өчнөөн зүйлсээ олон нийтэд хүргэх, ойлгуулах тал дээр дутагдалтай байна.

10. 2021 онд төрийн албан хаагчдын нийгмийн баталгааны эрх зүйн үндсийг сайжруулах чиглэлээр Төрийн албаны зөвлөл ажиллана.

Одоо бол 36 хүртэлх сарын тэтгэмж, удаан жилийн нэмэгдэл, нэмэгдэл хөлс гээд байгаа.

Цаашдаа олон журам, дүрмүүд дээр сууна.

Ангилал, зэрэглэлийн асуудалд өөрчлөлт оруулах санал дүгнэлт боловсрууллаа. Засгийн газар, салбар яамд идэвхтэй оролцож байгаа, судалгааны ажлууд үндсэндээ хийгдсэн.

Өнөөдөр хэлж яригдсан зүйлсийг ажил дээрээ тусган авч хэрэгжүүлээрэй.

Цаашид ч олон чиглэлээр зөвлөмж хүргүүлнэ.

Зөвлөмж гэхээр зөөлөн сонсогдоод байж магадгүй.

Зөвлөнө гэдэг алдахаас сэргийлж, онож ажиллахыг дэмжиж буй хэрэг. Нөгөө талаар алдаа гаргаад байгаа чиглэлээр өгч буй сануулга дохио, шүүмжлэл ч гэж ойлгож болно.

Төрийн нарийн бичгийн дарга гэдэг манай төр, улсын хамгийн эрхэмсэг нэртэй албан тушаал гэж би хувьдаа боддог. Төрийг төлөөлж, төрийн нэрийн өмнөөс бүхэл бүтэн салбарын хөгжил, хүний нөөцийн бодлогыг явуулж, төсвийг шууд захиран зарцуулж байгаа ажилтнууд бол Та бүхэн.

Төр, иргэд ширээний хоёр талаас бие биеэ харах бус, нэг тийшээ зэрэг харж чаддаг болж гэмээнэ иргэн төвтэй, итгэл даах төрийн албыг бид төвхнүүлж чадна. Хуулийн зарчмууд ч тийм байгаа. Алсын хараа-2050-ын үзэл санаа ч мөн адил.

Цаг хугацааны эргүүлэг, дэлхий нийтийн хөгжлийн хурдад бүдрэн унахгүй, харин ч цаг үеэ өөрсдөө хөтлөн жолоодох тийм цаг үед төрийн алба хашиж буйгаараа бид бахархах ёстой.

Ийм байх эрх, үүрэг хуулиар Та бүхэнд ногдсон.

Энэ эрх, үүргээ хэрэгжүүлэхдээ:

- инновац шингэсэн,
- шинийг эрэлхийлсэн,
- асуудлаас зугтан зайлах биш
- шийдэл, гаргалгааг олж чаддаг чадварлаг төрийн албыг
- чадахуйн зарчим-мерит, шатлан дэвших тогтолцоогоор “бүтээх” алсын хараатай ажиллахыг Та нартаа хүсье.

---o0o---



***“Төрийн албаны шинэтгэл-ёс зүйн хандлага”
сэдэвт төрийн байгууллагуудын Ёс зүйн
зөвлөлийн нэгдсэн зөвлөгөөнд хэлсэн үг***

2020.09.10

Эрхэм Улсын Их Хурлын дарга аа, Улсын Их Хурлын Ёс зүй, сахилга хариуцлагын байнгын хорооны дарга Б.Бат-Эрдэнэ болон УИХ-ын эрхэм гишүүд ээ, Канад Улсаас Монгол Улсад суугаа Онц бөгөөд Бүрэн эрхт Элчин сайд Катрин Ивкоф, НҮБ-ын Хөгжлийн хөтөлбөрийн суурин төлөөлөгчийн орлогч Нашида Саттар, энд хүрэлцэн ирсэн зочид, төлөөлөгчид, цахимаар холбогдож буй нийт хүмүүст энэ өглөөний мэнд хүргэе!

Та бидний оршин амьдарч, ажил үйлсдээ шамдан байгаа энэ цаг үеийг дэлхий нийтээрээ хувьсамтгай, тодорхойгүй, төвөгтэй, эргэлзээтэй **ВУКА эрин** гэж тодорхойлж байна.

Төр, бизнес, гэр бүл, хувь хүний аль алиных нь үйл ажиллагаа, бодлого төлөвлөлтөд зайлшгүй анхаарах зүйлийн нэг ВУКА болсныг судлаач шинжээчид онцлох боллоо.

Өвөрмөц, онцгой энэ орчинд уян хатнаар дасан зохицох, хөрвөн хувирах хэрэг байнга гарч байна.

Үүнд нийцсэн өөрчлөлт, шинэтгэлийг байнга, шуурхай хийх шаардлага төрийн алба, төрийн албан хаагчдын үйл ажиллагаанд тавигдах болсон.

Оновчтой маневр хийх чадвартай, уламжлалт бусаар, системийн түвшинд бүтээлчээр сэтгэж ажиллахыг нөхцөл байдал биднээс шаардаж, шахаж байна.

Гэхдээ өөрчилж болохгүй, бас өөрчлөгдөж болохгүй, өөрчлөх ч шаардлагагүй нэг эрхэм юм байна аа.


Бусдаас үл хамаарах, үл шалтгаалах, гагцхүү өөрөө хийж чадах, ноён нуруугаа алдахгүй байвал зохилтой тэр гайхалтай зүйлийн тухай бид өнөөдөр ярилцах гэж байна.

Хэн хүний дотоод сэтгэлээс эхэлдэг, гаднаас бус өөрөөсөө хайж олдог хүний хамгийн нандин чанарын тухай энд хөндөж, онцолж байна.

Хүнлэг нинжин сэтгэл, ёс суртахууны зангилаа болсон ёс зүй, түүн дотроо төрийн албаны ёс зүйн талаар бид нар тусгайлан ярилцана.

Энэ **“юманд”** санхүүжилт, төсөв, хөрөнгө оруулалт шаардагдахгүй боловч **бодитой, баталгаатай үр дүн** шууд гардаг .

Таван үгний тохиолдлын сонголт болгож **“Итгэл даах төрийн албаны төлөө”** гэх энэ уриаг гаргаагүй ээ. Ухаад бодвол өргөн утга, гүн агуулга багтаж байгаа.



Төрийн алба гэдэг эзэнгүй хоосон ойлголт биш. Энэ албыг төрийн албан хаагч хүн Та хашдаг учир амьд, хөгжил хөдөлгөөнтэй институт.

Зөвхөн хүнд байдаг ёс зүйн асуудлыг төрийн албанд хамаатуулан ярьж байна.

УИХ-ын дарга Г.Занданшатар, Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын дарга Л.Оюун-Эрдэнэ нар Төрийн албаны зөвлөлд өнгөрсөн жил ажиллаж, төрийн албан хаагчийн ёс зүйн асуудлыг хамарсан өргөн хүрээтэй асуудлыг оновчтой, шуурхай зохицуулах талаар үүрэг, чиглэл өгч, санал бодлоо хуваалцсан.

Хийх ажлыг эрчийг нэмж, урам зориг ч өгсөн.

Бодож төлөвлөсөн олон ажлын үргэлжлэл болгож энэ зөвлөгөөнийг хийж байна. УИХ-ын Тамгын газар, НҮБ-ын Хөгжлийн хөтөлбөр, Канад Улсаас Монгол Улсад суугаа ЭСЯ-тай хамтран зохион байгуулж байна.

Төрийн албаны томоохон зөвлөгөөнийг 2011, 2018 онуудад 2 удаа хийж өргөн цар хүрээтэй асуудлыг хэлэлцэн зөвлөлдөж байсан бол энэ удаад цорын ганц асуудалд төвлөрч байгаагаараа онцлогтой.

Төрд, нийгэм, гэр бүл, ахан дүүсийнхээ хүрээнд ч нэг л зангаараа байж, төлөвшил хүмүүжлээр олж авсан хүн чанараа гээхгүй байхын утга учрыг бид нар ярилцах гэж байна. Шийдэл гарц олж, олон талаас нь авч үзэхийг хичээж байна.

Иргэд, олон нийтийн төрөөс алсарсан шижмийг богиносгон бөхлөх, төр иргэнийг ойртуулан ойлголцуулах шийдэл, гарц гаргалгаа бол бидний өнөөдөр ярих сэдэв.

Энд зөвхөн дарга, сайд нар биш хуулийн дагуу төрийн байгууллагуудад ажиллаж байгаа Ёс зүйн зөвлөлийн гишүүд оролцож байна. Та нар бол хамт олныхоо саналаар итгэл хүлээн сонгогдсон хүмүүс.



Төрийн албаны шинэтгэлийг шинэ хуулиар эхлүүлээд 20 сар болж байна.

Шинэтгэлийн хүрээнд хийж байгаа, хийхээр төлөвлөсөн олон ажлуудыг УИХ, Засгийн газар бүхий л талаар ойлгон дэмжиж ирлээ.

Парламентын бүтцэд Ёс зүй, сахилга хариуцлагын байнгын хороо байгуулагдсан нь УИХ-аас төрийн албаны шинэтгэлийг эрчимжүүлэхэд хүч нэмсэн, уг асуудалд өндөр ач холбогдол өгсөн хэрэг.

Нөгөө талаас ёс зүй, сахилга хариуцлагын асуудал төрийн албаны бүх шатанд, улс орны хэмжээнд ямар чухлаар тавигдаж буйн илрэл.



**Ёс зүй, сахилга
хариуцлагын
байнгын хороо**



**НҮБ-ын Хөгжлийн
хөтөлбөр**



**Канад Улсаас Монголд
Улсад суугаа Элчин
сайдын яам**

Орчин үеийн төрийн албаны эерэг төлөвшлийн нэгэн жишиг болж яваа Канад Улсын Засгийн газар бидэнд мэдлэг туршлага, хөрөнгө санхүүгийн бодит дэмжлэг үзүүлж, НҮБ-аас хамтарсан төсөл хэрэгжүүлж байна.

Энэ завшааныг ашиглан Та бүхэнд зөвлөгөөнд оролцогчдынхоо өмнөөс гүн талархал илэрхийлж буйг хүлээн авна уу.

Өргөн цар хүрээтэй, бэрхшээл сорилт ихтэй төрийн албаны шинэтгэлийг хуулиар тогтоосон зарчмыг баримтлан Үндсэн хуулийн үзэл санаанд нийцүүлэн “Алсын хараа-2050” урт хугацааны хөгжлийн бодлого, үүнд үндэслэсэн шинэ Засгийн газрын мөрийн хөтөлбөртэй уялдуулан тууштай хэрэгжүүлнэ.

Ийм итгэл, урам зориг төрийн аль ч шатны байгууллага, албан тушаалтанд байгаа нь мэдрэгдэж байгаа.

Та бидний эхлүүлсэн төрийн албаны шинэтгэл юуны төлөө вэ гэдгийг бүгдээрээ сайн ойлгож байгаа.

Шинэтгэлийн эцсийн зорилго улс орны хөгжил дэвшил, хүн ардын амгалан тайван, сайн сайхан амьдрал.

Үүнийг бий болгоход төрийн албаны гүйцэтгэх ёстой үүргийг бүрэн дүүрэн хэрэгжүүлж, хариуцах ёстой ажлыг хангалттай сайн хийхийг хэлж байгаа хэрэг.

Төрийн албыг мэдлэг, чадвартай төрийн албан хаагч авч явдаг бол тэр албан хаагч бүрт хувь хүнийх нь хувьд жирийн иргэдээс, бусдаас онцлохуйц тусгай шаардлага тавигддаг нь эртний ч, өдгөөгийн ч жишиг хандлага.

Төлөвшил хүмүүжлээр олж авсан шулуун чигч нэг л зангаараа байх төрийн түшмэл эрдэний ёс зүйд бид хамгийн том найдлага тавьж байна.

Төрт ёсны эртний түүхтэй Монгол төрийн албан хаагчдад бусдаас харьцуулж сурахын зэрэгцээ өөрсдийн түүх, соёл, уламжлалаасаа авах зүйл олон бий, дагах зарчим ч хангалттай байгаа.



Өнгөрсөн жил хагасын хугацаанд Төрийн албаны зөвлөл нийт аймаг, хот, орон нутагт хүрч ажиллахдаа шинэтгэлийн үзэл санааг түгээн дэлгэрүүлэх, хийх ажил, гарах үр дүнг төрийн албан хаагчид маань нэг мөр ойлгох чиглэлд онцгойлон анхаарсан.

Иргэд, олон нийтийн зүгээс төрийн алба төлөвшиж, хууль нэг мөр хэрэгждэг болоосой гэсэн хүлээлт өндөр давтамжтай байна.

Төрд ажиллаж байгаа хүмүүсийг сул дорой, авлигач, өөдгүй гэсэн нийгмийн санаа, хандлага хүчтэй байсаар байна.

Сонин гарчиглаж, сайтуудын эхний нүүрийг харахад, social медиагаар өрнүүлж буй иргэдийн санал шүүмжлэлийг уншихад л үүнийг хангалттай батална.

Төрд итгэх ард түмний итгэлийг яаж буцааж авах вэ? Бахархалт төрийнхөө нэр хүндийг яаж сэргээх вэ?

Ёс зүй гэдэг байгууллага, интитуцэд гэхээсээ хувь хүн рүү, хувь хүний дотоод мөн чанар руу илүүтэй чиглэсэн ойлголт болохын хувьд эмзэг, нарийн асуудал мөнөөс мөн.

Төрийн нэг ажилтан алдаа гаргавал, ааш араншингаа хянахгүй бол, бүтэлгүйтэж будилбал, мэдлэг чадвар нь сулхан байвал тэр нь шууд утгаараа төрийн алба гэдэг бүхэл бүтэн институцыг муухай харагдуулдаг.

Энэ хэрээр төрийн явуулж буй бодлого саармагжих, олон түмний итгэл үнэмшил буурах жишээтэй. Ажил цалгардах, цаг алдахаас өгсүүлээд хор уршиг нь дэндүү их.

Эргэх холбоо, учир шалтгаантай энэ асуудал төр, ард түмний хоорондын итгэлцэл, иргэд, олон түмнээс төрд өгсөн итгэлийг дааж явах төрийн албан хаагчийн нинжин сэтгэлийн учигт оршдог.

Төрийн албан хаагч бүр өөр өөрсдийн хийх ажил, гүйцэтгэх үүрэг, дор бүрнээ гаргах үр дүнгээрээ ялгардаг хэдий ч тэдний ажил, амьдралдаа хандах хандлага “Ёс зүй” гэдэг ганцхан цэг дээр яг ижилхэн давхцдаг, бас төвлөрдөг онцлогтой.

Та нарыг энэхүү маш чухал сэдвээр бусдыгаа сонсож, бусадтай харилцаж, хэлэлцэж, нягталж, эргэцүүлэх боломжийг олгохоор энэ зөвлөгөөний зохион байгуулахаар шийдсэн.

Иймээс зөвлөгөөнд оролцогч та бүхэн өнөөдрөөс эхлэн **Монгол төрийн албаны ёс зүйн элч** болох юм.



Ёс зүйтэй, итгэл даах хүнд л хүмүүс, найз нөхөд нь итгэдэг. Тэгвэл төрийн алба ямар байгаасай гэж иргэд хүсч бана вэ?


Хамгийн энгийн жишээ хэлье. Сайн эмнэлэг, сайн эмч байгаа болохоор өвдөж зовох цагт эмчилгээ сувилгаа авчихна гэж бид итгэдэг.

Онцгой байдлын шуурхай алба байгаа болохоор өмч хөрөнгө, амь насанд гал усны аюул тохиолдоход авран хамгаалагдана гэж бид боддог.

Итгэл найдварын оч өвөртөлсөн иргэд, олон нийт та бидний л ахан дүүс, элэг нэгтнүүд.

Төр засагт итгэх итгэл гэдэг ийм нандин, хүний сэтгэлийн гүнд байдаг ариун зүйл.

Хүний сэтгэлд хүйтэн ус хийхгүй байна гэдэг тангараг өргөсөн төрийн албан хаагчийн байнга бодож, санаж сэргэж байх эрхэм чанар.



Иргэдээ алагчилдаггүй, ёс зүй, эрхэм чанарын үлгэр жишээ болсон төр, төрийн албан хаагчдад л хүмүүс итгэнэ, ойртоно, улмаар хүндэтгэнэ.

Үүнийг би ёс зүйтэй төрийн албаны цагаан толгойн эхний үсэг гэж бодож байна. Үсэг ганцаараа үг болдоггүй, үг ганцаараа өгүүлбэр болдоггүйчлэн хүн ёсны эрхэм чанар, итгэл үнэмшлийг та өөрөө гээхгүй бол таны эргэн тойронд тийм сайн үйл дэлгэрч, саар муу багасна.

Төрийн албан хаагчид ард түмний нэг хэсгийн хувьд өөрсдөө бас төрийн үйлчилгээ авагч иргэн. Иргэдэд төрийн үйлчилгээг хүргэхдээ тэр иргэний оронд өөрийгөө тавьж боддог халуун дулаан сэтгэлтэй байгаасай гэж би боддог.

Төрийн албаны зөвлөл асуудал болгоны дэргэд зогсож, манаж байх боломжгүй нь ойлгомжтой. Харин төрийн албан хаагчийн ёс зүйн хэм хэмжээг сахиулахтай холбогдсон зөвлөгөө өгөх, арга зүй удирдлагаар хангах, эдгээрийн хэрэгжилт, зөрчил, авах арга хэмжээний саналыг хуулиар хүлээсэн чиг үүргийнхээ дагуу цаашид улам эрчимтэй авч хэрэгжүүлэх болно.

Төр хэмээх үг ёс гэдэг утгаар хэрэглэгдэж байсан жишээ “Монголын нууц товчоо”-нд байдгийг эрдэмтэд нотолсон. Төр, ёс гэх хоёр үг эхэндээ ижил утгаар хэрэглэгдэж байгаад төрт ёсны хөгжлийн явцад утга салсан байх юм.

Аливааг ёс журамтай, хүндэтгэлтэй эзний ёсоор хийхийг “ёс төртэй” гэж бид хэлдэг. Тогтсон ёс зарчимтай түшмэлийн алба төрт ёсны чухал бүрэлдэхүүн, төрт ёсыг тээгч, уламжлуулагч юм.

Төрийн албан хаагчийн хувьд юуны өмнө шударга, нээлттэй өрсөлдөөний үндсэн дээр албан тушаалд томилогдсоноор шударга, үнэнч, аливаад бодитой хандах, үл алагчлах зэрэг төрийн албаны эрхэм нандин үнэт зүйлсийг орчин тойрондоо бий болгохын төлөө ажил үүргээ тууштай гүйцэтгэх итгэл үнэмшил төрнө.

Ард иргэддээ хүндлэгдсэн төрийн алба ард түмний итгэлийг олсон төрийн албан хаагч хүн нэг бүрийн хичээл зүтгэлийн үрээр төлөвшин тогтдогийг олон улс орны жишээ бэлхнээ харуулж байна.

Ёс зүйтэй, мэдлэг чадвартай төрийн түшмэд байж гэмээнэ төрт ёс бэхжинэ, төрийн үйл шударга явна.

Чадахгүй, дааж давшгүй зүйлийг ярьж шаардаж байгаа хэрэг огтоос биш. Танд, надад, бид бүхэнд бэлэн байгаа хүн чанар, нинжин сэтгэлийн тухай л ярьж байна.

Хөгжмөөр бол утсыг нь хөглөж, уянга эгшгийг нь сайхан гаргая гэсэн санаа. Бидэнд хөгжим нь, хөгжимчин нь байна, одоо хөгжмөө хөглөх л үлдсэн.

Сайн санааны үзүүрт тос гэдэгчлэн зөв хүнээс зөв үйл гарч, зөв үйлийн үр дүнд улс орон хөгжин цэцэглэж, өөрсдийгөө, үр хойчоо нүүр бардам, аз жаргалтай байлгах эрх, бас үүрэг нь та бидэнд байна.

Шударга үйлийн үр дүнд сайн засаглал тогтож, эдийн засаг сайжирна. Эдийн засаг сайжирч, иргэдийн амьдрал дээшлэх учиртай.

Төрөө тогтвортой, засаглалаа сайн байлгаж өндөр ёс зүй, чанд сахилга хариуцлагын цаг хугацааг өнөөдрөөс, энэ танхимаас эхлүүлцгээе.

Төрийн албаны ёс зүйн элч Та бүхэнд амжилт, сайн сайхныг хүсье!



--o0o---



“Төрийн албаны шалгалтын сорил” цахим номын нээлт дээр хэлсэн үг

2020.08.27

МОНГОЛ ТӨРИЙН ИРЭЭДҮЙН ТҮШМЭЛ ЭРДЭНЭ ТАНАА

Төрт ёсны өнө эртний уламжлал, түүх цадигтай Монгол төрийнхөө их үйл хэрэгт зүтгэхээр санаа зориг шулуудан, эрдэм боловсрол, мэдлэг чадвараа эх орны хөгжил, түмэн олныхоо сайн сайхан амьдралын төлөө хувь нэмрээ оруулах сэтгэл өвөрлөн буй Танд энэхүү цахим номыг өргөн барьж байна.

Төр улсдаа хүчээ өгөхөөр шийдсэн хэн боловч эх орныхоо их түүх, эдийн засаг, хууль ёс, нийгэм, соёл, орчин үеийн техник технологийн мэдлэг, чадвар, яруу тансаг монгол хэл, бичгийнхээ өв уламжлалыг хэдийнээ эзэмшсэн байх учиртай. Чухамхүү ийм мэдлэг, чадвар, өндөр ёс суртахуунтай, аливаад **чин** шударга, чигч зөв хандлагатай, нийтийн тусын тулд бүхий л боломжоо дайчилж чадах сэтгэл, эрмэлзэлтэй шилдэг сэхээтнүүд төрийн албанд хэрэгтэй байна.

Төрийн алба хашна гэдэг өнгөрсөн, одоо, ирээдүй гурван цагийн шинэ хөгжлийн эринд монголоо монголоор нь авч үлдэх, аливаа асуудалд гагцхүү хуулийн хүрээнд шинжлэх ухаанч, судалгаа нотолгоонд тулгуурлан ханддаг, эрдэм боловсролтой эх оронч хүмүүний үйл буюу.

Нийгмийн амьдрал хурдацтай өөрчлөгдөж байна. Монгол Улсын Үндсэн хуульд 2020 онд оруулсан нэмэлт, өөрчлөлттэй уялдан эрх зүйн баримт бичгүүд мөн адил өөрчлөгдлөө. Дэлхий нийтийн хөгжлийг дагаад технологи, мэдлэгийн салбар ч хурдан шинэчлэгдэж байна. Үүнээс улбаалан төрийн албаны шалгалтын

сорилын хувилбаруудыг өндөр түвшний мэргэжилтнүүдийн баг илүү боловсронгуй болгон засаж шинэчлэн, эрдэмтэн судлаачид хянан тохиолдуулав.



Чадахуйн /мерит/ зарчим, шатлан дэвшүүлэх тогтолцоонд суурилсан төрийн албаны шинэтгэлийн нэгэн шинэ үед төрийн алба хаах итгэл, урам зориг өвөрлөн байгаа хэн хүний зайлшгүй эзэмшвэл зохих мэдлэг, чадварыг шалгах сорил, тайлбар бүхий энэ гарын авлагыг төрийн албаны шалгалтад ашиглана. Нөгөө талаас эдгээр нь шалгалт авах суурь сэдэв, чиглэлийг агуулж байгаа болохоос шалгалтын иж бүрэн материал, жагсаалт биш гэдгийг та бүхэн анхаарна буй за.

Зөвхөн ерөнхий шалгалтад тэнцэхийн тулд бус төрд алба хаахын төлөө уг гарын авлагыг бүтээлчээр ашиглаж, үүгээр үл хязгаарлан холбогдох бусад эх сурвалжийг судлан өөрийгөө төрийн албанд бэлтгэхдээ тун хянуур,

хариуцлагатай хандах нь зүйтэй. Төгс төгөлдөр зүйл гэж байдаггүйчлэн сорилын талаар авах гээхийн ухааныг уралдуулан, санал бодлоо илэрхийлж, эргэх холбоотой байхыг **хүсье**.

Шалгалт өгөх, сорилын хариуг дүгнэх бүхий л үйл ажиллагаа хөндлөнгийн аливаа оролцоогүйгээр шударга, ил тод, бүрэн цахимжсан хэлбэрээр явагддаг тул шалгалтын дүнгийн хувьд зөвхөн өөртөө найдахаас өөр аргагүй. Төрийн албаны ерөнхий шалгалтаа амжилттай өгснөөр төрд ажиллах эхний алхам-төрийн жинхэнэ албаны нөөцөд бүртгэгдэж, монгол төрийн албанд ажиллах үүд хаалга нээгдэнэ. Улмаар төрийн албаны тусгай шалгалт өгч төр улсынхаа ажилд гар бие оролцох учиртай.

“Эзэн хичээвэл заяа хичээхийн” эрхэм үгийг сайтар тунгааж, мэдлэг оюунаа дайчлан, бэлтгэлээ сайтар хангахыг **хүсье**.

Хууль ёсыг чанд баримтлан, улс үндэснийхээ язгуур ашиг сонирхолд захирагдан ард түмэндээ нэгэн үзүүрт сэтгэлээр үйлчилж, төрдөө чин үнэнч зүтгэх зам мөр тань цагаан байхын ерөөл өргөө!

---o0o---



Завхан, Хөвсгөл аймагт ажиллах үеэр төрийн албан хаагчидтай хийсэн уулзалтууд дээр хэлсэн үгнээс

2020.05.29

Орчин үеийн төрийн албаны онцлог, дэлхий нийтийн жишиг

Удирдах ажилтан нь гүйцэтгэх албан тушаалын хүмүүстээ хяналт тавьж, ажлыг нь дүгнээд явдаг жишиг ард хоцорсон. Олон нийтийн хяналт, иргэдийн оролцоо маш өндөр түвшинд очсон, сошиал медиа хөгжихийн хэрээр хүн бүр “сэтгүүлч” болсон ийм цаг үе. Муу ажиллах, алдаагаа нуун далдлах гэдэг үндсэндээ байхгүй болж байна.

Төрийн үйлчилгээнээс иргэдийн хүсэмжилж буй **хүлээлт** улам нэмэгдсээр байна. Хувийн хэвшлээс бүтээгдэхүүн, үйлчилгээ авахдаа хүмүүс сайн чанартай, хямд өртөгтэйг чөлөөтэй сонгодог, яг тийм шаардлагыг төрийн ажил, үйлчилгээнд тавьдаг болсон. Зах зээлд олон сонголт байдаг бол төрийн үйлчилгээнд сонголт байхгүй болохоор төрийн нэг байгууллага, төрийн нэг албан хаагчийн ажил үйлчилгээнд доголдол гарахад иргэд шууд бухимдаж эхэлдэг.

Тиймээс илүү цахимжсан, илүү уян хатан, хүртээмжтэй, ойлгомжтой, хялбар, ил тод, хүн рүү чиглэсэн төрийн үйлчилгээнд хамрагдахыг иргэд хүсдэг. Энэ шаардлагыг оновчтой бүтэц, чадварлаг төрийн албан хаагчид л хангана.

Төрийн албаны шинэтгэл олон улсын хэмжээнд энэ чиглэл рүү эргэлт буцалтгүй орсон. Манай улсын төрийн албаны шинэтгэл ч энэ чиглэлд тууштай

явж байгаа. Үүний тод илрэл нь өнгөрсөн оны эхнээс үйлчилж эхэлсэн Төрийн албаны тухай хуулийн шинэчилсэн найруулга гэж болно.

Том зургаар нь авч үзвэл “төрийн албыг асуудал гэхээсээ илүүтэйгээр шийдэл” гэж би үздэг. Төрийн албаны онцлог нь өөрчлөлтийг жолоодоход туслан дэмжих, аливаа зүйлийг илүү сайн болгоход бэлэн байх явдал юм.

Өөрчлөлт, шинэтгэл нь манай төрийн албаны хувьд шинэ үзэгдэл биш. Ажиллаж ирсэн туршлагаасаа харахад төрийн албан хаагчид ихэнхдээ үйл ажиллагааны сул, дутагдалтай талуудаа дотоод талаас нь өөрсдөө харж чаддаг, мөн шинэтгэлийг хамгийн хүчтэй дэмждэг хүмүүс байдаг.

Өнөөгийн төрийн албаны чадавх, үр нөлөө урьд хожид байгаагүйгээр илүү хяналтын дор оршиж байна. Зүйрлэж хэлбэл аквариумд байгаа загас адил.

Нийтээрээ хүлээн зөвшөөрдөгчлөн эдгээр/энэ бүх шинэ эрэлт хэрэгцээг хангаж, сорилт бэрхшээлийг даван туулахын тулд өргөн цар хүрээтэй **тасралтгүй шинэтгэл** төрийн албанд шаардагдах болсон орчин, нөхцөлд бид ажиллаж амьдарч байна.



Энэ удаагийн Монгол Улсын төрийн албанд хийгдсэн шинэтгэлийн үндэс болох мерит чадахуйн зарчим, шатлан дэвших тогтолцоо зэрэг нь өндөр хөгжилтэй орнуудын орчин үеийн төрийн албанд мөрдөгдөж буй.

Ийм зарчим, үйл явц нэг өдөр бий болчихоогүй. Урт удаан хугацааны уламжлалтай.



ТӨРИЙН АЛБАНЫ
ЗӨВЛӨЛ

ᠲᠦᠷᠢᠨ ᠠᠯᠪᠠᠨ ᠵᠡᠪᠯᠡᠯ

БОЛОД ЧИНСАН



Төрийн албаны
зөвлөл, цэргийн
албаны зөвлөл
/1206/

- Үнэнч байдал
- Үүргээ биелүүлэх
- Шуурхай хэрэгжүүлэх



Хянах,
Шалгах



- Монголын түүхэнд цэргийн зөвлөл, цэцдийн зөвлөл
- Англи
- АНУ-Пендлетон хууль

Эртний түүх, соёлтой Итали улс 20-30 жилийн дараа өндөр хөгжилтэй орнуудын жагсаалтаас хасагдах өндөр магадлалтай гэж Канадын их сургуулийн итали профессор ярьж байсан. Англи хэлтэй италичуудын гадагшаа чиглэсэн их нүүдэл явагдаж байна гэж. Яагаад? Шударга бус байдал, авлигал, мафижсан эдийн засаг юм.

Төрийн алба хэмээх нарийн нийлмэл институт цаг үеийн шаардлагаа дагаад улам бүр төлөвшин хөгжсөөр байгаа. Болж бүтэхгүйг нь засаж залруулж, амжилт ололттой хэсгээ дэмжин ажиллаж байна, үр дүнд нь тогтвортой, чадварлаг төрийн алба төлөвшин тогтох үйл явц тасралтгүй, бас хурдацтай өрнөж байгаа гэдэгт итгэлтэй байгаа.

Үр дүнг нь үзэхийг нийгмээрээ яарч байгааг би мэдэрдэг, гэхдээ төрийн албаны төлөвшил, зан үйл, хандлагын өөрчлөлт гарахад цаг хугацааны хүчин зүйл шаардагдах нь зүйн хэрэг. 2019 он төрийн албаны шинэтгэлийн үйл явц дахь шилжилтийн, хариуцлагатай жил байсан, эрх зүйн шинэ орчин дахь хэрэгцээнд үндэслэсэн сургалтуудыг бүх түвшинд хийсэн. Энэ онд иргэд, олон нийт рүү чиглэсэн, төрийн үйлчилгээг хүргэгч-хэрэглэгчдийн хоорондын тасралтгүй, үр дүнтэй үйл ажиллагаа руу илүү төвлөрч ажиллаж байна.

Үндсэн хууль, Алсын хараа-2050



ТӨРИЙН АЛБАНЫ
ЗӨВЛӨЛ

ᠮᠣᠩᠭᠣᠯ ᠤᠯᠤᠰ ᠤᠯᠤᠰ ᠤᠯᠤᠰ ᠤᠯᠤᠰ ᠤᠯᠤᠰ

Үндсэн хуулийн нэмэлт, өөрчлөлт

2020.05.25





Төрийн алба гэдэг Үндсэн хуулиар тогтоогдсон шударга ёс, хууль дээдлэх зарчим, үндсэн үнэт зүйлсээ эрхэмлэж, төр улсын ой санамж, уламжлал, мэдлэг, чадварыг тасралтгүй тээж явдаг **үйл ажиллагаа, бүтэц, зохион байгуулалт**.

Үндсэн хуулийн нэмэлт, өөрчлөлтийг УИХ-аас баталсан, Үндсэн хуулийн хүрээнд шинэтгэл явагдаж буй цаг үед бид ажиллаж байна.

Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлогын баримт бичиг “Алсын хараа-2050”-ийг УИХ баталлаа. Ирэх 30 жилд улс орны хөгжилд **САЙН ЗАСАГЛАЛ**-ыг бий болгох цогц зорилт дэвшүүлсэн.



ТӨРИЙН АЛБАНЫ
ЗӨВЛӨЛ

ᠮᠣᠩᠭᠣᠯ ᠤᠯᠤᠰ ᠤᠯᠤᠰ ᠤᠯᠤᠰ ᠤᠯᠤᠰ ᠤᠯᠤᠰ



Бодит нөхцөл байдалд тулгуурлан төрийн бодлогыг тодорхойлох, хэрэгжүүлэх, үнэлж дүгнэх, үр нөлөөг нь тооцох үр дүнтэй, зохистой арга

хэлбэрийг Олон улсын байгууллагуудын хүрээнд “**Сайн засаглал**” гэж тодорхойлдог.

Засаглал нь дан ганц Засгийн газар, төрийн байгууллагуудын удирдлагаар хэрэгждэг уламжлалт хандлага шинэчлэгдэн, засаглалын үйл явцад иргэд, иргэний нийгэм, хувийн хэвшлийн оролцоог хангахыг чухалчлах болсон.

Өөрөөр хэлбэл, төр, засгийн газар дангаараа хөгжлийг удирдан чиглүүлж, хэрэгжүүлэх бус төр, иргэн, иргэний нийгэм, хувийн хэвшлийн оролцоотой хамтын үйл ажиллагаа гэж ойлгох болсон.

- Ухаалаг засаглал
- Ухаалаг бүтэц
- Цахим Монгол (иргэн, төр, хувийн хэвшлийн нэгдсэн систем)
- Чадварлаг, ёс зүйтэй төрийн алба
- Хүний эрхийг дээдэлсэн нийгэм
- Авлигагүй засаглал

Энэ үйл ажиллагаа, бүтэц, зохион байгуулалтын хөдөлгөгч хүч, амжилт ололтыг бүтээгч нь төрийн албан хаагч та бүхэн. Та бидэнд хуулиар олгогдсон эрх, ажиллах нөхцөл, баталгаа гээд олон давуу тал бий. Нөгөө талаас хүлээсэн үүрэг, ёс зүйн хэмжээ, хориглосон зүйлс ч байдаг. Энэ бүх нөхцөлийг хүлээн зөвшөөрч ажиллаж байгаа хүмүүс, та бид.

Бидний уулзаж буй энэ цаг мөчид 4 жил тутамд явагддаг УИХ-ын ээлжит сонгуулийн үйл ажиллагаа (бэлтгэл ажил/сурталчилгаа) хуулийн дагуу явагдаж байна. Удахгүй орон нутгийн сонгууль болно.



Төрийн албан хаагч улс төрийн сонгуульд оролцохдоо зарчмын сонголт хийдэг хуулийн зохицуулалттай. Ажил, албан тушаалаасаа чөлөөлөгдөж, төрийн

жинхэнэ албан хаагчийн нөөцөөс хасагддаг. Эрсдэлээ тооцож сонголтоо хийдэг системд бид орсон.



Нөгөө талаас төрийн алба аливаа сонгуулийн үр дүнгээс үл хамааран төрийн бодлогын залгамж халаа, уламжлал, ой санамжийг тээж явдаг, тасралтгүй үйл ажиллагаа.

Төрийн албан хаагчид сонгуулийн үр дүнгээс хамаарсан айдасгүй байх баталгааг шинэ хууль маань олгосон, үүний нөгөө талд төрийн алба хэзээ ч улстөржиж болохгүй гэсэн зарчим явж байгаа.

Томилгоотой холбоотой хуулийн зохицуулалтуудыг чанд дагаж мөрдвөл улс төржих эрсдэл нэмэгдэхгүй гэдэгт итгэлтэй байна. Ингэж байж илүү хариуцлагатай, илүү үр дүнтэй төрийн албыг бий болгох зорилт маань хэрэгжинэ.

-oOo-



Хүний нөөцийн удирдлага, аудитын газрын албан хаагчидтай хийсэн уулзалт дээр хэлсэн үгнээс

2020.01.19

Төрийн албаны тухай хууль, энэ дүрэм, байгууллагын стратеги төлөвлөгөөний холбогдох зүйл, заалт бүрийг та бүхэн мэдэж байгаа гэдэгт итгэж байна.

Хүний нөөцийн аудит гэдэг **“үр”**-ийг бид Монгол хөрсөндөө хуулиар **“тарьсан”**.

Хоёрхон жилийн өмнө хүний нөөцийн аудит гэдэг ойлголт ихэнх төрийн албан хаагчдад, түүний дотор бидэнд ч шинэ ойлголт, шинэ үг байсан үе бий.

Хэрэгтэй гэдэг нь тодорхой, хэрхэн хийх вэ гэдэг нь тодорхойгүй тийм ойлголтыг төрийн албанд нутагшуулах суурь хөрсөө бид үндсэнд нь тавьж чадлаа. Хоёр жил дараалан Хүний нөөцийн аудит “ургуулах” газраа боловсруулж, хөрсөө бордож, үрээ тарилаа.

Одоо бид 2021 онд **“тарьсан үр”-нээсээ “ургац” хураах ажлаа** хийхгүй бол болц нь хэтрээд, бусдын хоол болох байх. Хураахдаа өрөөлөөр биш **ӨӨРСДӨӨ хураах хэрэгтэй байна.**

Зөөлөн үг санагдаж байж магадгүй, гэхдээ минийхээр бол “ажлаа хурдавчлах, үйл ажиллагаагаа” бодитоор эхлэх цаг болсныг сануулж, бас шаардаж байгаа хэрэг юм.

Аливаа “аудит” тухайн байгууллагын нэр хүнд, үйл ажиллагааны **хуульд нийцсэн байдлын толь** маягаар явдаг нийтлэг ойлголт байдаг гэдэг.

Нэр хүндээ өсгөх, хууль журам зөрчдөггүй гэдгээ харуулахын тулд хувьцаат компаниудаас авхуулаад маш олон байгууллага **өч төчнөөн мөнгө** төлж санхүүгийн ч, хүний нөөцийн ч аудит хийлгэдэг. Тэгвэл бид **“мөнгө нэхэхгүйгээр”** энэ ажлыг хийх гэж байна.

Өөрсдийнхөө **давуу талыг** хөндлөнгийн, хараат бус, мэргэжлийн шинжээчдээр тодорхойлуулж, **дутуу талаа** ужигруулахгүй, цаг алдахгүй арилгах тийм боломжийг олж авдаг учир “аудит”-ын ажил уг нь их буянтай, бусдад дэм тустай ажил гэж хамгийн энгийн үгээр ойлгогддог юм билээ.

Төрийн албаны хүний нөөцийн “эмгэг хууч”, санаатай болоод санамсаргүй “алдаа”-г олж харж, алдаа зөрчлөөс урьдчилан сэргийлэх боломж олгох **хүний нөөцийн аудитор** гэдэг **боловсон хүчний эмч** гэхүйц **хүчтэй**, бас **хүндтэй** ажил гэж бүгдээрээ ойлгон ажиллацгаая.

Мөнгө хөрөнгөний зарцуулалтад л хамаарах мэт нийгэмд байсан энэ ойлголт “хүний нөөцийн аудит” гэдэг утгаараа хувийн хэвшилд тодорхой байр суурь эзэлчихсэн байгааг бид мэднэ.

Өнгөрсөн онд Та бүхнийг хувийн болон төрийн бус байгууллагын судлаач, шинжээчидтэй уулзах хүсэлт тавьж байсан санагдана, маргааш нь ажил хэрэг болсонд би талархалтай байгаа. Туршлага мэдлэг олж авах, хуваалцах ажлыг энэ мэтчилэн чамлахааргүй хийсэн.

Хүний нөөцийн аудит гэдэг “Аймшгийн мангас” биш гэдэг **нийгмийн сэтгэл зүйг анхнаас нь бий болгоосой**, бэлтгээсэй гэж хүсэж байна. Бэлтгэл ажил үр дүнгийн урьдач нөхцөл гэдгийг та нар надаар хэлүүлэлтгүй мэднэ.

Хүний нөөцийн аудиторуудыг урьдаг, энэ үйлчилгээг авах гэж “хөөцөлддөг”, Хүний нөөцийн аудиторууд очих гэж байгаад баярладаг тийм төрийн албан хаагч, удирдах ажилтнуудыг бий болгосноор энэ ажил хэмжигдэнэ.

Хүний нөөцийн аудиторууд тухайн байгууллагыг “дарамталж шалгадаг” **хадны мангаа** биш, харин ч **туслагч** нь, **зөвлөгч** нь, **итгэлт түнш** нь гэдгийг энд хэлж байна.

Дайн байлдаантай, гамшиг зовлон тохиолдсон газруудад **Улаан загалмайн нийгэмлэг** хүрч ажилладаг ямар нарийн системтэй байдгийг та нар мэднэ. **“Хэрэгтэй газар нь хэрэгтэй дэмжлэгийг хэрэгтэй цагт”** нь аваачдаг гэж би хувьдаа ойлгодог. Хүний нөөцийн аудит ч ийм л зорилготой гэж ойлгож болно.

Шинэ ойлголтыг төлөвшүүлж, шинэ ажлыг гардан хийх гэж байгаагаараа манай Хүний нөөцийн удирдлага, аудитын газрынхан баярлах хэрэгтэй, бахархах хэрэгтэй. Үр дүн гарна гэдэгт эргэлзэхгүй байна.



**Үл мэдэгдэх сорилт,
төлөвлөх боломжгүй
нөхцөл байдал**



Гамшгаас хамгаалах өндөржүүлсэн бэлэн байдлын зэрэгт шилжүүлсэн хугацаанд төрийн албаны тасралтгүй, хэвийн үйл ажиллагааг найдвартай хангаж, төрийн үйлчилгээг иргэдэд шуурхай хүргэх, оновчтой, зөв зохион байгуулахад дэмжлэг үзүүлэх үүднээс “Зохион байгуулалтын зарим арга хэмжээний тухай” **Төрийн албаны зөвлөлийн зөвлөмжийг 238-р нүүрэнд бүрэн эхээр нь толилууллаа.**

Энэхүү зөвлөмж нь гадаад орнуудын төрийн албаны төв байгууллагуудаас улс орондоо үүссэн онцгой нөхцөл байдалд явуулж байгаа бодлого, үйл ажиллагааг анхааралтай судалж, өөрийн орны хууль, эрх зүйн орчинд нийцүүлэн боловсруулсан энэхүү зөвлөмжид онцгой нөхцөл байдалд төрийн байгууллагууд үйл ажиллагаагаа хэрхэн уялдуулах, харилцан дэмжлэг үзүүлэх, хүний нөөцийн үйл ажиллагаа, ажлын байрны эрүүл ахуй, аюулгүй байдал, албан хаагчдын ажиллах нөхцөлийг хэрхэн зөв зохион байгуулах талаар арга зүйн зөвлөгөөг багтаасан болно.

---o0o---



Өвөрхангай аймгийн Хархорин суманд болсон “Шинэ хандлага” уулзалт дээр хэлсэн үгнээс...

МОНГОЛ УЛСЫН ТӨРИЙН АЛБАНЫ ЗӨВЛӨЛ
STATE SERVICE COUNCIL OF MONGOLIA

UN
DP

**“ШИНЭ ХАНДЛАГА”
УУЛЗАЛТ**

Монгол Улсын Төрийн албаны зөвлөлийн дарга Б. БААТАРЗОРИГ

2020.05.15

Төрийн Түшмэл эрдэнэ



Болодчинсан

Хубилай хааны үед Яамны Их зөвлөх, Ил хаадын зөвлөх, Ил хаадын зарлигийг баталгаажуулагч



- Дорно, өрнийг холбогч соёлын гүүр
- Ил хант улсад суусан Хубилай цэцэн хааны тусгай элч
- Ил хаад, Ил хант улсад (Иран, Ирак, Азербайжан, Армян, Грузин, Турк, Туркмен, Афганистан, Пакистан) төрийн зөвлөхөөр ажилласан.
- Ил хант улсад (Персид) ухаант “Ах” нэрээр алдаршсан
- “Судрын чуулган” номонд их эзэн Чингис хааны түүхийг Рашид ад-Дин дуудан бичүүлсэн түүхч эрдэмтэн
- Монгол, Хятад соёл, зан заншил, төрийн нарийн ухааныг Персийн орнуудад танилцуулж, Персийн орнуудад амьдрахдаа нутгийн соёл, зан заншлыг нэвтэрхий эзэмшсэн.



ТӨРИЙН АЛБА

Тогтвортой

Улс төрөөс
ангид

Мэргэшсэн

Чадварлаг



ТӨРИЙН АЛБАНЫ ТУХАЙ ХУУЛЬ

Шинэчилсэн найруулга

ИЛ ТӨД

МЭРГЭШСЭН

МЭРИТ ЗАРЧИМ

ТӨРИЙН ЗАХИРГААНЫ АЛБАНХААГЧ

ТӨРИЙН АЛБАНХААГЧИЙН ЭРХ ЗҮЙН БАЙДАЛ

НЭЭЛТТЭЙ СОНГОН ШАЛГАРУУЛАЛТ

ТУСГАЙ ШАЛГАЛТ

ХЯНАЛТ ТАВИХ

ХАРИУЦЛАГА

ТӨРИЙН ҮЙЛЧИЛГЭЭНИЙ АЛБАН
ХААГЧ

ЁС ЗҮЙ

НЭМЭГДЭЛ ХӨЛС

ТӨРД УЧРУУЛСАН ХОХИРЛЫГ
ТӨЛҮҮЛЭХ

ХАРААТ БУС БАЙДАЛ

НИЙГМИЙН БАТАЛГАА

66 зүйл





ШИНЭЧЛЭЛ



- шинэтгэлийн шинэ давалгаа
- шилжилтийн үеийн сорилт
 - бүх талын дэмжлэг
 - хөрс суурь



---o0o---

2020 ОНЫГ ХУУЛИА ДЭЭДЭЛСЭН, ИРГЭДЭЭ ЭРХЭМЛЭСЭН ЖИЛ БОЛГОНО



Яамдын Төрийн нарийн бичгийн дарга, агентлагийн дарга нарын оролцсон “Шинэ он –шинэ хандлага” сэдэвт зөвлөлдөх уулзалтад тавьсан илтгэлээс ...


БАГА ЗАРДЛААР ИХИЙГ ХИЙХИЙГ ШААРДАЖ БУЙ ЦАГ

“Бага зардлаар ихийг хийх”-ийг шаардаж буй цаг үед бид төрийн албанд ажиллаж байна. Шинэтгэлийн стратегийн зорилтуудаа Төрийн албаны зөвлөл 2020 онд дараах байдлаар эрэмбэлэн ТЭРГҮҮЛЭХ ЗОРИЛТУУДАА тодорхойллоо.


Эдгээр зорилтуудыг цаг тутам, өдөр тутам, сар тутам ажилдаа тусган авч хэрэгжүүлэн шударга ажиллаж, төрийн үйлчилгээг иргэдэд чанартай хүргэ!

1. Төрийн албаны шинэтгэлийн стратегийг шинэчлэн боловсруулж батлуулан, үйл ажиллагаанд мөрдөнө

Төрийн албаны шинэтгэлийн стратегийн баримт бичгийг шинэчлэн боловсруулж батлуулан, үйл ажиллагааны мөрдлөг болгоно.



СТРАТЕГИ



Шигтгээ



Анхаарлыг онилох стратеги



Итгэлийг олох стратеги



Сонголтыг онилох стратеги



Шийдэмгий байдлыг дэмжих стратеги

Төрийн албаны бодлогын зөвлөгөө, зөвлөмж өгөх чадавхыг сайжруулж, судалгаа, нотолгоонд суурилсан бодлогын зөвлөмжийг тэнцвэртэй, бодитой өгөх.

2. Төрийн албаны тухай хуулийг бүрэн хүчин чадлаар нь хэрэгжүүлнэ, үргэлжлүүлнэ




Та бид шинэтгэлийн эрчийг, иргэдийн итгэлийг хөсөрдүүлэхгүйн тулд хэрэгжилтийн явцад батлагдсан дүрэм, журмуудыг боловсронгуй болгох, сайжруулах, өөрчлөх ажил үргэлжилнэ.

Нийгэм, соёл, сэтгэхүй, эдийн засгийн өөрчлөлтийг үл тоомсорлож болохгүй. Эрх зүйн хүрээний шинэтгэлийн процесс тасралтгүй үргэлжлэх ёстой.


3. Томилгооны зөрчилгүй жил болгоно

Томилгооны зөрчилгүй жил болгоно.




Төрийн албаны тухай хууль тогтоомжийг нийт төрийн албаны хэмжээнд даган мөрдөж байгаа нөхцөл байдалд дүн шинжилгээ хийж, байгууллага бүрийг зөрчилгүй ажиллах дархлаатай болгоно. Томилгооны зөрчилгүй жил болгоно.

4. Хүний нөөцийн аудит



Төрийн албаны хүний нөөцийн аудитыг агуулга зорилтын дагуу хэрэгжүүлж, үр нөлөөг нь байгууллагын хөгжилд ашиглах боломжоор хангана.

5. Төрийн албан хаагчийн ёс зүй



Төрийн албан хаагчийн ёс зүйн талаар төрийн албан хаагчдыг соён гэгээрүүлэх, болзошгүй зөрчлөөс урьдчилан сэргийлэх, хяналт тавих, гарсан зөрчлийг таслан зогсоох, цаг тухайд нь шийдвэрлэх, холбогдох албан хаагчдад хариуцлага хүлээлгэх үйл ажиллагааг байгууллага нэг бүрд хэвшүүлнэ.

Хэчнээн чадвартай ажилтан байлаа ч иргэдийн итгэлийг алдаж байгууллагын дотоод уур амьсгалыг эвдэж байгаа бол чөлөөлөх хүртэл арга хэмжээ авах.

Төрийн алба бол итгэлийн алба. Төрийн алба хариуцлагатай, төрийн албан хаагч ёс зүй, дэг журамтай байж иргэдийн төрд итгэх итгэл сэргэнэ.

6. Сургалт, хөгжил

Төрийн албаны сургалт анх удаа хуульчлагдсан.

Төрийн албаны тухай хуулиас:

29 дүгээр зүйл. Албан тушаалын ажлын байрны сургалт

29.1. Иргэнийг төрийн албан тушаалд томилсны дараа богино болон дунд хугацааны сургалтад хамруулна.


29.2. Энэ хуулийн 29.1-д заасан сургалтыг Засгийн газрын харьяа төрийн албаны сургалтын байгууллага хариуцан зохион байгуулна.

29.3. Энэ хуулийн 29.1-д заасан сургалтын агуулга, хөтөлбөрийг төрийн албаны төв байгууллагын саналыг үндэслэн Засгийн газар тодорхойлно.



Төрийн албан хаагчийн сургалт, хөгжилтэй холбоотой асуудлыг Төрийн албаны тухай хууль тогтоомжид заасан агуулга, хэлбэрээр нь шинэчлэн зохион байгуулж түнш, хамтрагч байгууллагуудын хооронд зохистой хамтын ажиллагааны горим тогтооно.


Шатлан дэвших



ШАТЛАН ДЭВШИХ

Төрийн албанд мерит зарчмаар шатлан дэвших нөөцөд хамрагдах төрийн албан хаагчдын судалгааг бүрэн гаргаж, шатлан дэвшүүлэх болзол, шаардлагыг хангуулах арга хэмжээг төлөвлөн хэрэгжүүлнэ.

7. Шалгалт



- ЕРӨНХИЙ ШАЛГАЛТ
- ТУСГАЙ ШАЛГАЛТ


ШАЛГАЛТЫН ТЕХНОЛОГИ



Төрийн албанд орохыг хүссэн иргэдэд зориулсан ерөнхий шалгалт, сул орон тоонд томилохтой холбоотой тусгай шалгалтыг технологийн дэвшил, инновацад тулгуурлан шударга явуулах бүх талын нөхцөлийг бүрдүүлнэ.

8. Нэгдсэн систем


**ЦАЛИНГИЙН
СИСТЕМ**



Төрийн албан хаагчийн цалингийн нэгдсэн систем, бүртгэлийг шинжлэх ухааны судалгааны хэрэгцээ, төрийн албаны шаардлага, хууль, стандартад нийцүүлэн өргөтгөж, технологийн дэвшилд үндэслэн, программын хэмжээнд шийдвэрлэж, мэдээллийн ил тод, үр нөлөөтэй байдлыг хангана. Цалингийн нэгдсэн системээр дамжуулж томилгооны зөрчлийг арилгах эдийн засгийн арга механизмыг нэвтрүүлнэ.

Эрх тэгш байдал

ЖЕНДЕР



Төрийн захиргааны албан дахь эмэгтэйчүүдийн тэгш байдлыг бодитоор дээшлүүлнэ. Судалгаанаас дүгнэж үзвэл төрийн захиргааны албан тушаалын ахлах түшмэлийн ангилалд эмэгтэйчүүдийн эзлэх хувь 50 хувь байгаа нь шатлан дэвшүүлэх боломжийг нээж байна.

9. Иргэдийн сэтгэл ханамж



Төрийн албаны үйл ажиллагааны чанар, хүртээмж, үр нөлөөнд олон нийтийн хяналтыг өргөжүүлж, үнэлгээ, зөвлөмж өгөх нөхцөлийг бүрдүүлэн ажлын үр дүнг иргэдийн сэтгэл ханамжаар тодорхойлно.


Платон



Иргэдийн сэтгэл ханамжийн түвшингээс төрийн ажлын чанар тодорхойлогдоно.

Төрийн ажлыг төрийн байгууллага, албан хаагч өөрөө үнэлж дүгнэдэг байдлыг арилгаж, төрийн албаны тухай шинэ хуулиар төрийн үйлчилгээний чанар, хүртээмж, үр нөлөөг олон нийт буюу үйлчлүүлэгчид тодорхойлдог механизмыг бүрдүүлж энэхүү үйл явц дахь иргэдийн оролцоог нэмэгдүүлнэ.


10. Чадахуйн зарчим



Төрийн албаны хариуцлагыг хууль тогтоомжийн дагуу цаг тухайд нь хэрэглэх, сонгон шалгаруулалтыг чанартай явуулах, албан тушаалын тодорхойлолтын шалгуурыг бүрэн хангуулах замаар зөвхөн чадахуйн зарчимд бүрэн нийцэх албан хаагчаар төрийн алба бүрдэх болно.



**Тогтвортой, урьдчилан төсөөлөх боломжтой, үр ашигтай үйлчилгээг
иргэдэд үзүүлэх жил болгоно**



**Энэ жилийг тогтвортой, урьдчилан
төсөөлөх боломжтой, үр ашигтай
үйлчилгээг иргэдэд үзүүлэх жил болгоно.**

Төрийн алба 21 дүгээр зуунд ямар байх вэ, төрийн албаны 21 дүгээр зууны менежер ямар байх вэ гэдэг асуулт дэлхийн улс орнуудын өмнө тавигдаж, эрдэмтэн судлаачдын анхаарлыг татаж байна.

Засаглалын шинэ хэв маягийн тухай дэлхийн эрдэмтэн судлаачид олон санал дэвшүүлж байгаагийн хамгийн чухал нь меритээр дамжуулж засаглахуй, мерит зарчмыг хамгаалах явдал байна. Манай улс мерит зарчмыг шинэ хуулиар тов тодорхой тогтоосон. Энэ жилийг тогтвортой, урьдчилан төсөөлөх боломжтой, үр ашигтай үйлчилгээг иргэдэд үзүүлэх жил болгоно.

“Мэдэгдэж байгаа” бас “үл мэдэгдэх” сорилуудыг давна



Гараа сайн бол бариа сайн гэдэг. Шинэ ажлын гарааны нөхцөлөө бодитой тодорхойлж, мэдээллийн хүртээмж, ойлголтоо нэгтгэж чадвал шинэтгэлийн үр дүн гарна.

Мэдлэгтэй, ур чадвартай, мэдээлэл боловсруулж чаддаг, эрдэм илүү төрийн албан хаагч үүнийг хийж чадна. Төрийн албыг АЧАА гэж зүйрлэвэл Алдаагүй бодлогыг Чадварлаг ажилтан хэрэгжүүлсний үр дүнд, иргэдийн Айдас арилж, Амьдралын баталгаа нь бий болох учиртай гэдгийг дахин сануулъя.

HEADHUNTING буюу “толгой ангуучлах”



Хувийн хэвшил хүнээ бэлдээд, чадварлаг боловсон хүчнийг татаж байхад төрийн алба хүн ирж ажиллахыг хүлээгээд сууж таарахгүй. Өсөн дэвжих төрийн үйлийг өрсөлдөх чадвартай, өндөр боловсролтой, ёс зүйтэй хүмүүс залгуулах учиртай.

Бизнесийн үйл ажиллагаа нь амжилттай яваа хувийн хэвшлийн арга туршлагыг төрд нутагшуулах “headhunting” буюу “толгой ангуучлах” нь утгачилбал оюуны өндөр чадамжтай хүний сэтгэлгээг ашиглах тухай асуудал юм.

“Зөв хүнийг зөв ажилд нь томилж зөв үр дүнд хүргэх” зорилтыг дэвшүүлж бодит ажил хэрэг болгох зөв ажлын эхлэлийг тавьж байна. Меритийн зарчмын мөн чанар ч ийм юм аа.

Чадварлаг ажилтныг дэмжинэ



Шударга, ёс зүйтэй, авлигагүй нийгмийг хүссэн, гадаад хэлтэй, боломжийн мэдлэг боловсрол эзэмшсэн иргэдийн орчин үеийн их нүүдэл дэлхий дахинаа явагдаж байна. Бид гадаадад ажиллаж сурахаар явж байгаа хүмүүсээ дан ганц эдийн засаг, илүү орлогын талаас нь төдийгүй шударга ёсны хүсэмжлэлдээ хөтлөгдөн яваа эсэхийг ч бодолцох ёстой болжээ. Сурч ирсэн хүмүүсийг ч, чадвартай ажилтныг ч хэн хэнийг нь дэмжинэ.

Хууль дээдлэн ажиллана гэдэг хамгийн товчоор үүрэг, хариуцлагаа ухамсарлана, бас эрхээ зөв эдэлнэ гэсэн үг. Хуулиас ангид, хуулиас гадуур амьдрах боломжгүй болсон нийгэм, цаг үед бид ажиллаж байна. Шинэ үзэл санааг тээгч, нийгэмд түгээн дэлгэрүүлэгч байх эрх, бас үүрэг нь төрийн захиргааны тэргүүн түшмэд Та нарт ногдож байна.

Шилжилтийн VUCA эрин үе



Төрийн албаны үйл ажиллагааг блокчэйн технологи нэгдмэл цахим мэдээллийн сан/-д шилжүүлэх том алхам бидний урд байна. Хувьсамтгай, тодорхойгүй, төвөгтэй, эргэлзээтэй байдал буюу **VUCA** эрин үед төрийн албыг хэрхэн үр ашигтай зохион байгуулахаас бидний шинэтгэлийн үр дүн хамаарна.

Эстони улс үндсэндээ дижитал орон болж, төрийн үйлчилгээ нь блокчэйн технологид суурилан 24 цаг 7 хоногийн тасралтгүй системд шилжиж чаджээ. Төрийн бүх үйлчилгээ өдөр шөнө, амралт баяр ёслолын өдрүүдээс үл хамааран онлайнаар явагдаж байна. Хүлээлт, хүнд суртал, чирэгдэл алга болжээ.

Аргентин энэ оны эхний өдрөөс цаасгүй Засгийн газартай болж, технологийг авлигатай тэмцэх гол түншээ болгож байна.

Хятад “нийгмийн оноо”-ны системийг туршиж эхэлжээ. Архи авдаг, уудаг, гарцгүй газраар гардаг, гудамжинд зүй бус авирладаг, хэв журам зөрчдөг хүнийг царайгаар нь таниад хиймэл оюун ухааны оролцоотойгоор зээлжих зэрэглэлийг нь бууруулж, нийгмийн хариуцлага хүлээлгэж байна. Хүнд суртал цагийн дайсан байдаг бол дижитал шилжилт цаг хугацааны найз нөхөр болж байна.



Монгол Улсын Их Хурлын гишүүний ёс зүйн дүрэм, төрийн албаны ёс зүй, сахилга, хариуцлагын тухай хуулийн төслүүдийн хэлэлцүүлгийг нээж, хэлсэн үгнээс

2019.12.16

...Төрийн албан хаагчийн ёс зүйн хэм хэмжээг шинэчлэгдэн батлагдсан Төрийн албаны тухай хуулийн тодорхой зүйл, заалтуудаар зохицуулдаг болсныг Та бүхэн мэдэж байгаа.

Төрийн албан хаагчийн нийтлэг үүрэг, эрх, хориглох зүйлд хуулийг дээдлэн хүндэтгэж, сахин биелүүлэх, өргөсөн тангарагтаа үнэнч байж, шударга бус явдалтай эвлэрэхгүй байх, ёс зүйн хэм хэмжээ, байгууллагын соёл, дэг журмыг сахиж, төрийн албаны нэр хүндийг эрхэмлэн дээдлэх талаар холбогдох зохицуулалт орсон.

Төрийн жинхэнэ албан хаагчийн тангаргийн нийт 33 үгийн 6 нь буюу 18 хувь нь ёс зүйтэй холбоотой байгаа нь энэ хэм хэмжээ ямар их ач холбогдолтойг төвөггүй хэлээд өгнө.

Төрийн албаны зөвлөлийн бүрэн эрхийн нэг хэсэг нь төрийн албаны удирдах болон гүйцэтгэх албан хаагчид төрийн албан хаагчийн ёс зүйн хэм хэмжээг сахиулахтай холбогдсон зөвлөгөө өгөх, арга зүйн удирдлагаар хангах явдал.

Төрийн захиргааны болон үйлчилгээний албан хаагчийн албаны үйл ажиллагаанд баримтлах ёс зүйн нийтлэг хэм хэмжээг тогтоон хэвшүүлэх, төрийн албан хаагчийн ёс зүйн хэм хэмжээг зөрчсөн тухай иргэн, хуулийн этгээдийн гомдол, мэдээллийг хянан шийдвэрлэхтэй холбогдсон харилцааг зохицуулсан төрийн захиргааны болон үйлчилгээний албан хаагчийн ёс зүйн дүрмийг Засгийн газрын 2019 оны 1 дүгээр сарын 23-ны өдрийн 33 дугаар тогтоолоор батлуулан мөрдөж байна.

Үйл явц хурдацтай өрнөж, төрийн албан хаагчийн болон төрийн өндөр албан тушаалтны ёс зүйн асуудлыг хуулийн хүрээнд зохицуулах шаардлагын үүднээс УИХ-ын Тамгын газар, Засгийн газрын Хэрэг эрхлэх газраас Улсын Их Хурлын гишүүний ёс зүйн дүрэм, Төрийн албаны ёс зүй, сахилга хариуцлагын тухай хуулийн төслүүд боловсруулаад байна.

Эдгээр баримт бичгийн төслүүдийн талаар тал бүрээс нь хэлэлцэж, нэгдсэн санал дүгнэлт гаргах үүднээс Та бүхнийг урьсан.

Улсын Их Хурлын дарга Г.Занданшатарын Төрийн албаны зөвлөлд ажиллаж буй өдөртэй энэхүү хэлэлцүүлэг давхцаж байгааг бас бэлгэшээж байна.

Таны цохон тэмдэглэж байсанчлан **ТӨР ЦЭГЦРЭХ ИХ ӨӨРЧЛӨЛТИЙГ** авч ирэх Монгол Улсын Үндсэн хуульд оруулах нэмэлт, өөрчлөлтийн төсөл батлагдсанаас хойш яг нэг сарын дараа (2019-11-14) төрийн албаны төв байгууллага Төрийн албаны зөвлөлд ажиллахаар хүрэлцэн ирсэн Танд Төрийн албаны зөвлөлийн гишүүд, Ажлын албаны ажилтнуудынхаа өмнөөс гүн талархал илэрхийлье.

Төрийн өндөр албан тушаалтан аливаа байгууллагад зочилно гэдэг тухайн байгууллагын үндсэн үйл ажиллагаатай танилцахын зэрэгцээ алдаа оноог нь дэнсэлж, урам зориг, эрч хүч өгдөг, цаашдын зорилго, чиглэлийг нь тодорхойлоход ихээхэн дэм үзүүлдэг. Таны манай байгууллагад ажиллаж байгаа нь ч бидний ажил үйлсэд эерэг үр дүн авч ирнэ гэдэгт итгэлтэй байна.

Г.Занданшатар дарга Монгол Улсын сайд, Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын даргаар ажиллаж байсан, төрийн албаны боловсон хүчний бодлого, тулгамдсан асуудал, шийдвэрлэх арга замын талаар өөрийн итгэл үнэмшилтэй хүн. Бас бидний ажлыг яаж дэмжих вэ, бидэнд яаралтай шийдвэрлэх ямар асуудал байна вэ гэж асуудаг, бидний ажлыг сайн мэддэг хүн.

Таны санаачлан Засгийн газрын тогтоолоор батлуулсан **“Гурван тулгуурт хөгжлийн бодлого”** баримт бичигт **“Шударга ёсыг дээдэлсэн, сахилга, хариуцлагатай тогтвортой засаглал”** нь Монгол Улсын **“хөгжлийн гурван тулгуурын нэг”** хэмээгээд **“сайн төр, монгол хүн, монголын баялаг”** Монгол Улсын хөгжлийн үндэс гэж тодорхойлсон.

“Хариуцлагагүй, бүтээмжгүй, шударга бус, тогтворгүй засаглал хөгжилд саад болж, төрд итгэх итгэл буурсан нь үүний илрэл” гэдгийг өнгөрсөн оны 5 дугаар сард болсон “Төрийн байгууллагын бүтээмж-чадавхыг бэхжүүлэх асуудал” чуулганд онцолж байсныг тань санаж байна.

Энэ бүхэн төрийн албаны шинэтгэлийн баримт бичгүүдэд тусгалаа олж явааг тэмдэглэхэд таатай байна.

Төрийн албанд шинэчлэл хийгдэнэ гэсэн иргэдийн дунд байгаа өндөр давтамжтай хүлээлтэд хариу өгөх **зөв ажлыг, зөв хүнээр, зөв үр дүнд** хүргэх зорилт тавин ажиллаж байгаа үед Төрийн албаны Зөвлөлийн үйл ажиллагаатай Та танилцаж байна.

Энэ оны 5 дугаар сард УИХ-ын Төрийн байгуулалтын байнгын хороонд 2018 оны ажлаа тайлагнахад хийж буй ажилд маань урам дэм өгсөн, бас тодорхой үүрэг чиглэл өгсөн. Хийх ажлын төлөвлөгөө гарган, эзэнжүүлэн ажиллаж байгаа.

Төрийн албаны шинэ хууль хэрэгжиж эхлээд **348 хоног** боллоо. Зөвлөлийн шинэ бүрэлдэхүүн шинэ хуулийг шинэ хандлага, шинэ соёл, шинэ арга барилаар хэрэгжүүлэх зорилт тавин шахуу төлөвлөгөөтэй ажиллаж эхлээд **317 хоног** боллоо.

1. 47 журам батлагдахаас 94 хувь нь батлагдаад байна.

2. Хууль бусаар ажлаас халагдсан албан хаагчийг эгүүлэн томилох шүүхийн шийдвэрийг хэрэгжүүлж, ирүүлсэн өргөдөл, гомдлын дагуу маргаан үүсгэн шалгаж, хууль бус шийдвэрийг хүчингүй болгон шийдвэрлэж байна.

3. Төрд учруулсан хохирлыг буруутай албан тушаалтнаар нөхөн төлүүлэх шаардлага тавьж, холбогдох арга хэмжээг хууль хяналтын байгууллагуудтай хамтран авч хэрэгжүүлж эхэллээ.

4. Төрийн захиргааны албаны албан тушаалын тодорхойлолтыг хянаж, эрх бүхий этгээдэд батлах зөвшөөрлийг олгож байна. Албан тушаалын тодорхойлолт нь “хүнд тааруулах” байдлаар биш, шинжилгээ судалгааны үндсэн дээр тухайн албан тушаалыг гүйцэтгэхэд тавигдах шаардлагыг харуулах ёстой гэсэн зарчмыг баримтлан ажиллаж байна.

5. Төрийн албаны ерөнхий шалгалтыг шинэ хуулийн хүрээнд 11 дүгээр сард анх удаа орон даяар зохион байгуулав. Цахим систем ашиглан очер дугаар үүсгэлгүй, төлбөр хураамжийг хялбаршуулж, хуваарилалтыг автоматаар хийсэн тул нэг нь нөгөөгөө дагаж орохгүй байх, хяналтын оператор программ оноог шууд шалгаж, дүнг нь хэдхэн секундийн дотор хүний оролцоогүйгээр гаргаж чадлаа.

Бид зохион байгуулалт, техник, программ хангамж, тестийн агуулгын хувьд цоо шинэ зарчмаар ажиллаж чадсан.

Төрийн албаны зөвлөлийн Ажлын албаны даргын сонгон шалгаруулалтаар эхлүүлсэн тусгай шалгалтын сонгон шалгаруулалтууд үргэлжлэн явагдана.

6. 2019 онд явуулсан шинэтгэлийн гол зорилт төрийн албыг нийгмийн том системийнх нь хувьд өөрчлөн сайжруулах, энэ системд ажиллаж байгаа хүмүүсээ чадавхжуулж, ийшээ орж ирдэг шууд урсгалыг зогсоох явдал байлаа. Системийн цэгцрэлтийн эхлэл тавигдсан гэж болно.

Ирэх онд байгаа системээсээ давж сэтгэх, үр нөлөөтэй бодлого боловсруулж хэрэгжүүлэх явдал чухал байгаа. Энэ зорилтыг хэрэгжүүлэх боловсон хүчний асуудал сэтгэл зовоож байгааг нуух шаардлагагүй.

Өөрөө ирж, шалгалт өгч тэнцэж байгаа хүмүүсээр төрийн албаны хүний нөөц бүрдүүлдэг аргатай зэрэгцүүлэн мерит зарчмынхаа хүрээнд тухайн ажил үйлсийг хийж чадах оюуны өндөр чадавх (потенциаль)-тай хүмүүсийг төрийн албанд урин ажиллуулах шаардлага тавигдах төлөвтэй.



Headhunting (Хиэдхантинг)-ийн зарчмыг төрийн албанд нэвтрүүлэх нь үгийнхээ эхэнд дурдсан “ЗӨВ ХҮН”-ийг олж ажиллуулахад цаашид бидэнд хэрэг болох санаа гэж ойлгож байгаа.

Ухаалаг, чадварлаг залуусыг төлбөрийн чадварыг нь үл харгалзан төрийн албаны ирээдүй болгон бэлддэг механизм бий болгох талаар санал дэвшүүлснийг маань судлаачид, их, дээд сургуулиудын багш нар дэмжсэн.

7. Төрийн албаны тэргүүн болон эрхэлсэн түшмэл, төрийн өмчийн болон төрийн өмчийн оролцоотой компани, үйлдвэрийн газрын захирлууд зэрэг топ менежерүүдийн сургалтыг үе шаттайгаар хийж ирлээ.

Сургалтад оролцсон удирдах ажилтнууд шинэтгэлийн үзэл санааг байгууллага, нутаг орондоо түгээн дэлгэрүүлж ажиллаж байгаа. Зөвлөлийн гишүүдийн ахалсан багийнхан нийт аймаг, нэлээд олон сумдад очиж ажиллахад ийм сэтгэгдэл төрсөн. Хууль тогтоомжийг хэрэгжүүлэх талаар ойлголтоо нэгтгэх, баримталж буй бодлого, барьж буй зарчмаа тодорхойлоход дээрх ажлууд мэдэгдэхүйц дэм үзүүлсэн.

8. НҮБ-ын Ерөнхий Ассамблейн тогтоолоор 2003 оноос явуулж эхэлсэн НҮБ-ын Төрийн албаны интеграцид нэгдэн, төрийн албаны шинэтгэлийг

эрчимжүүлэхэд НҮБ-ын холбогдох нэгжүүдтэй хамтран ажиллах, бусад орны туршлагыг судлах, олон улсын тавцанд болон үндэсний хэмжээнд Монгол Улсын төрийн албаны нэр хүндийг өргөх, цогц үйл ажиллагаа явуулж эхэллээ.

Олон улсын хамтын нийгэмлэг, гадаад орнуудаас төрийн албаны шинэчлэлтийг маань талархан хүлээн авч, дэмжин ажиллаж байна.

Канад, БНСУ, Энэтхэг, Сингапур зэрэг орнуудтай төрийн албаны шинэтгэлийг үр дүнд хүргэх мэдээлэл, туршлагаа харилцан хуваалцах хамтын ажиллагааг амжилттай хөгжүүлж байна.

9. Хийж буй ажил, гарч буй үр дүн багагүй бий ч цөөн гэлтгүй болох бүтэхгүй зүйл тэр бүхнийг маань харлуулах явдал гарсаар. Саяхан албан ажлын автомашинаа хувийн хэрэгцээнд хэрэглэж байгаа эсэхэд тандалт, шалгалт хийсэн, зөрчил ч багагүй илэрсэн.

Болж бүтэхгүй зүйлсээс урьдчилан сэргийлж чадахгүй бол нэгэнт эхэлсэн хар бараан зүйл гинжин урвал адил цааш үргэлжлэх магадлалыг тодорхойлсон **“Хагархай цонхны онол” гэж байдаг.**

Энэ нь гэм буруутай, ёс зүйгүй үйлдлийг гаргуулахгүй байх нь хамгийн зохистой гэсэн үг. Энэ бодлогыг төрийн албанд цаашид тууштай баримталж, ёс зүйн асуудалд онцгой анхаарал хандуулна.

Яг одоо Төрийн албаны зөвлөл дээр Улсын Их Хурлын гишүүний ёс зүйн дүрэм, Төрийн албаны ёс зүй, сахилга хариуцлагын тухай хуулийн төслүүдээр төрийн захиргааны төв байгууллагуудын холбогдох ажилтнуудыг хамруулан хэлэлцүүлэг зохион байгуулж байна.

10. Дижитал шилжилтийн эринд төрийн албыг хэрхэн үр ашигтай зохион байгуулахаас бидний шинэтгэлийн үр дүн ихээхэн хамаарах нь тодорхой байна. Технологийн асар их хурд, өсөн нэмэгдэж буй хэрэгцээ, хэрэглээний орчинд бид хоцорч чирэгдэхгүй, манлайлж, хөтөлж явах ёстой болж байна.

Ил тод байдал, цаг хугацаа, зардал мөнгө, итгэлцэл, автоматжуулалт, хүний үл оролцоо-энэ бүхэн шударга ёс, хууль дээдлэх зарчим, авлигын эсрэг, иргэдийн сэтгэл ханамжийн баталгаа хэмээн үзэж байна.

11. Төрийн албаны шинэтгэлийг эрчимжүүлэх талаар Ерөнхийлөгч, Улсын Их Хурал, Засгийн газар, Төрийн албаны зөвлөл нэгдмэл итгэл үнэмшил, байр суурьтай ажиллаж байгааг онцгойлон тэмдэглэе.

Улсын Их Хурлаас төрийн албаны шинэтгэлийг гүнзгийрүүлэх, төрийн албаны зөвлөлийн хэвийн үйл ажиллагааг хангах бодлогын төдийгүй

санхүүжилтийн асуудлыг шийдвэрлэхэд Таны оруулсан хувь нэмрийг тэмдэглэхэд таатай байна.

2020 оны ажлаа “Хуулиа дээдэлсэн иргэдээ эрхэмлэсэн” зорилтын дор эрчимтэй зохион байгуулна.

Төрийн албаны шинэтгэлийн алсын харааг **“Чадахуйн зарчимд суурилсан, шатлан дэвших тогтолцоо бүхий, улс төрөөс хараат бус, иргэн төвтэй, жендэрийн мэдрэмжтэй, тогтвортой, мэргэшсэн төрийн албаны соёлыг төлөвшүүлнэ”** гэж тодорхойлж байна.

Ирэх онд:

- 1) Төрийн албаны шинэтгэлийн стратегийн баримт бичгийг шинэчлэн боловсруулж, батлуулан хэрэгжүүлнэ;
- 2) Төрийн албаны тухай хуулийн үзэл баримтлал, зарчимд бусад хууль тогтоомжийг нийцүүлнэ;
- 3) Нийт төрийн албаны хэмжээнд нэгэнт батлагдсан хууль тогтоомжийг хэрэгжүүлэн дагаж мөрдөж байгаа нөхцөл байдалд хяналт шинжилгээ хийж, байгууллага бүрийг төрийн албаны хууль тогтоомжийн зөрчилгүй ажиллах дархлаатай болгоно;
- 4) Төрийн албаны хүний нөөцийн аудитыг агуулга, зорилтын дагуу хэрэгжүүлж, үр нөлөөг нь байгууллагын хөгжилд ашиглах ажлыг эхлүүлнэ;
- 5) Төрийн албан хаагчийн ёс зүйн талаар соён гэгээрүүлэх, зөрчлөөс урьдчилан сэргийлэх, хяналт тавих, таслан зогсоох, зөрчлийг цаг тухайд нь шийдвэрлэж, хариуцлага хүлээлгэх үйл ажиллагааг байгууллага нэг бүр хэвшүүлнэ;
- 6) Төрийн албан хаагчийн сургалт, хөгжилтэй холбоотой асуудлыг хууль тогтоомжид заасан агуулга, хэлбэрээр шинэчлэн зохион байгуулж, хамтрагч байгууллагуудын (ТАЗ, ЗГХЭГ, Удирдлагын академи) хооронд зохистой хамтын ажиллагааны горим тогтооно;
- 7) Төрийн албаны шатлан дэвших нөөцөд хамрагдах төрийн албан хаагчдын судалгааг бүрэн гаргаж, шатлан дэвшүүлэх болзол шаардлагыг хангуулах арга хэмжээг төлөвлөн хэрэгжүүлнэ;
- 8) Төрийн албаны ерөнхий болон тусгай шалгалтыг технологийн дэвшилд тулгуурлан шударга, бодитой явуулах бүх талын нөхцөлийг бүрдүүлнэ;

- 9) Төрийн албан хаагчийн нэгдсэн тоо бүртгэлийг шинжлэх ухааны судалгаа, төрийн албаны шаардлага, хууль, стандартад нийцүүлэн өргөтгөж, төрийн алба, төрийн албан хаагчийн талаарх мэдээллийг иж бүрдлээр хангасан бүртгэл мэдээллийг технологийн дэвшилд тулгуурлан гүйцэтгэнэ;
- 10) Жендерийн хууль тогтоомжийг төрийн албанд хэрэгжүүлж, жендерийн мэдрэмжтэй төрийн албыг төлөвшүүлэхэд ахиц дэвшил гаргасан жил болгоно.

Төрийн албаны шинэтгэл төрийн албан хаагчдын зан үйлийн өөрчлөлт, эдийн засгийн өсөлтөөр хэмжигдсэн, шинийг эрэлхийлсэн, бүтээлч, инновацлаг шинжийг агуулсан, дижитал шилжилтэд шилжсэн байхын төлөө үргэлжлэн явагдах болно.



---o0o---



Төрийн албаны зөвлөлийн нэгдсэн сургалтыг нээж хэлсэн үг ³

2019.12.09

Монгол төрийн шинэхэн түүхийг бичилцэж, төрийн үйл хэргийг энэ цагт буухиалан авч яваа, эх орныхоо өнцөг булан бүрээс хуран цугласан Та бүхэнтэй дахин уулзаж байгаадаа баяртай байна.

Өвлийн жавартай, жиндүү өглөө ч амар мэндтэй дотно яриа, инээмсэглэлийг тань хараад сэтгэл дулаацаж байна.

Та бүхнийг дараах 5 сэдэвт анхаарлаа хандуулахыг хүсье.

1. Гарааны жил-хамтын ажиллагаа
2. АЧАА үүрэх чадварлаг ажилтан
3. Шинэтгэлийг шинэ үзэл санаагаар
4. Хууль дээдлэх ёс-хариуцлага.

³ Энэ үгийг 2020 оны 1-р сарын 16 өдөр болсон яамдын Төрийн нарийн бичгийн дарга, агентлагийн дарга нарын “Шинэ он-шинэ хандлага” сэдэвт уулзалт дээр хэлсэн.

5. Технологийн шинэчлэл – бүтээлч сэтгэлгээ

Нэг. Гарааны жил-хамтын ажиллагаа

21 дүгээр зууны төрийн алба ямар байх вэ? 21 дүгээр зууны төрийн албаны менежер ямар байх вэ гэдэг асуулт дэлхийн бүх улс орны өмнө тавигдаж, эрдэмтэн судлаачдын анхаарлыг татах болж.



21 ДҮГЭЭР ЗУУНД ТӨРИЙН АЛБА ЯМАР БАЙХ ВЭ?

Энэ асуултад Монгол Улсын төрийн албаны тогтолцоо, бүтэц, харилцааг зохицуулах шаардлагын дагуу Төрийн албаны тухай /шинэчилсэн найруулга/ хууль нэг жилийн өмнө батлагдаж хариулсан.

Хуулийн заалт бүрийг хэрэгжүүлэх зорилгоор 47 журам, дүрэм батлагдсан, цаашид ч боловсронгуй болно. Үүнийг Та бид хамтран зохион байгуулж байна. **Өнөөдрийн нэгдсэн сургалтаар шинэ хуулийн хэрэгжилтийн гарааны жилийн явц, хэрэгжилтийн байдал, тулгамдсан асуудал, сургамж цаашид хамтран шийдвэрлэх, хэрэгжүүлэх ажлын талаар ярилцах юм.**

Засаглалын шинэ хэв маягийн тухай дэлхийн эрдэмтэн судлаачид олон санал дэвшүүлж байгаагийн хамгийн чухал нь меритээр дамжуулж засаглахуй, мерит зарчмыг хамгаалах. Манай улс мерит зарчмыг шинэ хуулиар тов тодорхой тогтоосон эхний алхам.

Монгол Улсын 2020 оны Төсвийн тухай хуулиар төрийн албан хаагчдын цалин хөлсийг инфляцтай уялдуулж нэмэгдүүлэх, төрийн үйлчилгээний албан хаагчдад төрийн алба хаасан хугацааны нэмэгдлийг шинээр олгох, төрийн үйлчилгээний албан хаагчдыг гавьяаны амралтаа тогтоолгоход 36 сарын тэтгэмж олгох болсон бөгөөд уг хуульд төрийн албаны шинэтгэлийн талаар онцгой анхаарсан Сангийн яаманд талархал илэрхийлье.

Олон улсын хамтын нийгэмлэг, гадаадын зарим орнуудаас төрийн албаны шинэчлэлтийг талархан хүлээн авч, дэмжин ажиллаж байгаа. Энэ шинэтгэлийн төслийг хамтран хэрэгжүүлж буй НҮБ-ын Хөгжлийн хөтөлбөрийн Суурин төлөөлөгчийн нэр хүндтэй албанд саяхан томилогдсон, сайн засаглал, хүний эрх, жендер, сөргөлдөөнийг зохицуулах талаар мэргэшсэн, олон оронд ажиллаж байсан туршлагатай Хатагтай **Илейн Конкиевич** Таны ажил үйлсэд амжилт хүсье.

Хатагтай **Илейн Конкиевич**, Суурин төлөөлөгчийн орлогч **Хатагтай Нашида Саттар** нартай 3 хоногийн өмнө уулзаж, шинэтгэлийг хэрэгжүүлэх талаар санаа бодлоо нэгтгэж чадсандаа баяртай байгаагаа энэ танхимд илэрхийлье.

Өнөөдрийн сургалтыг НҮБ-ийн дэмжлэгтэй, Канадын санхүүжилттэй хэрэгжиж байгаа “Мэргэжлийн, иргэн төвтэй Төрийн албыг төлөвшүүлэх төсөл”-тэй хамтран зохион байгуулж байна.

Канад, Сингапур, Солонгос, Энэтхэг зэрэг орнуудтай төрийн албаны хамтын ажиллагааг амжилттай хөгжүүлж байна. Өнгөрсөн 5 дахь өдөр БНСУ-ын Хүний нөөц, боловсон хүчний яамны сайд манай улсад ажиллаж, хөгжлийн үйл явцад төрийн албаны гүйцэтгэх үүргийн талаар мэдлэг онцлог, арга туршлагын онцлогоосоо харамгүй хуваалцлаа.

НҮБ-ын Ерөнхий Ассамблей 2003 оноос жил бүрийн 6 дугаар сарын 23-ныг “Төрийн албаны өдөр” болгон товлон тогтсон. Энэ жилээс манай Зөвлөл жил бүр зохион байгуулагддаг харилцан туршлага солилцох үйл явцад онцгой анхаарал хандуулж, улс орнуудын мэдээлэл, харилцааны технологи ашиглах чадамжийг нэмэгдүүлэх, өргөн хүрээтэй хэлэлцүүлэг өрнүүлдэг Төрийн албаны олон улсын форумд оролцож эхэллээ.

НҮБ-аас жил бүр олгодог төрийн албаны нэр хүндтэй шагналд Монгол Улсын төрийн байгууллагуудаас нэр дэвшүүлэх урилга хүлээн авлаа.

Цаашид олон улсын энэхүү арга хэмжээнд та бүхний төлөөллийг оролцуулах, хийж бүтээсэн онцлог ажлаа нэр дэвшүүлж, олон улсын тавцанд үнэлүүлэх, үндэсний хэмжээнд төрийн албаны нэр хүндийг, эергээр өөрчлөх ажлыг тасралтгүй зохион байгуулна.

Германы Олон Улсын Хамтын Ажиллагааны Нийгэмлэг төрийн албаны ил тод байдлыг хангах, сайн засаглал, шилдэг туршлагыг шалгаруулж түгээн дэлгэрүүлэх, төрийн албаны инновац хөгжлийг нэмэгдүүлэх замаар төр, иргэн, хувийн хэвшил хоорондын итгэлцлийг сайжруулах зорилго бүхий “Төрийн албаны менежментийн хөгжлийн асуудал” форумыг Орхон аймагт өнгөрсөн сард зохион байгуулсан.

Салбар зөвлөлүүд идэвхтэй оролцож сайн туршлага, ололт, амжилтаа түгээн дэлгэрүүлсэн хэлэлцүүлгийн явцад НҮБ-ын төрийн албаны шагналд энэ

жилийн хувьд Орхон аймгийн Нийгмийн даатгалын хэлтсийн ухаалаг, цахим засаглалын ололт амжилтыг нэр дэвшүүлэхээр санал нэгдсэн.

Тогтвортой, урьдчилан төсөөлөх боломжтой, үр ашигтай үйлчилгээг иргэдэд үзүүлэх жил болгоно.

Хоёр. АЧАА үүрэх чадварлаг ажилтан

Бүгдээрээ ойр ойрхон нүүр тулан уулзаж, санаа бодлоо илэн далангүй солилцож, өдөр шөнийг үл ажран их ажлын эхлэлийг тавьсаар энэ оныг үдэж байна.

Гараа сайн бол бариа сайн гэдэг. Шинэтгэлийг шинэ ажлын гарааны нөхцөлөө бодитой тодорхойлж, мэдээллийн хүртээмж, ойлголтоо нэгтгэж чадвал үр дүн гарна гэж үзсэн.

Яамдын Төрийн нарийн бичгийн дарга, агентлагийн дарга, аймаг, нийслэлийн ЗДТГ-ын дарга, ИТХ-ын нарийн бичгийн дарга зэрэг тэргүүн болон эрхэлсэн түшмэл, төрийн өмчийн болон төрийн өмчийн оролцоотой компани, үйлдвэрийн газрын захирлууд зэрэг топ менежерүүдийн сургалтыг үе шаттайгаар зохион байгууллаа. Бүх аймагт ажиллалаа.

Сургалтын үзэл санааг ажилдаа тусган авч хэрэгжүүлсэн гэдэгт итгэлтэй байна.

Ирэх жил сурснаа хэрэгжүүлэх, үр дүн гаргах, иргэдэд хүргэх төрийн үйлчилгээг чанаржуулах жил болгоно. Цаад утгаараа 21 дүгээр зууны төрийн албаны удирдах ажилтанд “мэдэгдэж байгаа”, бас “үл мэдэгдэх” олон сорилуудад өөрсдийгөө бэлтгэхийг хичээж буй хэрэг. Бэлтгэгдэж чадсан хүн сорилуудыг бэрхшээл, хохирол багатай даван туулна.

Мэдлэгтэй, ур чадвартай, мэдээлэл боловсруулж чаддаг эрдэм илүү төрийн албан хаагч үүнийг чадна. Тиймээс төрийн албыг **АЧАА** гэж зүйрлэвэл **алдаагүй** бодлогыг **чадварлаг** ажилтан хэрэгжүүлсний үр дүнд **айдасгүй** иргэдийн **амьдралын** баталгаа бий болно гэж томъёолдогоо дахин хэлье.

Гурав. Шинэчлэлийг шинэ үзэл санаагаар

Саяхан манай улсын эрдмийн уурхай болсон МУИС-ийн дугуй танхимд зохион байгуулагдсан эрдэмтэд, судлаачид оролцсон “Тэсрэлтэт технологийн эрэн ба бодлого” хэлэлцүүлэгт миний бие ухаалаг, чадварлаг залуусыг төлбөрийн чадварыг нь үл харгалзан бэлддэг тогтолцоо бий болгох талаар санал дэвшүүлж, үзэл бодлоо илэрхийлсэн.



Төлбөрийн чадвар нь хязгаарлагдмал боловч оюуны чадавхтай залуучуудыг тэтгэлэгт хөтөлбөрт хамруулах санал дэвшүүлсэн. Дэвшүүлсэн саналыг их, дээд сургуулийн төлөөллүүд таатай хүлээн авч хэрэгжүүлэхээ илэрхийлсэн.

Хувийн хэвшил хүнээ бэлдээд, чадварлаг боловсон хүчнийг татаж байхад төрийн алба хүн ирж ажиллахыг хүлээгээд сууж таарахгүй. Өсөн дэвжих төрийн үйлийг өрсөлдөх чадвартай, өндөр боловсролтой, ёс зүйтэй хүмүүс залгуулах учиртай.

Дэлхийн улс орнуудад хувийн хэвшлийн хийж ирсэн “хээд хантинг” буюу мэргэжлийн топ экспертүүдийг байгууллагадаа урин ажиллуулдаг туршлагыг Мерит зарчмын хүрээнд төрийн албанд нэвтрүүлнэ.

Хээд хантинг нь “Шууд”, “Шууд бус”, “Гуравдагч тал” гэсэн 3 төрөлтэй байдаг байна. Судлаад үзнэ биз ээ.



Зөв хүн

Right person



Зөв ажил

Right task



Зөв үр дүн

Right result

Чадахуйн зарчмын мөн чанар ч ийм юм аа.

Дөрөв. Хууль дээдлэх ёс-хариуцлага.

Төрийн албаны шинэтгэл, төлөвшлийн үндэс суурь нь төрийн албан хаагч Та бид өөрсдөө шударга ёсны туйл байж, хуулиа чандлан мөрдөх учиртай юм аа.



МОНГОЛ УЛСЫН ТӨРИЙН АЛБАНЫ ШИНЭТГЭЛ

ШУДАРГА ЁС ХУУЛЬ ДЭЭДЛЭХ

Та бид өргөсөн тангарагтаа үнэнч байж гэмээнэ төрийн ажил үйл урагштай, төр түвшин байх хийгээд тангаргаа биелүүлж чадаж байвал түмэн олны төрдөө итгэх итгэл дээшилнэ.

Шударга, ёс зүйтэй, авлигагүй нийгмийг хүссэн гадаад хэлтэй, боломжийн мэдлэг боловсрол эзэмшсэн иргэдийн орчин үеийн **их нүүдэл** дэлхий дахинаа явагдаж байна. Бид гадаад руу ажиллахаар явж байгаа хүмүүсээ дан ганц эдийн засаг, илүү орлогын талаас нь төдийгүй шударга ёсны хүсэмжлэлдээ хөтлөгдөн яваа эсэхийг ч бодолцох ёстой болжээ.

Өндөр хөгжилтэй оронд боловсрол эзэмшсэн Төрийн албан хаагчдыг дэмжинэ.

Хууль дээдлэн ажиллана гэдэг хамгийн товчоор үүрэг, хариуцлагаа ухамсарлана, бас эрхээ зөв эдэлнэ гэсэн үг. Хуулиас ангид, хуулиас гадуур амьдрах боломжгүй болсон нийгэм, цаг үед бид ажиллаж байна.

Эрх эдлэхээс гадна эрдэм илүү байх нь чухлыг дахин хэлье.

Хууль дээдлэх төрийн албаны амин чухал зарчмыг хэрэгжүүлэгч, зохион байгуулагч, үлгэрлэгч, манлайлагч, харилцагч нь төрийн албан хаагч та бид нар юм.

Хүний эрх, шударга ёс, хуулийг дээдэлж хууль сахиулдаг салбарын сургалт, эрдэм шинжилгээний гол түшиц байгууллага болсон Дотоод Хэргийн Их сургуулийн саруул танхимыг сонгон өнөөдрийн сургалтаа явуулж буй нь ч санамсаргүй тохиолдол биш юм.

2020 он хуулиа дээдэлсэн, ёс зүйн дээд эрэмбийг төрийн албанд нутагшуулсан жил байна.

Тав. Технологийн шинэчлэл – бүтээлч сэтгэлгээ

“Сөрөг үйл явдлыг сөрөн зогсож болдог, харин **цаг нь ирсэн үзэл санааг** зогсоох боломжгүй” гэсэн ухаантны үг буй. Шинэ хуулиар баталгаажсан төрийн албаны шинэчлэлт, дэлхийн улс орнуудын хэрэгжүүлж буй НҮБ-ын Тогтвортой хөгжлийн зорилтууд бол нийгэм, иргэдийн хүсэн хүлээж байгаа **“шинэ үзэл санаа”**. Үүнийг зогсоох боломжгүй юм.

Шинэ **үзэл санааг** тээгч, нийгэмд түгээн дэлгэрүүлэгч байх **эрх**, бас **үүрэг** нь төрийн захиргааны тэргүүн түшмэд, Та нараар манлайлуулсан Төрийн албаны салбар зөвлөлийн гишүүд, нарийн бичгийн дарга нарт ногдож байна.

Улс орны хэмжээнд хийж буй ажил, гарч буй үр дүн багагүй бий ч цөөн гэлтгүй болох бүтэхгүй зүйл тэр бүхнийг маань харлуулах явдал гардаг. Болж бүтэхгүй зүйлсээс урьдчилан сэргийлж чадахгүй бол нэгэнт эхэлсэн хар бараан зүйл гинжин урвал адил цааш үргэлжлэх магадлалыг тодорхойлсон **“Хагархай цонхны онол”** гэж байдаг.

ТАВ. “ХАГАРХАЙ ЦОНХНЫ ОНОЛ”




Товчхондоо гэм буруутай, ёс зүйгүй үйлдлийг гаргуулахгүй байх нь хамгийн зохистой гэсэн үг. Буруу үйлдлийг давтан үйлддэг. Энэ байдалтай эвлэрч болохгүй. Тиймээс ч иргэд, олон нийтийн дунд төрийн албаны шинэчлэлтийн хүлээлт өндөр давтамжтай, шударга ёсны хүсэмжлэл их байгаа нь тодорхой.

Дижитал шилжилтийн эринд төрийн албыг хэрхэн үр ашигтай зохион байгуулахаас бидний шинэтгэлийн үр дүн ихээхэн хамаарах нь тодорхой байна. Технологийн асар их хурд, өсөн нэмэгдэж буй хэрэгцээ, хэрэглээний орчинд бид хоцорч чирэгдэхгүй, бүдэрч унахгүй, харин ч манлайлж явах учиртай.

Манай улсын хувьд интернэтэд гар утаснаасаа ордог хүн давхардсан тоогоор 3.9 сая, суурин интернэт хэрэглэгчид 300 мянга байгаа бол фэйсбүүкийг 2.2 сая хүн хүн хэрэглэдэг болж, интернэтийн суурь дэд бүтэц болон хэрэглээгээрээ цахим шилжилтэд үндсэндээ бэлэн болчихсон ийм цаг үед бид амьдарч байна.

Цаашид төрийн албаны үйл ажиллагааг блокчэйн технологи (нэгдмэл цахим мэдээллийн сан)-д шилжүүлэх том алхам бидний урд байна.

Саяхан электрон засаглалын асуудлаар өргөн хүрээтэй хэлэлцүүлэг хийгдэж, Эстони улстай хамтран ажиллахаар боллоо. Эстони улс үндсэндээ дижитал орон болж, төрийн байгууллагуудынх нь ихэнх үйлчилгээ блокчэйн технологид суурилан 24/7-ийн (24 цаг 7 хоног) тасралтгүй системд шилжиж чаджээ. Төрийн бүх үйлчилгээ өдөр шөнө, амралт баяр ёслолын өдрүүдээс үл хамааран онлайнаар явагдаж байна. Мэдээллийн аюулгүй байдлаа хангах үүднээс дэлхийн анхны дата Элчин сайдын яамыг Люксембург улсад нээжээ.



Аргентин энэ оны эхний өдрөөс цаасгүй Засгийн газартай болж, технологийг авлигатай тэмцэх гол түншээ болгож байна.

Хятадад “**нийгмийн оноо**”-ны системийг туршиж эхэлж. Архи их авдаг, уудаг, гарцгүй газраар гардаг, гудамжинд зүй бус авирладаг хүнийг царайгаар нь таниад хиймэл оюун ухааны оролцоотойгоор зээлжих зэрэглэлийг нь бууруулж, нийгмийн хариуцлага хүлээлгэж байна.

Хүнд суртал цагийн дайсан байдаг бол дижитал шилжилт цаг хугацааны найз нөхөр болж байна.

Хүн төрөлхтний түүхэнд хамгийн амь бөхтэй дагалдаж ирсэн **худлаагийн асуудал** дижитал эринд байхгүй болох нь. Энэхүү зайлшгүй үзэгдлийг сөрөх ч юм уу, устгах, тойрох боломжгүй. Харин үүнийг яаж нийлэмжтэй, хүртээмжтэй ашиглаж маш хурдан нэвтрүүлэх вэ гэдгийг бодох хэрэгтэй болж байна. Технологи, хууль 2 бүх секторт нэвтрэх нь. Бид үүнд бэлэн байж, зөв ашиглах хэрэгтэй байна.

Оксфордын их сургуулиас төрийн албаны үр ашгийн индексийг 12 үзүүлэлтээр жил бүр гаргадаг. Энэ судалгаанд манай улс хамрагддаггүй ч үндэсний хэмжээнд адил төстэй шалгуураар индекс тогтоож болно гэж бодож

байна. Ямар үзүүлэлт дээр аль улс ямар үзүүлэлтээр явж байгааг хялбархан харж болдог.

Та бид өнөөдөр шинэтгэлийн олон чухал асуудлыг хэлэлцэж, улс орондоо мэргэшсэн, тогтвортой, хариуцлагатай, чадварлаг төрийн албыг төлөвшүүлэх зорилтыг хэрэгжүүлэх арга замын талаар зөвшилцөж санал бодлоо солилцон, ирж буй 2020 онд дэвшүүлэх зорилт, хийх ажлынхаа талаар өнөөдөр ярилцана.

Ирэх он жилүүдэд Төрийн албаны зөвлөл, төрийн бүх шатны байгууллага, төрийн албан хаагчдыг их сорилт хүлээж байна.

Төрийн албаны зөвлөл өөрөө төрийн ажил, төрийн албаны толь байх ёстой гэдгийг бид ойлгож, ухамсарлаж байгаа.

Шинэтгэлийг бүрэн дүүрэн гүйцэтгэхэд төрийн албан хаагчид төдийгүй улстөрчдийн сэтгэлгээ, зан үйлийн өөрчлөлт маш чухал байна.

“21 дүгээр зууны “бичиг үсэггүй хүн” гэдэг уншиж, бичиж чаддаггүй хүнийг хэлэхгүй, харин суралцдаггүй, бас юуг хаяж, юуг шинээр сурах ёстой вэ? Юунд ач холбогдол өгч, эрэмбэ тогтоох вэ гэдгээ мэддэггүй хүнийг хэлнэ”. Энэ хатуу үгийг дижитал болон харилцааны хувьсгалыг соёлын талаас нь судалсан, “Фортюнь” сэтгүүлийн редактор, футурист Алвин Тоффлер хэлснийг бид санахад илүүдэхгүй ээ.

Хуулийн хэрэгжилтийн хүрсэн түвшинг дүгнэж, ирэх жилийн хүрэх өндөрлөгөө тогтоох Төрийн албаны зөвлөлийн нэгдсэн сургалтад амжилт хүсье.

---o0o---



**Өмнөговь аймгийн төрийн албан хаагчдад
зориулсан сургалтыг нээж хэлсэн үгнээс**

Даланзадгад хот 2019.06.13

Эртний уламжлалт монгол төрийнхөө шинэ түүхийн хуудсыг бичилцэж, төрийн үйл хэргийг энэ цаг үед буухиалан авч яваа Та бүхэнд энэ өглөөний мэнд хүргэе!

Говьд зуншлага сайхан болох төлөвтэй байна. Уулзсан хүмүүсийн нүүр царайнд баяр баясгалан, үг ярианд нь өөдрөг үзэл мэдрэгдэж байна.

Төрийн албаны үзэл санаа, зарчмыг цоо шинээр зохицуулсан Төрийн албаны тухай шинэ хууль хүчин төгөлдөр мөрдөгдөөд хуанлийн хуудас 164 дэх удаагаа эргэж байгаа энэ өдөр бүгдээрээ уулзалдаж байна. Бидний хийх ёстой ажил хором мөчөөр хэмжигдэж байгаа учраас цаг хугацааны мэдрэмжтэй байх үүднээс энэ хугацааг байнга хэлж, сануулж явна.

Төрийн албаны шинэтгэлийг ажил хэрэг болгох, гардан хэрэгжүүлэх үүрэг хариуцлагыг хүлээсэн та бид энэ шинэтгэлд бэлэн болох нь юу юунаас чухал. Шинэ ажлын гарааны нөхцөлөө бодитойгоор тодорхойлж, мэдээллийн хүртээмж, ойлголтоо нэгтгэж чадвал үр дүн гарна.

Шинэчлэлтийг бүх салбарт үр дүнтэй хүргэх зорилтыг Төрийн албаны зөвлөлийн шинэ бүрэлдэхүүн тавьж байна.

Яамдын Төрийн нарийн бичгийн дарга, агентлагийн захирал, аймаг, нийслэлийн ЗДТГ-ын дарга, ИТХ-ын нарийн бичгийн дарга зэрэг тэргүүн, эрхэлсэн түшмэл, төрийн өмчийн болон төрийн өмчийн оролцоотой компани, үйлдвэрийн газрын захирлууд зэрэг топ менежерүүдийн сургалтыг үе шаттайгаар хийж байна.

Энэ сургалтад оролцсон аймгийн удирдах ажилтнууд шинэтгэлийн үзэл санааг нутаг орондоо түгээн дэлгэрүүлж ажиллаж байгаа гэдэгт эргэлзэхгүй байна.

Эдийн засгийн бодлого, өрсөлдөх чадварын судалгааны төвөөс жил бүр гаргадаг аймгуудын өрсөлдөх чадварын тайлан судалгаагаар Өмнөговь аймаг 2018 онд улсдаа **өндөрт эрэмбэлэгдсэн**. Эдийн засгийн хөгжил, хүн амын амьжиргааны түвшин, үндсэн дэд бүтэц, төсөв санхүү, институтийн тогтолцоо зэрэг үзүүлэлтээр тэргүүлсэн төдийгүй засаглалын үр ашгийн үзүүлэлт өмнөх жилээс илүүтэй ахисан.

Аймгийн удирдлагын бодлого шийдвэр, төсвийн удирдлага, захиргааны зохицуулалт, төрийн үйлчилгээний үр ашгаараа нэгд эрэмбэлэгдсэн.

АЖИЛ-ыг Алдаагүй бодлого, Жинхэнэ албан хаагч, Иргэн төвтэй үйлчилгээ, Лидер-манлайлагч гэж ойлгож болно.

Хүн ам, өрхийн тооноос эхлээд улс орныхоо эдийн засагт оруулж буй хувь нэмэр гээд олон эерэг үзүүлэлтүүд жил ирэх тутам өсөж байгаа нь Өмнөговийн хөгжлийн толь, хүн ардынх нь өөдрөг ирээдүйн баталгаа. Хөгжлийн хурд их байх тусам сорил бэрхшээл, шийдвэрлэх ёстой асуудлууд мөн адил өсөж байдаг жам энд бас байгаа.

Багийн ажил сайн байж сумын ажил сайн байна, сумын ажил сайн байж аймгийн ажил сайн байх нь ойлгомжтой. Баг, сумын ажил сайн байх эсэх нь байгууллага, агентлаг, газруудын ажил үйлс, тэнд ажиллаж байгаа хүмүүсийн үйл ажиллагаанаас хамаарна.

Улс орны хэмжээнд хийж буй ажил, гарч буй үр дүн багагүй бий ч цөөн гэлтгүй болох бүтэхгүй зүйл тэр бүхнийг маань харлуулах явдал гарах юм. Саяхан дипломат албанд ажилладаг хүн хар тамхины хэрэгт холбогдсон нь “нэг үхрийн эвэр доргивол мянган үхрийнх доргидог” гэдгийн нэг жишээ, **буруу** хүнийг томилсны хар гай юм.

Тиймээс ч иргэд, олон нийтийн дунд төрийн албаны шинэчлэлтийн хүлээлт өндөр давтамжтай, шударга ёсны хүсэмжлэл их байна. Бүгдийг нэг дор, нэг зэрэг хийх боломжгүй ч сайтар төлөвлөсөн эрэмбэ дарааллын дагуу ажиллаж чадвал иргэдийн төрд итгэх итгэлийг нэмэгдүүлэх боломжтой.

....Шинэтгэлийн үйл явц иргэд, олон нийтийн төдийгүй олон улсын байгууллагын дэмжлэгийг хүлээх болсон нь бодит ахиц дэвшил. НҮБ-ын Хөгжлийн хөтөлбөртэй хамтран “Мэргэжлийн, иргэн төвтэй төрийн албыг бэхжүүлэх нь” төслийг хэрэгжүүлж байна. Энэ ажлын явцад төрийн албаны тогтвортой байдал, төрийн албан хаагчдын хөдөлгөөн, жендерийн асуудал, мэргэшүүлэх болон онлайн сургалтын агуулга, хөтөлбөр, мэргэшлийн шалгалтыг шинэчилнэ.

Одоо ингээд ярианыхаа дараагийн хэсэгт оръё. Энэ хэсэгт би төрийн албаны орчин үеийн чиг хандлагатай уялдуулаад та бүхэнд хэрэгтэй зарим мэдээллийг хуваалцана.

Технологийн асар их хурд, өсөн нэмэгдэж буй хэрэгцээ, хэрэглээний орчинд бид хоцорч чирэгдэхгүй, бүдэрч унахгүй, харин ч манлайлж, хөтөлж явах ёстой болж байна.

Мэдлэгтэй, ур чадвартай, мэдээлэл боловсруулж чаддаг төрийн албан хаагч үүнийг чадна. Тиймээс төрийн албыг **АЧАА** гэж зүйрлэвэл **Алдаагүй** бодлогыг **Чадварлаг** ажилтан хэрэгжүүлсний үр дүнд **Айдасгүй** иргэдийн **Амьдралын** баталгаа бий болно гэж томъёолмоор байна.




АЧАА ҮҮРЭХ ЧАДВАРЛАГ АЖИЛТАН.



ТӨРИЙН АЛБА

Алдаагүй бодлого
Чадварлаг ажилтан
Айдасгүй иргэд
Амьдралын баталгаа

АЧААны хүндийг үүрэх



Зөвхөн интернэтийн орчны нэг минутыг харъя. 1 сая орчим доллараар бараа бүтээгдэхүүн авч, 188 сая и-мэйл, 18 сая мессеж, 87,500 жиргээ бичигдэж, нийгмийн сүлжээнд 1 сая хүн орж, 390.000 аппликэйшн таталт хийгдэж байх жишээтэй.

Интернэт орчинд 1 минут тутамд



Улс орны хөгжил дэвшилд биднээс **үндсэндээ үл хамаарах**, эсвэл маш **бага хамааралтай** олон хүчин зүйл бий. Соёл, зан заншил, уур амьсгалын өөрчлөлт, дэлхийн зах зээл дээрх алт, зэсийн үнэ гээд.

Харин бидний хийж, сайжруулж чадах зүйл бол төрийн үйлчилгээ. Төрийн үйлчилгээг сайжруулж, үр дүнд нь маш олон эерэг өөрчлөлт гаргаж чаддаг жишиг өндөр хөгжилтэй улс орнуудад байна. Монгол маань өөдлөн дэгжиж, хүчирхэг, нэр хүндтэй явсан түүх бидэнд бий. Улс орноо хөгжүүлж, хүн ард нь аз жаргалтай байх

тийм орчин, нөхцөлийг буй болгоход төрийн албаа төгөлдөржүүлэх төрийн албан хаагч та бидний хүчин чармайлт юу юунаас чухал байна.

Засгийн газраас 2019 оныг **“Иргэн төвтэй төрийн үйлчилгээний жил”** болгон зарласан. Иргэдийн хэрэгцээнд суурилсан, ил тод төрийн үйлчилгээний үр дүнд суурилсан удирдлагыг бий болгох Засгийн газрын зорилт төрийн албаны эрх зүйн шинэ орчин, шинэтгэлийн үйл явцтай нягт уялдаж байгаа.

Төрийн албаны шинэ хуулиар төрийн албанд ажиллах босго өндөр болж, тохиолдлын хүн томилогдохгүй байх эрх зүйн үндэс тавигдсан.

Энэ бүхний ард өөрийн итгэл үнэмшил, байр суурьтай, ирээдүйдээ итгэлтэй төрийн жинхэнэ албан хаагч төлөвшиж, үр дүнд нь төрийн алба, улс орны нэр хүнд өндөрсөнө гэдэгт би хувьдаа эргэлздэггүй.

Төрд бэлтгэгдсэн, мэргэшиж төлөвшсөн хүмүүс ямар ч байдалд барьц алдахгүй байх сэтгэлийн хат, маневр (хөрвөх чадвар)-тай байдгийн ганц хоёр жишээг сонирхуулъя гэж бодлоо. Наанаа хөгжилтэй мэт харагдавч цаад утга агуулгаар нь ойлгох гээд үзвэл нэгийг бодогдуулж хоёрыг ухааруулна байх.

Ирэх он жилүүдэд Төрийн албаны зөвлөл, төрийн бүх шатны байгууллага, төрийн албан хаагчдыг их сорилт хүлээж байна.

Төрийн албаны зөвлөл өөрөө төрийн ажил, төрийн албаны толь байх ёстой гэдгийг бид ойлгож, ухамсарлаж байгаа.

Шинэтгэлийг бүрэн дүүрэн гүйцэтгэхэд төрийн албан хаагчид төдийгүй улс төрчдийн сэтгэлгээ, зан үйлийн өөрчлөлт маш чухал.

Ажилдаа чин сэтгэлээсээ ханддаг албан хаагчидтай төрийн албыг төлөвшүүлэхийг зорьж байна. Хийх ажлаа илүү үр нөлөөтэйгөөс нь эхлүүлэх, шинэчлэлийнхээ үзэл баримтлалыг иргэдэд ойлгуулан таниулж, иргэдийн зүрх сэтгэлд хүрэхийг чухалчилж байна.

...Энэ шинэчлэлийг эрчимжүүлж манлайлахад төрийн албан хаагч та бүхний чин сэтгэл, шаргуу үйл ажиллагаа чухал байна....



**“21 ДҮГЭЭР ЗУУНЫ ТӨРИЙН АЛБАНЫ МЕНЕЖЕР”
НОМЫН НЭЭЛТИЙН ЁСЛОЛЫН ҮЙЛ АЖИЛЛАГАА ДЭЭР ХЭЛСЭН
ҮГ**

2019.08.30

Улсын Их Хурлын эрхэм гишүүн, Монгол Улсын сайд, Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын дарга Л.Оюун-Эрдэнэ, Эрхэм хүндэт зочид оо!



Эрдэм номын их үйлс дэлгэрэх хичээлийн шинэ жилийн босгон дээр Та бүхнийг урьсан маань учиртай. Яагаад гэвэл бид “21 дүгээр зууны төрийн албаны менежер” номыг төрийн албан ёсны хэл дээр унших боломж бүрдэж байгаа баярт мөчийг хамтдаа хуваалцах гэж байна.

“21 дүгээр зууны төрийн албаны менежер” ном төрийн албаны удирдах, гүйцэтгэх албан тушаалтнууд, монгол төрийн ирээдүйн залуу халаа, оюутан сурагчид, судлаач шинжээчдийн ширээний төдийгүй сэтгэлгээний ном болно гэдэгт итгэлтэй байна.

Орчуулах, хянан тохиолдуулах эрдэм нь үг найруулгыг механикаар хуулбарлан буулгах төдийхөн хэрэг биш, нэг үндэстний соёлын үнэ цэнтэй бүтээлийг нөгөө үндэстний сэтгэхүйд дүйцүүлэн хувиргах бүтээлч үйл ажиллагаа юм.

Тийм ч учраас нэгэн гүн ухаантан "... ямар улс хамгийн түрүүнд орчуулга түлхүү хийж эхэлсэн байна, тэр улс түрүүлэн хөгжиж байсан зүй тогтлыг олж харахад төвөггүй" гэснийг анхаарахгүй байх аргагүй.

Дээрх үг сэргэн мандалтын үеийн философич Макиавеллийн хэлсэнчлэн “Ард түмний гарт эд агуурс, материал баялаг өгөхөөс илүүтэйгээр түүнтэй тэнцэх ном өгвөөс тэд өөрсдөө баялгийг бий болгож чаддаг” гэдгийг бэлхнээ нотолж байгаа хэрэг.

Төрийн албаны тухай шинэ хуулийн гол үзэл баримтлал болсон чадахуйн зарчмын үндсэн суурь нь төрийн албан хаагчдыг мэргэшүүлэх, ажил хэргээ явуулахад нь шаардлагатай мэдлэг, ур чадварыг олгоход дэмжлэг үзүүлэх явдал.

Энэ асуудлыг Төрийн албаны зөвлөл, ЗГХЭГ-аас онцгойлон анхаарч төрийн албан хаагчийн “Мэргэшүүлэх багц сургалтын агуулга, хөтөлбөр”-ийг шинэчлэн баталсан.



Шинэ агуулга, хөтөлбөрийн дагуу төрийн албаны тэргүүн болон эрхэлсэн түшмэлийн сургалтыг үе шаттайгаар зохион байгуулж байна.

9 дүгээр сараас ээлжит сургалтууд үргэлжилж энэ ондоо багтаан тэргүүн, эрхэлсэн, ахлах түшмэлийн ангилалд 3000 гаруй төрийн албан хаагчдын сургалтыг зохион байгуулна.

Энэ ажилд НҮБ-ын Хөгжлийн хөтөлбөр, Канад Улсын Засгийн газраас хамтран хэрэгжүүлж байгаа “Монгол Улсад мэргэжлийн, иргэн төвтэй төрийн албыг төлөвшүүлэх нь” болон “MERIT” төслөөс мэргэжил, арга зүй, санхүүгийн дэмжлэг үзүүлэн ажиллаж байна.

Удирдлагын академид сургалтын агуулга, хөтөлбөр шинэчлэх ажил үргэлжлэн хийгдэж байгаа. Үүний зэрэгцээ Төрийн албаны зөвлөлөөс топ менежерүүдийн мэргэшүүлэх сургалтад гадаадын нэр хүндтэй их сургуулийн болон өөрийн орны эрдэмтэн, багш нарыг урьж оролцуулж байна.

Төрийн албаны зөвлөлөөс хамгийн сүүлийн үеийн гэгдэх, олон улсын практик шалгуурыг давж, судлаач, шүүмжлэгчдээс өндөр үнэлгээ авсан сурах бичиг, зохиол бүтээлийг сонгож, энэ чиглэлийн таван ч номын зохиогчийн эрхийг авах гэрээ байгуулаад байгаа.



Эдгээрийн нэг нь өнөөдөр Та бүгдэд эх хэл дээр хөрвүүлэгдэн очиж байгаа төрийн албаны удирдах ажилтны ур чадварын тухай профессор Зегер ван дэр Валын “21 дүгээр зууны төрийн албаны менежер” ном юм.

Би өөрөө профессор Зегерийн хичээлд топ менежерүүдтэйгээ хамт сууж, бас энэ номыг уншсан. Төрсөн сэтгэгдлээсээ товч хуваалцъя.

Иргэдэд үйлчлэх зорилго, үүргээ улам сайн гүйцэтгэхийн зэрэгцээ хувьсамтгай, тодорхойгүй, төвөгтэй, эргэлзээтэй болсон VUCA орчинд ажиллахад хэрэг болох олон шинэ ур чадварыг эзэмших нь чухлыг номд өгүүлжээ.

Эдгээр ур чадваргүйгээр төрийн алба, төрийн албан хаагчид нийгмээ урагш хөгжүүлэх хөдөлгөөр байж чадахгүй, харин ч арагш чангаасан тоормос болох цаг үед амьдарч байгааг нотлон өгүүлсэн байна лээ.

Бид дэлхий ертөнц, нийгмийн маш хурдацтай өөрчлөлтийн энэ цаг үед “болж байсан юм, болох байлгүй дээ” гэсэн байдлаар ажиллаад явахгүй нь ээ.

“Бүргэд өндөрт нисэх тусам алсыг хардаг”. Энэхүү номыг унших, судлах тусам төрийн албан хаагчид алсыг харна гэдэгт эргэлзэхгүй байна.

Хандлага, сэтгэлгээний олон чухал шинэ санаа дэвшүүлэн тавьж, холбогдох арга хэрэгслүүд, олон улсын амжилт болон бүтэлгүйтлийн жишээ, кэйсийг толилуулсан нь уншигчдад ач тусаа өгнө гэдэгт итгэлтэй байна.

90-ээд оны дунд үеэс хойш төрсөн “унаган дижитал-Z” (зэт) үеийнхэн нийгмийн идэвхтэй амьдралд орж байгаа энэ үед тэдний сэтгэл зүйн онцлог байдлыг таньж мэдэх, зөв удирдах талаар сонирхолтой санаануудыг ч уг номоос Та бүхэн олж мэдэх болно.

Номд дурдагдаж байгаа дэлхий хөгжлийн 21 дүгээр зууны чиг хандлага, сорилт, бэрхшээл манай орны хувьд ч ихээхэн төстэй. Иймд бид ялангуяа төрийн албан хаагчдыг 21 дүгээр зуунд хэрхэн бэлдэх вэ гэдэгт уг номоос авах туршлага, санаа маш их.

Улсын Их Хурлын ТББХ энэ хавар Төрийн албаны зөвлөлийн үйл ажиллагааны тайланг хэлэлцээд 2030 он хүртэл төрийн албаны шинэтгэлийг хэрэгжүүлэх үзэл баримтлал, стратегийн баримт бичиг боловсруулахыг бидэнд даалгасан.

Үүний зэрэгцээ Л.Оюун-Эрдэнэ сайдын санаачилгаар Монгол Улсын урт хугацааны хэтийн төлөвийг тодорхойлох ажил Засгийн газрын бүхий л түвшинд хийгдэж байгаа.


Дээр дурдсан бодлогын баримт бичгүүд, стратеги, мөн хүний нөөцийн удирдлагатай холбоотой журмууд, ялангуяа албан тушаалд тавигдах тусгай шаардлагад эдгээр үзэл санааг тусган, Монголын хөрсөнд буулгаж болохоор шинэ санаа дэвшүүлснийг эх хэлнээ хөрвүүлсэн нь цагаа олсон ажил боллоо.

“21 дүгээр зууны төрийн албаны менежер” номыг зохиогч Сингапурын Их сургуулийн профессор Зегер ван дэр Вал, орчуулсан төслийн техникийн зөвлөх Ц.Даваадулам, редакторласан УИХ-ын даргын зөвлөх Ж.Сүхбаатар нарт хүрэлцэн ирсэн Та бүхний болон Төрийн албаны зөвлөлийн өмнөөс талархал илэрхийлье.

Бид шинэ зууныхаа ажил үйлсийг бодож төлөвлөхдөө, НҮБ-аас дэвшүүлсэн тогтвортой хөгжлийн зорилтуудыг үндэснийхээ хэмжээнд хэрэгжүүлэхдээ шинэ зууны төрийн албаны өнгө төрхийг тодорхойлсон энэ номын авлага болгоё гэж зорьсон юм.

“Ном надад хаан ширээнээс илүү үнэтэй” гэсэн их зохиолч Шекспирийн үгээр номын цагаан буян ашид дэлгэрэхийг билэгдэн энэхүү ёслолын үйл ажиллагааг нээснийг мэдэгдье.

---o0o---



Яамны Төрийн нарийн бичгийн дарга, Агентлагийн дарга нарын төрийн жинхэнэ албан хаагчийн тангараг өргөх ёслолын үйл ажиллагааг нээж хэлсэн үг

Төрийн ёслол хүндэтгэлийн өргөө
2019.05.31

Өнө эртний уламжлалт монгол төрийн нэн шинэ түүхийн хуудсыг бичилцэж, төрийн үйл хэргийг энэ цаг үед буухиалан авч яваа Та бүхэнд төрийн жинхэнэ албан хаагчийн тангараг өргөх билэгт сайн өдрийн мэнд хүргэе!

Төрийн албаны үзэл санаа, зарчмыг цоо шинээр зохицуулсан Төрийн албаны тухай шинэ хууль хүчин төгөлдөр мөрдөгдөөд хуанлийн хуудас 150 дахь удаагаа эргэж байгаа энэ өдөр хуулийн дагуу төрийн жинхэнэ албан хаагчийн тангараг өргөхөөр Та бүхэн хүрэлцэн ирээд байна.

Гарал үүслээс нь хөөвөл “Тангараг” нь үнэнч шударга, бат нотыг амласан андгайлал, ариун нандин үг, бичиглэл.

Тангаргаасаа няцна гэдэг аль ч үед, ямар ч соёлт улс оронд хамгийн шившигтэй явдал байж ирснийг түүх шастираас мэднэ.

Авьяас билигт их бичгийн хүн Данзанравжаа хоосон тангарагладаг, тангарагтаа хүрдэггүй хүнийг “тангаргийн буг”-тай адилтгаж байжээ. Иймээс өргөсөн тангараг гэдэг ам ажил нь нэгдэлтэй байхын утга учир юм.

Төрийн жинхэнэ албан хаагчийн тангараг гурван гурвыг билэгдсэн 33 үгтэй. Үг цөөн байх тусмаа хүчтэй гэдэг.

Хуулийн бүхэл бүтэн зүйл заалт бүрийг агшааж хэдхэн үгэнд багтаасан нь монголчуудын “Үхрийн мах давсагтаа багтдаг” гэж ярьдагтай адил.

Тангараг бол амлалт, бас хариуцлага. Өргөсөн тангарагтаа үнэнч байж, нийтийн тусын тулд хууль бус, шударга бус явдалтай эвлэрэхгүй байх нь тангаргийн амин сүнс юм.

Төрийн албаны шинэчлэл, төлөвшлийн үндэс суурь нь хамгийн товчоор хэлбэл хуулиа чандлан мөрдөж, Та өөрөө шударга ёсны туйл байх амлалт юм. Тангарагтаа үнэнч байж гэмээнэ төр түвшин байна, таны сэтгэл амгалан байна, түмэн олны Монгол төрдөө итгэх итгэл дээшилнэ. Бид зөв ажлыг зөв хүнээр хийлгэж, зөв үр дүнд хүрэх өнөөдрийн биш өнө холын зорилготой ажиллаж байна.

“Сөрөг үйл явдлыг сөрөн зогсож болдог, харин цаг нь ирсэн үзэл санааг зогсоох боломжгүй” гэсэн ухаантны үг буй. Шинэ хуулиар баталгаажсан төрийн албаны шинэчлэл, Тогтвортой хөгжлийн зорилтууд бол нийгэм, иргэдийн хүсэн хүлээж байгаа “шинэ үзэл санаа” юм. Үүнийг зогсоох боломжгүй.

Энэ үзэл санааг тээгч, нийгэмд түгээн дэлгэрүүлэгч байх эрх нь, бас үүрэг нь төрийн захиргааны тэргүүн түшмэл-яамны Төрийн нарийн бичгийн дарга, агентлагийн дарга Та бүхэнд бий.

Төрдөө үнэнч зүтгэж, түмэн олондоо хоёргүй сэтгэлээр үйлчилж эх орныхоо хөгжил дэвшлийн гэрч байх хувь заяа, түүхэн боломж Та бидэнд ногдсон.

Монгол төрийн түүхэнд сайныг бичих, эс бичихийн түүхэн хариуцлага бидэнд бий. Тангараг өргөсөн төрийн хүний үүрэг хариуцлага, хандлага төлөвшил, хичээл зүтгэл, хүсэл зорилгыг үлгэрлэж, алхам тутамдаа санаж яваарай.

Төрийн ёслол хүндэтгэлийн өргөөнд төрийн далбаандаа адислан тангараг өргөх Та бүхний Монгол Улсынхаа төрийг түвшитгэх шударга үйл хэргийн их үйлсэд амжилт хүсье!

Төрийн сүлд ивээх болтугай.

-оОо-



**УИХ-д үйл ажиллагаагаа тайлагнадаг байгууллагын
Тэргүүн түшмэлүүдэд зориулсан Төрийн албаны
мэргэшүүлэх сургалтыг нээж хэлсэн үгнээс**

2019.06.08

....Нийгмийн анхаарлын төвд ямагт байдаг төрийн байгууллагуудын топ менежер, дарга нар та бүхэнд энэ өглөөний мэнд хүргэе!

Гараа сайн бол бариа сайн гэдэг. Төрийн албаны шинэ хууль тогтоомжийн хэрэгжилтийн гарааны саруудад сургалт ойр ойрхон зохион байгуулж байгаа.

Энэ хугацаанд яамдын Төрийн нарийн бичгийн дарга, агентлагийн дарга, аймаг нийслэлийн ЗДТГ-ын дарга, иргэдийн Хурлын нарийн бичгийн дарга нарын удаа дараагийн багц сургалтууд элэгсэг дотно, ажил хэрэгч, ажил хийх тэмүүлэлтэй, харилцан бие биеэ дэмжсэн, энгийн үгээр хэлбэл танхим хүртэл бүлээн дулаан уур амьсгалтай зохион байгуулагдаж ирсэн.

Төрийн албаны зөвлөлөөс анх удаа зохион байгуулсан төрийн өмчит үйлдвэрийн газрын 150 захирал оролцсон сургалт ч амжилттай болсон.

Та бүхэн ч гэсэн өнөөдрийн сургалтыг албадлага хэлбэртэй бус, ач холбогдол өгч бүгдээрээ суралцагч байж чадна гэдэгт итгэлтэй байна.

Төрийн албаны зөвлөлөөс ирэх долоо хоногт орон нутагт зөвлөн туслах, мэргэжил, арга зүйн зөвлөгөө өгөх үйл ажиллагаа өргөн хүрээтэй эхэлнэ.

Төрийн албаны шинэчлэлт зөвхөн төрийн жинхэнэ албан хаагчдын хүрээгээр хязгаарлагдахгүй. Шинэчлэлтийг бүх салбарт үр дүнтэй хүргэх зорилтыг Төрийн албаны зөвлөлийн шинэ бүрэлдэхүүн тавьж байна.

Иргэд, олон нийтийн дунд төрийн албаны шинэчлэлтийн хүлээлт өндөр давтамжтай, шударга ёсны хүсэмжлэл их байна.

Төрийн албаны шинэ хуулиар төрийн албанд ажиллах босго өндөр болж, тухайн албан тушаалын багц сургалтад зайлшгүй хамрагдаж, төгссөн байх тусгай шаардлага тавигдсан.

Ажлын замналаа үргэлжлүүлэх, ажил хийх сэтгэлтэй хүмүүс энэ сургалтыг хүлээдэг болж.

Албан тушаалын тусгай шаардлагыг бид өөрсдөө хангаж үлгэр дуурайл үзүүлэх хэрэгтэй юм.

Төрийн албаны тухай хуулийг хэрэгжүүлэх ажил, шинэчлэлийг эрчимжүүлэх, технологийн шинэчлэл, мэдээллийн эрин үе, **ВУКА** (VUCA) буюу улам бүр хувьсамтгай, тогтворгүй, нарийн төвөгтэй, эргэлзээтэй болж байгаа дэлхий ертөнцөд төрийн албаны удирдах ажилтан ямар ур чадвартай байх зэрэг

олон асуудлыг хамтдаа тал талаас нь нухацтай ярилцаж, мэдлэг, мэдээллээ хуваалцах сургалтуудыг үе шаттай явуулж байгаа.



Сургалт сонирхолтой болох эсэх нь та бидний оролцооноос шууд шалтгаална.

Өнөөдрийн сургалтдаа 2 эрхмийг урьсан.

Бүгд Найрамдах Солонгос Улсын Ионсей Их сургуулийн профессор, доктор Пан Сук Ким үндэсний төдийгүй, гадаад орон, олон улсын нэр хүндтэй байгууллагын хэмжээнд үнэлэгдсэн эрдэмтэн хүн, Солонгосын Төрийн албаны комиссын дарга, Хүний нөөцийн яамны сайд байсан хүн.

Раэйн Оорэнж гуай бол “Монгол Улсад мэргэжлийн, иргэн төвтэй төрийн албыг төлөвшүүлэх нь” төслийн бодлогын зөвлөхөөр ажилладаг, төрийн албаны шинэтгэлийн ажилд экспертийн зөвлөгөө өгөх чиглэлээр өндөр түвшинд мэргэшсэн, Шинэ Зеландын төрийн албаны “Төрийн албаны шинэ тэмүүлэл” гэдэг үзэл баримтлалыг үндэслэгчдийн нэг.

Иргэдийн төрд итгэх итгэлийг сэргээхэд төрийн албаны менежерийн ур чадвар шууд хамаарна.

Та бидний ёс зүйтэй, улс төрийн хувьд төвийг сахисан үйл ажиллагаа, шударга, хүндэтгэлтэй хандлага туйлын чухал.

Төрийн албан хаагчид хуулийг чанд мөрдөж, хуулийн үзэл санаанд захирагдах, үндэсний эрх ашгийг хувийн ашиг сонирхлоос дээгүүр тавих үүрэгтэй.

Ёс зүйн алдаа гаргавал хариуцлага хүлээх нь ойлгомжтой.

.... Та бидний өнөөдрийн багц сургалт бол шинэчлэлтийн хүрээнд зохион байгуулагдаж буй сургалтын бүрэлдэхүүн хэсэг юм.

Энэ сургалтад хамрагдсанаар та 21 дүгээр зууны төрийн албаны удирдах ажилтанд “мэдэгдэж байгаа”, бас “үл мэдэгдэх” олон олон сорилуудад бэлтгэгдэнэ.

Бэлтгэгдэж чадсан хүн сорилуудыг бэрхшээл, хохирол багатай даван туулна.

Сургалтыг хамтран зохион байгуулж буй Төрийн албаны зөвлөл, ЗГХЭГ, Удирдлагын академийнхандаа талархал илэрхийлье.

Сургалтын үйл ажиллагаанд амжилт хүсье!

-ооо-



Төрийн албаны зөвлөлийн салбар зөвлөл, орон нутгийн төрийн албаны зарим удирдах ажилтнуудтай хийсэн видео хурлыг хааж хэлсэн үг

2019.05.15

Өнөөдрийн хуралд санаа бодлоо илэрхийлж, ажил хэрэгч хандсан та бүхэнд баярлалаа.

... Асуулт асууж, тэр бүгдэд хариулт сонсож, тэр хэмжээгээр бидний ойлголт нэг цэгт төвлөрөх, хийх ажлын зүг чигээ тодорхой болгоход тус дөхөм үзүүллээ гэж бодож байна.

Видео хурлыг цаашид тодорхой давтамжтай, байнгын болгон үргэлжлүүлнэ.

Өнөөдөр яригдсан асуудлууд протокольд бүрэн бичигдэж, хугацаандаа шийдвэрлэгдэх болно. Шаардлагатай асуудлаар манай ажилтнууд та бүхэнтэй эргэн холбогдож тодруулна.

Хүн болгон, та бид ч мөн адил бүгдийг мэддэггүй, бас мэддэг байх албагүй, тийм ч шаардлагагүй биз. Гэхдээ яг хариуцсан ажил албандаа хэрэглэх хууль тогтоомж, дүрэм журмыг мэдэж байх, хамгийн гол нь нэг мөр ойлголттой байх нь бид үйл ажиллагаагаа шуурхай, алдаагүй явуулах суурь нөхцөл болно.

Төрийн ажил, явцуу утгаар нь хэлбэл, **та бидний ажлын үр дүн** хууль тогтоомжид нийцэж, төрийн үйлчилгээ авч буй иргэд ч сэтгэл ханамжтай үлдэх тийм таатай орчин бүрдэж чадвал төрийн албаны шинэчлэл, бид бүхний зорьж байгаа тэр үр дүн гарна, би хувьдаа ингэж чадна гэдэгт итгэлтэй байгаа.

Дээр нь нэмээд хэлэхэд хийж байгаа ажилдаа чин сэтгэлээсээ хандаж, хийсэн ажлынхаа үр дүнгээс баяр баясгалан, таашаал, урам зориг авдаг, түүнийг нь удирдлагууд ойлгож, хэр хэмжээнд нь таарсан урамшил олгодог байж төрийн алба өөрөө “амьд” байх учиртай.

Хэвшмэл, царцмал байдлаар явж ирсэн бидний зарим “туршлага” шинэ орчин, шинэ цаг үед яагаад ч таарахаа больсныг бүгдээрээ хүлээн зөвшөөрөхөөс өөр аргагүй.

Ирэх он жилүүдэд Төрийн албаны зөвлөл, төрийн бүх шатны байгууллага, төрийн албан хаагчдыг олон сорилт хүлээж байгаа.

Төрийн албаны зөвлөл төдийгүй салбар зөвлөлүүд, тэдгээрийг ахалж яваа, гишүүнээр ажиллаж байгаа хүн бүр төрийн ажил, төрийн албаны толь байх ёстой гэдгийг та бид ойлгож, ухамсарлах хэрэгтэй.

Шинэтгэлийг бүрэн дүүрэн гүйцэтгэхэд төрийн албан хаагчид, ялангуяа та бүхний сэтгэлгээ, зан үйлийн өөрчлөлт маш чухал.

Ажилдаа чин сэтгэлээсээ ханддаг албан хаагчидтай төрийн албыг төлөвшүүлье. Хийх ажлаа илүү үр нөлөөтэйгөөс нь эхлүүлж, шинэчлэлийнхээ үзэл баримтлалыг иргэдэд ойлгуулан таниулж, иргэдийн зүрх сэтгэлд хүрэхийг чухалчилъя.

Бүх шатны төрийн захиргааны байгууллагын томилох эрх бүхий албан тушаалтнуудад хүний нөөцийн хууль бус томилгооны зөрчлөө өөрсдөө арилгах, шүүхийн шийдвэрийг биелүүлэх, зэрэг дэв олгохдоо батлагдсан журмыг мөрдөж ажиллах хугацаатай албан даалгавар өгсөн. Хууль бусаар гаргасан шийдвэрээ албан тушаалтнууд та нар өөрсдөө залруулахгүй бол бид түүнийг нь

хуульд нийцүүлж залруулах арга хэмжээ авна. **Үүнээс үүдэн гарах үр дагаврыг хэн хариуцахыг та нар сайн мэднэ.**

Монгол орон, монголчуудынхаа өөдрөг ирээдүйн төлөө төрийн албан хаагчид маань шаргуу ажиллаж байгаа. Гэхдээ оочин цоочин ажиллаж, ачааллыг цөөн хүн үүрэх явдал амь бөхтэй оршсоор байна.

Хийж чаддаг, ажлын ард гарч чаддаг хэдхэн хүний нуруун дээр бүхэл бүтэн баг, хамт олны ажил яваад байдаг жишгийг арилгах цаг болсон. Албан хаагч бүрийн ажлын ачаалал жигд, авч буй цалин урамшуулалтайгаа дүйж байх ёстой. Үүнийг ажил дүгнэх, үнэлэлт өгөхдөө харгалзах болно.

Төрийн албан хаагчид бүгдээрээ ар гэртэй, хань ижилтэй, үр хүүхэдтэй хүмүүс. Тэд нар бусдын адил гэр бүлдээ аз жаргалтай байж, гэр бүлийнхэнтэйгээ цагаа өнгөрүүлэх, чөлөөт цагтай байх эрхтэй хүмүүс.

Яаруу сандруу, онцгой цаг мөчид төрийн албаныхан бид цаг наргүй ажиллаж сурсан, тэгэх ч үүрэгтэй. Гагцхүү ажлын ачааллыг нь жигд байлгаж, цагийн ажлыг цагт нь дуусгадаг ажлын цагийн менежментийг та бүхэн хатуу мөрдөх хэрэгтэй. Хэрэв илүү цаг ажиллуулсан бол цалин хөлсийг нь нэмж бодох хэрэгтэй, амралтын цагийг нь сунгах хэрэгтэй. **Цагтаа эхэлж, цагтаа дуусдаг төрийн албаны цагийн менежментийг өнөөдрөөс эхлээд хэрэгжүүл.**

Төрийн албаны шинэчлэлийн шинэ үе шатны гарааны жил 2019 он болох учиртай.

2019 он шинэчлэлээ бодит ажил хэрэг болгох, үр дүнгээс нь төрийн албан хаагчид ч, иргэд, олон нийт ч мэдэрч, хүртэж эхлэх жил болно. Үүний төлөө та бид хичээн зүтгэх хэрэгтэй.

2019 онд хууль бус томилгоотой эвлэрэхгүй. 2019 оныг тохиолдлын хүн төрийн албан хаагч болж томилогдох байдлыг эцэслэх жил болгоно.

2019 он ажил, албан тушаалын шаардлага хангахгүй төрийн албан хаагчийг ажиллуулах боломжийг олгохгүй жил байна.

2019 он төрийн албанд зөвд зөөлөн, бурууд хатуу жил байх болно.

2019 он бүхэлдээ төрийн үйлчилгээ иргэдэд чанартай хүрдэг болох, шинэчлэл иргэдэд өгөөжөө өгч, улмаар төрд итгэх олон түмний итгэлийг нэмэгдүүлэх жил байх болно.

Энд хэлж ярьсан, онцлон дурдсан зүйлсийг аймагтаа хэрхэн хэрэгжүүлэх арга замыг та бүхэн мэдэж байгаа, хэрэгжилтэд нь бид хяналт тавина.

Түмний төлөө зүтгэсэн төрийн ажлын шинэчлэлийг эрчимжүүлж манлайлахад Та бүхний үүрэг хариуцлага, зөв ойлголт, зүтгэл чармайлт юу юунаас чухал байна. Бүгдээрээ зөв ойлголттой байж, радиогоор бол нэг долгион дээр нэвтрүүлэг сонсож, түүнийгээ нэгэн жигд хэрэгжүүлдэг болох зорилгоор энэ удаагийн видео хурлыг хийлээ.

Дараа дараагийн хурлуудад шинэ санаа, урам зориг улам илүү тээсэн, асуудлыг “яах вэ” гэж биш “ингэж шийдвэл ямар байна” гэсэн бүтээлч хандлагаар оролцоосой гэж та нараас хүсэж байна.

-ооо-



Аймаг, нийслэлийн ИТХ-ын нарийн бичгийн дарга, ЗДТГ-ын дарга нарт зориулсан Төрийн албаны мэргэшүүлэх сургалтыг нээж хэлсэн үг

2019.05.05

Монгол Улсын Төрийн албаны тухай шинэ хууль энэ оноос хэрэгжиж эхэлсэн. Төрийн албан хаагчийг сонгон шалгаруулах, томилох, албан тушаалд дэвшүүлэхэд чадахуйн болон шатлан дэвших зарчмыг мөрдүүлэх нь Монгол Улсын төрийн албаны шинэчлэлийн хамгийн том тэргүүлэх чиглэлийн зорилт

билээ. Чадахуйн зарчмын үндсэн суурь нь төрийн албан хаагчдыг мэргэшүүлэх, ажил хэргээ явуулахад нь шаардлагатай мэдлэг, ур чадварыг олгох юм.

Энэ чиглэлээр дараах ажлууд хийгдэж байна:

1. Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын дарга, Төрийн албаны зөвлөлийн даргын хамтарсан тушаалаар “Мэргэшүүлэх багц сургалтын агуулга, хөтөлбөр”-ийг өнгөрсөн сард баталсан. Энэ хөтөлбөрийн дагуу төрийн албаны тэргүүн, эрхэлсэн, ахлах түшмэлийн ангиллын албан тушаалд томилогдох албан хаагчдад “Бодлого, стратеги”; “Захиргаа, удирдлага”; “Мэдээллийн технологи”; “Ёс зүй, хүний эрх” гэсэн дөрвөн багц сэдвийн хүрээнд хамрагдах сургалтын сэдвүүдийг тодорхойлсон.

2. Дээрх шийдвэрийн дагуу төрийн албаны сургалтын байгууллага болох Удирдлагын академийн хувьд хичээлийн хөтөлбөр, агуулга, заах арга зүйн хувьд томоохон шинэчлэл хийх шаардлагатай болж байгаа. Үндсэндээ одоо зааж буй хичээлийн 90 хувь нь шинэчлэгдэж, 30 орчим хичээлийн агуулгыг цоо шинээр боловсруулах ажил хийгдэнэ. Энэ ажилд ЗГХЭГ, ТАЗ, НҮБХХ-ийн “Монгол Улсад мэргэжлийн, иргэн төвтэй төрийн албыг төлөвшүүлэх нь” төслийн зүгээс мэргэжил, арга зүй, санхүүгийн дэмжлэг үзүүлнэ.

3. Энэ шинэчлэгдсэн хөтөлбөр, агуулгын дагуу тэргүүн, эрхэлсэн, ахлах түшмэлийн ангилалд хамаарах албан тушаалд одоо ажиллаж байгаа 3000 гаруй ажилтны мэргэшүүлэх сургалтыг 2019 онд багтаан зохион байгуулах төлөвлөгөөтэй ажиллаж байна.

Эхний ээлжид яамдын Төрийн нарийн бичгийн дарга, Засгийн газрын агентлагийн дарга нар хамрагдаж, нийт 48 хүн сургалтын анхны гэрчилгээгээ өчигдөр хүлээн авлаа.

4. Аймаг, нийслэлийн Засаг даргын Тамгын газар, иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын нарийн бичгийн дарга нарын сургалтын эхний хэсэг өнөөдөр эхэлж байна.

Өнөөдрийн сургалтын сэдэвтэй холбоотойгоор хоёр асуудлыг онцлон хөндмөөр байна.

1. Төрийн захиргааны үндсэн чиг үүргүүдийн нэг бол төрийн бодлого боловсруулах, хэрэгжүүлэх байдаг. Өнөөдөр Монгол Улсад хүчин төгөлдөр 600 гаруй бодлогын баримт бичиг байгаа гэсэн статистик тооцоо бий.

Гэхдээ эдгээр баримт бичиг хоорондын уялдаа муу, хэрэгжих санхүүгийн болон хүний нөөцийн боломжгүй, хэрэгжилтийг нь дүгнэдэггүй, үр дүнгийнх нь талаар хариуцлага тооцдоггүй, бодлогын баримт бичгийн чанар хангалтгүй байгаа

талаар өргөн шүүмжлэл гардаг. Үүнийг цэгцлэх ажил Засгийн газрын түвшинд хийгдэж эхлээд байгаа.

Цаашид Монгол Улсын төрийн албаны шинэчлэлийн нэг тэргүүлэх чиглэл нь төрийн албан хаагчдын бодлого боловсруулах, Засгийн газарт бодлогын зөвлөгөө өгөх чадавхыг сайжруулах явдал байх болно.

Нийгэм, эдийн засгийн асуудлууд улам бүр нарийн төвөгтэй, харилцан хамааралтай болж байгаа нөхцөлд бодлогын үйл явц ч өөрөө олон талын оролцоо, санаа бодлыг тусгах нээлттэй байдал, салбар дундын хамтын ажиллагааг шаардсан шинжтэй болж байна.

Төрийн албан хаагчдад ажлаа хийхэд шинэ ур чадвар, арга хэрэгсэл шаардлагатай болох нь илэрхий харагдаж байна. Мөн бодлого боловсруулахад ул суурьтай судалгаа, нотолгоо шаардлагатай байдаг. Үүний зэрэгцээ шинжлэх ухаан асар хурдацтай хөгжиж, шинэ мэдлэг, шинэ хандлага, шинэ арга зүй бий байнга бий болж байна. Эдгээр шинэ зүйлийг сонирхон судалж, дэлхий нийтийн чиг хандлагатай хөл нийлүүлэх хэрэгцээ ч бидэнд гарч байна.

Энэ зорилгоор бид өнөөдрийн сургалтдаа Сингапурын Үндэсний их сургуулийн Ли Куан Юугийн нэрэмжит Төрийн бодлогын сургуулийн профессор Др.Рубенийг зочин багшаар урьж авчраад байна. Бидний урилгыг хүлээн авсан Др.Рубен Танд сургалтад оролцогчдынхоо өмнөөс гүн талархал илэрхийлье.

2. Ар араасаа гарч байгаа авлигын дуулиант хэргүүд, төрийн албан тушаалтны ёс зүйгүй үйлдлээс болж төр засагт итгэх иргэдийн итгэл маш доогуур байна. Цаашлаад энэ нь төр засгийн легитим⁴ байдал буурахад нөлөөлж байгаа нь манай орны хувьд түгшүүрийн харанга дэлдсэн асуудал болоод байна.

Төр засаг нь тогтворгүй, легитим шинж нь алдагдсан орнуудад ард нийтийн бослого, үймээн гарч, нэг хүний захиргаадлын дэглэм тогтдогийг Арабын орнуудад өрнөсөн хувьсгалт үйл явц харуулсныг бид санахад илүүдэхгүй.

Төрийн албаны тухай хуулиар тунхагласан меритэд үндэслэх зарчмын үндсэн үзэл санаа нь төрийн албан хаагчдын шударга, ёс зүйтэй ажиллагаа юм. Төр засагт итгэх итгэлийг сэргээхэд төрийн албан хаагчид бидний ёс зүйтэй, улс төрийн хувьд төвийг сахисан үйл ажиллагаа, шударга, хүндэтгэлтэй хандлага туйлын чухал.

⁴ М.Вебер: “Улс төрийн ноёрхол, ноёрхол бол тодорхой тушаал шийдвэрт захирагдаж даган биелүүлэх боломж юм” гэж хэлж байжээ. Франц хэлний “Хууль ёсны, хуульчлагдсан” гэсэн үг бөгөөд засаглалын шинжтэй легитимийг уламжлалт, харизматик, рациональ гэж ангилдаг.

Төрийн албан хаагчид хуулийг чанд мөрдөж, хуулийн үзэл санаанд захирагдах, үндэсний эрх ашгийг хувийн ашиг сонирхлоос дээгүүр тавих үүрэгтэй. Ёс зүйн алдаа гаргасны төлөө хариуцлага хүлээлгэхийн зэрэгцээ тухайн төрийн албан хаагчийн ёс зүйн зөрчил, холбогдох шийдвэрийг бүртгэх нь албан тушаал дэвшүүлэхэд харгалзах чухал үзүүлэлтийн нэг болж байна. Засгийн газраас оны эхэнд “Төрийн захиргааны болон үйлчилгээний албан хаагчийн ёс зүйн дүрэм”-ийг баталсан.

Төрийн албаны тухай хуульд зааснаар төрийн албаны удирдах болон гүйцэтгэх албан хаагчид төрийн албан хаагчийн ёс зүйн хэм хэмжээг сахиулахтай холбогдсон зөвлөгөө өгөх, арга зүйн удирдлагаар хангах үүргийг Төрийн албаны зөвлөл хүлээсэн. Төрийн албаны зөвлөлийн энэ чиг үүргийг идэвхжүүлэх талаар ойрын үед дорвитой ажлуудыг эхлүүлнэ гэж миний хувьд төлөвлөж байгаа.

-ооо-



“Монгол Улсад мэргэжлийн, иргэн төвтэй төрийн албыг төлөвшүүлэх нь” (МОН/18/101) төслийн Удирдах зөвлөлийн хурал дээр хэлсэн үг

2019.05.22

Улсын Их Хурлын эрхэм гишүүн, төслийн Удирдах зөвлөлийн дарга Д.Тогтохсүрэн, НҮБ-ын Хөгжлийн хөтөлбөрийн суурин төлөөлөгч хатагтай Биата Транкманн, “Монгол Улсад мэргэжлийн, иргэн төвтэй төрийн албыг төлөвшүүлэх нь” төслийн Удирдах зөвлөлийн хуралд хүрэлцэн ирсэн Та бүхний энэ өдрийн амгаланг айлтгая.

Монгол Улсад сүүлийн 20 гаруй жилийн турш үргэлжилж буй төрийн албаны шинэтгэлийн түүхэнд нэгэн томоохон хуудас болж, зарчмын цоо шинэ утга, агуулгыг зүйл, заалт бүрдээ шингээсэн Төрийн албаны тухай хууль энэ оны эхний өдрөөс хэрэгжиж байна.

[Энэ үйл явц иргэд, олон нийтийн төдийгүй **олон улсын байгууллагын** дэмжлэг, итгэлийг хүлээх болсны нэгэн тод томруун илрэл нь НҮБ-ын хөгжлийн хөтөлбөрийн шууд оролцоотойгоор хэрэгжиж буй энэхүү төсөл билээ.](https://exam.csc.gov.mn/Хууль хэрэгжүүлэх ажлын хүрээнд төрийн албаны шинэчлэлийг эрчимжүүлэх, мэргэшсэн, тогтвортой, ёс зүйтэй, улс төрийн нөлөөллөөс ангид, хариуцлагатай, шинэчлэгдсэн төрийн албыг төлөвшүүлэх талаар Улсын Их Хурал, Засгийн газар, Төрийн албаны зөвлөл нэгдмэл итгэл үнэмшил, байр суурьтай боллоо.</p></div><div data-bbox=)

Үйл ажиллагааны өргөн цар хүрээг хамарсан бодлого, санхүүжилт, сургалт, зохион байгуулалтын томоохон дэмжлэг үзүүлэн ажиллаж буй хатагтай Биата Транкманнд Төрийн албаны зөвлөлийн нэрийн өмнөөс болон хувиасаа талархал илэрхийлье.



Долоо хоногийн өмнө УИХ-ын Төрийн байгуулалтын байнгын хороонд 2018 оны ажлаа тайлагналаа. Байнгын хорооноос Төрийн албаны зөвлөлийн үйл ажиллагаанд эерэг үнэлэлт, урам дэм өгсөн. Төрийн албаны шинэтгэлийн үйл явцад цаг зав, оюун бодлоо зориулж яваа эрхэм гишүүн Д.Тогтохсүрэнд хамт олныхоо өмнөөс талархал илэрхийлье.

Төрийн албаны шинэ хууль хэрэгжиж **эхлээд 142 хоног** боллоо. Шинэ хуулийг хуучин хандлага, хуучин арга барилаар хэрэгжүүлэх боломжгүй, шинэ хандлага, шинэ соёл, шинэ арга барилаар хэрэгжүүлэх зорилгоор Төрийн албаны зөвлөлийн шинэ бүрэлдэхүүн ажлын шахуу төлөвлөгөөтэй ажиллаж эхлээд **108 хонож** байна.



ШИНЭ

ОЙЛГОЛТ

ХАНДЛАГА

СОЁЛ

АРГА БАРИЛ

1. 47 журам батлагдахаас 90 хувь нь батлагдаад байна. Одоогоор Төрийн албаны зөвлөлөөс “Салбар зөвлөлийн ажиллах журам”, “Олон нийтийн хяналтын зөвлөлийн дүрэм”-ийн төслийг тус тус боловсруулж, санал авахаар холбогдох байгууллагуудад хүргүүлээд байна.

Төрийн албаны зөвлөл өнгөрсөн 7 хоногт “Төрийн үйлчилгээний байгууллагын төсвийн шууд захирагчийн сонгон шалгаруулах журам”-ыг хэлэлцэн баталлаа.

2. Хууль бусаар ажлаас халагдсан албан хаагчийг урьд эрхэлж байсан албан тушаалд эгүүлэн томилох шүүхийн шийдвэрийг хэрэгжүүлэхийг Төрийн албаны зөвлөлөөс томилох эрх бүхий этгээдэд даалгаснаар албан хаагчид өмнөх албан тушаалдаа томилогдож байна.

Түүнчлэн төрийн жинхэнэ албан хаагчдаас ирүүлсэн 288 өргөдөл, гомдлын дагуу маргаан үүсгэн шалгаж, хууль бус шийдвэрийг Төрийн албаны зөвлөлөөс хүчингүй болгон шийдвэрлэж байна.

3. Төрд учруулсан хохирлыг буруутай албан тушаалтнаар нөхөн төлүүлэх шаардлагыг холбогдох этгээдэд тавьж байна. Хэрвээ тогтоосон хугацаанд төрд учирсан хохирлыг бүрэн төлөөгүй бол дараагийн шатны арга хэмжээг Төрийн албаны зөвлөл, хууль хяналтын холбогдох байгууллагатай хамтран авч хэрэгжүүлнэ.

4. Төрийн захиргааны албаны албан тушаалын тодорхойлолтыг хянаж, эрх бүхий этгээдэд батлах зөвшөөрлийг олгож байна. Албан тушаалын тодорхойлолт нь “хүнд” тааруулах байдлаар биш шинжилгээ судалгааны үндсэн дээр тухайн албан тушаалыг гүйцэтгэхэд тавигдах шаардлагыг харуулах ёстой гэсэн зарчмыг баримталж байна.

Мөн аймгийн төвөөс бусад сумын Засаг даргын Тамгын газрын дарга, ажилтнуудын ажлын байрны тодорхойлолтын талаар хэлэлцсэн. Энэ ажлын үр дүнд 2400 ажлын байрны тодорхойлолт бэлэн болох ёстой.

5. Төрийн албаны шалгалтыг хүний оролцоогүй, хөндлөнгийн нөлөөгүй авдаг системийг боловсронгуй болгож байна. Төрийн албаны тухай хуульд заасан 7 багц ур чадварыг бодитой шалгахад анхаарал тавьж, шалгалтын санг шинэчлэн баяжуулж байна.

Төрийн албаны зөвлөлийн Ажлын албаны даргын албан тушаалын сонгон шалгаруулалтыг зохион байгууллаа. Цаашид сонгон шалгаруулалтууд үргэлжлэн явагдана.

Өнгөрсөн 5 дахь өдөр нийт аймгуудын Төрийн албаны зөвлөлийн Салбар зөвлөлийн гишүүд, төрийн байгууллагын зарим удирдах албан тушаалтнуудыг оролцуулан Засгийн газрын Хэрэг эрхлэх газартай хамтарч цахим хурал зохион байгууллаа. Энэ нь хууль тогтоомжийг хэрэгжүүлэх талаар ойлголтоо нэгтгэх, баримталж буй бодлого, зарчмаа тодорхойлоход ихээхэн дэм үзүүлсэн гэж бодож байна.

НҮБ-ын төрийн албаны өдрийг эх орондоо тэмдэглэж, шинэ хуулиа хэрэгжүүлэх, төрийн албаны шинэтгэлийг эрчимжүүлэхэд НҮБ-ын холбогдох нэгжүүдтэй хамтран ажиллах, бусад орны туршлагыг судлах, олон улсын тавцанд болон үндэсний хэмжээнд Монгол Улсын төрийн албаны нэр хүндийг өргөх, иргэдийн төрд итгэх итгэлийг нэмэгдүүлэх цогц үйл ажиллагаа явуулдаг байя гэж Төрийн албаны зөвлөл саяхан шийдвэрлэсэн.

Засгийн газар энэ саналыг маань дэмжинэ гэдэгт итгэж байна.

Төрийн албаны зөвлөл өөрөө төрийн ажил, төрийн албаны толь байх ёстой гэдгийг бид ойлгож, ухамсарлаж байгаа.

Монголын төрийн албаны босго өндөр болж байгаа ч манай байгууллагын босго улам намхан байж, иргэд, төрийн албан хаагчид, төрийн албанд зүтгэхийг хүсэж буй мэдлэг, чадвартай хүмүүст бодит болон цахим орчинд улам бүр нээлттэй байхыг зорин ажиллаж байна.

Мэргэжлийн, иргэн төвтэй төрийн албыг төлөвшүүлэх ажлын бодит үр дүн гарна гэдэгт эргэлзэхгүй байна.

-оОо-

Төрийн албаны шинэчлэлийн шинэ үе шатны гарааны жил буюу 2019 он

Төрийн албаны олон талт харилцааг зарчмын шинэ агуулгаар зохицуулсан эрх зүйн орчин дахь шинэтгэлийн гараа, эрх зүйт төрийн албаны орчин үеийн хөгжлийн шинэ хандлага, соёлыг төлөвшүүлэх үйл явцыг эхлүүлсэн шилжилтийн жил бол 2019 он байлаа.

Монгол Улсын Ерөнхийлөгч, Улсын Их Хурал, Засгийн газар, төрийн төв болон орон нутгийн байгууллагуудаас төрийн албаны хууль тогтоомжийг



хэрэгжүүлэхэд бүхий л талын дэмжлэг үзүүлж, төрийн албаны шинэтгэлийг эрчимжүүлэхэд нэгдмэл байр суурь, зорилго, чиглэлтэй ажилласан нь үйл ажиллагаагаа амжилттай явуулах чухал хүчин зүйл болсон төдийгүй гадаад улс, олон улсын байгууллагын дэмжлэг, итгэлийг хүлээх болсон юм.

Үүний тод илрэл бол Төрийн албаны зөвлөл Канад Улсын Засгийн газрын санхүүжилтээр Нэгдсэн Үндэстний Байгууллагын Хөгжлийн Хөтөлбөртэй 2018 оноос хамтран хэрэгжүүлж байгаа “Монгол Улсад мэргэжлийн, иргэн төвтэй төрийн албыг бэхжүүлэх нь” төслөөс үзүүлж буй санхүү, ажил, үйлчилгээний дэмжлэг, туслалцаа нь төрийн албаны шинэтгэлийг үр өгөөж, үр нөлөөтэй хэрэгжүүлэхэд чухал хөшүүрэг болж байгааг тэмдэглэе.

-ооо-



Төрийн ордонд 2019 оны 2 дугаар сард болсон орон нутгийн удирдах ажилтны улсын зөвлөгөөн дээр тавьсан “Төрийн албаны шинэтгэлийн зарим асуудал” илтгэлээс...

... Шинэчлэл эрчээ авч байна. Шинэ хууль үйлчилж эхэлсэн. Одоо Та бид юу хийх ёстой вэ?

1. Та бүхэн өөр өөрийн засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгждээ хуулийн хэрэгжилтийг зохион байгуулах онцгой үүргийг төрийн өмнө хүлээсэн гүйцэтгэх засаглалын бие төлөөлөгчид.

- Төрийн албаны хуулийн хэрэгжилтийн явц, түүнд тавих хяналт Та бүхний ажлын гүйцэтгэлийг дүгнэх нэг гол үзүүлэлт байх болно.
- Иймд энэ хуулийг хэрэгжүүлэхэд улс төрийн ашиг сонирхлоор бус, төрийн хүний ухаанаар хандахыг зөвлөө.

2. Хүний нөөцийн томилгоо, сонгон шалгаруулалт, шатлан дэвшүүлэх болон ажлын гүйцэтгэлийг үнэлэх, дүгнэх, төрийн захиргааны харилцаанд хөндлөнгөөс нөлөөлөх, шахалт, дарамт үзүүлэх зүй бус, хууль бус оролцоог таслан зогсоох.

- Ийм хандлага, сэтгэлгээг өнөөдрөөс хойш тэвчих нь шинэчлэлийг хүлээн авч буй бодит үйлдэл байх болно.
- Хол ойрын хамаатан садан, ашиг сонирхол нэгтэн, аль эсвэл цүнх баригч, тал засагч, нам бүлгийн төлөөллөө төрийн албанд шахах зүтгүүлэхийг иргэд тэвчихгүйгээр барахгүй үзэж чадахгүй болсон шүү.

3. Улс төрийн болон захиргааны ажил, албан тушаал тус тусдаа байхыг шинэ хуулиар тодорхой зохицуулсан. Үүнтэй холбоотойгоор төрийн захиргааны албан тушаал давхар хашиж буй орон нутгийн Иргэдийн хурлын төлөөлөгчдийг сонголтоо хийх шаардлагыг Төрийн албаны зөвлөл тавьж байна.

- Мэдээж цаг хугацааны боломж олгоно.
- Засаг дарга Та бүгд төлөөлөгчид болон иргэдийн төлөөллийн байгууллагатайгаа ухаалгаар ярилцаж, зөвшилцөж энэ асуудлыг үе шаттай нэг тийш болгох хэрэгтэй.

4. Аймаг, нийслэл, сум бүрийн түвшинд Засаг дарга нар харьяа агентлагийн төсвийн шууд захирагч болон төрийн захиргааны албан хаагчидтай үр дүнгийн гэрээ байгуулахгүй, үйл ажиллагааны төлөвлөгөөг нь баталж өгөхгүй, ажлыг нь дүгнэхгүй байх тохиолдол цөөнгүй байна.

- Хийх ёстой үнэлгээ хийхгүй байна гэдэг хууль зөрчиж буй хэрэг.
- Санаатайгаар төрийн ажлыг саатуулж буй хэлбэр. Төрийн албан хаагчид үзүүлж буй улс төрийн дарамт гэж үзнэ.
- Төрийн албаны зөвлөл энэ бүхэнд хяналт тавих, хариуцлага тооцох үүргийг хуулиар хүлээсэн.

5. Засаг дарга нар Ажлын алба буюу Тамгын газрынхаа үйл ажиллагаанд улс төрийн дэмжлэг үзүүлж хамтран ажиллах нь нэн чухал.

- Тийм газар ажил нь сайн явдаг. Иргэд нь талцалгүй байдаг. Нөгөө талаар Тамгын газраа шахааны буюу таалсан, тал зассан хүмүүсээр биш чадварлаг мэргэжилтнээр бэхжүүлэх, шаардлага тавьж бай.
- Ийм мэргэшсэн, туршлагажсан төрийн жинхэнэ албан хаагчдын баг Та бүхний мөрийн хөтөлбөрийн зорилтуудыг хэрэгжүүлэх хүчирхэг ар тал болж чадна.
Ингэж чадвал бүгд хожно. Та хөтөлбөрөө хэрэгжүүлсэн байна. Иргэд ам сайтай байна. Албан хаагчид ажилдаа урамшина. Таны улс төрийн замнал уртсах болно.

6. Улс төрийн удирдах албан тушаалтан бүр мэргэшлийн сонгон шалгаруулалтаар бус ард түмний итгэл хүлээсэн аль нэг улс төрийн хүчний дэмжлэгээр олон түмний сонголтоор сонгогдож байгаа.

- Тийм учраас Та бүхэн иргэдийг, төрийн албан хаагчдыг алагчилж ялгаварлахгүй, талцуулж хагаралдуулахгүй, адил тэгш, шударга зарчимч хандаж, ард иргэдийн амьдрал, албан хаагчдын ажлын нөхцөл, нийгмийн баталгааг хангахад эн тэгш хандах учиртай.
- Эс тэгж чадваас Та хувийн нэр төр, өөрийн албан тушаалаа эрсдэлд оруулаад зогсохгүй улс төрийн дэмжлэг, ард түмний итгэлийг алдах болдог.
- Энэ нь эцэстээ төрийн эмгэнэл түүнд итгэж сонгосон иргэдийн харуусал, зэвүүцэл болон хувирдаг. Энэ бүхнийг ухаарч, ухамсарлаж зөв зүг рүү, зөв алхам хийх эрх зүйн хөтөч нь төрийн албаны шинэ хууль юм.
- Иймээс төрийн албаны шинэчлэл бодитоор хэрэгжиж, ард иргэдийн төрд итгэх итгэл сэргэх нь Та бүхний улс төрийн ухаарал мэдрэмж, сэтгэлийн чинь зоригоос хамаарна.

Төр түвшин, Түмэн олон амгалан байг



-000-